



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүрэнжавын ЛҮНДЭГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-03-85, Факс: 32-70-16
E-mail: lundeg@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.07.04 № 449-03/8490
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хүнсний Бүтээгдэхүүний Аюулгүй Байдлыг Хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЛҮНДЭГ

А.АРИУНЗАЯА

У.ОТГОНБАЯР

Б.ЖАРГАЛАН

Д.РЭГДЭЛ

З.МЭНДСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ж.ЧИНБҮРЭН

С.ЗАМИРА

000000128



Д.БУМ-ОЧИР

Т.МӨНХСАЙХАН

Ж.ЭНХБАЯР

Б.МӨНХСОЁЛ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Ц.МӨНХБАТ

М.САРНАЙ

М.МАНДХАЙ



Б. Мөнхсайф



Н. Батсүмбэрэл

Ц. Мөнхбат

М. Сарнай



М. Мандхай

00000128



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүрэнжавын ЛҮНДЭГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-03-85, Факс: 32-70-16
E-mail: lundeg@parliament.mn
http://www.parliament.mn

2025.06.20 № 442-03/7614
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу Хүнсний Бүтээгдэхүүний Аюулгүй Байдлыг Хангах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалтай холбоотой дараах хуулийн төсөл, холбогдох тайлан, судалгаануудыг хавсаргав. Үүнд:

1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл;
3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийн товч танилцуулга;
4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан;
5. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан;
6. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоолол;
7. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой дагалдах хуулийн төсөл.
8. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал
9. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хавсралт *212* хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЛҮНДЭГ

00000104

 БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  С.ЛҮНДЭГ

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Хүн бүр эрүүл амьдарч, хөдөлмөрлөх үндсэн нөхцөлийн нэг бол хоол хүнс бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаат хоол хүнсээр хангагдах нь хүний үндсэн эрх юм.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-ын 3.4.2.1.-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, ...” гэж, 3.4.2.4.-д “Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна” гэж, 3.4.2.5.-д “Хүнсний түүхий эд үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно” гэж, 3.4.2.6.-д “...малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг дээшлүүлж, халдвар хамгаалал био-аюулгүй байдлыг хангах..., байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ” гэж, 3.4.2.7.-д “Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, ...” гэж, 3.4.2.8.-д “..., импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын урьдчилсан хяналт, бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоо бий болгох, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангана” гэж, 3.4.2.9.-д “Нано-технологи, биотехнологийн эрсдэлийг үнэлэх, хянах, түүний хор хөнөөлөөс хамгаалах арга хэмжээ авна” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах стратегийг тодорхойлсон байдаг.

Мөн Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.1.-д “..., иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан хэрэгжүүлнэ” гэж, 3.4.1.3.-д “Хүн амын дунд хоол тэжээлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэн бичил тэжээлийн дутлыг бууруулна” гэж тус тус заасны дагуу холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлснээр Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх болно.

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-д “..., баталгаат хүнсээр хангана” гэж заасан ба 2021-2030 онд хүрэх үр дүнг “4.хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ” гэж, 2031-2040 онд хүрэх үр дүнг “3.баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон ... эрүүл хүнсний хэрэглээтэй болно.” гэж тус тус тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.4.-д “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хэсэгт “... мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, ... хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах ... хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх” арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгажээ.

Дээр дурдсан хууль тогтоомжид заасан зорилго, зорилтын хүрээнд баталгаат хүнсээр хэрэглэгчийг хангахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Мөн Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд туссан “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны нэршил нь хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж байгаа төдийгүй эрдэмтэн судлаачдын дунд маргаан үүсгэсэн. Иймд хуулийн нэр томъёог ойлгомжтой болгох, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн хэлэлцэн баталсан “Хүнсний нэр томъёоны толь”²-ийг баримтлан “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоноос ялгаж, нэршлийг нь “хүнсний баталгаат байдал” гэж өөрчилж, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулсан. Үүнтэй холбоотойгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж, холбогдох зүйл, заалтад байгаа “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг өөрчлөх шаардлага гарсан.

1.2.Практик шаардлага

УИХ-аас 2012 онд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг батлан хэрэгжүүлж байгаа ч хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний

² Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны 02 тоот тогтоолоор баталсан.

түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт үр дүнтэй хэрэгжээгүй байна. Энэ нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо оновчгүй болж, мэргэжлийн удирдлага болон хяналт шалгалтын бодлого алдагдсан, хүнсний сорилт, шинжилгээний лаборатори чадавхгүй болсон, стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулах зарим харилцааг аргачлал, зөвлөмжөөр зохицуулах гэж оролдсон, хэрэглэгчийн шошготой танилцаж, эрүүл хүнсээ сонгон авах чадвар сул, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрт хамаарах үйл ажиллагаанд тохирох зохистой дадлыг нэвтрүүлээгүйтэй холбоотой³ болох нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр тогтоогдсон болно.

Иймд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлт хийхээр тусгасан болно.

1/Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний баталгаат байдал” болгон өөрчилсөнтэй уялдуулан хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчилж, холбогдох зүйл, заалтад байгаа үг хэллэг, бичвэрийг өөрчлөх.

2/ДЭМБ-ын 2024 оны статистикийн урьдчилсан тойм мэдээллээр Монгол Улс элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд 1 дүгээрт эрэмбэлэгдэж байгаа нь хоол, хүнсээр дамжих халдварт болон халдварт бус өвчлөлийн гаралт, давтамж нэмэгдэж, Монгол Улсын хүнсний баталгаа алдагдаж байгаагийн илрэл юм. Мөн Үндэсний статистикийн хорооноос жил бүр эрхлэн гаргадаг “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд”⁴ тайланд дурдсанаар 2023 оны байдлаар нийт халдварт өвчний 18.8 хувь гэдэсний халдварт өвчин эзэлж байна. Энэ нь хүнсний баталгаат байдалд тавих хяналтын бодлого алдагдсан, хөдөө аж ахуйн болон хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн хариуцлага сул, хүнсний сүлжээний бүх үе шатны үйл ажиллагаа бүрэн зохицуулагдаагүй⁵, хэрэглэгчийн хүнсээ сонгон хэрэглэх боловсрол, мэдлэг дутмаг байдалтай холбоотой байна.

Иймд хүнсний сүлжээний үе шатны зохицуулагдаагүй харилцааг нарийвчлан тусгах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүр өөрт хамаарах үйл ажиллагааны үе шат бүрд зохистой дадлыг мөрдөхийг үүрэг болгоно.

3/Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2022 оны 12 сард татан буугдаж⁶, салбарын хяналт холбогдох төрийн захиргааны төв байгууллагад, хүнсний лабораториудыг Стандарт, хэмжил зүйн газрын харьяанд шилжүүлсэн⁷. Энэхүү бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн улмаас

³ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ.2025 он

⁴ хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын 13 үзүүлэлтийн тоон мэдээллийг эрхлэн гаргадаг.

⁵ Хүнсний сүлжээ дэх тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл-үйлчилгээ бүрэн зохицуулагдаагүй

⁶ “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 417 тогтоол

⁷ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори ажиллуулж, итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лаборатори Нийслэлийн төв

хүнсний хяналтын бодлого, хяналтын үйл ажиллагаа доголдож, салбарын хяналтын нэгж, орон нутгийн хяналтын байгууллага болон лаборатори хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдсан, лабораторийн шинжилгээний дээжийн тоо⁸, давтамж буурсан, шинжилгээний төлбөрийн асуудал маргаан дагуулах болсон⁹.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хүнсний хяналтыг хэрэгжүүлэх төрийн байгууллага, хүнсний хяналтын ерөнхий байцаагчид тавигдах шаардлага, эрсдэлд суурилсан, шинжлэх ухаанд үндэслэсэн хүнсний хяналтын бодлого, чиглэл, Үндэсний лавлагаа лабораторийн харьяалал, хүнсний сорилт, шинжилгээний лабораторитой байгуулах урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ, лабораторийн санхүүжилтийн асуудлыг тодорхой тусгана.

4/Малын халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүх төрлийн арга хэмжээнд хангалттай хэмжээний төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг боловч малын гоц халдварт өвчний гаралт, тархалт нь буурахгүй, улмаар махны экспортод сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаа байдлыг хангахад чиглэгдсэн “хүнсний зориулалтаар бэлтгэх мал, амьтан, таримал ургамал эрүүл байх” гэсэн зарчим практикт хэрэгжээгүйн¹⁰ нэг илрэл юм.

Иймд хүнсний нэмэлт, пестицидийн үлдэгдэл, антибиотикийн үлдэгдэлтэй холбоотой хязгаарлалт, тухайлбал ургамлын болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн, ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдвол тариалан үйлдвэрлэл эрхлэгч, малчин, мал эмнэлгийн гэрчилгээ олгосон малын эмч, эрүүл бус мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдээр хүнс үйлдвэрлэсэн үйлдвэрлэгч, малын эмчийн тодорхойлолт, лабораторийн шинжилгээг шалган аваагүй худалдагч, түгээгч, хүргэгч нарт хариуцлага хүлээлгэхээр тусгана.

5/Эрүүл хооллолтыг дэмжих, эрүүл бус хооллолтыг хязгаарлах хориглох замаар хэрэглэгчийн хоол, хүнсээ зөв сонгох хэрэглэх, эрүүл мэндээ хамгаалах соёлыг төлөвшүүлэх зорилгоор нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хоолны цэсийн шошго, зар сурталчилгаа, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, тухайлбал, нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэгт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдүүлэхээр заана.

Мөн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлах, хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжихээр тусгана.

лаборатори болон аймаг орон нутгийн хүнсний лабораториудыг лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахаар болсон.

⁸ 2020-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр 3590 түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч, шинжлүүлсэний 54 буюу 1.5 хувь, урьдчилан сэргийлэх шалгалтаар авсан 2054 дээжний 45 буюу 2.1 хувь нь эерэг гарсан байна. Эдгээр үзүүлэлтээс харахад салбарын хяналтын хяналт шалгалтын тоо, хяналт шалгалтад хамрагдаж буй объектын тоо бага байна.

⁹ Стандарт хэмжил зүйн газар, салбарын яам, орон нутгийн хяналтын байгууллага шинжилгээний зардлыг хариуцах асуудлаар маргаан үүсдэг.

¹⁰ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар хийсэн үнэлгээ 2025 он

Хэвлэл мэдээлэл байгууллагуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүнсний бүтээгдэхүүнийг дэмжин сурталчлахгүй байх, энэ талаар сэрэмжлүүлэг, анхааруулга өгч байхыг үүрэг болгоно.

6/Олон улсад хүнсний үйлдвэрлэлд өнгө оруулах буюу өнгийг сэргээж тодотгох, байгалийн өнгийг нь далдлах¹¹, бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, төрөл бүрийн нян, бактери мөөгөнцрөөс хамгаалах¹², бүтээгдэхүүнийг исэлдэх, гашлахаас хамгаалах¹³, бүтээгдэхүүний хэлбэрийг хадгалах¹⁴, хөөс буулгах, бүтээгдэхүүний амт, үнэрийг сайжруулах, зорилгоор 2000 гаруй хүнсний нэмэлт бодисыг ашигладаг. Гэвч хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэсэн, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэсэн, зориудын бусаар хэрэглэсэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө /харшил үүсгэх, хавдрыг өдөөх/ үзүүлэх төдийгүй хүний хүний амь насанд ч аюул учруулж болзошгүй юм.

Мөн ойн дагалт баялаг буюу байгалийн жимс, самар, мөөг түүж, түүнийг зах зээлд худалдан борлуулахдаа дур мэдэн хүнсний нэмэлт хольж хэрэглэж байгааг таслан зогсоох шаардлагатай байна.

Иймд хуульд заасны дагуу бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэн хүнс үйлдвэрлэх, эсхүл хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хүнсэнд хэрэглэх, зориулалтын бусаар хэрэглэхийг хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заана.

7/Хуулиар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад захиргааны хэм хэмжээ тогтоох эрх олгосон боловч хэм хэмжээ тогтоосон актыг шуурхай баталдаггүй¹⁵, баталсан ч үзэмжээрээ хүчингүй болгодог¹⁶, эсхүл зохицуулах харилцааг дутуу орхигдуулдаг¹⁷ нь захиргааны хэм хэмжээний ач холбогдлыг бууруулж, хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Иймд хүн амыг эрүүл, чанартай, баталгаатай хоол, хүнсээр хангахын тулд шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулагддаг стандартын шаардлагыг захиргааны хэм хэмжээгээр бууруулах, давхардуулан журамлаж байгааг өөрчилж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрт хамаарах үе шатанд тохирох зохистой дадлын стандартыг мөрдүүлэхээр тусгана.

1.3.Хуулийн төслийн, зохицуулах харилцаа

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд 3 зүйл, 14 хэсэг, 6 заалт нэмсэн, 1 хэсэг, 3 заалтад үг нэмсэн, 8 хэсэг, 3 заалтыг өөрчлөн найруулсан, 20 хэсэг, 20 заалтын үг хэллэгийг өөрчилсөн, 1 хэсэг, 1 заалтаас үг хассан, 3 хэсгийг

¹¹ будагч бодисууд

¹² консервантууд

¹³ антиоксидантууд

¹⁴ Тогтворжуулагч, өтгөрүүлэгч бодисууд /E400-499/

¹⁵ хууль хэрэгжиж эхэлснээс хойш 3 жилийн дараа буюу 2014 онд зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийг, 12 жилийн дараа буюу 2024 онд зохистой дадалыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг баталсан

¹⁶ "Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам" ҮХАА-н Сайдын 2013 оны 08 сарын 06-ны өдрийн А/98 дугаар тушаалаар баталж, 2016 оны А/37 дугаар тушаалаар хүчингүй болгосон.

¹⁷ ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/196 дугаар тушаалаар "Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам" баталсан, харин мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг зохицуулалтгүй үлдээжээ.

заалтыг хүчингүй болсонд тооцож, хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсрууллаа. Энэхүү өөрчлөлт нь хуулийн нийт заалтын 50 хувьд хүрэхгүй бөгөөд хуулийн бүтэц, уялдааг алдагдуулахгүй.¹⁸

Иймд хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хүнсний баталгаат байдал” гэсэн нэр томъёог нэмж тусгасантай уялдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр боловсруулж, хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчлөхөөр энэхүү үзэл баримтлалд тусгалаа.

Хуулийн төслөөр дараах харилцааг зохицуулахаар тусгана.

- хуулийн холбогдох зүйл, заалтад байгаа “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг “хүнсний баталгаат байдал” гэж өөрчлөх, хууль хоорондын давхардлыг арилгах үүднээс зарим нэр томъёог эшлэл татах;

- хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоог тодорхой болгох, хүнсний хяналтын бодлого, мэргэжлийн удирдлагаар хангах, хүнсний хяналтын улсын ерөнхий байцаагчид тавигдах шаардлага;

- хүнсний хяналт зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг;

- стандарт, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Үндэсний лавлагаа лабораторийг хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллуулах, эрсдэлийн үнэлгээний баг"-ийн нэршлийг “эрсдэлийн үнэлгээний төв” гэж өөрчлөх;

- тухайн шинжилгээний нэг, эсхүл хэд хэдэн үзүүлэлтээр олон улсын стандартын хүрээнд итгэмжлэгдсэн тохиолдолд төрийн, орон нутгийн болон хувийн хэвшлийн хүнсний сорилын лабораторитой урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллуулах;

- эрсдэлийн үнэлгээ, тандалт хийхэд авах дээж, лабораторид зайлшгүй шаардлагатай зардлын санхүүжилт, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тохирох хөдөө аж ахуйн, үйлдвэрлэлийн, эрүүл ахуйн, тээвэрлэлтийн, хүнсний худалдааны, хадгалалтын, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийтийн бусад орчинд үйлчилгээний зохистой дадлын стандарт, техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, хүлээх хариуцлага;

- импортын хүнсний түүхий, эд бүтээгдэхүүний шошгонд дотоодын хүнсний түүхий, эд бүтээгдэхүүний шошгонд тавигдах шаардлага нэгэн адил хамаарах, гадаад хэл дээрх шошгын мэдээлэл монгол хэл дээр орчуулсан шошгын мэдээлэл үнэн зөв байх, хяналт, эрүүл бус хүнсний зар сурталчилгааны хязгаарлалт;

- ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотикийн үлдэгдэл

¹⁸ Хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор 40 хэсэг, заалтын үг хэллэгийг жигдрүүлж, редакцийн шинжтэй өөрчлөлт хийсэн болно.

зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх, газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх, ойн дагалт баялаг¹⁹-т дур мэдэн хүнсний нэмэлт хэрэглэхийг хориглох, сорилын лабораторийн шинжилгээний дүнгээр хүнсний нэмэлт, пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн, ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэсэн нь тогтоогдсон бол малчин, малын эмч, тариаланч, хүнс үйлдвэрлэгч, ойн дагалт баялаг түүсэн, худалдаалсан этгээдэд хариуцлага хүлээлгэх;

- нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд²⁰-ын хоолны цэс, түүнд байршуулах хоолны агууламж, илчлэгийн мэдээлэл;

- лабораторийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах эрсдэлийн тандалтын шинжилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, дээж авах, урвалж бодис зэрэг зардлыг төрийн болон орон нутгийн лаборатори жил бүр төсөвтөө тусгах;

- хүнсэнд бүтцийн шинжилгээг хийх, хоол, хүнсээр дамжих нянгийн тэсвэржилт, харшил үүсгэгч, хуурамч хүнсийг тогтоох, бүх төрлийн хүнсний нэмэлт, биологи, химийн бохирдлыг бүрэн шинжлэх;

- зах зээл дээр худалдаалагдаж байгаа дотоодын үйлдвэрийн, импортын болон экспортын хүнс нь холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангаж байгаад хяналт тавих;

- стандартын шаардлагыг захиргааны хэм хэмжээгээр бууруулж байгаа, зөвлөмж, аргачлал батлахтай холбоотой заалтуудыг хасах, үүнтэй холбогдуулан зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулахаар заах;

- хүнсний асуудал эрхэлсэн Засгийн гишүүн стандартад тавигддаг шаардлага, хэм, хэмжээг тогтоож батлахаар заасныг холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөхөөр заах.

Хууль батлагдсаны дараа үүсэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хүнсний хяналтын бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, төлөвлөх, төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгээр хүнсний хяналтын бодлогыг засаж залруулж, эргэх холбоо хангаснаар хүний баталгаат байдал хангагдана.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон журмаар зохицуулах байсан хүнсний эрүүл ахуйн шаардлагуудыг хүнсний сүлжээний үе шат бүрд хамаарах зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулснаар хүнсний чанар, эрүүл ахуйн шаардлага хангагдах нөхцөл бүрдэнэ.

¹⁹ байгалийн жимс, жимсгэнэ, самар, мөөг, цайны ургамал зэрэг

²⁰ нийтийн хоолоор үйлчилдэг газарт ресторан сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээний газар, асрамжийн газар, эмнэлэг, хүмүүжүүлэх газар, төрийн захиргааны байгууллагууд хамаарна.

Төрийн, орон нутгийн болон хувийн сорилын лабораториудын урт хугацааны хамтын ажиллагаа сайжирч, сорилын лабораторийн бүтээмж нэмэгдэж, шинжилгээний шинэ арга аргачлалыг нэвтэрч аюулгүйн үзүүлэлтийг улсын хэмжээнд бүрэн шинжлэх, ялангуяа хүнсэнд бүтцийн шинжилгээг хийх, хоол, хүнсээр дамжих нянгийн тэсвэржилт, харшил үүсгэгч, бүх төрлийн хүнсний нэмэлт, биологи, химийн бохирдлыг бүрэн шинжлэх шаардлагатай урвалж бодис, багаж хэрэгслээр хангагдах боломж бүрдэнэ.

Зах зээл дээр худалдаалагдаж байгаа дотоодын, импортын болон экспортын хүнсний хяналт тогтмолжиж, хүнсний баталгаат байдал сайжирч, хүн амын хүнснээс шалтгаалсан халдварт болон халдварт бус өвчлөл буурч, эрүүл мэндийн салбарын болон хувь хүний зардал багасна.

Хэрэглэгч нь эрүүл мэнддээ сөрөг нөлөө үзүүлэх орц, найрлагын агууламжтай бүтээгдэхүүн сонгон авахаас татгалзан өөрийн эрүүл мэндийг хамгаалж, хүнсний баталгаат байдлыг хангахад өөрийн хувь нэмрийг оруулна.

Хүнсний үйлдвэрлэлд хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориудын бусаар хэрэглэх, пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл агуулсан түүхий эд хэрэглэх зөрчил арилна.

Дээр дурдсан хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Хууль хооронд уялдаа холбоог хангах үүднээс дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Энэ хууль батлагдсантай холбогдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль хоорондын зөрчил давхардлыг арилгах, үг хэллэгийг жигдлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр, сортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Дээр дурдсан холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсрууллаа.

-oOo-

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-д ундны усны чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх, хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах, хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэх, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангах, хоол тэжээлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэн бичил тэжээлийн дутлыг бууруулахаар, “Алсын хараа-2050”² Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод баталгаат хүнсээр хангаж, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх, баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгох стратегийг тодорхойлсон байдаг.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.4.-д “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Дээр дурдсан хууль тогтоомжид заасан зорилго, зорилтын хүрээнд баталгаат хүнсээр хэрэглэгчийг хангахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Мөн Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд туссан “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны нэршил нь хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж байгаа төдийгүй эрдэмтэн судлаачдын дунд маргаан үүсгэсэн. Иймд хуулийн нэр томъёог ойлгомжтой болгох, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн хэлэлцэн баталсан “Хүнсний нэр томъёоны толь”³-ийг баримтлан “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоноос ялгаж, нэршлийг нь “хүнсний баталгаат байдал” гэж өөрчилж, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулсан. Үүнтэй холбоотойгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж, холбогдох зүйл,

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

³ Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны 02 тоот тогтоолоор баталсан.

заалтад байгаа “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг өөрчлөх шаардлага гарсан.

1.2.Практик шаардлага

УИХ-аас 2012 онд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг батлан хэрэгжүүлж байгаа ч хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт үр дүнтэй хэрэгжээгүй байна. Энэ нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй, бүтэц, зохион байгуулалтын оновчгүй тогтолцоо, хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний лабораторийн чадавх сул, зах зээл дэх дотоодын болон импортын хүнсэнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тандалт хийх зэрэг хяналтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлага алдагдсан, зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулах харилцааг захиргааны хэм хэмжээгээр зохицуулах гэж оролдсон, нөгөө талаас хэрэглэгчийн шошготой танилцаж, эрүүл хүнсээ сонгон авах чадвар сул, хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрт хамаарах үйл ажиллагаанд тохирох зохистой дадал болон хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлээгүйтэй холбоотой байна⁴.

Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд дараах зарчмын шинжтэй өөрчлөлт хийхээр хуулийн төсөлд тусгасан болно.

1/Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний судалгаанд⁵ “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний баталгаат байдал” болгон өөрчлөх нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх, хууль хэрэглээнд гарч байгаа хүндрэлийг арилгахад эерэг нөлөө үзүүлнэ гэж тусгажээ. Тус хуулийн үзэл баримтлалд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчилж, хуулийн холбогдох зүйл, үг хэллэгийг жигдлэх замаар хууль хоорондын уялдаа холбоог хангахыг тэмдэглэсэн.

Хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчилж, холбогдох зүйл, заалтад байгаа үг хэллэг, бичвэрийг өөрчлөх.

2/ ДЭМБ-ын 2024 оны статистикийн урьдчилсан тойм мэдээллээр Монгол Улс элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд 1 дүгээрт эрэмбэлэгдэж байгаа нь хоол, хүнсээр дамжих халдварт болон халдварт бус өвчлөлийн гаралт, давтамж нэмэгдэж, Монгол Улсын хүнсний баталгаа алдагдаж байгаагийн илрэл юм.

Мөн Үндэсний статистикийн хорооноос жил бүр “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд” тайланд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын 13 үзүүлэлтийн тоон мэдээллийг эрхлэн гаргадаг бөгөөд уг тайланд 2023 оны байдлаар нийт халдварт өвчний 18.8 хувь гэдэсний халдварт өвчин эзэлж байна. Энэ нь хүнсний баталгаат байдалд тавих хяналтын тогтолцоо оновчгүй болсон,

⁴ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2025 он

⁵ Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний судалгаа, 2025 он

хөдөө аж ахуйн болон хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн хариуцлага сул, хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагаа бүрэн зохицуулагдаагүй⁶, хэрэглэгчийн хүнсээ сонгон хэрэглэх боловсрол, мэдлэг дутмаг байдал нөлөөлж байна.

Иймд хүнсний сүлжээний үе шатны зохицуулагдаагүй харилцааг нарийвчлан тусгах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүр өөрт хамаарах үйл ажиллагааны үе шат бүрд зохистой дадлыг мөрдөхийг үүрэг болгоно.

З/Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2022 оны 12 сард татан буугдаж⁷, салбарын хяналт холбогдох төрийн захиргааны төв байгууллагад, хүнсний лабораториудыг Стандарт, хэмжил зүйн газрын харьяанд шилжүүлсэн⁸. Энэхүү бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн улмаас хүнсний хяналтын бодлого, хяналтын үйл ажиллагаа доголдож, салбарын хяналтын нэгж, орон нутгийн хяналтын байгууллага болон лаборатори хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдсан, лабораторийн шинжилгээний дээжийн тоо⁹, давтамж буурсан, шинжилгээний төлбөрийн асуудал маргаан дагуулах болсон¹⁰. Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг дараах байдлаар тусгана:

-шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний хяналтын бодлогыг боловсруулахад тандалт судалгааны дүнг ашиглах, хүнсний хяналтын бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, түүнд үндэслэн төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, хяналтын үр дүнгээр хүнсний хяналтын бодлогыг засаж залруулах, эргэх холбоог хангах;

-Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулан хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний дэргэд хүнсний баталгаат байдлын эрсдэлийг төлөвлөх, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий эрсдэлийн үнэлгээний хүрээлэн, хяналтын сорилын лаборатори ажиллуулах, тэдгээрийн чиг үүрэг, удирдлагад тавигдах шаардлагыг нарийвчлан тусгана.

-хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналтыг өргөжүүлэх, хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний лабораторийн чадавх, бүтээмжийг сайжруулах зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тодорхой нэг итгэмжлэлд хамрагдсан үзүүлэлтээр нь урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулах, шинжилгээнд хамрагдаж буй дээжийн мэдээллийн нууцлалыг хамгаалах үүднээс кодчилох хэлбэрт бүрэн шилжүүлэх, эрсдэлийн үнэлгээ, тандалт хийхэд дээж авах, лабораториудын санхүүжилт, хүний нөөцтэй холбогдсон харилцааг тусгана. Ингэснээр хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний

⁶ Хүнсний сүлжээ дэх тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл-үйлчилгээ бүрэн зохицуулагдаагүй

⁷ “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 417 тогтоол

⁸ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори ажиллуулж, итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лаборатори Нийслэлийн төв лаборатори болон аймаг орон нутгийн хүнсний лабораториудыг лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахаар болсон.

⁹ 2020-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр 3590 түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч, шинжлүүлсэний 54 буюу 1.5 хувь, урьдчилан сэргийлэх шалгалтаар авсан 2054 дээжний 45 буюу 2.1 хувь нь эерэг гарсан байна. Эдгээр үзүүлэлтээс харахад салбарын хяналтын хяналт шалгалтын тоо, хяналт шалгалтад хамрагдаж буй объектын тоо бага байна.

¹⁰ Стандарт хэмжил зүйн газар, салбарын яам, орон нутгийн хяналтын байгууллага шинжилгээний зардлыг хариуцах асуудлаар маргаан үүсдэг.

лабораторийн чадавхыг эрс нэмэгдүүлж, аюулгүйн үзүүлэлтийг улсын хэмжээнд бүрэн шинжилдэг болох, ялангуяа хүнсэнд бүтцийн шинжилгээг хийх, хоол, хүнсээр дамжих нянгийн тэсвэржилт, харшил үүсгэгч, хуурамч хүнсийг тогтоох, бүх төрлийн хүнсний нэмэлт, биологи, химийн бохирдлыг бүрэн шинжлэх, шинжилгээнд шаардлагатай урвалж бодис, багаж хэрэгслээр хангах зардлыг төсвөөс санхүүжүүлж, зарцуулалтад хяналт тавих боломж бүрдэнэ.

4/Малын халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүх төрлийн арга хэмжээнд хангалттай хэмжээний төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг боловч малын гоц халдварт өвчний гаралт, тархалт нь буурахгүй, улмаар махны экспортод сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаа байдлыг хангахад чиглэгдсэн “хүнсний зориулалтаар бэлтгэх мал, амьтан, таримал ургамал эрүүл байх” гэсэн зарчим практикт хэрэгжээгүйн¹¹ нэг илрэл юм. Үүнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаандаа зохистой дадлыг хэрэгжүүлээгүй, хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг батлаагүй, хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохистой дадлыг нэвтрүүлэх талаар сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг хийдэггүй нь нөлөөлөх хүчин зүйл болсон.

Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнсийг хэрэглэх, газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх нь хүний эрүүл мэндэд төдийгүй амь насанд аюул учруулахаар байна. Иймд тэдгээртэй холбоотой хориглох хэмжээг тогтоож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

Тухайлбал, ургамлын болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн, ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдвол тариалан үйлдвэрлэл эрхлэгч, малчин, мал эмнэлгийн гэрчилгээ олгосон малын эмч, эрүүл бус мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдээр хүнс үйлдвэрлэсэн, түүнийг худалдаалсан, түгээсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгана.

5/“Хүн бүр зохистой хүнсээ сонгон хэрэглэх эрх”-ийг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, эрүүл хооллолтыг дэмжих, эрүүл бус хооллолтыг хязгаарлах хориглох замаар хэрэглэгчийн хоол, хүнсээ зөв сонгох хэрэглэх, эрүүл мэндээ хамгаалах соёлыг төлөвшүүлэх зорилгоор дараах хэм хэмжээг тусгана:

-нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хоолны цэсийн шошго, хоолны илчлэгийн хэмжээг хянах, зар сурталчилгаатай холбоотой зохицуулалтыг төсөлд тусгана. Тухайлбал, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд¹²-ын хоолны цэсийн агууламжийн бодлогыг нэвтрүүлж, эрүүл хоолыг санал болгох цэсэд илчлэг, нийт сахар, уураг, ханасан өөх тос, натрийн агууламж, хоолны хэмжээг ил тод байрлуулж байх, нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн

¹¹ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар хийсэн үнэлгээ, 2025 он

¹² Нийтийн хоолоор үйлчилдэг газарт ресторан сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээний газар, асрамжийн газар, эмнэлэг, хүмүүжүүлэх газар, төрийн захиргааны байгууллагууд хамаарна.

зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэгүүдийн зардаг цэгүүдэд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдүүлэхээр заана. Тухайлбал,

-давс ихтэй хүнсний бүтээгдэхүүн, чипс, чихэрлэг, хийжүүлсэн болон согтууруулах ундаа зэрэг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлах, харин жимс, хүнсний ногоо зэрэг хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүний үйлдвэрлэх асуудлыг зээлийн бодлогоор дэмжихээр тусгана.

-хэвлэл мэдээлэл байгууллагуудад сахар, ханасан өөх тос, натрийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн, эсвэл нэмэлт транс тос агууламжтай, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүнсний бүтээгдэхүүнийг дэмжин сурталчлахгүй байх, мөн энэ талаар сэрэмжлүүлэг, анхааруулга өгч байхыг үүрэг болгоно.

6/Хүнсний үйлдвэрлэлд бүтээгдэхүүнийг өнгө оруулах буюу өнгийг сэргээж тодотгох, байгалийн өнгийг нь далдлах¹³, бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, төрөл бүрийн нян, бактери мөөгөнцрөөс хамгаалах¹⁴, бүтээгдэхүүнийг исэлдэх, гашлахаас хамгаалах¹⁵, **бүтээгдэхүүний хэлбэрийг хадгалах¹⁶, хөөс буулгах**, бүтээгдэхүүний амт, үнэрийг сайжруулах, **зорилгоор 2000 гаруй хүнсний нэмэлт бодисыг ашигладаг. Гэвч хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэсэн, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэсэн, зориудын бусаар хэрэглэсэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө / харшил үүсгэх, хавдрыг өдөөх/ үзүүлэх төдийгүй хүний хүний амь насанд ч аюул учруулж болзошгүй юм.**

Иймд хуульд заасны дагуу бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгөөр хүнс үйлдвэрлэх, хүнсний үйлдвэрлэлд нэмэлтийг хэтрүүлэн хэрэглэх, зориулалтын бусаар хэрэглэхийг хориглохоор тусгана.

Түүнчлэн байгалийн жимс, самар, мөөг түүж, түүнийг зах зээлд худалдан борлуулдаг иргэн, хуулийн этгээд тухайн жимс, мөөг, самрын өнгө зүс, амт чанарыг алдагдуулахгүйгээр урт хугацаанд хадгалах зорилгоор **хүнсний нэмэлт болох** тогтворжуулагч, будагч, амт оруулагч бодисыг ямар ч мэргэжлийн хүн, байгууллагын зөвлөгөө, тусламжгүйгээр, хяналтгүйгээр хольж хэрэглэж байгааг таслан зогсоож, тэдгээрт хяналт тавих, ургамал хамгааллын бодис, хүнсний нэмэлт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн нь лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдсон бол түүсэн, худалдаалсан иргэн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заана.

6/Хуулиар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад захиргааны хэм хэмжээ тогтоох эрх олгосон боловч хэм хэмжээ тогтоосон актыг шуурхай баталдаггүй, баталсан ч үзэмжээрээ хүчингүй болгох¹⁷, зохицуулах

¹³ будагч бодисууд

¹⁴ консервантууд

¹⁵ антиоксидантууд

¹⁶ Тогтворжуулагч, өтгөрүүлэгч бодисууд /E400-499/

¹⁷ "Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам" ҮХАА-н Сайдын 2013 оны 08 сарын 06-ны өдрийн А/98 дугаар тушаалаар баталж, 2016 оны А/37 дугаар тушаалаар хүчингүй болгосон.

харилцааг дутуу орхигдуулж¹⁸ байгаа, зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийг хууль хэрэгжиж эхэлснээс хойш 3 жилийн дараа буюу 2014 онд, зохистой дадал¹⁹-ыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг 12 жилийн дараа буюу 2024 онд баталсан зэрэг нь захиргааны хэм хэмжээний ач холбогдлыг бууруулж, хүнсний баталгаат байдлыг алдагдуулахад хүргэж байна. Зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмжийг боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлд суурилан мэргэжлийн түвшинд, туршлага чадавх шаардагдана.

Иймд хүн амыг эрүүл, чанартай, баталгаатай хоол, хүнсээр хангахын тулд захиргааны шинжтэй журам, заавраар шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулагддаг стандартын шаардлагыг бууруулах, түүнийг хэрэгжүүлэх аргачлал зөвлөмж баталж байгааг өөрчилж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрт хамаарах үе шатанд тохирох зохистой дадлын стандартыг мөрдүүлэхээр тусгана.

1.3.Хуулийн төслийн, зохицуулах харилцаа

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд 3 зүйл, 14 хэсэг, 6 заалт нэмсэн, 1 хэсэг, 3 заалтад үг нэмсэн, 8 хэсэг, 3 заалтыг өөрчлөн найруулсан, 20 хэсэг, 20 заалтын үг хэллэгийг өөрчилсөн, 1 хэсэг, 1 заалтаас үг хассан, 3 хэсгийг заалтыг хүчингүй болсонд тооцож, хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсрууллаа. Энэхүү өөрчлөлт нь хуулийн нийт заалтын 50 хувьд хүрэхгүй бөгөөд хуулийн бүтэц, уялдааг алдагдуулахгүй²⁰ болно.

Иймд хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хүнсний баталгаат байдал” гэсэн нэр томъёог нэмж тусгасантай холбоотой Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр боловсруулж, хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчлөхөөр энэхүү үзэл баримтлалд тусгалаа.

Хуулийн төслөөр дараах харилцааг зохицуулахаар тусгана.

- хуулийн холбогдох зүйл, заалтад байгаа “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг “хүнсний баталгаат байдал” гэж өөрчлөх, хууль хоорондын давхардлыг арилгах үүднээс зарим нэр томъёог эшлэл татах;

-хүнсний баталгаат байдлын тогтолцоо, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний дэргэд ажиллах

¹⁸ ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/196 дугаар тушаалаар “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам” баталсан, харин мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг зохицуулалтгүй үлдээжээ.

¹⁹ Зохистой дадал гэдэг бол хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавигдах эрүүл ахуй, ариун цэврийн хамгийн доод түвшний шаардлага буюу үйл ажиллагаа эрхлэхийн өмнөх урьтал нөхцөл юм.

²⁰ Хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор 40 хэсэг, заалтын үг хэллэгийг жигдрүүлж, редакцийн шинжтэй өөрчлөлт хийсэн болно.

эрсдэлийн үнэлгээний төв, Үндэсний лавлагаа лаборатори, тэдгээрийн чиг үүргийг ялгамжтайгаар тусгах, хүнсний хяналтын ерөнхий байцаагчид тавигдах шаардлага;

-хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаандаа хөдөө аж ахуйн, үйлдвэрлэлийн, эрүүл ахуйн, тээвэрлэлтийн, хүнсний худалдааны, хадгалалтын, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүд зохистой дадлын стандартыг хэрэгжүүлэх;

-нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд²¹-ын хоолны цэсийн агууламжийн бодлого, хоолны илчлэгт тавих хяналт, нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүдэд мөрдөх зохистой дадлын стандарт, нийтийн хоол үйлдвэрлэлийн хүний нөөцөд тавигдах шаардлага;

-хүнсний баталгаат байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хуурамч хүнсэнд тавих хяналт, зар сурталчилгааны хязгаарлалт;

-ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх, газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэхийг хориглох, хэрвээ лабораторийн шинжилгээний дүнгээр пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн, ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэсэн нь тогтоогдсон бол малчин, тариаланч, үйлдвэрлэгч болон холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх;

-байгалийн жимс, жимсгэнэ, самар, мөөг, цайны ургамал зэрэгт ургамал хамгааллын бодис, хүнсний нэмэлт хэрэглэсэн нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн нь лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдсон бол түүсэн, худалдаалсан иргэн, хуулийн этгээд хариуцлага хүлээлгэх;

-хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, худалдааны явцад стандарт, техникийн зохицуулалт зөрчсөн, технологийн горим алдагдсан тогтоогдвол тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцлага хүлээлгэх;

-лабораторийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах эрсдэлийн тандалтын шинжилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, дээж авах, урвалж бодис зэрэг зардлыг төрийн болон орон нутгийн лаборатори жил бүр төсөвтөө тусгах;

-Зах зээл дээр худалдаалагдаж байгаа дотоодод үйлдвэрлэсэн, импортын болон экспортын хүнс нь холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг тодорхой зааж тусгах;

Хуульд туссан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд тавигдах эрүүл ахуйн шаардлага, хүнсний аюулгүйн үзүүлэлт, хүнс дэх пестицид болон малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хүнсний шошгын мэдээлэл болон бусад журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн гишүүн тогтоож батлахаар

²¹ нийтийн хоолоор үйлчилдэг газарт ресторан сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээний газар, асрамжийн газар, эмнэлэг, хүмүүжүүлэх газар, төрийн захиргааны байгууллагууд хамаарна.

заасныг холбогдох хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөхөөр заах.

Хууль батлагдсаны дараа үүсэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хүнсний хяналтын бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, төлөвлөх, төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгээр хүнсний хяналтын бодлогыг засаж залруулж, эргэх холбоо хангаснаар хүний баталгаат байдал хангагдана.

Төрийн, орон нутгийн болон хувийн сорилын лабораториудын урт хугацааны хамтын ажиллагаа сайжирч, сорилын лабораторийн бүтээмж нэмэгдэж, шинжилгээний шинэ арга аргачлалыг нэвтэрч аюулгүйн үзүүлэлтийг улсын хэмжээнд бүрэн шинжлэх, ялангуяа хүнсэнд бүтцийн шинжилгээг хийх, хоол, хүнсээр дамжих нянгийн тэсвэржилт, харшил үүсгэгч, бүх төрлийн хүнсний нэмэлт, биологи, химийн бохирдлыг бүрэн шинжлэх шаардлагатай урвалж бодис, багаж хэрэгслээр хангагдах боломж бүрдэнэ.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон журмаар зохицуулах байсан хүнсний эрүүл ахуйн шаардлагуудыг хүнсний сүлжээний үе шат бүрд хамаарах зохистой дадлын стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулснаар хүнсний чанар, эрүүл ахуйн шаардлага хангагдах нөхцөл бүрдэнэ.

Зах зээл дээр худалдаалагдаж байгаа дотоодын, импортын болон экспортын хүнсний хяналт тогтмолжиж, хүнсний баталгаат байдал сайжирч, хүн амын хүнснээс шалтгаалсан халдварт болон халдварт бус өвчлөл буурч, эрүүл мэндийн салбарын болон хувь хүний зардал багасна.

Хэрэглэгч нь эрүүл мэнддээ сөрөг нөлөө үзүүлэх орц, найрлагын агууламжтай бүтээгдэхүүн сонгон авахаас татгалзан өөрийн эрүүл мэндийг хамгаалж, хүнсний баталгаат байдлыг хангахад өөрийн хувь нэмрийг оруулна.

Хүнсний үйлдвэрлэлд хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориудын бусаар хэрэглэх, пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл агуулсан түүхий эд хэрэглэх зөрчил арилна.

Дээр дурдсан хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Хууль хооронд уялдаа холбоог хангах үүднээс дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Энэ хууль батлагдсантай холбогдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль хоорондын зөрчил давхардлыг арилгах, үг хэллэгийг жигдлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр, сортын тухай хууль /Шинэчилсэн

найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

-oOo-

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹, Мөн Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”²-д хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах, эрсдэлийн үнэлгээ хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангахтай холбогдсон стратегийг тодорхойлжээ. Мөн Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.4.-д “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Дээр дурдсан хууль тогтоомжид заасан зорилго, зорилтын хүрээнд баталгаат хүнсээр хэрэглэгчийг хангахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэр томъёог ойлгомжтой болгох, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн хэлэлцэн баталсан “Хүнсний нэр томъёоны толь”³-ийг баримтлан “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний баталгаат байдал” гэж өөрчилж тусгасантай холбоотойгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж, холбогдох зүйл, заалтад байгаа “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг өөрчлөх шаардлага гарсан.

Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, дараах харилцааг зохицуулахаар тусгав. Үүнд:

1/Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний баталгаат байдал” болгон өөрчилсөнтэй уялдуулан хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчилж, холбогдох зүйл, заалтад өөрчлөлт оруулах.

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

³ Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны 02 тоот тогтоолоор баталсан.

2/Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор баталгаат байдалд хяналт тавих тогтолцоог оновчтой болгох, мэргэжлийн удирдлагаар хангах, хүнсний хяналтын бодлого болон хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоотой холбогдсон зохицуулалтыг нэмж тусгана. Хүнсний хяналт зохицуулалтын байгууллага болон лабораториудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, чадавхыг дээшлүүлэх зорилгоор Үндэсний лавлагаа лабораторийн харьяаллыг өөрчлөх, төрийн, орон нутгийн болон хувийн хэвшлийн хүнсний сорилын лабораторитой урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах, лабораторийн санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгана.

3/Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг өндөржүүлэх, хүнсний сүлжээний бүх үе шатны үйл ажиллагаа бүрэн зохицуулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүр өөрт хамаарах үйл ажиллагааны үе шат бүрд зохистой дадлыг мөрдөхөөр тусгана. Үйлдвэрлэл эрхлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориулалтын бусаар хэрэглэх, ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэхийг хориглож, зөрчсөн нь лабораторийн шинжилгээгээр тогтоогдвол холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заана

4/Эрүүл хооллолтыг дэмжих, эрүүл бус хооллолтыг хязгаарлах хориглох замаар хэрэглэгчийн хоол, хүнсээ зөв сонгох хэрэглэх, эрүүл мэндээ хамгаалах соёлыг төлөвшүүлэх зорилгоор нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хоолны цэсийн шошго, зар сурталчилгаа, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, тухайлбал, нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэгт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдүүлэхээр заана.

Мөн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлах, хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжихээр тусгана. Мөн хэвлэл мэдээлэл байгууллагуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүнсний бүтээгдэхүүнийг дэмжин сурталчлахгүй байх, энэ талаар сэрэмжлүүлэг, анхааруулга өгч байхыг үүрэг болгоно.

5/Стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулах боломжтой харилцааг журам, аргачлал, зөвлөмжөөр зохицуулахаар заасныг өөрчилж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрт хамаарах үе шатанд тохирох зохистой дадлын стандартыг мөрдүүлэхээр тусгана.

Хууль хэрэгжсэнээр хүнсний хяналтын бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, төлөвлөх, төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгээр хүнсний хяналтын бодлогыг засаж залруулж, эргэх холбоо хангагдана. Ингэснээр хүний баталгаат байдал хангагдаж, хэрэглэгч эрүүл хүнс сонгох хэрэглэх боломж нэмэгдэнэ.

Зах зээл дээр худалдаалагдаж байгаа дотоодын, импортын болон экспортын хүнсний хяналт тогтмолжиж, хүнсний баталгаат байдал сайжирч, хүн амын хүнснээс

шалтгаалсан халдварт болон халдварт бус өвчлөл буурч, эрүүл мэндийн салбарын болон хувь хүний зардал багасна.

Хэрэглэгч нь эрүүл мэнддээ сөрөг нөлөө үзүүлэх орц, найрлагын агууламжтай бүтээгдэхүүн сонгон авахаас татгалзан өөрийн эрүүл мэндийг хамгаалж, хүнсний баталгаат байдлыг хангахад өөрийн хувь нэмрийг оруулна.

Хүнсний үйлдвэрлэлд хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориудын бусаар хэрэглэх, пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл агуулсан түүхий эд хэрэглэх зөрчил арилна.

Дээр дурдсан холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Хууль хооронд уялдаа холбоог хангах үүднээс дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Энэ хууль батлагдсантай холбогдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль хоорондын зөрчил давхардлыг арилгах, үг хэллэгийг жигдлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр, сортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Дээр дурдсан холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хүнсний тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

-oOo-

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 7 дугаар зүйлийн 7.1.4-7.1.8 дахь заалт:

“7.1.4.хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой дадал;

7.1.5.хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалтын зохистой дадал;

7.1.6. хүнсний сүлжээний нэг үе шатаас нөгөө үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээх, хүргэх шатанд тээвэрлэлтийн зохистой дадал;

7.1.7. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтын шатанд худалдаа үйлчилгээний зохистой дадал;

7.1.8.мал эмнэлгийн үйлчилгээний зохистой дадал;

7.1.9.мал, амьтныг эрүүл өсгөх, тэжээх үе шатанд холбогдох зохистой дадал.

2/ 7 дугаар зүйлийн 7.5-7.9 дахь заалт:

“7.5.Энэ хуулийн 7.1.4-д заасан зохистой дадалд хоол үйлдвэрлэл, нийтийн орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүдэд зориулсан стандарт, хоолны орц, давтан хэрэглээ, кросс бохирдлоос сэргийлэх, үйлчлүүлэгчид хүрэх хүртэлх баталгаат байдлыг хангах үйл ажиллагаа хамаарна.

7.6.Энэ хуулийн 7.1.5-д заасан зохистой дадалд хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнс хадгалах, агуулах, зоорь, хөргүүрийн зохистой ашиглалт, температур, чийгшил, хугацаа, ялгах хураах, QR код, хөлдөөлт, гэсгээх үйл ажиллагаа хамаарна.

7.7.Энэ хуулийн 7.1.6-д заасан зохистой дадалд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээх үеийн хяналт, хөргүүртэй машин, тээврийн бичиг баримт, хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь тусгаарлах, температур, чийг, бохирдолд тогтмол хяналт хийх, тээврийн эрсдлийг бүртгэх үйл ажиллагаа хамаарна.

7.8.Энэ хуулийн 7.1.7-д заасан зохистой дадалд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, түүгээр үйлчлэх, малын

болон ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, борлуулах үйл ажиллагаа хамаарна.

7.9.Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д заасан зохистой дадалд мал эмнэлгийн үйлчилгээ, түүний хяналт, мал үржлийн үйлчилгээг хамруулна.

7.7.Хүнсний сүлжээний бүх шатанд зохистой дадал, техникийн зохицуулалтыг зөрчсөн нь тогтоогдвол тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцлага хүлээнэ.

2/10¹ дүгээр зүйл:

“10¹ дүгээр зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

10¹.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно:

10¹.1.1.хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;

10¹.1.2.энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.2-т заасан эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэх;

10¹.1.3.хүнс үйлдвэрлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хүнсний нэмэлтийг хэмжээнээс нь хэтрүүлэн хэрэглэх, зориулалтыг өөрчилж хэрэглэх;

10¹.1.4. түүсэн ойн дагалдах баялгийн өнгө, зүс, амт чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт дур мэдэн хольж хэрэглэх, зах зээлд нийлүүлэх;

10¹.1.5.ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх;

10¹.1.6.газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх;

10¹.1.7.Хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах.

10¹.2.Энэ хуулийн 10¹.1-д заасныг зөрчсөн дараах этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ:

10¹.2.1.Энэ хуулийн 10¹.1.1-10¹.1.2-т заасныг зөрчсөн буруутай этгээд;

10¹.2.2.Энэ хуулийн 10¹.1.3-10¹.1.6-д заасныг зөрчсөн нь лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдвол тариаланч, малчин, малын эмч, үйлдвэрлэгч, ойн дагалдах баялаг түүсэн, худалдаалсан этгээд.

3/11¹ дүгээр зүйл:

“11¹ дүгээр зүйл.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага

11¹.1.Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах шаардлага тавигдана:

11¹.1.1. хоолны цэсийн агууламжийн бодлогыг нэвтрүүлэх;

11¹.1.2.эрүүл хоолыг санал болгох цэсэд илчлэг, нийт сахар, уураг, ханасан өөх тос, натрийн агууламж, хоолны хэмжээг ил тод байрлуулах.

11¹.2. Энэ хуулийн 11.1-д зааснаас бусад нийтийн бусад орчинд үйлчилдэг хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэг зэрэг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдөнө.”

4/12 дугаар зүйлийн 12.10-12.13 дэх хэсэг

“12.10.Энэ хуулийн 12.4, 12.5-д заасан шаардлага импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод нэгэн адил хамаарна.

12.11.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах гадаад хэл дээрх мэдээлэл, монгол хэл дээрх орчуулга агуулгын хувьд нийцсэн байна.

12.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүн брайль болон программ хангамж ашиглан мэдээлэл авах боломжтойгоор хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгыг хийж болно.

12.13.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошго нь цаасан, эсхүл цахим, хэлбэртэй байна.”

5/14¹ дүгээр зүйл:

“14¹ дүгээр зүйл.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо

14¹.1.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо нь улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага/цаашид “хяналт, зохицуулалтын байгууллага” гэх/, Үндэсний лавлагаа лаборатори, эрсдэлийн үнэлгээний төв, аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ.

14¹.2.Хүнсний баталгаат байдлыг хангахад доор дурдсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд оролцоно:

14¹.2.1. эрүүл мэндийн, боловсролын, гадаад харилцааны болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

14¹.2.2.стандартчилал, хэмжил зүй, гааль, мал эмнэлэг, ургамал хамгаалал, үндэсний итгэмжлэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага.

14¹.3.Хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “хяналт зохицуулалтын байгууллага” гэх/ нь хүнсний хяналтын

бодлогыг тодорхойлж энэ хуулийн 15^{1.2}-т заасан байгууллагыг мэргэжлийн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавина.

14^{1.4}.Аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага энэ хуулийн 15^{1.3}-т заасны дагуу тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнана.

14^{1.5}.Энэ хуулийн 15^{1.2.1}, 15^{1.2.2}-д заасан байгууллагаас хүнсний хяналтын бодлогын хэрэгжилт, үр дүнг 15^{1.3}-д байгууллагад тогтмол тайлагнана.

14^{1.6}.Энэ хуулийн 15^{1.1}, 15^{1.2}-д заасан байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж хүнсний баталгаат байдлыг хангана.

14^{1.7}.Энэ хуулийн 15^{1.1}-д заасан хүнсний хяналт зохицуулалтын байгууллагын дарга буюу хүнсний хяналтын ерөнхий байцаагч нь хүнсний чиглэлээр магистр, ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй хүнсний технологич байна.”

5/15 дугаар зүйлийн 15.2.9 дэх заалт:

“15.2.9.хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх харшил үүсгэгч, тэсвэржсэн бичил биетний тандалтыг 3 жилд хийж, эрсдэлийн үнэлгээний төвд хүргүүлэх.”

6/15 дугаар зүйлийн 15.6-15.8 дахь хэсэг:

“15.6.Тухайн шинжилгээний нэг, эсхүл хэд хэдэн үзүүлэлтээр олон улсын стандартын хүрээнд итгэмжлэгдсэн тохиолдолд төрийн, орон нутгийн болон хувийн хэвшлийн хүнсний сорилын лабораторитой урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллуулж болно.

15.7.Хүнсний хяналт зохицуулалтын байгууллага энэ хуулийн 15.7-д заасан гэрээ байгуулах, чиг үүрэг гүйцэтгүүлэх шийдвэрийг гаргана.

15.8.Лабораторийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах эрсдэлийн тандалтын шинжилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, дээж авах, урвалж бодис зэрэг зардлыг төрийн болон орон нутгийн лаборатори жил бүр төсөвтөө тусгана.”

15.9.Лабораторийн шинжилгээнд шинжүүлэх сорьцын дээжний мэдээллийн нууцлалыг чанд сахих, цахим бүртгэлээр шинжилгээний дүнг илгээнэ.

15.10.Лабораторийн шинжилгээний үйл явцад хөндлөнгийн нөлөөллийг бууруулж цахимжуулна.”

9/16 дугаар зүйлийн 16.3.5, 16.3.5 дахь заалт:

“16.3.4.эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, өөрчлөлт оруулах, эрсдэл бүхий хүнсний бүтээгдэхүүний жагсаалт гаргах, шинэчлэх, эрсдэлийн зураглал хийх, шошгон дээрх орчуулгыг хянах, залруулах;

16.3.5.Эрсдэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэж, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан бэлтгэх, хяналтын арга зүйг боловсруулах.”

10/18 дугаар зүйлийн 18.1.7, 18.1.8 дахь хэсэг:

“18.1.7.хүнсний сүлжээнд мөрдөх стандартын шүүлт хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтэд үндэслэн стандартыг хүчингүй болгох санал, стандартын төсөл боловсруулах, батлуулах, мөрдүүлэх, хэрэгжилтийн үнэлгээ хийх;

18.1.8.шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний хяналтын бодлогыг боловсруулахад эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгааны үр дүнг ашиглах, бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, түүнд үндэслэн төсөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, хяналтын үр дүнгээр хяналтын бодлогод өөрчлөлт оруулах.”

11/18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг:

“18.2.Энэ хуулийн 6.1, 8.11, 16.5 дэх хэсэгт заасан мэдээллийн санг уялдуулан зохицуулах, шинэчлэх, баяжуулах, хасалт хийж байгаа эсэхэд хяналт тавина.”

12/18 дугаар зүйлийн 18.4, 18.5 дахь хэсэг:

“18.4. Хүнсний баталгаат байдалд тавих хяналт дараах чиглэлтэй байна:

18.4.1.хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилт;

18.4.2.энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан зохистой дадлыг нэвстрүүлж, баталгаажуулсан эсэх;

18.4.3..дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгололт, шошгодох тэмдэг, тэмдэглэгээ;

18.4.4.Хүнсний тухай хуулийн 5¹ зүйлд заасан стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрөл олголт;

8.4.5.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авалт;

18.4.6. энэ хуулийн 9.5.1, 9.5.2.-д заасан ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл;

18.4.7. хуульд заасан бусад

18.5.Энэ хуулийн 13¹.1-д заасан байгууллага, нэгж, улсын байцаагч нь хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран үйл ажиллагааных нь чиглэлээр мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилыг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, зөвлөгөө, мэдээллээр хангах, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.”

13/18¹дүгээр зүйл:

“18¹дүгээр зүйл.Эрүүл зөв хүнс сонгон хэрэглэхийг дэмжих

18¹.1.Хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжинэ.

18¹.2.Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлана.

18¹.3.Хэвлэл мэдээллийн байгууллага хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүнсний бүтээгдэхүүнийг дэмжин сурталчлахгүй байх, энэ талаар сэрэмжлүүлэг, анхааруулга өгч байх үүрэг хүлээнэ.

18¹.4.Энэ хуулийн 18¹.1, 18¹.2-т заасан зээлийн бодлогоор дэмжих, татварын бодлогоор хязгаарлах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “суурилсан” гэснийг “, шинжлэх ухааны үндэслэсэн” гэж, 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “шаардлагыг” гэсний дараа “стандарт,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтын “үйлдвэрлэдэг” гэсний дараа “савладаг, шошголдог, хадгалдаг, түгээдэг, хүргэдэг” гэж, 10.1.9 дэх заалтын “тээвэрлэх” гэсний дараа “түгээх, хүргэх” гэж, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтын “шаардлагыг” гэсний дараа “стандартад нийцүүлэн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1.Энэ хууль хүнсний сүлжээний үйл ажиллагаанд үйлчилнэ.”

2/ 4 дүгээр зүйлийн 4.14, 4.1.5, 4.1.6 дахь заалт:

“4.1.4.хүнсний баталгаат байдал” гэж хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, сөргөөр нөлөөлөхгүй, чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байхыг;”

4.1.6.“хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, түгээх, худалдаа эрхлэх, хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг;”

3/7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг:

4/ 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6 дахь хэсэг:

“9.5. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах журмыг батална.

9.5.1.мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх;

9.5.2.ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх.

9.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцооны стандартыг хүнсний сүлжээнд мөрдөнө.”

5/ 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэг:

“8.10.Энэ хуулийн 8.2, 8.6, 8.7-д заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах стандартыг мөрдөнө.”

6/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Энэ хуулийн 16.3.5-д заасан эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэслэн хяналтын бодлогын шийдвэр гаргаж, холбогдох арга хэмжээ хэрэгжүүлнэ.”

4 дүгээр зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийн “БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 2 зүйлийн гарчгийн, 2.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 3.3 дахь хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “аюулгүй байдал” гэснийг “баталгаат байдал” гэж, 4.1.5 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 4.1.12 дахь заалтын “аюулгүй байдал” гэснийг “баталгаат байдал” гэж, 4.1.13 дахь заалтын “аюулгүй байх” гэснийг “баталгаатай байх” гэж, “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 4.1.19, 4.1.20, 4.1.21 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 5 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1, 5.1.2, 5.1.3 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Засгийн газрын гишүүн” гэснийг “төрийн захиргааны байгууллага” гэж, 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “аюулгүйн үзүүлэлт” гэснийг “баталгаат байдлын үзүүлэлт” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 7.3 дахь хэсгийн “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “дүрэм, журмыг” гэснийг “журам, стандарт, техникийн зохицуулалтыг” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 13.7 дахь хэсгийн “хийж болно” гэснийг “хийнэ” гэж, дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсгийн “Стандарт, хэмжил зүйн” гэснийг “Хүнсний хяналт, зохицуулалтын” гэж, 15.2.1 дэх заалтын “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 15.2.4 дэх заалтын “баг” гэснийг “төв” гэж, 15.2.7 дахь заалтын “аюулгүй байдлын талаарх техникийн зохицуулалт” гэснийг “баталгаат байдлын талаарх стандарт, техникийн зохицуулалт” гэж, 15.3 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж, 15.5 дахь хэсгийн “багийн” гэснийг “төвийн” гэж, 16 дугаар

зүйлийн 16.1 дэх хэсгийн “баг” гэснийг “төв” гэж, 16.1.1 дэх заалтын “түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 16.2 дэх хэсгийн “багийн” гэснийг “төвийг” гэж, 16.3 дахь хэсгийн “Баг” гэснийг “Төв” гэж, өөрчлөх, 17 дугаар зүйлийн гарчиг, 17.1 дэх хэсгийн “түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 17.1.3 дахь заалтын “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 17.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн гарчгийн “түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 18.1 дэх хэсгийн түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 18.1.3 дахь заалтын “техникийн нөхцөл, эрүүл ахуй, ариун цэврийн бусад шаардлагыг” гэснийг “эрүүл ахуй, ариун цэврийн стандартын шаардлагыг” гэж, 18.1.5 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж, “багийн” гэснийг “төвийн” гэж, “техникийн” гэснийг “дүгнэлт” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “ утас” гэсний дараах “ факсын дугаар” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан” гэснийг, 18 дугаар зүйлийн “захиргааны” гэсний дараах “төв” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.4 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлин 5 дахь хэсгийн 3 дахь заалтын “төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах” гэсний дараа, “хүнсний хяналт, зохицуулалтын” гэж нэмсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын “аюулгүй байдал” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж, 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.6 дахь заалтын “бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 6.15 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтын “стандарт” гэсний дараа “техникийн зохицуулалт” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 6.15 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.2 дахь заалтын “нэвтрүүлээгүй” гэснийг “нэвтрүүлж баталгаажуулаагүй” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах ” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 2 дугаар дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн” Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Таримал ургамлын үр, сортын тухай /шинэчилсэн найруулга/
хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хүнсний аюулгүй байдлыг” гэснийг
“хүнсний баталгаат байдлыг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Хүнсний
аюулгүй байдал” гэснийг “Хүнсний баталгаат байдал ” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авто тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14."хүнсний аюулгүй байдлыг" гэснийг "хүнсний баталгаат байдлыг" гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ...
сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

"ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ"

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын тохируулагч агентлаг" гэсэн хэсэгт "Хүнсний хяналт, зохицуулалтын газар" гэж нэмсүгэй.

2."Хүнсний хяналт, зохицуулалтын газрын орон тооны хязгаар, бүтцийн ерөнхий бүдүүвчийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар /-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

УДИРТГАЛ	4
НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	8
1.1. Үнэлгээ хийх үндэслэл	8
1.2. Үнэлгээний хүрээ	8
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	9
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	10
1.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн томъёолол	11
1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга зүй.....	13
ХОЁР. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ.....	14
2.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх асуудлаарх хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	17
2.3. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	58
2.4. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	71
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	103
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	110

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- 1 дүгээр хүснэгт. *Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ*
- 2 дугаар хүснэгт. *Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан хүнсний бүтээгдэхүүний тоо, хэмжээ*
- 3 дугаар хүснэгт. *Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн тоо*
- 4 дүгээр хүснэгт. *Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн тоо*
- 5 дугаар хүснэгт. *Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсэн, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн болон нас барсан хүний тоо*
- 6 дугаар хүснэгт. *Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл*
- 7 дугаар хүснэгт. *Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл*
- 8 дугаар хүснэгт. *Газрын доорх усны нөөц батлагдсан сум, дүүргийн тоо, 2023 он*
- 9 дүгээр хүснэгт. *Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадавх*
- 10 дугаар хүснэгт. *Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл*
- 11 дүгээр хүснэгт. *Хариуцлага тооцсон байдал*

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- | | |
|-----------------|---|
| 1 дүгээр зураг. | Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоо |
| 2 дугаар зураг. | Ундны усны эрүүл аюулгүй байдал, хүн амын эзлэх хувь, 2023 он |
| 3 дугаар зураг. | Цацрагийн лабораторийн шинжилгээний тоо, жилээр |
| 4 дүгээр зураг. | Бруцеллёзын тандалт судалгааны эерэг дээжийн эзлэх хувь |
| 5 дугаар зураг. | Гэдэсний халдварт өвчний тохиолдол, 10 000 хүн амд, төрлөөр, 2014-2023 он |
| 6 дугаар зураг. | Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоо |

УДИРТГАЛ

Хүн бүр эрүүл амьдарч, хөдөлмөрлөх үндсэн нөхцөлийн нэг бол хоол хүнс бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаат хоол хүнсээр хангагдах нь хүний үндсэн эрх юм.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-ын 3.4.2.1.-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, ...” гэж, 3.4.2.4.-д “Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна” гэж, 3.4.2.5.-д “Хүнсний түүхий эд үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно” гэж, 3.4.2.6.-д “...малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг дээшлүүлж, халдвар хамгаалал био-аюулгүй байдлыг хангах..., байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ” гэж, 3.4.2.7.-д “Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, ...” гэж, 3.4.2.8.-д “..., импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын урьдчилсан хяналт, бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоо бий болгох, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангана” гэж, 3.4.2.9.-д “Нано-технологи, биотехнологийн эрсдэлийг үнэлэх, хянах, түүний хор хөнөөлөөс хамгаалах арга хэмжээ авна” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах стратегийг тодорхойлсон байдаг.

Мөн Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.1.-д “..., иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан хэрэгжүүлнэ” гэж, 3.4.1.3.-д “Хүн амын дунд хоол тэжээлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэн бичил тэжээлийн дутлыг бууруулна” гэж тус тус заасны дагуу холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлснээр Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх болно.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.4.-д “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

2012 онд Монгол Улсын Их Хурлаас Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль²-ийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажилласан 13 жилийн хугацаанд тус хуульд нийт 2 удаа өөрчлөлт оржээ. Эдгээр өөрчлөлтүүд нь цаг үеийн шинжтэй үүссэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийгдсэн бөгөөд энэ нь хүнсний

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

² Монгол Улсын Их Хурал 2002 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2002 оны №23 дугаарт нийтлэгдсэн.

баталгаат байдлыг цогц байдлаар хангахтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэгдээгүй байна.

2017, 2023 онд хийсэн “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний 5, 6 дугаар судалгааны дүнг харьцуулахад хүн амын дундах хоол тэжээлийн дутал буураагүй байгаа нь зохистой хооллох мэдлэг, дадал дутмаг, хоол, хүнсний хяналтгүй хэрэглээтэй холбоотой. Шим тэжээлгүй хоол хүнсийг хэрэглэснээс таргалах өвчлөх зэрэг сөрөг үр дагаврууд илэрч байна.

Нэг талаас зарим хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч буюу үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн мэргэжлийн ур чадвар хангалтгүй, нөгөө талаас хэрэглэгчийн хоол, хүнсний зөв, зохистой хэрэглээний талаарх мэдлэг дутмаг байгаа нь хүн бүрийн эрүүл ахуйн шаардлагыг хангасан, баталгаат хүнсээр хангагдах эрхийг хөндөж байна. Тухайлбал, 2023 онд нийт халдварт өвчний 18.8 хувь гэдэсний халдварт өвчин эзэлсэн байна. Улсын хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварын 8 дэгдэлт бүртгэгдсэн ба дэгдэлтээр нийт 683 хүн өвдөж, 105 хүн эмнэлэгт хэвтэн хоёр тэрбум гаруй төгрөгийг эмчилгээний зардалд зарцуулсан байна. Харин 578 хүн гэрээр өрхийн эмчийн хяналтад эмчлэгджээ.

2024 оны ДЭМБ-ын статистикийн урьдчилсан тойм мэдээллээр Монгол улс элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Эдгээр статистикийн үзүүлэлтээс харахад хоол, хүнсээр дамжих халдварт болон халдварт бус өвчлөлийн гаралт, давтамж нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд “хүнсний сүлжээнд чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах”-тай холбоотой харилцааг иж бүрнээр зохицуулах, хүнсний хяналтын бодлогын чиглэлийг тодорхойлох, түүний хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах, чиглүүлэх зохицуулалтыг зайлшгүй тусгах цаг үеийн хэрэгцээ шаардлага бий болсон гэж үзэж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хүнсний хяналтын болон салбарын хүний нөөцийн бодлого алдагдаж, мэргэжлийн удирдлага, түүний тогтолцоо гажуудалд орсонтой холбоотой гэж үзэж байна. Мөн үйлдвэрлэлийн явц дахь тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, түгээлт, хүнсний шимт байдал, хүнсний зохистой хэрэглээтэй холбоотой харилцааг дутуу зохицуулсантай холбоотой юм.

Иймд хүнсний баталгаат байдлыг хүнсний сүлжээнд бүхэлд нь хангах хүрээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хүнс тээвэрлэх, хадгалах, худалдах, хоол үйлдвэрлэх, үйлчлэхтэй холбоотой хуулийн зохицуулалт хангалтгүй байгаа учир Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шаардлагатай байна.

Энэхүү үнэлгээний зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн³ 14 дүгээр зүйлийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг ... хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл

³Монгол Улсын Их Хурал 2015 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

баримтлалын төсөл боловсруулна.”, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.” гэж, 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж тус тус заасны дагуу Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх Засгийн газрын 2019 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлэхэд оршино.

Үнэлгээний зорилго

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, хүнсний баталгаат байдлын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох замаар хүн амын дундах халдварт бус өвчлөл, ялангуяа хоол хүнснээс шалтгаалсан өвчлөл, хоолны хордлого, халдварт өвчин гарсан тохиолдол, давтамж, түүний шалтгаан, үр дагаврын улмаас хүн амын эрүүл мэндэд хохирол учруулсан байдлыг судлан тогтоож, хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудал, хүндрэл, бэрхшээл, энэ нь нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, үүн дээр үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх явдал юм.

Үнэлгээ хийхэд баримталсан зарчим

Үнэлгээг бие даасан, хараат бус байдлаар, судалгааны арга зүйг ашиглах замаар хийж, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэв.

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд заасны дагуу дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд үнэлгээ хийх шалтгаан нь энэ хуулийн зохицуулалтаар хүнсний сүлжээнд бүхэлд нь хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хүнсний сүлжээнд хүнсний салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг тогтоох замаар хуулийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тогтоох юм.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.4-т “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”-ээр заасан нь үнэлгээ хийх шалтгаан юм.

1.2. Үнэлгээний хүрээ

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээг хийх бөгөөд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, хуулийн зорилгыг хангахад чиглэсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналт гэсэн 3 бүлэг, 12 зүйл, нийт 112 заалтаар үнэлгээний хүрээг сонголоо.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2013-2018, 2019-2024 оны хоорондох Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх статистикийн болон албаны мэдээллийг цуглуулав. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт ярилцлага⁴ хийж, холбогдох тоо баримт, судалгааны бүтээл зэргийг судалж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үнэлэхэд шаардлагатай мэдээллийг нэмж тусган нэгтгэн дүн шинжилгээг хийв.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь үнэлэх бөгөөд үнэлэх шаардлагатай зүйл, хэсгийг дараах хүснэгтээр үзүүлбэл:

д/д	Үнэлэгдэх бүлэг	Үнэлэгдэх зүйл, хэсэг
1	Хоёрдугаар бүлэг. Хүнсний чиглэлийн	6 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл

⁴Үнэлгээний тайлангийн хавсралтад ярилцлагын аргаар авсан судалгааны тайланг хавсаргав.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

	үйл ажиллагаа эрхлэх	7 дугаар зүйл. Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр 8 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах 9 дүгээр зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг
2	Гуравдугаар бүлэг. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага	11 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 12 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 14 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн
3	Дөрөвдүгээр бүлэг. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналт	15 дугаар зүйл. Үндэсний лавлагаа лаборатори 16 дугаар зүйл. Эрсдэлийн үнэлгээ хийх 17 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 18 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Үнэлгээний хүрээ, онцлогоос шалтгаалан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах дараах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгосон.

Зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал, бусад үр дагавар гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байдлыг харгалзан сонгож авсан болно. Үүнд:

1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт нь хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоох замаар хууль зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх юм.

2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлт нь хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч буй эерэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж үнэлэх юм.

3. “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлт нь урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагавар байгаа эсэхийг үнэлэх юм.

д/д	Үнэлэгдэх бүлэг	Үнэлэгдэх хэсэг, заалт	Шалгуур үзүүлэлт
1	Хоёрдугаар бүлэг. Хүнсний чиглэлийн	6 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

	үйл ажиллагаа эрхлэх	7 дугаар зүйл. Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр 8 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах 9 дүгээр зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг	Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
2	Гуравдугаар бүлэг. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага	11 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 12 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 14 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.
3	Дөрөвдүгээр бүлэг. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналт	15 дугаар зүйл. Үндэсний лавлагаа лаборатори 16 дугаар зүйл. Эрсдэлийн үнэлгээ хийх 17 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 18 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаа дээр үндэслэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээг хийх болно.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн ба хэрэгжсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгыг хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Үүнийг харьцуулах тоо баримт нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, статистикийн болон албаны мэдээлэл, судалгааны бүтээл зэрэг байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтооно.

Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

д/д	Үнэлэгдэх зүйл	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1	6 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл 7 дугаар зүйл. Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр 8 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах 9 дүгээр зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи Тодорхой тохиолдол судлах
2	11 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 12 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 14 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи Тодорхой тохиолдол судлах
3	15 дугаар зүйл. Үндэсний лавлагаа лаборатори 16 дугаар зүйл. Эрсдэлийн үнэлгээ хийх 17 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 18 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнөх болон эхэлснээс хойшхи Тодорхой тохиолдол судлах

1.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн томьёолол

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхмууд нь томьёолсон шалгуур үзүүлэлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	6 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл 7 дугаар зүйл. Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр 8 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах 9 дүгээр зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг	Хуулийн зорилгод хүрсэн байдал ба хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх эдгээр заалтууд нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? Хүнсийг бүртгэх, үйл ажиллагааг баталгаажуулах талаарх хуулийн зохицуулалт нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх? Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх үйл явц болон ХЧҮАЭ-ийн хүлээх үүргийг тодорхойлсон хуулийн зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх?
2	11 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 12 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн 14 дүгээр зүйл. Хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн	Хуулийн зорилгод хүрсэн байдал ба хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? Энэхүү хуулиар тогтоосон тусгай шаардлага нь цаг үетэйгээ нийцэж байгаа эсэх буюу практикт нийцэж байна уу?
3	15 дугаар зүйл. Үндэсний лавлагаа лаборатори 16 дугаар зүйл. Эрсдэлийн үнэлгээ хийх 17 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 18 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт	Хуулийн зорилгод хүрсэн байдал ба хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах	Лабораторийн чадавхи шаардлага хангаж, шинжилгээний дүн нь хүлээн зөвшөөрөгддөг эсэх? Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа явц нь практикт нийцэж буй эсэх? Хуулийн хэрэгжилтэд төр бүрэн хяналт тавьж чадаж буй эсэх?

1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга зүй

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Үнэлгээ хийхэд шаардагдах мэдээллийг цуглуулахдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Сангийн яам, Стандартчилал хэмжил зүйн газар, Үндэсний статистикийн хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний итгэмжлэлийн газар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабоартори, Нийслэл, аймаг, салбарын хяналтын газруудаас хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлан, статистикийн тоон мэдээлэл, танилцуулга, үр нөлөөний үнэлгээ, салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, салбарын эрдэмтэн судлаачдын бүтээл, ном туурвил, хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн танилцуулга, мэдээлэл зэрэг мэдээллийг эх сурвалж болгон ашигласан.

- **Холбогдох субъектүүдтэй уулзаж, мэдээлэл авах:** Хуулийн хэрэгжилтийн талаар үнэн бодитой мэдээлэл цуглуулах, уг хуулийн үйлчлэлд оролцогч субъектүүдээс тэнцвэртэй мэдээлэл авах зорилгоор салбарын мэргэжилтэн, эрдэмтэдтэй ганцаарчилсан ярилцлага хийх, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдлага, салбарын хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийхээс гадна орон нутагт ажиллаж хуулийн хэрэгжилтэд оролцогч субъектүүдтэй уулзалт, ярилцлага хийх зэргээр мэдээлэл цуглуулсан.

- **Цуглуулсан анхны тоон мэдээлэл үнэлгээ хийхэд шаардлага хангах эсэхэд дүн шинжилгээ хийж, сайжруулах:** Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг үнэн зөв, бодит, эргэлзээгүй, статистикийн тоон мэдээтэйгээр зохион байгуулахын тулд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, холбогдох хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас анх ирүүлсэн тоон мэдээлэлд дүн шинжилгээг хийж, зөрүүтэй, эргэлзээтэй, тодорхойгүй, мэдээлэл огт ирүүлээгүй мөн бүртгэлд огт байхгүй зэрэг тоон мэдээллийг шинээр бүртгэлжүүлэх, засч залруулах, ойлголтын зөрүүг арилгах, нэр томъёоллыг жигдлэх, нэгдсэн ойлголтод хүрэх, нэгтгэх зорилгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн заалт тус бүр дээр албаны болон статистикийн тоо ба чанарын мэдээллийг цуглуулах хүснэгтийг боловсруулан, хүснэгтийн дагуу мэдээлэл цуглуулж, мэдээллийг сайжруулан, боловсруулж үнэлгээнд ашигласан.

ХОЁР. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль нь **хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналттай** холбогдсон харилцааг зохицуулсан 5 бүлэг 20 зүйлтэй батлагдсан.

Хуулийн 3 бүлэг, 12 зүйл, нийт 112 заалтын хүрээнд гаргаж, нэгтгэн дүгнэхэд өнөөгийн хүнсний хяналтын бодлого алдагдаж, хүнсний сүлжээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах мэргэжлийн удирдлагын тогтолцооны гажуудлаас үүдэн энэ хуулийн хэрэгжилт, хуулийн үзэл баримтлалд анх дэвшүүлсэн зорилгодоо хүрч чадахгүй байна гэж дүгнэж байна. Иймд **хуулийн хэрэгжилт 44.6 хувьтай байна.**

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээг гаргахад шаардлагатай суурь өгөгдөл, мэдээллийг Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээ болон холбогдох төрийн захиргааны байгууллагын албаны мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн.

УИХ-аас 2012 онд баталж 13 дах жилдээ хэрэгжиж буй Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг Хүнсний тухай хуулийн дагаж гарах процессын хууль гэж үздэг. Энэ хуулиар хүнсний сүлжээнд бүхэлд нь хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан боловч хүнсний худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн үеийн эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах, транс тос, хүнсээр дамжих бичил биетний тэсвэржилт, хүнсний нэмэлт болон хуурамч бүтээгдэхүүнийг шинжлэн тогтоохтой холбоотой зохицуулалтыг тодорхой тусгаагүй байна. Мөн хүнсний хяналтын бодлого, түүний чиглэл, хяналтын үйл ажиллагаанд бүх талын оролцоог хангахтай холбоотой хуулийн зохицуулалт хангалтгүй туссан байна гэж дүгнэж байна.

Энэхүү хуулийн үйлчлэх хүрээ нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хамрагдахгүй байна. Тухайлбал хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч, анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчид, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгчид, нийтийн хоолны салбарын үйл ажиллагаанд тавигдах шаардлага тодорхойгүй, хэт ерөнхий хүнсний чиглэлийн үйл эрхлэгчдэд ангилал зэрэглэл тогтоох, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийх хяналтын чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хүнсний гаралтай хордлого халдварын нөхцөлд хариу арга хэмжээг хэн хэрхэн яаж авч хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаж, эрх зохицуулалт, үйлчлэх хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна гэсэн саналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргаж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг дагаж гарах нийт 12 эрх зүйн баримт бичиг байхаас 9 журам, нэг загвар, нэг заавар, нэг аргачлал байхаар хуульчилсан боловч 2025 оны байдлаар 7 журам, нэг заавар баталсныг дараах хүснэгтэд харуулав. Батлагдсан журмаас 3 журмыг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойших 6-12 жилийн дараа баталсан, огт батлагдаагүй 2 журам, нэг загвар, нэг аргачлал байгаа нь энэ хуулийн хэрэгжилтэд нөлөөлсөн гэж үзэж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

1 дүгээр хүснэгт. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг дагаж гарсан журам, заавар, аргачлал, бусад баримт бичгийн жагсаалт

№	Захиргааны хэм хэмжээний актын		Агуулга, хэрэгжилтийн байдал
	Баталсан арга хэлбэр	Огноо, Дугаар	
1.	ХХААХҮ, ЭМ-ийн сайдын "хамтарсан тушаал	2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/100, А/68 дугаар тушаал	Энэ хуулийн 7.2-д Зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар батлах тухай" гэж заасны дагуу "Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадлын хялбаршуулан нэвтрүүлэх заавар", "Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадлын хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ыг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш 12 жилийн дараа баталсан байна.
2.	Засгийн газрын тогтоол	2013 оны "Журам батлах тухай" 172 дугаар тогтоол	Энэ хуулийн 8.10-д заасны дагуу "Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам", "Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах үйл ажиллагааг бүртгэх, мэдээлэх маягт"-ыг баталсан.
4.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал	2022 оны А/196 дугаар тушаал	Энэ хуулийн 9.5-д "Журам батлах тухай" гэж заасны дагуу "Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ыг 2016 оны А-37 дугаар тушаалаар хүчингүй болгосноос хойш 6 жилийн дараа баталсан байна.
5.	Эрүүл мэндийн сайдын тушаал	2017.04.14-ний А/145 дугаар тушаал	Энэ хуулийн 10.2-д журам батлах тухай заасны дагуу "Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам" батлагдсан.
6.	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал	2013 оны А/46/115 дугаар тушаал	Энэ хуулийн 12.2-д журам батлах тухай заасны дагуу "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам"-ыг баталсан.
7.	Засгийн газрын тогтоол	2013 оны "Журам батлах тухай" 341 дугаар тогтоол	Энэ хуулийн 13.8.-д журам батлах тухай заасны дагуу "Зээл тусламжаар авах болон өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журам"-ыг баталсан.
8	Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалын	2020 оны "Журам батлах тухай" А/602/А/393/А/ 689 дугаар тушаал	Энэ хуулийн 14.1-д журам батлах тухай заасны дагуу "Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэх журам"-ыг хууль хэрэгжиж эхэлснээс хойш 8 жилийн дараа баталсан.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан батлагдах зарим журам хууль батлагдсанаас хойших 13 жилийн хугацаанд огт батлагдаагүй 4 эрх зүйн баримт бичиг байгааг доорх хүснэгтэд харуулав.

2 дугаар хүснэгт. Хуулийг дагаж гараагүй хууль, журам бусад баримт бичгийн жагсаалт

№	Захиргааны хэм хэмжээний актын		Агуулга
	Батлагдах арга хэлбэр	Хуулийн заалт	
1.	Хяналтын байгууллага	Энэ хуулийн 6.1.2.-д заасан журам батлах	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, иргэний регистрийн дугаар, хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журам батлагдаагүй байна.
2.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал	Энэ хуулийн 6.1.-д заасан маягтын загварыг батлах	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, иргэний регистрийн дугаар, хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журамд заасан маягтын загвар батлагдаагүй байна.
3.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал	Энэ хуулийн 9.5.-д заасан Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	"Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ыг баталсан хэдий ч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-37 дугаар тушаалаар хүчингүй болгосон ба 2016 оноос хойших хугацаанд Мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам батлагдаагүй байна.
4.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал	Энэ хуулийн 9.6-д заасан журам батлах	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх аргачлал батлагдаагүй байна.

Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд "хүнсний сүлжээнд бүхэлд нь хүнсний баталгаат байдлыг хангах"-тай холбоотой зохицуулалтыг тусгахдаа хүнсний хяналтын бодлого, мэргэжлийн болон эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны чиглэл, оролцогч талууд гэсэн хүнсний баталгаат байдлыг хангах бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлж, улмаар хүнсний сүлжээнд хүнсний хяналтын нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, тогтолцоогоор хангах зохицуулалтыг зайлшгүй тусгах цаг үеийн хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Мөн энэ хуульд туссан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд тавигдах эрүүл ахуйн шаардлага, хүнсний аюулгүйн үзүүлэлт, хүнсэнд дэх пестицид болон малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хүнсний шошгоны мэдээлэл болон бусад журмаар зохицуулахаар, эсхүл хүнсний асуудал эрхэлсэн Засгийн гишүүн тогтоож батлахаар заасныг холбогдох стандарт, техникийн зохицуулалт байхаар хуульд өөрчлөлт оруулах саналтай байна. Учир нь эдгээр дүрэм

журмаар зохицуулж буй харилцаа нь хүнсний салбарын мэргэжлийн түвшинд боловсруулагддаг ба олон улсад ихэвчлэн стандарт шаардлагыг хэмжээнд батлагддаг эрх зүйн барим бичгүүд юм.

Хүнсний сүлжээнд мөрдөх стандарт, техникийн зохицуулалтад тавих хяналт, шалгалт, тандалт, шинжилгээ хийх төрийн байгууллага болох хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хүнсний судалгааны хүрээлэн, хүнсний шинжилгээний төр, хэвийн хэвшлийн лабораторийн чиг үүргийг зааглаж хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

2.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх асуудлаарх хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Хуулийн хэрэгжилтэд шинжилгээ хийх ажлын хүрээнд Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдэд үндэслэн шинжилгээ хийлээ. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэлтийн өнөөгийн бодит нөхцөл байдалтай танилцах хүрээнд холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн төлөөлөлтэй ялангуяа дотоодын үйлдвэрлэгч болон хүнс импортлогч нартай уулзах уулзалтыг зохион байгуулж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдаж буй асуудал, шалтгааныг тогтоох, түүнийг бууруулах, арилгах зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрхэн хамтран ажиллах талаар харилцан ярилцаж, санал солилцлоо.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6-10 дүгээр зүйлийн хэрэгжилтэд шинжилгээ хийсэн. Үүнд:

Үнэлэгдэх хэсэг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль	6 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл, 7 дугаар зүйл. Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр, 8 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах, 9 дүгээр зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл, 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх эдгээр заалтууд нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? Хүнсийг бүртгэх, үйл ажиллагааг баталгаажуулах талаарх хуулийн зохицуулалт нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх? Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх үйл явц болон ХЧҮАЭ-ийн хүлээх үүргийг тодорхойлсон хуулийн зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх?

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх эдгээр заалтууд нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх, мөн хуулиар тодорхойлсон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хүлээх үүргийн хуулийн зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэхэд хуулийн заалт тус бүрээр дүн шинжилгээ хийж үнэлгээ өгсөн.

Хүнсийг бүртгэх, үйл ажиллагааг баталгаажуулах талаарх хуулийн зохицуулалт нь энэ хуулийн зорилгыг хангахад хангалттай зохицуулалт болж чадсан эсэхийн талаарх мэдээллийг цуглуулж, мэдээллийг нэгтгэн дүгнэлээ.

2.2.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахим бүртгэл захиргааны шинжтэй, админ суурьтай, бүртгэсэн мэдээллийг ашиглах харилцааг дутуу төлөвлөсөн, мэдээллийг захиргаа болон олон нийтэд хандсан байдлаар төрөлжүүлээгүй байна. Тодруулж хэлбэл, цахим санг бүрдүүлэх, ашиглах, хэрэглэх, удирдах үйл ажиллагаа цогц биш байна. Иймд тус мэдээллийн санг шинэчлэснээр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хооронд хийгдэх түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох үйл ажиллагааг тус санд түшиглэн зохион байгуулах, зардал, цаг хугацаа хэмнэх боломжтой.

Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хяналт тавих журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран баталж бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцдог тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ шаардлага гарч ирсэн. Улмаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэж заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах ажлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2013 оны “Заавар батлах тухай” 37, 2014 оны “Заавар батлах тухай” 129 тушаалаар тус тус батлуулан мөрдөж байсан. Тус тушаалаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн маягт”-ын загвар, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр”, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн маягтыг нөхөн бичих заавар”, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч мэдээллээ цахимаар бүртгүүлэх аргачлал, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах заавар”, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэлийг ашиглах аргачлал”-ыг тус тус батлаад 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн гүйцэтгэсэн байна. Энэ хүрээнд 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн бүртгэлийн санд нийт 147150 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 396387 төрөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх зааврын хэрэгжилт хууль хэрэгжиж эхэлснээс хойших эхний 6 жилийн дунджаар 81.5 хувьтай гэж тухайн үеийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тайланд дурдагдсан байна.

2022 оны 12 дугаар сард Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан боловч мэргэжлийн хяналтын байгууллагын хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим бүртгэл одоог хүртэл өөрчлөгдөөгүй тус цахим бүртгэлд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэл хийгдэж байгаа гэж Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан боловч бодит байдал дээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар байх үед бүртгэгдсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээлэл нь 2025 оны байдлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын мэдээлэлтэй зөрүүтэй байсан бөгөөд

энэ нь бүртгэлийн системд харилцан өөр мэдээлэл байх магадлал өндөр байна. Тухайлбал, 2019-2024 онд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон тохиолдолд энэ бүртгэлийн системээс хасалт хийхгүй байгаа нь бүртгэлийн мэдээлэл үнэн зөв, бодит байж чадахгүй байна гэж дүгнэлээ.

Иймд цахим шилжилттэй холбогдуулан хуулийн төсөлд мэдээллийн цахим санг бүрдүүлэх, төрийн байгууллагад хүргүүлэх, эсхүл бүртгүүлэх баримт бичиг, мэдээллийг цахимаар хүргэхтэй холбогдох заалтуудыг өөрчлөх саналтай байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” А/76 дугаар тушаалын хавсралтаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг батлагдсан байна.

Энэ хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (хуучнаар)-ын цахим бүртгэлийн <https://igov.mn/certificates> цахим системээр дамжуулан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн хүсэлтийг хүлээн авч бүртгэж байгаа хэдий ч Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нарыг цахим /lgov.mn/ бүртгэлийн системд бүртгэдэг байдал нь татан буугдсан Мэргэжлийн хяналтын байгууллагын нэр дээр бүртгэдэг, цахим системийн хөгжүүлэлт сайжруулалт хийх шаардлагатай гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тайлагнасан.

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нарыг бүртгэдэг цахим бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан байна. Тодруулбал, Мэргэжлийн хяналтын байгууллагын нэр дээр бүртгэдэг, хяналтын улсын байцаагч нарт тус системд нэвтрэх эрх байхгүй, цахим системд бүртгэгдсэн үйл ажиллагаа эрхлэгч нар мэдээлэл давхардуулан оруулсан, үйл ажиллагааг зогсоосон, мэдээлэл буруу оруулсан байдлыг шалгах, бүртгэх боломжгүй, тус хуулийн 6.5 дахь заалтад заагдсан улсын байцаагчийн ажлын байранд гаргасан дүгнэлт ордоггүй зэрэг хэвийн үйл ажиллагаа алдагдсан.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.2 дахь /Энэ хуулийн 6.1-д заасан маягтын загварыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална/ заалт Мэргэжлийн хяналтын байгууллага тарснаас хойш шинэчилж батлагдаагүй. Цахим системийг Цахим хөгжлийн яам хариуцаж байгаа нь практикт нийцэхгүй байна гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тайлагнасан.

Иймд хуулийн энэ заалтын хэрэгжилт хангалтгүй түвшинд хэрэгжсэн гэж үнэлсэн. Цаашид бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, шинэчлэлт, сайжруулалт хийгдэх шаардлагатай гэж үзэж байна.

Хүнсний чиглэлийн хяналт хэрэгжүүлэх байгууллага энэ заалтыг хэрэгжүүлдэг боловч дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахад шаардагддаг /галын дүгнэлт, хог тээврийн гэрээ, дүүргийн бүртгэлийн qr код авах зэрэг/ бусад бичиг баримтыг гаргуулаагүй бол үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй байдаг байна.

Энэ хуулийн 6.3.-д “Энэ хуулийн 6.5-д зааснаас бусад тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 6.1-д заасны дагуу мэдээлснээр үйл ажиллагаагаа эхлүүлж болно” гэж заасны дагуу хүнсний чиглэлийн хяналт хэрэгжүүлэх байгууллага энэ заалтыг хэрэгжүүлдэг боловч дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахад шаардагддаг /галын дүгнэлт, хог тээврийн гэрээ, дүүргийн бүртгэлийн qr код авах зэрэг/ бусад бичиг баримтыг гаргуулаагүй бол үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй байдаг байна.

Хамгийн гол нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахим бүртгэл мэдээллийн системийг хэвийн ажиллагаанд оруулсны дараа энэ заалтын хэрэгжилт бүрэн хангагдах нөхцөл бүрдэх юм.

Энэ хуулийн 6.4.-д “Хяналтын байгууллага энэ хуулийн 6.1-д заасан мэдээлэлд тулгуурлан эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөнө” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2011 оноос хойш эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд 2013-2018 онд нийт 29722 объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан байна. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөлт эрсдэлтэй газруудыг бүрэн хамарч чаддаггүй, хяналт шалгалт хийх улсын байцаагчийн тоо цөөн, нэг байцаагч жилд 30 объектод хяналт шалгалт хийх нормативтай тул улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 4040-5596 объектод хяналт шалгалт хийсэн байна. Мөн төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд урьдчилан мэдэгдэж хяналт шалгалт хийж байгаа нь үр дүн багатай, бодит зөрчил дутагдлыг илрүүлэх боломжгүй байсан байна. Энэхүү заалтын хэрэгжилт **хууль хэрэгжиж эхэлсэн эхний 6 жилийн дунджаар 70 хувь** гэж дүгнэж байжээ.

Шилэн хяналтын цахим системд болон судалгаанд бүртгэлтэй хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг ихэвчлэн хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг Засгийн газрын 2023 оны эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр үнэлж их, дунд эрсдэлтэйгээс төлөвлөгөөт шалгалтад хамруулдаг.

2022/2023 оны хичээлийн жилд төвлөрсөн бус ус хангамжтай 1202 сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагын 1813 ундны усны дээжийг авч лабораторид хими, нян судлалын шинжилгээ хийлгэж, шинжлэгдсэн дээжийн 16.3% нь нянгийн тоо үзүүлэлтээр стандартын шаардлага хангахгүй гарсан нь өмнөх жилийнхтэй харьцуулахад хяналт шинжилгээнд хамруулсан дээжийн тоо 565-аар, шаардлага хангахгүй дээжийн эзлэх хувь 6.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлтэй гарсан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 сард татан буулгаж салбарын хяналтыг харьяа төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн. Харин Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Нийслэлийн төв лаборатори болон аймаг орон нутгийн хүнсний лабораториудыг Шадар Сайдын харьяа Стандарт, хэмжил зүйн газрын дэргэд байхаар салбарын хяналтаас салган шилжүүлсэн байна. Энэхүү бүтцийн өөрчлөлтөөс үүдэн улсын хэмжээнд хүнсний хяналтын үйл ажиллагаа доголдож, удирдлагын босоо тогтолцоо алдагдсанаас салбарын хяналтын газрууд болон лаборатори хоорондын хамтын ажиллагаа саарч, үйл ажиллагааны уялдаа холбоо доголдсон, лабораторид шинжлүүлдэг шинжилгээний дээжийн тоо, давтамж буурсан, шинжилгээний төлбөрийн асуудал үүссэн зэрэг сөрөг үр дагаврууд бий болсон нь энэхүү хуулийн зорилт бүрэн хангагдаагүй байна.

Харин эрүүл мэндийн хяналт Эрүүл мэндийн яаманд шилжин ирж эрсдэлийн үнэлгээ хийх хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлийн 3 эрсдэлийн шалгуурыг шилэн хяналтын системд угсарч эрсдэлийн үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлсэн. Шилэн хяналтын системд бүртгэлтэй нийт объектод 2 жил тутам нэг удаа эрсдэлийн үнэлгээ хийж баталгаажуулан, их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, Хяналт, үнэлгээний үндэсний хороонд (2023 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт) жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэн батлуулж байна.

Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1а/4452 дугаар албан бичгээр Хяналт үнэлгээний үндэсний хороонд хүргүүлж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. 2025 онд “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх объектын жагсаалт”-ыг ЭМС-ын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/496 дугаар тушаалын хавсралтаар батлуулаад байна. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газраас объектыг хяналт шалгалтад хамруулах давтамжийн хугацаа, “Улсын байцаагчийн жилийн ажлын хөдөлмөрийн жишиг норматив”, “Нэг объект шалгахад зарцуулах хугацааны норматив”, “Нэг объектын гүйцэтгэлийг шалгахад зарцуулах хугацааны норматив”-ийг боловсруулан ЭМС-ын 2024.07.03-ны өдрийн А/309 дүгээр тушаалаар батлуулж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар-т хүргүүлэн мөрдөн ажиллаж байна.

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх аргачлал, төлөвлөлтийг эргэж харан боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5.-д “Хяналтын байгууллага дор дурдсан үйлдвэрлэлийг шинээр эрхлэх хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Хүнсний тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд 2013-2022 онд мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэх, нялх, балчир хүүхдийн хүнс үйлдвэрлэл, цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудсыг гаргаж, хяналт шалгалт хийн дүгнэлт гарган ажиллаж байсан.

2018 онд мах, махан бүтээгдэхүүний 16 үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүний 3 үйлдвэрлэл шинээр эрхлэхэд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргасан байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр өөрчлөлт оруулснаар Ерөнхий боловсролын сургуулийн цайны газрын түрээслэгч солигдох бүрд НМХГ-т хандан ажлын байрны дүгнэлт гаргуулж ажиллаж эхэлсэн бөгөөд 2018 онд улсын хэмжээнд цэцэрлэг, ЕБС-ийн нийт 36 хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргасан байсан байна.

Харин 2023 оноос эхлэн Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын Улсын Ерөнхий байцаагч нарийн хамтран баталсан удирдамжийн дагуу аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, ХХөдөө аж ахуйн газрын хяналтын нэгж урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. Харин хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нарыг цахим /lgov.mn/ бүртгэлийн системд

бүртгэдэг байдал нь татан буугдсан Мэргэжлийн хяналтын байгууллагын нэр дээр бүртгэдэг, хяналтын улсын байцаагч нарт тус системд нэвтрэх эрх байхгүй, цахим системд бүртгэгдсэн үйл ажиллагаа эрхлэгч нар мэдээлэл давхардуулан оруулсан, үйл ажиллагаа зогсоосон, мэдээлэл буруу оруулсан байдлыг шалгах, бүртгэх боломжгүй, тус хуулийн 6.5 дахь заалтад заагдсан улсын байцаагчийн ажлын байранд гаргасан дүгнэлтийг оруулдаггүй зэрэг олон асуудлууд байгаа нь хяналтын байгууллагаас суурь судалгаа хийгдэхгүй болсон байна.

Гэсэн хэдий ч хяналт шалгалтаар улсын хэмжээнд 2024 онд “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас” хяналтын хуудсаар “бага” эрсдэлтэй дүгнэгдсэн 24 газарт дүгнэлт гаргасан байна. (цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд 10, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлд 14 дүгнэлт) их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3 газарт шаардлага хангаагүй дүгнэлт гарсан байна.

2019-2022 онд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тайлан мэдээлэл Улсын архивд байгаа гэж, мөн тухайн үед ажиллаж байсан улсын байцаагчид ихэнх нь ажлаас гарсан гэсэн тайлбарыг салбарын хяналтын газраас өгсөн тул хуулийн хэрэгжилтэд үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл хязгаарлагдмал байсан. Энэ байдал үргэлжилбэл төрийн үйл хэргийн ой санамж, залгамж халаа алдагдах эрсдэлтэй гэж үзэж байна.

Хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж буй аймаг, нийслэлийн ХХөдөө аж ахуйн газрын хяналтын хэлтсийн хүнсний чанар, стандарт, ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч, аймаг, нийслэлийн Эрүүл, мэндийн газрын хяналтын хэлтсийн хүнсний хяналт хэрэгжүүлэгч эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын махны чанар аюулгүй байдалд хяналт хэрэгжүүлж буй мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарыг нэгтгэсэн агентлаг, хяналтын байгууллага байгуулж, иргэдээс ирүүлж буй өргөдөл гомдол, төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг мэргэжлийн түвшинд түргэн шуурхай хийж, асуудлыг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэхэд ач холбогдолтой байна гэсэн саналыг хүнсний хяналтын байцаагчдын зүгээс тавьж байна.

Энэ хуулийн 6.5.1.-6.5.2.-д заасны дагуу 2019-2024 оны байдлаар 124 ахуйн нэгж, иргэний мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл шинээр эрхлэхэд дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүлээн авч, хуульд заасан хугацааны дотор 100 хувь шийдвэрлэсэн байна. Хяналтын хуудасны үнэлгээгээр “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн 81 үйлдвэрт эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангаж байгаа тухай улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтын биелэлтийг ханган ажилласан байна.

2019-2024 оны байдлаар ахуйн нэгж, иргэний сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл шинээр эрхлэхэд дүгнэлт гаргуулах 21 хүсэлтийг хүлээн авч, хамтарсан хяналт шалгалтаар эрүүл ахуйн хяналтын хяналтын хуудсаар “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн 20 үйлдвэрт Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR 2:2011-ийн эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа тухай улсын байцаагчийн дүгнэлт үйлдсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дах заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Салбарын ерөнхий байцаагчийн

баталсан “Мах махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдийн хүсэлтээр төлөвлөгөөт бус (үйл ажиллагааны дүгнэлт гаргах) хяналт шалгалт хийх” 2023 оны удирдамжийн хүрээнд 9 аймаг, нийслэлийн 29 аж ахуйн нэгж, иргэдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу мал төхөөрөх 6, мах, махан бүтээгдэхүүн, бууз баншны 12, сүү, сүүн бүтээгдэхүүний 8, зайрмагийн 1, бусад чиглэлийн 2 газарт урьдчилсан хяналтыг хийж, батлагдсан хяналтын хуудасны дагуу эрсдэлийг үнэлэхэд их 5, дунд 2, бага эрсдэлтэй 19 объект үнэлэгдсэн байна. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалтад нийцсэн, стандарт шаардлагыг хангасан талаарх улсын /ахлах/ байцаагчийн нийт 19, хангаагүй 1 дүгнэлт гаргаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Нийт 30 хүсэлт ирснээс 7-д татгалзсан байна.

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран хүнсний үйлдвэрлэл шинээр эрхлэгч 110 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулан холбогдох хууль тогтоомжийн талаар болон хяналтын нэгжид бүртгүүлэх, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл мэдээллийг танилцуулж, шинээр батлагдсан техникийн зохицуулалтыг мөрдөх, зохистой дадлыг хэрхэн хэвшүүлэх талаар зөвлөмж мэдээлэл өгч, сургалт явуулж мэдлэг мэдээллээр ханган ажилласан гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан.

Мөн 2023 онд салбарын ерөнхий улсын байцаагчийн баталсан “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж болон малын эм хангамжийн байгууллага, өлөн гэдэсний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдийн хүсэлтээр хийгдсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд салбарын хяналтын газар, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт ирүүлсэн “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж болон малын эм хангамжийн байгууллага, өлөн гэдэсний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдийн хүсэлтээр”-ээр 9 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл эрхлэх объектын байршил, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн дамжлага, мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах, тээвэрлэх үеийн мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл, шаардлага, температурын горим, мэргэжлийн боловсон хүчин /малын эмч/-тэй эсэх, тэдгээрийн холбогдох бичиг баримтын бүрдэлд урьдчилсан хяналт шалгалт хийж, 7 аж ахуйн нэгжид үйл ажиллагааны дүгнэлт гаргаж, 2 аж ахуйн нэгж нь стандартын шаардлага хангахгүй байсан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5.3 дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд 2019-2024 онд Нялх балчир, бага насны, цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл шинээр эрхлэх үйл ажиллагаа явуулах нийт улсын хэмжээнд 212 газраас хүсэлт ирүүлсний дагуу хяналт шалгалт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 187 объектод улсын байцаагчийн дүгнэлт гаргаж ажилласан байна.

Үүнээс 2024 онд Нялх балчир, бага насны, цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл шинээр эрхлэх үйл ажиллагаа явуулах 6 аймгийн 22, нийслэлийн 9, нийт улсын хэмжээнд 31 газраас хүсэлт ирүүлсний дагуу хяналт шалгалт хийж, давхардсан тоогоор нийт 116 зөрчил дутагдал илрүүлж, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод албан шаардлага хүргүүлж, 1 объектод гүйцэтгэлийн хяналт

хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул нийт 30 объектод улсын байцаагчийн дүгнэлт гаргаж, гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдаагүй дунд эрсдэлтэй 1 объектод дүгнэлт гаргаагүй байна. 31 сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн газруудад “Цэцэрлэг болон сургуулийн бага ангийн сурагчдын хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийх хяналтын хяналтын хуудас”-аар үнэлэхэд 29 буюу 93.5 хувь нь бага, 2 буюу 6.4 хувь нь дунд эрсдэлтэй үнэлэгдэж, гүйцэтгэлийн шалгалтаар 1 объектын эрсдэлийн түвшин буурч, хууль тогтоомжийн хэрэгжилт 86.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 7.6 хувиар дээшилсэн, эрсдэл үүсэх магадлал 13.7 хувьтай байсан байна.

Салбарын хяналтын газраас жил бүр холбогдох удирдамжийг батлан гаргаж, түүний дагуу аж ахуйн нэгж, иргэдийн өргөдөл, хүсэлтийн дагуу урьдчилсан хяналт шалгалтыг хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Тухайлбал, НЭрүүл мэндийн газар-2024 онд Нялх балчир хүүхдийн хүнсний үйлдвэр, цехийн үйл ажиллагаа явуулах 1 хүсэлт хүлээн авсан боловч хяналт шалгалтын удирдамж, хяналтын хуудас батлагдаагүй тул хүсэлийг буцаасан байна. 2025 онд Нялх балчир хүүхдийн хүнсний үйлдвэр, цехийн үйл ажиллагаа явуулах нэг хүсэлт хүлээн авч улсын /ахлах/ байцаагчийн ажлын байрны дүгнэлт гаргасан байна.

Энэ хуулийн 6.6-д заасны дагуу хяналтын байгууллага дүгнэлт гаргаагүй тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч үйлдвэрлэлээ эхлүүлэх эрхтэй гэж заасан. Хяналтын байгууллага шинээр эрхлэх хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн доторх хугацаанд дүгнэлт гаргаагүй тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч үйлдвэрлэлээ эхлүүлсэн зарим тохиолдол гарсныг дурьдвал сургуулийн цайны газрын сонгон шалгаруулалт оройтсоноос дүгнэлт гаргаагүй байхад сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ зайлшгүй шаардлагаар эхлэх нөхцөл байдал үүсэж байсан байна. Хүнсний тухай хуульд хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаанд заавал зохистой дадлыг мөрдөхөөр заасан боловч энэ заалтын хүрээнд харин эсрэгээрээ хүнсний баталгаат байдал хангах урьтал нөхцөл хангагдсан эсэхийг үл хамааран тухайн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаагаа шууд эхлүүлэх эрх нээж өгч байгаа нь Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль хооронд зохицуулалтын зөрчилтэй буюу нийцлийг хангах үүднээс **энэ заалтыг хасах шаардлагатай гэж үзлээ**. Учир нь дүгнэлт гаргаагүй тохиолдолд үйлдвэрлэл эхлүүлснээр хүнсний аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл үүсэх өндөр магадлалтай.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.7-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт, түүнийг боловсруулах, үйлдвэрлэх нөхцөл, шаардлагыг техникийн зохицуулалтад тусгана гэсэн заалтын хэрэгжилтийг төрийн байгууллагын төлөөллүүд харилцан адилгүй үнэлсэн бөгөөд 2013-2018 оны дунджаар 30 хувь, 2019-2024 онд 50 хувьтай байна гэжээ.

Засгийн газрын 2008 оны 159 дугаар тогтоолоор баталсан “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт MNTR 1:2008”, Засгийн газрын 2011 оны 305 дугаар тогтоолоор баталсан “Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”, Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор баталсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн

зохицуулалт”, Засгийн газрын 2011 оны 304 дүгээр тогтоолоор батлагдсан Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR 2:2011 болон 206 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх ЗГ-ын 2025:02:05-ны өдрийн 69 -р тогтоолоор батлагдсан Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтуудад тус тус хуулийн 6.5-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт, түүнийг боловсруулах, үйлдвэрлэх нөхцөл, шаардлагыг тусгасан нь **энэ хуульд заасан 2 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний техникийн зохицуулалт батлагдсан байна.**

Цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хоол үйлдвэрлэлд зориулсан үйлдвэрлэх нөхцөл, шаардлагыг тусгасан техникийн зохицуулалт байдаггүй. “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага” MNS 4946:2019-ыг шинэчлэхдээ цэцэрлэг, сургуулийг хамрах хүрээнээс хассан байна. Цаашид сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг заавал дагаж мөрдүүлэхээр, мөн хоол үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүн, туслах материалд тавигдах аюулгүйн үзүүлэлтүүдийн шаардлагын хэм хэмжээг тогтоосон эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх хүрээнд Засгийн газрын 2018 оны 235 тогтоолыг хэрэгжүүлэх бодит ажил бий болгоход яам, агентлагууд хамтран ажиллах шаардлагатай байна. Энэхүү тогтоолд дурьдсан “Цэцэрлэг, сургуулийн орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах” техникийн зохицуулалтыг яаралтай гаргах нь зүйтэй.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас үйлдвэрлэлийн бус уламжлалт аргаар боловсруулсан сүү, цагаан идээ боловсруулахад урьдчилсан хяналт хийж дүгнэлт огт гаргаагүй байна. **Энэ хуулийн 6.8.-д** Уламжлалт аргаар сүү, цагаан идээ боловсруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 6.5 дахь хэсэг хамаарахгүй гэж заасан байдаг. Гэтэл Хүнсний тухай хуульд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд зохистой дадлыг заавал мөрдөж, өөрийн үйлдвэрлэж, үйлчилж, түгээж байгаа хоол, хүнснийхээ баталгаат байдлыг хариуцахаар хуульчилсан. Энэ 2 хуулийн зохицуулалтууд нь өөр хоорондоо эсрэг утгыг илэрхийлж хоёрдмол агуулгатай байгаа тул **энэ заалтыг эргэн харах хэрэгтэй гэж үзлээ.** Учир нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгааг хангах урьтал нөхцөлийг бүрдүүлж хэрэглэгчдэд баталгаатай хоол, хүнсээр үйлчлэх нөхцөл бүрдэх юм.

Хуулийн 6.9.-д заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн бүртгэлийг тогтмол ажиллуулахгүй байгаагаас тухайн үйлдвэрлэгч, хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэл, шилжилт хөдөлгөөнд өөрчлөлт орсон талаарх мэдээлэл нэгдсэн бүртгэлийн санд тухайн цаг хугацаанд динамик хэлбэрээр бүртгэгддэггүй байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг сайжруулах, төрийн байгууллага хоорондын хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээлэл харилцан солилцох, мэдээллийн нэг урсгалын тогтолцоотой болох, бүртгэлийн нэгдсэн санг оролцогч талууд бүрэн ашиглах нэн шаардлагатай байна.

Хүнсний сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч нарын мэдээллийг жил бүр шинэчилдэг программын тохиргоо хийх, хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар үйл

ажиллагаа түр болон бүрмөсөн зогссон газруудыг автоматаар хасагддаг болгох бүртгэл мэдээллийн үнэн зөв бодит байдлыг хангах шаардлагатай байна.

Бүртгэлийн системийг шилэн хяналтын системтэй холбох, бүртгэлийн системд бүртгэгдсэн объектын мэдээлэл, жагсаалтыг холбогдох төрийн байгууллагууд ашигладаг, нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, хяналт хэрэгжүүлж буй байгууллага, улсын байцаагч нарыг бүртгэлийн системийг ашиглах боломжоор хангах нь төрийн үйл хэргийг тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Мөн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарын итгэмжлэгдсэн лабораторид өгсөн шинжилгээний сорилтын дүн зэрэг гарсан тохиолдолд хяналт хэрэгжүүлэгч байгууллага, улсын байцаагч нарт мэдээлэл, дохио ирдэг зэрэг хүнсний аюулгүй байдал алдагдсан тохиолдол бүрийг шуурхай хүлээн авах боломжоор хангах тогтолцоог бүрдүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй байна.

2.2.2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйл. Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр

Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ” гэсэн заалтын хэрэгжилт маш хангалтгүй түвшинд байна гэж үнэллээ. Хуулийн энэ заалтын хэрэгжилтийн хүрээнд зарим хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлсэн ч түүнийг баталгаажуулах итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагыг төрийн зүгээс бойжуулах, түүнийг бий болгох үйл явц маш удаан байгаа нь энэ үнэлгээнд шууд нөлөөлсөн гэж үзэж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 156 дугаар тушаалаар зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийг баталсан. Энэ хүрээнд хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нийтлэг зөвлөмжийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2013-2018 онд хүнсний үйлдвэр эрхлэгчдэд тогтмол сургалт зохион байгуулдаг байсан боловч энэ **хууль хэрэгжиж эхэлснээс хойших нийт 13 жилийн хугацаанд огт хэрэгжээгүй заалт бол энэ заалт юм.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас энэ чиглэлийн сургалт, соён гэгээрүүлэх ажлыг огт хийдэггүйг онцгой анхаарах хэрэгтэй байна.

Хоол үйлдвэрлэлийн салбарт Эрүүл ахуйн зохистой дадлыг /GHP/ хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулсан боловч батлуулаагүй байна. Зохистой дадал нэвтрүүлэх зохицуулалт нь хоолны газрын зэрэглэл тогтоох зохицуулалттай зэрэгцэж хэрэгжихээр төлөвлөж байсан.

Тухайн үед Стандартчилал хэмжил зүйн газар болон Үндэсний итгэмжлэлийн газраас зохистой дадлыг нэвтрүүлснийг баталгаажуулах итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагыг бойжуулаагүй, энэ чиглэлийн байгууллага байгаагүй хэдий ч Мэргэжлийн хяналтын ерөнхий газар энэ чиг үүргийг хэрэгжүүлж байжээ. Тухайлбал, 2017-2018 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага нь үйл ажиллагаандаа эрүүл ахуй зохистой

дадал нэвтрүүлсэн байх ХБАБХТХ-ийн 10.1.2 дахь заалтын хэрэгжилт хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд 70 гаруй хувь, хүнсний худалдаа эрхлэгчдэд 65.7 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 67.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж байгаа Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд гишүүн орнуудын хүнсний аюулгүй байдлын стандартчиллыг боловсронгуй болгох, худалдааг хөнгөвчлөх төслийн хүрээнд хүнсний боловсруулах салбарт Үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/, HACCP нэвтрүүлэх талаарх арга зүйн сургалтыг 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулжээ. Энэ сургалтын хүрээнд хүнсний боловсруулах салбарт үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх нь цаг хугацаа, хөрөнгө оруулалт шаарддаг талаар онцлон тэмдэглэж байсан. Иймд улс орнууд хүнсний боловсруулах салбартаа үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд тодорхой туршилтын хугацааг товлон, энэ хугацаанд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүжилтийн нэн хөнгөлөлттэй нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны удирдамжийн хүрээнд нийт 567 хүнсний худалдааны газраас 479 газар буюу 84.4 хувь нь төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хяналтын хуудсаар хийхэд 76 буюу 16 хувь нь их, 204 буюу 42.9 хувь нь дунд, 199 буюу 41.8 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын тайланд дурдсан байна.

2023 оноос салбарын хяналтын газраас хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаанд зохистой дадал нэвтрүүлсэн эсэхэд хяналт шалгалт хийсэн талаар хяналт шалгалтын мэдээ байхгүй байсан бөгөөд зөвхөн эрсдэлийн түвшинг тогтоосон тухай тайлан, тоон мэдээ гаргасан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.1.1.-7.1.3.-д “хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал”, “хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал” “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал”-ыг тус тус нэвтрүүлэхээр заасан. Гэтэл хууль хэрэгжиж эхэлснээс хойш 6 жилийн дараа 2018 оны 06 дугаар сарын 31-ны өдрийн Стандартчиллын үндэсний зөвлөлийн 20 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн зохистой дадал /ХААБЗД/ хэрэгжүүлэх удирдамж MNS6737:2018 стандартыг баталсан. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх хуулийн заалтын хэрэгжилт 2013-2018 оны дунджаар 29.48 хувьтай байсан бол 2019-2024 онд 10 хувьтай үнэлэгдсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын дарга, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 онд намрын ургац хураалт, ургацын чанарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн байна. Тус хяналт шалгалтыг 16 аймаг, нийслэлийн 28 улсын/ахлах/ байцаагч хяналт тавьж ажиллажээ. 2023 онд улсын хэмжээгээр 339.5 мянган га-д үр тариа, үүнээс 316.9 мянган га-д улаан буудай, 18.3 мянган га-д төмс, 13.4 мянган га-д хүнсний ногоо, 101.7 мянган га-д малын тэжээл, 121.4 мянган га-д тосны ургамал, 7.0 мянган га-д жимс,

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

жимсгэнэ, нийтдээ 601.3 мянган га-д тариалалт хийсэн байна. Ургацын нийт дүнгээр 510.0 мянган тонн үр тариа, үүнээс 480.0 мянган тонн улаан буудай, 165.0 мянган тонн төмс, 165.7 мянган тонн хүнсний ногоо, 64.8 мянган тонн тосны ургамал, 225.6 мянган тонн малын тэжээлийн ургамал, 5.0 мянган тонн жимс жимсгэнэ тус тус хураан авах боломжтой гэсэн төлөв гарсан. Цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлын улмаас ургац хураалт 7-10 хоног хойшилсон үүнээс болж ангилсан болон босоо тарианд дахин соёололт үүссэн, чанарт нөлөөлсөн байна. Тухайлбал: босоо болон ангилсан тариа хураахад соёололт үүссэн, цавуулаг багасаж, чийг өссөн, тарианы хольц өндөрссөн, эзлэхүүн жин буурсан байгаа нь Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас тайлбар өгсөн. Тариаланчдын ургацыг шинжилж буй гурилын үйлдвэрүүдийн лабораториудын харилцан адилгүй шинжилгээний дүнгээс шалтгаалан борлуулалтад сөргөөр нөлөөлсөн. Нийт борлогдоогүй улаан буудайн 30 хувь буюу 36917,4 тонн нь түрүүн дээр соёолсон, үлдэгдэл 70.0 хувь буюу 86140.6 тонн нь тарианы хольц цэвэршилт, эзлэхүүн жин чийгээрээ хүнсний улаан буудайн стандартын шаардлага хангаагүй байсан байна.

Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 онд баталсан удирдамжийн дагуу хийсэн хяналт шалгалтын дүнгээр 21 аймаг, нийслэлийн ХХөдөө аж ахуйн газарт цахим болон цаасаар хүргүүлж, улсын хэмжээнд өвс 18,796 тонн бэлтгэхээс 94,5 хувь, тэжээл 12,420 тонн бэлтгэхээс 79,1 хувь буюу дунджаар 86,8 хувийн гүйцэтгэлтэйгээр бэлтгэсэн байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших 7 дахь жилд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, ЭМ сайд нарын 2019 оны 05 сарын 29-ны өдрийн хамтарсан А/166, А/251 дугаартай тушаалаар “Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ыг баталсан байна.

Хүнсний аюулгүй байдал, хүнсний баталгаат байдлыг хангах төрийн бодлого, суурь хууль тогтоомжийн хүрээнд дагаж гарах зайлшгүй шаардлагатай эрх зүйн орчныг цаг хугацаанд нь бүрдүүлдэггүйгээс салбарын бодлогын хэрэгжилт удаашралтай байна.

Хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлд зохистой дадлыг нэвтрүүлээд 13 жил болсон бол өнөөдөр хүнс, хөдөө аж ахуйн салбарт үүсээд байгаа улаан буудайн чанарын асуудал, малын гоц халдварт өвчний гаралт, тархалтын асуудал, малын үр шимийн асуудал, хөрс, ус, орчны бохирдол мөн хоол хүнсээр дамжих пестицид, антибиотикийн үлдэгдлийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдчихсэн, улмаар үүний үр дагавраар бий болж буй хүн амын дундах хоол хүнснээс гаралтай халдварт болон халдварт бус өвчлөл, нас баралт буурсан байх учиртай. Гэтэл 13 жилийн өмнө ярьж, хэлэлцэж байсан асуудал өнөөдөр мөн адил байгаа нь салбарын яаманд салбарын бодлогыг цогцоор харах, түүнийг төлөвлөх, холбогдох төсвийн хуваарилалтыг тэгш хүртээмжтэй хуваарилах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг цогц байдлаар хэрэгжүүлэх, түүнийг шийдвэрлэхэд мэргэжлийн хяналт, мэргэжлийн удирдлага алдагдсаныг илтгэж байна.

Хүнсний сүлжээний анхан шатын үе шат болох жимс, жимсгэнэ, хүнсний ногоо тариалагчид үйл ажиллагаандаа зохистой дадлыг мөрдсөнөөр хүнсний дараагийн үе шатанд чанар, аюулгүй байдлыг хангасан хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгдэж зорилго

хангагдана. Тариалан эрхлэгчдийн хувьд амьдралд нийцэх боломжтой. Учир нь уг дадлыг хэрэгжүүлэхэд пестицид бордоог зохистой тун нормоор хэрэглэж ургацыг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдал алдагдахгүй байх боломжтой юм. Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш одоогийн байдлаар нийслэлийн хэмжээнд 8 иргэн, аж ахуйн нэгж ХААЗД-ыг нэвтрүүлснийг хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан байна.

Гэсэн хэдий ч Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн хяналтын хэлтсээс хүнсний сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч нарт үйлдвэрлэлийн зохистой дадлыг үйл ажиллагаандаа мөрдүүлэхтэй холбоотой сургалтыг жил бүр хяналтын чиглэл тус бүрээр зохион байгуулж ажилласан байна. Нийслэлд үйл ажиллагаа нь жигдэрсэн, дунд болон томоохон хүнсний үйлдвэр, худалдаа, үйлчилгээний газрууд, франчайзингийн эрхтэй сүлжээ дэлгүүр, хоолны газруудад ЗГ-ын 311-р тогтоолоор батлагдсан аж ахуйн үйл ажиллагааны дотоодын хяналтын журмыг батлуулан, үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлж хэвшүүлсэн сайн жишээ байх боловч нийслэлийн нутаг дэвсгэрт хүнсний сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч нарын дийлэнх хувийг жижиг ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүд, иргэд үйл ажиллагаа явуулдаг тул зохистой дадлыг нэвтрүүлсэн байдлын хэрэгжилт хангалтгүй байна.

Хүнсний тухай хуулийн 10.1.1 болон **Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.1.2, 7.1.3 дах заалтыг** үндэслэл болгон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулж хүнсний чанарын удирдлагын тогтолцооны угтвар нөхцөл болох зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар, салбарын хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор цахим болон танхимын хэлбэрээр, аж ахуйн нэгжийн байранд зохион байгуулж ажилласан байна. 2018-2024 оныг дуустал 45 удаагийн сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөөнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нийт 3907 төлөөллийг хамруулсан байна.

Энэ заалтын хэрэгжилтийг хангах баталгаажуулалтын тогтолцоо хууль хэрэгжиж эхэлснээс хойших 13 жилийн хугацаанд бүрдээгүйгээс хэрэгжилт хуулийн анхны зорилгод хүрч чадахгүй, туйлын хангалтгүй байна. Баталгаажуулалтын тогтолцоогоор зохион байгуулагдах боломжтой энэ ажлыг 2013-2022 он хүртэл Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2023 оноос Эрүүл мэндийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас огт хийж гүйцэтгээгүй байна.

Үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлэх талаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд сургалт явуулах, мөн олон нийтэд таниулах, сурталчлах ажил хангалттай сайн хийгддэггүй, мөн хариуцлага тооцох механизм байдаггүй тул хуулийн **хэрэгжилт “30” хувьтай үнэлэгдэж байна.**

“Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд” Үндэсний статистикийн хорооноос жил бүр эрхлэн гаргадаг статистикийн мэдээнд 2018 оны байдлаар зохистой дадал нэвтрүүлж түүнийг баталгаажуулсан аж ахуй нэгж бүртгэгдээгүй байна. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлсэн байх хуулийн энэ заалтын хэрэгжилт 0 хувьтай байсныг баталгаажуулах тогтолцоо бүрдээгүй, баталгаажуулах байгууллага тодорхой бус, зохистой дадлыг нэвтрүүлэх хөгжүүлэх мэргэшсэн баг байхгүй байгаатай холбон тайлагнаж байсан байна. Гэтэл өнөөдөр энэ нөхцөл байдал мөн адил байгаа нь Стандарт хэмжил зүйн

**Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан**

газар болон Үндэсний итгэмжлэлийн газраас хуульд заасан зохистой дадлыг нэвтрүүлснийг баталгаажуулах итгэмжлэгдсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн аж ахуйн нэгжийг бойжуулаагүй, мэргэжил арга зүйгээр хангаагүй, энэ чиглэлийн мэдээ, мэдээлэл хязгаарлагдмал, мэдээллийн ил тод байдал алдагдсан, хуулийн хэрэгжилтийг хангахад огт сэтгэл гаргаагүй өнөөг хүрсэн байна гэж дүгнэж байна.

Тухайлбал, 2018 оны байдлаар улсын хэмжээнд “Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO22000 стандарт”-ыг нэвтрүүлсэн нийт 5 аж ахуй нэгж, “Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо”-г нэвтрүүлсэн нийт 6 аж ахуй нэгж бүртгэгдсэн байна. Аж ахуй нэгжүүд нь энэхүү стандарт болон тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж олон улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар тохирлын үнэлгээ хийлгүүлж баталгаажуулалт авсан байна.

2023 оны статистикийн мэдээнд Эрх бүхий байгууллагаас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон нийт 33 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас 17 аж ахуйн нэгж байгууллага хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг, 16 аж ахуйн нэгж байгууллага эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн байна. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн 16 аж ахуйн нэгж байгууллагын 2 аж ахуйн нэгж байгууллага нь 2023 онд шинээр нэвтрүүлсэн бол үйл ажиллагаандаа ISO14000 байгаль орчны менежментийн багц стандартыг нэвтрүүлсэн 3 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага байна. Харин үйл ажиллагаандаа хүнсний хог хаягдлын менежмент нэвтрүүлсэн аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдээгүй байна.

Дээрх үзүүлэлтүүдэд харьцуулалт хийхэд хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж байгууллага 2018 онд 5 байсан бол 6 жилийн дараа буюу 2023 онд 17 болж зөвхөн 12 аж ахуйн нэгж байгууллагаар, харин эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн аж ахуйн нэгж байгууллага 2018 онд 6 байсан бол 2023 онд 16 болж 10 аж ахуйн нэгж байгууллагаар тус тус нэмэгдсэн боловч энэ тоо нь улсын хэмжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага хангасан байдал, мөн хүнсний баталгаат байдал хангагдаж байгааг илэрхийлэх үзүүлэлтийнхээ хувьд чамлалттай тоо юм.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.-д заасан зохистой дадлыг үйлдвэрлэлд хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш 12 жилийн дараа ХХААХҮС, ЭМС-ын 2024.02.16-ны өдрийн А/100, А/68 дугаар тушаалаар батлуулсан байна. Тушаалын нэгдүгээр хавсралтаар “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”, хоёрдугаар хавсралтаар “Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар” тус тус батлагдаж хэрэгжиж эхлээд эхний нэг жил болж байна. Цаашид хүн амыг эрүүл, чанартай, баталгаатай хоол, хүнсээр хангах энэ хуулийн зорилгын биелүүлэхийн тулд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг үйл ажиллагааных нь цар хүрээнээс нь үл хамааран үйл ажиллагаандаа тохирох зохистой дадлын хялбаршуулсан зааврыг биш

зөвхөн стандартыг заавал мөрдүүлэхээр тусгах ёстой. Учир нь хоол, хүнсийг чанартай, баталгаатай үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, түгээхэд үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохистой дадлыг хялбаршуулах ямар ч боломжгүй. Зохистой дадал гэдэг бол хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавигдах эрүүл ахуй, ариун цэврийн хамгийн доод түвшний шаардлага буюу үйл ажиллагаа эрхлэхийн өмнөх урьтал нөхцөл юм. Үүнээс доош эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага буюу хялбаршуулах заавар гэж байх ёсгүй гэж үзэж байна. Үүнийг жишээ татан тайлбарлахад, тухайлбал ресторанд хоол үйлдвэрлэлийг эрхэлбэл тогооч, зөөгч гарын ариун цэврийг хангана, харин гадаа эсвэл гуанзанд тогооч, зөөгч гараа угаахгүй ч байж болно гэсэнтэй нэг адил юм. Иймд энэ хялбаршуулан нэвтрүүлэх зохистой дадлыг батлах гэсэн **заалтыг өөрчилж** хүнсний сүлжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрт хамаарах үе шатанд тохирох **зохистой дадлын стандартыг** боловсруулж, батлуулах, улмаар мөрдөхтэй холбоотой зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

Энэ хуулийн 7.3.-д “Хүнсний үйлдвэрлэл эрхлэгч үйл ажиллагаандаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд нөлөөлөх аюулыг илрүүлэн тогтоох, үнэлэн дүгнэх, хянан шалгах зорилгоор аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж болно” гэж заасны дагуу дараах ажлуудыг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй “Эрсдэлийн менежмент. Зарчим ба заавар. MNS ISO 31000:2017” стандартын дагуу тохирлын үнэлгээний байгууллагууд хүнсний салбарт амжилттай хэрэгжүүлж аюулгүй зэргийн үнэлэх боломжтой. Мөн Олон улсын жишгийн дагуу Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 14.7-14.9 заалтын дагуу хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд тухайн бүтээгдэхүүн аюулгүй бөгөөд холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад тохирч буйг илэрхийлэх “Аюулгүй тэмдэг” хэрэглэх журам, тэмдэг, шалгах хуудсыг боловсруулж 5 аж ахуйн нэгжид техникийн зохицуулалтын баримт бичгийн дагуу тэмдэг олгосон байна.

2013-2018 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн хяналт шалгалтын дүнгээр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмжийн хүрээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журмын хэрэгжилт 57.3-58.8 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлттэй байсан байна.

Олон улсын жишгийн дагуу Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 14.7-14.9 заалтын дагуу хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд тухайн бүтээгдэхүүн аюулгүй, холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад тохирч буйг илэрхийлэх “Аюулгүй тэмдэг” хэрэглэх эрхийг одоогоор 10 аж ахуйн нэгжид олгоод байна. Мөн аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцооны чиглэлээр Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж буй Олон улсын стандартын байгууллагаас баталсан ISO 22000, Хүнсний хууль эрхзүйн хорооноос баталсан CAC/RCP-1 стандартыг орчуулан үндэсний стандартаар батлан мөрдөж байна. 2019 оны байдлаар Стандартчилал хэмжил зүйн газраас ISO 22000 стандартыг 8 аж ахуйн нэгж, HACCP тогтолцоог нэвтрүүлсэн 7 аж ахуйн нэгж тохирлын үнэлгээнд хамрагдсан байна.

2024 оны I улирлын байдлаар эрх бүхий байгууллагаас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж гэрчилгээ олгосон 33 аж ахуйн нэгж байгууллага байна. Үүнээс 16 аж ахуйн нэгж эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо НАССР нэвтрүүлсэн байна. НАССР тогтолцоог нэвтрүүлэх эсэх нь сайн дурын үндсэн дээр хийгддэг, мөн цаг хугацаа санхүү, хүний нөөцийн чадамжийг ихээхэн шаарддаг тул баталгаажуулалт хийлгэсэн аж ахуйн нэгж цөөхөн байгаа тухай Нийслэлийн хөдөө аж ахуйн газрын тайланд дурдсан байна.

Цаашид ISO 22000, CAC/RCP-1 олон улсын стандартуудыг аж ахуйд нэвтрүүлэхэд холбогдох яам, агентлаг, МХАҮТ хамтран сургалт, сурталчилгаа хийх шаардлагатай байна. Мөн Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй “Эрсдэлийн менежмент. Зарчим ба заавар. MNS ISO 31000:2017” стандартын дагуу хүнсний үйлдвэрүүдэд эрсдэлийн үнэлгээ хийх, аюулгүйн зэргийг үнэлэх боломжийг бүрдүүлэх боломжтой юм.

2.2.3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах

Энэхүү заалтын хэрэгжилт 30 хувьтай буюу маш хангалтгүй байгаа бөгөөд хадгалах хугацаа дууссан, чанар байдлаа алдсан хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалах зөрчил Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн дунд арилахгүй байна. Хяналтын байгууллагаас ямар шийдвэр гардаг, шийдвэрийн дагуу худалдан авалтыг яг зогсоодог эсэх эсвэл худалдааг үргэлжлүүлэн хийдэг эсэх эргэлзээтэй байсаар байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлд “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах”-тай холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг. Энэ хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам”-ыг ЗГ-ын 2013.05.18-ны 172 дугаар тогтоолоор батлуулжээ.

Хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд 2014-2017 онд Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнд үндэслэн гарсан хяналтын байгууллагын шийдвэрээр нийт 1493 кг, 3388.6л, 22267 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг татан авахуулах арга хэмжээ авсан байна.

Энэ хуулийн 8.1.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл тэдгээрийг хүнсний сүлжээнээс буцаан авна” гэж заасны дагуу хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг шалгах мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, зайрмаг, гурил, гурилан бүтээгдэхүүн, кремт бүтээгдэхүүн, архи спирт, ундаа, жүүс, ус рашаан, нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд хяналт шалгалт хийсэн хяналтын хуудсанд **Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18 дахь заалтын** хэрэгжилт хууль хэрэгжиж эхэлснээс хойших эхний 6 жилийн дунджаар 63.1 хувьтай, 2018 оныг 2013 онтой харьцуулахад 9.5 хувиар буурсан байна.

Харин мөн онуудад хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлд мал эмнэлгийн чиглэлээр гахайн аж ахуй, өрхийн гахайн аж ахуй, шувууны аж ахуй, өрхийн шувууны аж ахуй, сүүний чиглэлийн мал аж ахуй, мах эхлэн боловсруулах үйлдвэрлэл, мал

төхөөрөх үйл ажиллагаа, өлөн гэдэс боловсруулах үйлдвэрлэл, мал, амьтны гаралтай түүхий эдийн хадгалалт, махны хадгалалтын нөхцөлийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар хийсэн хяналт шалгалтын дүнгээс авч үзэхэд хууль тогтоомжийн хэрэгжилт хууль хэрэгжиж эхэлсэн эхний 6 жилийн дунджаар 44.3-80.6 хувьтай байна. Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл өрхийн шувууны аж ахуй, мал төхөөрөх үйл ажиллагаа, махны хадгалалтын шатанд 44.3-59.0 хувьтай байгаа нь хамгийн бага хэрэгжилттэй байгаа бол мал, амьтны шилжилт хөдөлгөөн, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн шатанд 80.6 хувийн хэрэгжилттэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Хуулийн хэрэгжилтийг 2018 оныг 2013 онтой харьцуулахад гахайн аж ахуй, сүүний чиглэлийн мал аж ахуйд 2-15 хувиар буурсан байна.

Хэрэв хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хадгалалт, тээвэрлэлт, худалдааны явцад технологийн горим алдагдсан тогтоогдвол хадгалалтын үйл ажиллагаа эрхлэгч Зөрчлийн болон эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхтэй холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж оруулах саналтай байна.

2020-2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 2256 объектод хяналтын хуудасны үнэлгээгээр өөрийн хүнсний сүлжээний үе шатад түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавьж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл буцаан авах, бүртгэх шаардлага **59 хувьтай байна.**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны "Мал, амьтны эм хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаа, эмийн чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн 943 мал, амьтны эм хангамжийн байгууллагыг хамруулсан байна. Хяналт шалгалтаар нийт 1081 зөрчил илрүүлэн 489 зөрчлийг арилгуулан 45,2 хувийн хэрэгжилтийг хангуулсан байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлын хүрээнд 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн улсын ахлах байцаагчийн актаар бүхэлд нь зогсоосон тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын тайланд дурдсан.

Гадаад улсад болон дотоодын зах зээлд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болохуйц асуудал үүссэн үед холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Жишээ нь: 2023 онд Бельги Улсын Kim's chocolate үйлдвэрийн "Cachet" нэрийн бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй талаарх мэдээллийн дагуу нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 404 хүнсний худалдааны газарт хяналт тавьж ажилласан байдаг. Шалгалтаар Бельги Улсын Kim's chocolate үйлдвэрийн "Cachet" нэрийн L63100, L22343, L22302, L23067 L230685 цуврал бүтээгдэхүүнийг битүүмжлэх, татан авах ажлуудыг зохион байгуулсан байдаг.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8.3-д "Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан үндэслэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ тухайгаа нэн даруй хяналтын байгууллага, хэрэглэгчид болон тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авсан хүнсний сүлжээний дараагийн шатны үйл ажиллагаа

**Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан**

эрхлэгчид мэдэгдэнэ” гэсэн заалт байдаг ч хяналтын байгууллагад мэдээлдэггүй байсаар хууль хэрэгжиж эхэлснээс хойш 13 жил болж байна.

Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирсэн мэдээлэлд үндэслэн гаргадаг. Доорх хүснэгт 11-ээс харахад 2018 онд хяналт шалгалтын явцад хураасан хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээг 2016 онтой харьцуулахад эрс буурсан үзүүлэлт гарсан байна. Харин 2018 оны байдлаар хяналт шалгалтаар буцаасан болон татан авсан хүнсний бүтээгдэхүүн нь 2016 онтой харьцуулахад 3-4 дахин нэмэгдсэн байна. Мөн устгасан хүнсний бүтээгдэхүүн 2016 онд 2200 гаруй кг байсан бол 2018 онд ойролцоогоор 13000 кг болж нэмэгдсэн дүн гарчээ.

1 дүгээр хүснэгт. Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018
Хураасан бүтээгдэхүүн	киллограмм	654.9	5 572.5	425.3
	литр	544.5	1 574.0	489.8
	ширхэг	82 670	42 010	20 082
Буцаасан бүтээгдэхүүн	киллограмм	313.5	781.7	1443.4
	литр	115.0	214.0	440.3
	ширхэг	5 391	12 573	3 659
Татан авсан бүтээгдэхүүн	киллограмм	238.3	611.7	3 013
	литр	6.4	64.0	84.0
	ширхэг	12 869	6 030	36 151
Устгасан бүтээгдэхүүн	киллограмм	2 229.7	8 396.6	12 989.4
	литр	648.5	1 546.1	523.3
	ширхэг	82 530	39 552	67 755

Эх үүсвэр: МХЕГ

Эрүүл мэндийн яамны хяналт, шалгалтаар 2023 онд 402.8 килограмм, 29.0 литр, 12.3 мянган ширхэг бүтээгдэхүүн хураасан байна. Хяналт шалгалтаар буцаасан бүтээгдэхүүн 300.0 килограмм болж, өмнөх оноос 291.0 килограмм (33 дахин)-аар, 755.0 литр болж, 605.0 литр (5 дахин)-ээр, 1.7 мянган ширхэг болж, 1405 ширхэг (6 дахин)-ээр өссөн байна. Татан авсан бүтээгдэхүүний хэмжээ 2.6 тонн (98.3 хувь)-оор, 108.0 литр (95.6 хувь)-ээр, 4.7 мянган ширхэг (97.9 хувь)-ээр тус тус буурсан байна.

2 дугаар хүснэгт. Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан хүнсний бүтээгдэхүүний тоо, хэмжээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	Өөрчлөлт, хувиар
Хураасан бүтээгдэхүүн	килограмм	14 782.2	1 470.7	-	402.8 ²	-
	литр	1 343.0	369.1	-	29.0 ²	-
	ширхэг	55 077	16 910	-	12 251 ²	-
Буцаасан бүтээгдэхүүн	килограмм	198.8	957.6	9.0	300.0 ²	33 ¹
	литр	-	44.0	150.0	755.0 ²	5 ¹
	ширхэг	2 222	4 225	306	1 711 ²	6 ¹
Татан авсан бүтээгдэхүүн	килограмм	60.0	85.6	2 609.9	43.1 ²	-98.3
	литр	66.5	63.5	113.0	5.0 ²	-95.6
	ширхэг	1 593	4 287	4 816	99 ²	-97.9
Устгасан бүтээгдэхүүн	килограмм	3 058.4	1 317.1	666.3	15.0 ³	-97.7

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

литр	1 267.0	193.9	127.0	36 088.0 ³	284 ¹
ширхэг	63 764	17 717	6 504	11 674 ³	79.5

¹ Дахин их, ² Эх үүсвэр: ³ ЭМЯ, ³ Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар

Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар 2023 онд 15.0 килограмм, 36.1 мянган литр, 11.7 мянган ширхэг бүтээгдэхүүн тус бүр устгасан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хяналт, шалгалтаар 2023 онд 943 төрлийн 89.3 мянган ширхэг хүнсний бүтээгдэхүүн хураасан бол 98 төрлийн 1.6 мянган ширхэг хүнсний бүтээгдэхүүн татан авсан байна.

INFOSAN мэдээллийн санд 2023 онд буцаан татсан хүнсний 9075 бүтээгдэхүүн бүртгэгдсэний 6465 (71.2 хувь) бүтээгдэхүүн Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн тоог Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн тоо, мэдээнд үндэслэн гаргасан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2018 онд явуулсан хяналт, шалгалтад нийт 6188 аж ахуйн нэгж байгууллага, 4744 иргэд хамрагдаж, зөрчил гаргасан 51 аж ахуйн нэгж байгууллага, 32 иргэдийн үйл ажиллагааг зогсоож, 19 аж ахуйн нэгж байгууллага, 29 иргэдийн үйл ажиллагааг сэргээсэн байна. Хүснэгтээс харахад үйл ажиллагааг нь түр зогсоосон аж ахуйн нэгжийн тоо жил бүр буурсан байдалтай байгаа нь хяналт шалгалтад хамрагдсан нийт объектын үйл ажиллагаанд зөрчил бага илэрсэн эсвэл илрээгүй гэж ойлгогдохоор харагдаж байна. Гэтэл 2018 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас явуулсан хяналт, шалгалтаар нийт 30.6 мянган зөрчил илрүүлснээс 71.1 хувь буюу 21.8 мянган зөрчлийг арилгуулсан гэсэн статистик мэдээ гарчээ. Мөн хяналт шалгалтад хамрагдсан нийт хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдийн зөвхөн 0.67 хувьд нь зөрчил илэрч тэдний үйл ажиллагааг түр зогсоожээ. Сүүлийн үед хувь хүн нийтийн хоол үйлдвэрлэлийг гэрийн нөхцөлд эрхэлж, хяналт шалгалтад бэлдсэн дээжийг хамруулан зах зээлд худалдан борлуулах, түгээх байдал ихэссэнтэй энэхүү статистикийн үзүүлэлт уялдаж байгаа харагдахгүй байна.

3 дугаар хүснэгт. Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн тоо

Үзүүлэлт	2016		2017		2018	
	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд
Хяналтад хамрагдсан	4 785	3 072	5 290	4 850	6 188	4 744
Үйл ажиллагааг түр зогсоосон	119	44	81	49	51	32
Үйл ажиллагааг сэргээсэн	58	30	45	19	19	29

Эх үүсвэр: МХЕГ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас явуулсан хяналт, шалгалтад нийт 7.0 мянган аж ахуйн нэгж байгууллага, 5.1 мянган иргэд хамрагдаж, өмнөх оноос зөрчил гаргаж үйл ажиллагааг нь түр зогсоосон аж ахуйн нэгж байгууллагын тоо 38-аар, иргэдийн тоо 5-аар өссөн байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

4 дүгээр хүснэгт. Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн тоо

Үзүүлэлт	2020		2021		2022		2023	
	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд
Хяналтад хамрагдсан	15 179	6 711	4 075	3 661	8 313	-	6957	5064
Үйл ажиллагааг түр зогсоосон	31	49	35	37	6	-	44	5
Үйл ажиллагааг сэргээсэн	20	38	24	29	3	-	-	-

Эх үүсвэр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Иймд хувь хүн хүнсний худалдаа, наймаа эрхлэх, хууль бусаар хүнс импортлох, түүнийг худалдан борлуулах, хяналтгүйгээр түгээх, гэрийн нөхцөлд хоол хийж, худалдан борлуулж буй асуудлыг хянах, эдгээр асуудлыг илэрхийлэх статистикийн тоон үзүүлэлтийг тооцдог болоход анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2018 онд хяналт, шалгалтын явцад илрүүлсэн болон арилгуулсан зөрчил: Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас явуулсан хяналт, шалгалтаар нийт 30.6 мянган зөрчил илрүүлснээс 71.1 хувь буюу 21.8 мянган зөрчлийг арилгуулсан байна. Илрүүлсэн зөрчлийн 20.0 хувийг дотоодын хяналтын, 16.1 хувийг түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын, 14.3 хувийг хадгалалт, тээвэрлэлтийн, 12.0 хувийг сав, баглаа, боодол, хаяг, шошгын, 9.6 хувийг ариун цэвэр, эрүүл ахуйн, 9.6 хувийг барилга, байгууламжийн норм дүрмийн, 9.5 хувийг технологийн үйл ажиллагааны, 8.8 хувийг ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн зөрчил эзэлж байна. Харин эдгээр зөрчил тус бүрийн 55.0-82.5 хувийг арилгуулсан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.1, 6.9, 8.2, 8.9, 10.1.9 дэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь харьяалах нутаг дэвсгэрийн хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээллээ бүртгүүлнэ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах зэрэг заалтуудын хэрэгжилт **30 хүрэхгүй хувь** буюу хамгийн бага үзүүлэлттэй байна.

2023-2024 онд хяналт шалгалтаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа дууссан, хаяг шошгогүй гарал үүсэл нь тодорхойгүй хүнс байхад худалдаалсан, өөрийн сүлжээнээс буцаан аваагүй 11 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн арга хэмжээ авч ажилласан байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хаяг шошгын зөрчилтэй 16 нэр төрлийн 78кг 12,198,279 ширхэг 91,833,900 (ерэн нэгэн сая найман зуун гучин гурван мянга есөн зуун) төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татан авахуулж хаяг шошгын зөрчлийг арилгуулж болзошгүй эрсдэлээс сэргийлэн ажилласан байна.

Энэ хуулийн 8.2.1.-д “хоол хүнснээс шалтгаалсан өвчлөл гарсан” тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүнсний сүлжээнээс татан авна” гэж заасан байдаг.

“Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт” 2018 оны байдлаар Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт гэж ижил төрлийн хоол хүнс хэрэглэснээс үүдэн нэг

өвчний гурав ба түүнээс олон тохиолдол илрэхийг хэлнэ. 2014-2018 оны байдлаас харахад 2018 онд хоол хүнсээр дамжих өвчин хамгийн их буюу өвчний дэгдэлт 20 удаа бүртгэгдэж 624 хүн өвчилсний 263 буюу 42.1 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, хүний амь нас эрсдээгүй байна.

Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл 2018 оны байдлаар 554 тохиолдол байсан бөгөөд энэ нь нийт хордлогын 88.78 хувийг эзэлж байна. Харин химийн гаралтай хоол, хүнснээс шалтгаалсан хордлогын талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яамны зүгээс гаргадаггүй байсан. Учир нь архи, согтууруулах ундааг хүнсний бүтээгдэхүүнд тооцдоггүй гэсэн тайлбар тавьж байсан боловч сүүлийн 5 жилээс эхлэн архинд хордсон буюу химийн бодисоор хордсон хордлогын гаралт, давтамжийг тооцдог болсон.

Нөгөө талаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын ерөнхий байцаагчийн баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу Ulaanbaatar.mn цахим сайтын Онлайн бизнес төвийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ээр дүгнэлт гаргуулахаар 2024 онд 4765 хүсэлт ирснээс 3585 буюу 75,2 хувьд нь хяналт хийж 3367 аж ахуйн нэгжид улсын (ахлах) байцаагчийн үйл ажиллагааны дүгнэлт гаргаж, дунд болон их эрсдэлтэй дүгнэгдсэн талбайн хэмжээ хүрээгүй, гал тогоогүй, бичиг баримтын бүрдэл дутуу зэрэг 218 аж ахуйн нэгжид дүгнэлт гаргах боломжгүй талаар татгалзсан албан бичиг хүргүүлж, 1027 хүсэлтийг буцааж шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газарт хоолны хордлоготой холбоотойгоор ХӨСҮТ-өөс ирүүлсэн мэдээ, мэдээллийн дагуу хяналт шалгалтыг явуулж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хоолны дээж, ундны уснаас дээж авч шинжлүүлэх арга хэмжээг тогтмол авч, сорилын дүнд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа.

2013-2023 онд улсын хэмжээнд хоолны хордлогот халдварын 1091 дэгдэлт бүртгэгдэж, 5702 хүнд хордлогын шинж тэмдэг илэрсэн ба 1524 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

2024 онд 21 удаагийн дэгдэлт бүртгэгдэж, 1108 хүнд хордлогын шинж тэмдэг илэрч, 470 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, 21 дэгдэлтийн 6 дэгдэлт нь цусан суулга, 1 суулгалт халдвар, 13 нь бусад нянгаар үүсгэгдэн хоолны хордлого, 1 нитритийн хордлого байна. 2025 оны эхний 4 сарын байдлаар Өмнөговь аймгийн 3 уул уурхайн компанийн ажилчдын дунд 3 дэгдэлт бүртгэгдэж, 478 хүнд хордлогын шинж тэмдэг илэрсэн ба 313 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна гэсэн Эрүүл мэндийн яамны албаны мэдээлэл байна.

Хоолны хордлогын үед Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газар хариу арга хэмжээг ахлан ажилладаг байсныг болиулж Шадар сайдын 2023 оны А/28 тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газарт шилжүүлсэн нь мэргэжлийн удирдлагын хувьд хүндрэл бий болгож байгаа тул цаашид хүнсний хяналтын бодлого, түүний мэргэжлийн удирдлагын тогтолцоог харин эргэн харах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Энэ хуулийн 8.2.2.-д “тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага болон аюулгүйн үзүүлэлтийг хангаагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг хяналт шалгалтаар тогтоосон” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2014-2017 онд хийсэн хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлөөс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй нь 26 хувийг, сав баглаа боодол, хаяг шошгын шаардлага хангахгүй зөрчил 17.9 хувийг эзэлж байна. Харин зах зээл дээрээс санамсаргүй байдлаар дээж авч хуурамч хүнсний бүтээгдэхүүн болохыг тогтоох хяналт шалгалтын үйл ажиллагааг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойших 13 жилийн хугацаанд огт явуулаагүй байна. Иймд хуулийн **энэ заалтын хэрэгжилтийг хангалтгүй буюу 30 хүрэхгүй хувьтай байна гэж үнэлсэн**. Учир нь иргэд баталгаатай хүнсний бүтээгдэхүүнийг урт хугацаандаа хэрэглэж, хүртэх боломжоор хангагдсанаар иргэдийг эрүүл мэнд хамгаалагдана.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын 2020-2024 оны хяналт шалгалтын тайлангаар лабораторийн шинжилгээтэй хяналтаар хүнсний бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн шаардлага болон аюулгүйн үзүүлэлтийг хангаагүй зөрчлийг тогтоосон 15, буруу шошголсон 34 зөрчил илрүүлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчлийн үр дагаврыг арилгуулсан байна.

Салбарын хяналт яамны харьяанд шилжсэнээс хойших хугацаанд улсын байцаагчдын шинжилгээнд хамруулсан дээжний ерөнхий тоо буурсан, хяналт, шалгалтын үйл ажиллагааны цар хүрээ хязгаарлагдсан, хүнсний хяналтын бодлого алдагдаж, мэргэжлийн удирдлагагүй болсон байна гэж дүгнэж байна. Үүний нэг жишээ болгож тухайлбал, 2024 оны хяналт шалгалтын явцад хуульд заасныг хангаагүй 5824 ширхэг, 138 кг, 195 литр, 30,334,140 (гучин сая гурван зуун гучин дөрвөн мянга нэг зуун дөч) төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг албадлагын журмаар хурааж, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлж, шийдвэрлүүлэн ажилласан гэх тоон үзүүлэлт Монгол Улсын хэмжээнд хүнсний баталгаат байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны үзүүлэлт гэхэд хангалтгүй түвшинд байна.

Зөрчилтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах агуулах байр байдаггүйгээс тэдгээрийг хадгалах, цаашид хэрхэн шийдвэрлэх тал дээр хүндрэл бэрхшээлтэй байгаа. Тухайлбал, 2023 онд 49 нэр төрлийн 320 ширхэг, 6320 ширхэг 64.982.000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг, 2024 онд импортын 6 нэр төрлийн 49.666.900 төгрөгийн бэлэн гоймонг нэмэлт стикер наалгахаар хүнсний сүлжээнээс татан авалтыг аж ахуйн нэгжээр хийлгэж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Цаашид хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага болон аюулгүйн үзүүлэлтийг хангаагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг хяналт шалгалтаар тогтоосон тоон мэдээллийг тусгайлан гаргадаг болох шаардлагатай байна.

Энэ хуулийн 8.2.3.-д заасны дагуу импортолсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулын талаарх сэрэмжлүүлэг олон улсын мэдээллийн сүлжээгээр мэдээлэгдсэн /INFOSAN/ мэдээллийг хэрхэн хүлээн авч, импортын шаардлага хангахгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлээс татан авах үйл ажиллагааг зохицуулсан журам, заавар одоог хүртэл гараагүйтэй холбоотойгоор хүнсний

сүлжээнээс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлээс татан авах заалтын хэрэгжилт 30 хувьтай гэж үнэлсэн.

Хэдий “INFOSAN”- гийн журам батлаагүй ч Эрүүл мэндийн яамнаас 2022 онд *Salmonella Typhimurium* – халдварын тохиолдол бүртгэгдэж, *Kinder Surprise*, *Kinder Happy Moment* нэрийн шоколадан бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой байж болзошгүй” мэдээллийн дагуу 2022.04.10-ны 15 цагт Инфосангаас ирүүлсэн “database codici” экселийн produced in Arlon файлд шүүлт хийхэд нийт 56638 багц бүтээгдэхүүний мэдээлэл байгаагаас Монголд түгээгдсэн байж болох 1317 багц 13 цувралын дугаартай *Uovo Maxi Schokobons* байсан байна. Улсын хэмжээнд 1000 гаруй хүнсний худалдааны цэгээс 3065 бүтээгдэхүүнийг хамруулан тандалт судалгаанд хамруулж бохирлогдсон байж болзошгүй бүтээгдэхүүнийг зах зээлээс татан авхуулах үйл ажиллагааг зохион байгуулж инфосанд эргэн мэдээлж ажиллажээ.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас БНСУ-ын “Dongsuh Foods Corporation” компанийн “Maxim mocha gold mild” нэрийн кофе гаднын бодис орж бохирдсон талаар тус компанийн пэйж хуудсаар мэдэгдэл гаргаж татан авалт хийж байгаа гэх мэдээллийн дагуу Гаалийн Ерөнхий газарт 2023.04.06-ны өдрийн 09/1486 дугаарын албан бичгээр хандаж тус кофены импортын сүүлийн 5 жилийн мэдээллийг авч, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн байна. Импортын мэдээллээс харахад 2023 онд нэр бүхий нэг компани 3 удаа импортолж бүртгэсэн байх тул тус компанийн агуулах, хүнсний худалдааны сүлжээд хяналт хийхэд 2023 онд импортолсон БНСУ-ын “Dongsuh Foods Corporation” компанийн “Maxim mocha gold mild” нэрийн 20, 100, 170, 210 граммын ширхгээр савласан, 600 граммаар шилэнд савласан кофенуудад тус компаниас сэрэмжлүүлсэн 2024 оны 09 дүгээр сарын 19, 20, 21, 22, 26-ны өдрүүдэд дуусах хугацаатай кофе байхгүй байсан байна. Олон нийт, иргэдэд “Maxim mocha gold mild” нэрийн кофе худалдан авахдаа хадгалалтын хугацааг харж сонголтоо хийх талаар сэрэмжлүүлэг хийж ажилласан байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичгийг хадгалж буй эсэх талаар хяналтын хуудсанд тусгайлсан асуулт оруулан хянаж ажиллаж байгаа хэдий ч бодит байдал дээр INFOSAN-ийн мэдээлэл мэргэжлийн хяналтын байгууллагад тухай бүр ирдэггүй, зохицуулалт хангалтгүйн улмаас мэдээллийн ил тод байдал, мэдээлэл солилцох урсгал хязгаарлагдмал, иргэд олон нийтэд энэ талаарх мэдээлэл хангалттай очдоггүй байна. Иймд **Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8.3.-д заасан** “Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан үндэслэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ тухайгаа нэн даруй хяналтын байгууллага, хэрэглэгчид болон тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авсан хүнсний сүлжээний дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэнэ” гэх, мөн хуулийн 8.11.-д “Хяналтын байгууллага энэ хуулийн 8.2-т заасны дагуу татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ” гэсэн заалтуудын **хэрэгжилт хангалтгүй буюу 30 хүрэхгүй хувьтай байна** гэж үнэллээ.

Тухайлбал, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээнээс сав баглаа боодол гэмтсэн, задарсан, хонхойсон, хугацаа дууссан бүтээгдэхүүнийг

буцаан авсан ч мэргэжлийн хяналтын байгууллага 2022 онд татан буугдсантай холбоотойгоор эдгээр мэдээллүүд холбогдох байгууллагуудад ирээгүй талаар Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын тайланд дурдсан байна.

Шалгалтаар 2023 онд 167 нэр төрлийн 87274 ширхэг 15кг 360800л 412.770.400 төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн, 2024 онд 28 нэр төрлийн 5534 ширхэг 7тн 929кг 137,053,650 (нэг зуун гучин долоон сая тавин гурван мянга зургаан зуун тавин) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг дотоод хяналтаар нь хураан авч тухайн аж ахуйн нэгжүүдээс 11,240,0 (арван нэгэн сая хоёр зуун дөчин долоон мянган) төгрөгийг зардал гарч устгуулсан бөгөөд 143 нэр төрлийн 52554 ширхэг 930,9 кг, 37,8литр 233,052,410 (хоёр зуун гурван сая тавин хоёр мянга дөрвөн зуун арван) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн устгуулсан байна.

Энэ хуулийн 8.4.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичгийг хадгална” гэж заасан.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын хяналт шалгалтын 2019-2024 оны дүнгийн нэгтгэлээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичгийг хадгалах заалтын хэрэгжилтийн дундаж 63 хувьтай, дотоод хяналтын нэгж болон давхар санхүүгийн нэгжийн архивын баримтад хадгалсан байна.

Энэ хуулийн 8.5. дахь заалтууд “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ... хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ татан авсан тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрийг гартал хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авсан он, сар, өдрийг тэмдэглэн тухайн түүхий эд, бүтээгдэхүүнийг тусгаарлан битүүмжилж хадгална” гэж заасны дагуу хяналтын байгууллага нь холбогдох арга хэмжээг тухай бүр нь авч, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчилж, эрсдэл аюулыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

2014-2018 онд мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнгээр 54 хувьтай уг заалт хэрэгжсэн байна.

Харин 2019-2024 онд хяналтын байгууллагын хяналт шалгалтын явцад хадгалах болон хэрэглэх хугацаа дууссан, лабораторийн шинжилгээгээр шаардлага хангахгүй дүнтэй гарсан, хадгалалт тээвэрлэлтийн нөхцөл алдагдаж бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал алдагдсан болон олон улсын сүлжээгээр хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээр зарлагдсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ХЧҮАЭ-д тэмдэглэл үйлдэн тусгаарлан хадгалж, улсын байцаагч тухайн бүтээгдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын орон тооны бус зөвлөлд шилжүүлэн шийдвэрлүүлтэл тусгаарлан хадгалдаг байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.-д “Хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг энэ хуулийн 8.10-т заасан журмын дагуу устгана” гэж заасны дагуу Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 172 дугаарт тогтоолоор “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

боловсруулах журам”, “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах үйл ажиллагааг бүртгэх, мэдээлэх маягт”-ыг баталсан байна. Хэрэгжилт хангалттай гэж дүгнэсэн.

Энэ хүрээнд хяналт шалгалтын явцад хүний амь нас, эрүүл мэндэд аюултай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг улмын байцаагч хураан авч, аймаг, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын орон тооны бус зөвлөлд хүргүүлэн шийдвэр гаргуулан устгадаг байна. 2014-2017 онд мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын явцад нийт 17697,4 кг, 4841,9 литр, 144973 ширхэг хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах арга хэмжээ авахуулсан байна.

Шалгалтаар 2023 онд 167 нэр төрлийн 87274 ширхэг 15кг 360800л 412.770.400 төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг Нийслэлийн засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн, 2024 онд 28 нэр төрлийн 5534 ширхэг 7тн 929кг 137,053,650 (нэг зуун гучин долоон сая тавин гурван мянга зургаан зуун тавин) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг дотоод хяналтаар нь хураан авч тухайн аж ахуйн нэгжүүдээс 11,240,0 (арван нэгэн сая хоёр зуун дөчин долоон мянган) төгрөгийг зардал гарч устгуулсан бөгөөд 143 нэр төрлийн 52554 ширхэг 930,9 кг, 37,8литр 233,052,410 (хоёр зуун гурван сая тавин хоёр мянга дөрвөн зуун арван) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг Нийслэлийн засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн устгуулж ажилласан хэдий ч хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтэд өртсөн хүний тоо 2018 онд 624 байсан бол 2023 онд 683 болсон буюу өвчний дэгдэлтэд өртөж өвчилсөн хүний тоо буураагүй байна.

Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт гэж ижил төрлийн хоол хүнс хэрэглэснээс үүдэн нэг өвчний гурав ба түүнээс олон тохиолдол илрэхийг хэлнэ. 2014-2018 оны байдлаас харахад 2018 онд хоол хүнсээр дамжих өвчин хамгийн их буюу өвчний дэгдэлт 20 удаа бүртгэгдэж 624 хүн өвчилсний 263 буюу 42.1 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, хүний амь нас эрсдээгүй байна.


5 дугаар хүснэгт. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн болон нас барсан хүний тоо

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн тоо	11	6	12	5	20
Өвчилсөн хүний тоо	548	311	382	118	624
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн	244	33	127	98	263
Амь насаа алдсан хүний тоо	-	-	-	-	-

Улсын хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварын 8 дэгдэлт бүртгэгдэж, өнгөрсөн оноос 4 (33.3 хувь)-өөр буурсан байна. Дэгдэлтээр нийт 683 хүн өвдөж, 105 хүн эмнэлэгт хэвтэн, 578 хүн гэрээр өрхийн эмчийн хяналтад эмчлэгдсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

1 дүгээр зураг. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоо



Тайлбар: Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтэд ижил төрлийн хоол хүнс хэрэглэснээс үүдэн нэг өвчний гурав ба түүнээс олон тохиолдол илрэхийг авч үзсэн. Нийт хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоонд химийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогын дүн ороогүй болно.
Эх үүсвэр: ЭМЯ

Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл **2018 оны байдлаар 554 тохиолдол байсан бөгөөд энэ нь нийт хордлогын 88.78 хувийг** эзэлж байсан. Харин химийн гаралтай хоол, хүнснээс шалтгаалсан хордлогын талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яамны зүгээс гаргадаггүй байсан байна. Учир нь архи, согтууруулах ундааг хүнсний бүтээгдэхүүнд тооцдоггүй гэсэн тайлбар тавьж байжээ.

6 дугаар хүснэгт. Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Өвчилсөн хүний тоо	548	482	430	133	554
Хот	235	375	386	89	328
Хөдөө	313	107	44	44	226

Эх үүсвэр: ЭМЯ

Улсын хэмжээнд 2023 онд хоол хүнсээр дамжих өвчнөөр өвчилсөн 683 хүнээс нян судлалын шинжилгээгээр 644 хүнд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илэрсэн байна.

7 дугаар хүснэгт. Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл

зүүлэлт	2020	2021	2022	2023	Өөрчлөлт, хувиар
Өвчилсөн хүний тоо	205	264	515	644	25.0
Хот	125	10	450	256	-43.1
Хөдөө	80	254	65	388	6 ¹

¹дахин их, Эх үүсвэр: ЭМЯ

Харин сүүлийн 5 жилийн хугацаанд хийгдсэн хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг Зөрлийн шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын байгууллагын хяналт дор албадлагын журмаар хураан авч холбогдох нийслэл, аймаг, дүүргийн Засаг

даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд улсын байцаагчийн актаар 100 хувь шилжүүлэн, шийдвэрлүүлж ажилласан тухай албаны мэдээллийг ирүүлсэн боловч хэдэн зөрчил илрүүлж, ямар зөрчил байсан, энэ зөрчлийг иргэд олон нийтэд мэдээлсэн эсэх, хариу ямар арга хэмжээ авсан зэрэг мэдээлэл тодорхойгүй байсан. Иймд хуулийн энэ хэрэгжилтийг 50 хувьтай үнэлсэн.

Энэ хуулийн 8.7.-д “Буцаан болон татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг мал, амьтны тэжээл, ургамлын бордооны зориулалтаар энэ хуулийн 8.10-т заасан журмын дагуу дахин боловсруулж болно”, **мөн хуулийн 8.8.-д** “Энэ хуулийн 8.7-д заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулах тохиолдолд мал, амьтны эрүүл мэндийн болон ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна” гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж буцаан болон татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг мал, амьтны тэжээл, ургамлын бордооны зориулалтаар дахин боловсруулах асуудлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас батлагдсан журмын хэрэгжилтийг хангах талаар нэг ч шийдвэр гаргаж мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлээгүй байна.

Засгийн газрын 2013 оны 5-р сарын 18-ны өдрийн 172 дугаар тогтоолоор “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам”-ыг баталсан. **Тус журамд** татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь ямар нэгэн аюултай үр дагавар үүсэхгүй нь батлагдсан тохиолдолд шинж чанар, зориулалтыг өөрчлөн, мал, амьтны тэжээл, ургамлын бордооны зориулалтаар дахин боловсруулалт хийж хоёрдогч түүхий эд байдлаар хэрэглэж болно гэж заасан бөгөөд холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна гэж заасан. Гэтэл 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр 8.8 дахь заалт хүчингүй болсон тул дахин боловсруулах шийдвэрийг хэн хэрхэн гаргах нь тодорхойгүй болсон байна. Иймд хуулийн хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлсэн байна.

Гэсэн хэдий ч технологийн хувьд чанар, аюулгүй байдал нь алдагдсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулах арга хэмжээг авахгүйгээр Нийслэлийн засаг даргын зөвлөлийн шийдвэрээр устгах арга хэмжээг авч хэрэгждэг байна.

Иймд Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас эсвэл Засгийн газраас хүнсний хяналтын бодлого, зохицуулалтын арга хэмжээг анхааралдаа авч ажиллах шаардлагатай байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8.9.-д “Энэ хуулийн 8.2, 8.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбогдон гарсан зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учирсан хохирлыг буруутай хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцна” гэсэн заалтын дагуу **энэ хуулийн 8.10.-д** заасан Засгийн газрын 20213 оны “Журам батлах тухай” 172 дугаарт тогтоолоор “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам”, “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах үйл ажиллагааг бүртгэх, мэдээлэх маягт”-ыг баталсан ба одоо энэ журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Энэ хүрээнд шаардлага хангахгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авах, устгахтай холбогдон гарсан зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учруулсан хохирлыг буруутай хүнсний чиглэлийн үйл

ажиллагаа эрхлэгчээр төлүүлсэн талаарх мэдээллийн хувьд 2013-2018 оны байдлаар хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн түвшинд 48.6 хувийн хэрэгжилттэй байсан байна.

Энэ хуулийн 8.11.-д “Хяналтын байгууллага энэ хуулийн 8.2-т заасны дагуу татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу 2019-2024 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас хяналт шалгалтын явцад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, хадгалах болон хэрэглэх хугацаа хэтэрсэн зэрэг зөрчил бүхий хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний татан авсан талаарх мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэдэг. Мөн 2019-2024 оны байдлаар Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газраас татан авч устгасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээнд 18 удаа мэдээлсэн гэж тус газрын тайланд тусгагдсан байна.

Цаашид хуулийн уг заалтын хэрэгжилтийг хүнсний сүлжээний бүх үе шатаар нарийвчлан гаргадаг болгох, Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож хэрэгжүүлэх шаардлагатай.

2.2.4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл

Энэ хуулийн 9.1.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг энэ хуулийн 9.5-д заасан журмын дагуу хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хөтөлнө” гэж заасны дагуу ҮХАА-н Сайдын 2013 оны 08 сарын 06-ны өдрийн А/98 дугаар тушаалаар батлагдсан “Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам” ХХААХҮС-ын 2016 оны А-37 дугаар тушаалаар хүчингүй болсон. Энэ журмыг хүчингүй болгосноос хойш 6 жилийн дараа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/196 дугаар тушаалаар “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам” батлагдахдаа мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох зохицуулалтаа орхиод зөвхөн газар тариалангийн түүхий эд, бүтээгдэхүүн дээрээ илүү анхаарал тавьж түүний эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Сүүлийн жилүүдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь зөвхөн газар тариалангийн яам шиг ажилладаг болсон нь олон жишээн дээр харагдаж байна. Тухайлбал, энэ журмыг батлуулах үйл явцаас харахад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зөвхөн газар тариалангийн бодлого, түүний зохицуулалтыг хариуцсан яам шиг үйл ажиллагаа явуулж байгааг онцгой анхаарах хэрэгтэй байна.

Засгийн газрын тухай хуулиар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хариуцах чиг үүрэгтэй. Хүнсний аюулгүй байдал гэдэгт хүнсний хангамж, хүртээмж, хүртэмж, хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал, хүнсний шимт байдал, хүнсний хэрэглээ, хүнсний тогтвортой байдал зэрэг бүрэлдэхүүн хэсгийн асуудлыг нэг түвшинд ярьж, асуудлыг шийдвэрлүүлэх

үүрэгтэй. Хүнсний хангамж гэхэд зөвхөн газар тариалангийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний асуудлыг хөндөх учиргүй. Хүнсний хангамжид импортын хүнс болон дотоодын хүнсний үйлдвэрлэлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний олон асуудал хамрагдана. Тухайлбал, хүнсний импортод хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас ямар дуу хоолой гаргаж, ямар асуудлыг шийдвэрлэж байна вэ?

Хүнсний дотоодын үйлдвэрлэлд олон асуудлууд тулгамдаж байгаа гэтэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам жил бүр зөвхөн улаан буудай, гурилын асуудлыг л хөндөж олон нийтийн анхаарлыг татан ажил хийж байгаа мэт дүр эсгэж байна. Үүний оронд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зүгээс мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалттай хэрхэн тэмцсэн бэ? Малын эрүүл мэнд, бүртгэлийн асуудал одоог хүртэл асуудалтай байгаа.

Хүнсний сүлжээн дэх хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийг үнэн зөв, бодитоор бүртгэх бүртгэл мэдээллийн асуудлаа цэгцлэх хэрэгтэй байна. Бүртгэл мэдээллийн асуудал нь ойлгомжгүй, бүртгэл нь өссөн дүнгээр бүртгэгддэг, худлаа мэдээллээр шийдвэр гаргагч нарыг хангадаг зэрэг зөрчлүүд үнэлгээ хийх явцад илэрсэн. Хэрэгжилт хангалтгүй байна.

2023 он хүртэл Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2023 оноос салбарын хяналтын байгууллагаас эрдлийн үнэлгээг хийж байгаа хэдий ч эрдлийг үнэлэх, түүнд хариу арга хэмжээ авах, засаж залруулахтай холбоотой асуудлыг олон улсын сайн жишгээр шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргахын тулд Хяналтын байгууллагууд нь дэргэдээ Эрсдэлийн үнэлгээний хүрээлэнг ажиллуулдаг байна. Манайх энэ бүтэц шилжих нь зүйтэй гэж дүгнэж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А-98 дугаар тушаалаар баталсан. Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжсэнтэй холбогдуулан хийсэн эрх зүйн давхардал, хийдэл, зөрчлийг хянаж үзэх ажлын хүрээнд тус журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны А-74 дүгээр тушаалаар баталсан Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журамтай зөрчилдсөн гэж үзэж хүчингүй болгосон.

2013-2018 онд мэргэжлийн хяналтын байгууллагаас хүнсний сүлжээн дэх эрсдэл гарсан үе шатыг тогтоох зорилгоор ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөлтийг ашиглан хяналт шалгалт хийхэд уг заалтын хэрэгжилт хангалтгүйгээс хүндрэлтэй байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 9.1-д заасан бүртгэлийг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хэрэглэж дуусах хугацаа дууссанаас хойш 30-аас доошгүй хоногийн хугацаанд, эсхүл хадгалах хугацаа дууссанаас хойш нэгээс доошгүй жилийн хугацаанд тус тус хадгалж байгаа эсэх заалтын хэрэгжилтийг хяналт шалгалтын явцад шалгадаг боловч тухайн үед хэрэгжилтийг гаргах боломжгүй байна.

Ингээд Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А-105 дугаар тушаалаар баталсан. УИХ-аас Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 2017 онд баталсан. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд УИХ-аас 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулж журмын нэрийг “Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам” гэж өөрчилсөн.

Хүнсний сүлжээн дэх түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлээс малын бүртгэлийг Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд тусгайлан хэрэгжүүлэх зохицуулалттай болсон. Иймд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдээс хүнсний чиглэлийн анхан шатны үйл ажиллагаа эрхлэгчийг хамрах хүрээнээс хасч зохицуулалтыг шинээр хийх шаардлагатай болсон. Мөн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг хойш нэг шат, урагш нэг шат зарчмаар бүртгэж, бүртгэлийг тодорхой хугацаанд заавал хадгалах нь тухайн аж ахуйн нэгжээс цаг хугацаа, мөн бичиг баримтын зардал багагүй шаардахаар байна. Иймд бүртгэлийг цахим орчинд хийх нь зүйтэй гэж үзсэн.

Хуулийн 9.5. дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд дээр дурдсан тушаалыг хүчингүй болгосноос хойш 11 жилийн дараа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/196 дугаар тушаалаар “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам” батлагдаж, хэрэгжилтийг тус яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт даалгасан байна. Харин тушаалыг шинэчлэх хүрээнд мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэхтэй холбоотой зохицуулалтыг орхигдуулж, дээрх журамд тусгаагүй байна. Иймд мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэх зохицуулалт огт байхгүй байгаа, мөн ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг 11 жилийн дараа батлуулсан тул **хуулийн энэ заалт хуулийн зорилго анх дэвшүүлсэн зорилтот түвшинд хүрч чадахгүй гэж үзээд хэрэгжилтийг 30 хувиар үнэллээ.**

Тэгэхээр хууль хэрэгжиж эхэлсэн эхний 10 жилийн хугацаанд дээрх журам батлагдаагүй байсан тул хуулийн хэрэгжилт хангагдах гэсэн ойлголт үүсэхгүй тул энэ **хуулийн 9.2.-д “Энэ хуулийн 9.1-д заасан бүртгэлийг ашиглан хүнсний сүлжээн дэх эрсдэл гарсан үе шатыг тогтооно” гэж, 9.3.-д “Энэ хуулийн 9.1, 9.2-т заасныг хэрэгжүүлсний үр дүнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтооно” гэж, 9.4.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 9.1-д заасан бүртгэлийг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хэрэглэж дуусах хугацаа дууссанаас хойш 30-аас доошгүй хоногийн хугацаанд, эсхүл хадгалах хугацаа дууссанаас хойш нэгээс доошгүй жилийн хугацаанд тус тус хадгална” гэж тус тус заасан хуулийн заалтыг хэрэгжүүлэх процесс тодорхойгүй байсантай холбоотойгоор **хэрэгжилт хангалтгүй байсан гэж дүгнэсэн.****

“Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох” журмыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн

сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаалаар баталсан.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, бүртгэл хөтлөх аргачлал Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014.02.20-ны 79 дүгээр тушаалаар баталсан. Харин энэ хуулийн 9.6. дахь заалтад 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр өөрчлөлт орсонтой холбоотойгоор “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх аргачлалыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан. Энэ хүрээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх аргачлалыг **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд шинэчлэн батлаагүй байна.** Иймд хуулийн хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлсэн.

2.2.5. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай **хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1.-д** “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэв буруутай үйл ажиллагаа хийвэл түүнээс улмаас учирсан хохирлыг хариуцах”-аар хуульчилсан. Хүнсний сүлжээний үе шатанд хяналт хэрэгжүүлэх байгууллагаас Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж Зөрчлийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Гэвч хордлого, халдвар гарсан тохиолдолд тухайн зөрчил гаргасан аж ахуйн нэгж, иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу хохирол, нөхөн төлбөрийг тооцож, барагдуулж байгаа боловч хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд мэргэжлийн хяналтын байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтын мэдээлэл хангалтгүй байна.

Хуулийн 10.1.1 дэх заалтын хэрэгжилт төлөвлөгөөт хяналт шалгалтын хяналтын хуудасны нэгтгэлийн үнэлгээгээр сүүлийн 2 жилд 59.1 хувьтай тухай мэдээллийг Эрүүл мэндийн яамны салбарын хяналтаас ирүүлсэн. Тухайлбал, 2024 онд 18 аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсээс иргэний өргөдөл гомдлоор 349 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөрчлийн шинжгүй үйлдэлд илэрсэн дутагдлыг 1094 заалттай 121 албан шаардлага хүргүүлэн тайлант хугацаанд 76.7 хувийг арилгуулж, 1 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзан, илэрсэн зөрчилд 60-г хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 17 зөрчлийн хэрэг үүсгэн, 2 зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож, 2 зөрчлийг харьяалалын дагуу шилжүүлэн, 73 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд 145,720,000 (нэг зуун дөчин таван сая долоон зуун хорин мянга) төгрөгийн торгох шийтгэл, 336,000 (гурван зуун гучин зургаан мянга) төгрөгийн хохирол, нөхөн төлбөр ногдуулж, 7,915,400 (долоон сая есөн зуун арван таван мянга дөрвөн зуу) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг албадлагын журмаар хурааж холбогдох орон тооны бус зөвлөлд шилжүүлэн, зөрчлийн үр дагаврыг арилгуулан ажилласан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.2, 10.1.5, 10.1.7, 12.1 дахь зохистой дадлыг өөрийн үйлдвэрлэлийн бүх үе шатанд

хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө мэдээлэх, урьдчилсан хяналт шалгалтад хамрагдах, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савлах зэрэг заалтуудын хэрэгжилт 74.0-82.0 хувь буюу хамгийн өндөр үзүүлэлтэй байсан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг үйл ажиллагааны төрлөөр 2018 оныг 2013 онтой харьцуулахад мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, кремт бүтээгдэхүүн, ундаа, жүүс, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 0.6-12.0 хувиар буурсан байна.

Энэ хуулийн 10.1.2.-д “энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан зохистой дадлыг өөрийн үйлдвэрлэлийн бүх үе шатанд хэрэгжүүлэх” заасны дагуу тухайн үеийн мэргэжлийн хяналтын байгууллагаас 2017-2018 онд явуулсан хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын зохистой дадал нэвтрүүлсэн байх заалтын хэрэгжилт хүнсний худалдаа эрхлэгчдэд 65.7 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 70.4 хувь, мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлд 29.4 хувийн хэрэгжилттэй байна. Эрүүл ахуйн зохистой дадлын хэрэгжилтийн байдлыг тодруулбал: хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд 72.3 хувь, хүнсний худалдаа эрхлэгчдэд 65.7 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 67.5 хувийн хэрэгжилттэй байсныг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тайланд тусгагдсан байсан. Харин хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлснийг баталгаажуулах тогтолцоо өнөөдрийг хүртэл бүрдээгүй байгаа тул энэ харилцааг нарийвчлан зохицуулж тусгах шаардлагатай байна.

Иймд хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах зохистой дадлын стандартыг мөрдлөг болгоно. Үүнд:

- Хөдөө аж ахуйн зохистой дадал;
- Үйлдвэрлэлийн зохистой дадал;
- Эрүүл ахуйн зохистой дадал;
- Тээвэрлэлтийн зохистой дадал;
- Хүнсний худалдааны зохистой дадал;
- Хадгалалтын зохистой дадал;
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ /технологич/-ний зохистой дадал;
- Бусад гэж энэ хуулийн 7.1 дэх заалтыг өөрчлөн найруулах саналтай байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тайланд 2017 онд зохистой дадал нэвтрүүлсэн хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн түвшинд 51 хувь, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд 52 хувь, хүнсний үйлдвэр эрхлэгчдэд 61.4 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 68.9 хувийн хэрэгжилттэй байсан байна. Харин 2018 онд хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн түвшинд 65.8 хувь, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд 56.2 хувь, хүнсний үйлдвэр эрхлэгчдэд 60.4 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 55.49 хувийн хэрэгжилттэй байсан байна. Эдгээр үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийхэд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадлыг нэвтрүүлснийг баталгаажуулах итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаа байгаагүй ч тухайн үеийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас энэ чиг үүргийг хэрэгжүүлдэг байсан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт **хууль хэрэгжиж эхэлснээс хойших эхний 6 жилийн дунджаар** зохистой дадлыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байдал 58.7 хувь, нийтээр үйлчлэх хоол үйлдвэрлэлд 63.9 хувь, эрүүл мэндийн байгууллагын хоол үйлдвэрлэлд 69.8 хувь, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд 30.8 хувьтай байсан байна.

Ковидын цар тахлын нөхцөл байдлын улмаас 2021 онд нийслэлд, 2022 онд ЗГ-ын шийдвэрээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна. Харин 2020-2021 он, 2023-2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнд хамрагдсан 2256 объект эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудасны үнэлгээгээр 270(11.9 хувь) нь их эрсдэлтэй, 1130(50.0 хувь) нь дунд эрсдэлтэй, 856(37.9 хувь) нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

2019-2024 онд “Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-аар хийсэн эрсдэлийн үнэлгээний дүнг хяналтын хуудсын бүлгээр авч үзвэл Үйлдвэрийн гадна орчин, барилга байгууламжид тавигдах шаардлага 71.2 хувь, Ажиллагсдад тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага 62.8 хувь, Ажлын байр, тоног төхөөрөмж, хоолны хэрэгсэл, тээвэрлэлтэд тавигдах эрүүл ахуйн нөхцөл шаардлага 63.9 хувь, Ахуйн шавж, мэрэгчтэй тэмцэхэд тавих шаардлага 83.9 хувь, Түүхий эд, бүтээгдэхүүн, сав баглаа боодолд тавигдах эрүүл ахуйн шаардлага 79.7 хувь, Эрүүл ахуйн дотоод хяналтын тогтолцоонд тавигдах шаардлага 50.9 хувийн хэрэгжилттэй байна. Худалдаалах үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-ны бүлэг асуумжийн шаардлага хангасныг авч үзвэл Гадна орчин, барилга байгууламжид тавигдах шаардлага 73 хувь, Түргэн хоолны үйлчилгээний хэсэгт тавих эрүүл ахуйн шаардлага 83.7 хувь, Ажиллагсдад тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага 51.8 хувь, Үйлдвэрийн эрүүл ахуй, угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэл, хортон шавж, мэрэгчгүйтгэлд тавигдах шаардлага 63.4 хувь, Бүтээгдэхүүнд тавигдах эрүүл ахуйн, дотоод хяналтын шаардлага 83.3 хувь, Нялх, балчир хүүхдийн хүнсний худалдаалалтад тавигдах шаардлага 96.2 хувь, Эрүүл ахуйн сургалтын шаардлага 32.7 хувь нийт шаардлагын хэрэгжилтийн дундаж 69.14 хувьтай байсан байна.

Боловсролын Ерөнхий Газрын даргын баталсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зөвлөн туслах ажлын удирдамж”-ийн дагуу 2023 оны 05 дугаар сард JICA ОУБ-ын төсөл хэрэгжиж байгаа Өвөрхангай аймгийн 4-р сургууль, 5-р сургууль, Дундговь аймгийн Мандал сургууль, Говийн ирээдүй сургуулийн Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн Өвөрхангай аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсролын газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Эрүүл мэндийн газар, JICA төслийн ажлын бүрэлдэхүүнтэй уулзалт зохион байгуулж, “Үдийн хоолны зөвлөл”-ийг байгуулан ажиллах, хүнсний хангамжийг орон нутгийн малчид, тариаланчид, хүнсний үйлдвэр эрхлэгчдээс хангах талаар, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар ярилцжээ. Өвөрхангай аймгийн 19 суманд нэг загварын “Мал төхөөрөх газар” бариулахаар 180 сая төгрөгийн өртөгтэй зураг төслийг хийлгэж байгаатай танилцсан байна. Сургуулийн хоолны үйлдвэрлэлд хоршоологчдын тариалсан хүнсний ногоог бэлтгэн нийлүүлж байна. Дундговь аймагт “Үдийн хоолны зөвлөл”-ийн ажлын төлөвлөгөөтэй танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөгөө өгсөн. JICA төсөл хэрэгжиж байгаа Мандал сургуулийн

Үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байгаа 640 хүүхдэд 5 өдрийн 3 өдөрт, Говийн ирээдүй сургуулийн 447 хүүхдэд 5 өдрийн 2 өдөрт сүү өгөхөөр төсөв тооцоог гаргаж, 2023 оны 09 сарын 1-нээс “Сүү” хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөсөн байна. Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа 5 газарт дүгнэлт гаргасан байна.

2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объект 7 эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудасны үнэлгээгээр их эрсдэлтэй 55 (14.5 хувь), дунд эрсдэлтэй 235 (49.1 хувь), бага эрсдэлтэй 197 (41.2 хувь), эрсдэл үүсэх магадлалын дундаж 34.9 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилт 66.0 хувьтай үнэлэгдэж, холбогдох арга хэмжээ авч, 276 объектод гүйцэтгэлийн хяналт хийж ажилласны дүнд 37 (7.7 хувь) нь их эрсдэлтэй, 217 (45.5 хувь) нь дунд эрсдэлтэй, 233 (47.8 хувь) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, эрсдэл үүсэх магадлалын дундаж 24.7 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшин нэмэгдэх хандлагатай байна.

Боловсрол шинжлэх ухааны, Эрүүл мэндийн, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамдын салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны удирдамжийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 19 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын хүнсний чанар, стандартын хяналтын 36 улсын (ахлах) байцаагч, 11 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн хяналтын 47 улсын (ахлах) байцаагч, нийт 83 улсын (ахлах) байцаагчид хамтран 2023 оны 09 дүгээр сард хийж гүйцэтгэсэн байна. Улсын хэмжээнд 239 цэцэрлэг, 198 ерөнхий боловсролын сургууль, 24 дотуур байр, 7 бусад (худалдааны төв, бэлтгэн нийлүүлэгч), нийт 468 объектыг хамруулан хяналт шалгалт хийсэн байна.

2023 онд хяналт шалгалтад хамрагдсан сургууль, цэцэрлэгийн хоолны газар, гал тогоог Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудсаар шалгахад 214 объект буюу 45.7 хувь нь бага эрсдэлтэй, 207 объект буюу 44.3 хувь нь дунд эрсдэлтэй, 47 объект буюу 10 хувь нь их эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Хяналт шалгалтаар нийт 1173 зөрчил илрүүлсэн бөгөөд 768 зөрчил буюу 65,5 хувийг арилгуулсан байна. Хяналт шалгалтаар нийт 1398 зөрчил илрүүлсэн бөгөөд 937 зөрчил буюу 67 хувийг арилгуулсан байна.

Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын хяналтын хэлтсээс Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад Эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан 62 сургууль, 51 цэцэрлэгийн удирдлагуудад хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын хяналтын хэлтсээс хүнсний сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч нарт үйлдвэрлэлийн зохистой дадлыг үйл ажиллагаандаа мөрдүүлэхтэй холбоотой сургалтыг жил бүр хяналтын чиглэл тус бүрээр зохион байгуулж байна. Нийслэлд үйл ажиллагаа нь жигдэрсэн, дунд болон томоохон хүнсний үйлдвэр, худалдаа, үйлчилгээний газрууд, франчайзингийн эрхтэй сүлжээ дэлгүүр, хоолны газруудад ЗГ-ын 311-р тогтоолоор батлагдсан аж ахуйн үйл ажиллагааны дотоодын хяналтын журмыг батлуулан, үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлж хэвшүүлсэн байна. Гэвч нийслэлийн нутаг дэвсгэрт хүнсний сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч нарын дийлэнх хувийг жижиг ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүд, иргэд үйл ажиллагаа явуулдаг тул зохистой дадлыг хэрэгжилт хангалттай бус байгааг анхааралдаа авах шаардлагатай байна. Эдгээр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа

эрхлэгчдийг үйл ажиллагаандаа зохистой дадлын стандартыг заавал мөрдүүлдэг болтол нь мэргэжил арга зүйгээр тасралтгүйгээр хангах, мөн тэдний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг технологи болон барилга байгууламжийн хувьд сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь шаардлагатай санхүүжилтийн хөнгөлттэй зээл, зээлийн хүүгийн нөхцөлийг бүрдүүлэх бодлого барих асуудлыг салбарын яам яг улаан буудай болон гурилын асуудлыг шийдвэрлүүлдэгтэй адилаар хөөцөлдөж зохистой дадлыг улс орон даяар хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл болон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд, хүнсний үйлдвэрт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд, хүнсний хадгалалт, тээвэрлэлт, түгээлтэд нэвтрүүлэх энэ хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах нь Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг хангахад хувь нэмэр оруулах юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас хийсэн мал үржүүлэг, технологийн хяналтын чиглэлээр 2024 онд 223 объект төлөвлөснөөс 121 объектод буюу 54.2 хувийн гүйцэтгэлтэй төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтыг холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд их эрсдэлтэй 17, дунд эрсдэлтэй 45, бага эрсдэлтэй 57 объект үнэлэгдсэн байна. **Хууль сахин мөрдөлтийн түвшин 45.4 хувиар үнэлэгдсэн байна.**

Цаашид энэ хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг үйл ажиллагаанд тохирох зохистой дадал нэвтрүүлэх чиг үүргийг мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагад өгч, төрийн үйл хэргийг төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилж явуулахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.3, 10.1.9, 11.1.7, 12.4, 12.7-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах, хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэлтэй холбоотой заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас одоогийн байдлаар тус журам батлагдаж гараагүй. 2013 онд А/98 дугаар тушаалаар тус журам батлагдан гарсан боловч хууль зүйн яаманд бүртгэгдээгүй учраас хүчин төгөлдөр бус болсон тул ямар загвараар ул мөрийн бүртгэх асуудал тодорхойгүй байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тайланд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалах гэсэн заалтын хэрэгжилт 2013-2018 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээр хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд 74.5 хувь, хүнсний худалдаа эрхлэгчдэд 70.9 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 72.3 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 77.5 хувийн хэрэгжилттэй байсан байна.

Энэ хуулийн 10.1.3.-д заасны дагуу аймаг, нийсэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмаар холбогдох хяналтыг тавихаар хуульчилсан боловч хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн бүртгэлийн ажил бүрэн

хийгдэхгүй байгаа тул хуулийн зорилго хангагдаагүй, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хүрэхгүй хувьтай байна гэж үнэллээ.

Хамгийн гол нь ул мөр бүртгэх загварыг тодорхой, хялбар байдлаар гаргавал практикт илүү нийцнэ. Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш журам хүчингүй болох хүртэл урагш нэг, хойш нэг шатыг бүртгэж байсан. Одоогоор зарим аж ахуйн нэгж, иргэд энэхүү хэлбэрээр бүртгэл хийж байгаа тохиолдлууд ажиглагдлаа.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.4.-д “энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ буцаан болон татан авах” гэж заасны дагуу ЗГ-ын 2013 оны 5-р сарын 18-ны өдрийн 172 дугаар тогтоолын хавсралтаар Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журмыг баталсан. Одоогоор энэ журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Сүүлийн 5 жилийн хяналт шалгалтын дүнгийн тайлангаар дотоод хяналтаар татан авах шаардлагын хэрэгжилт 59 хувьтай байна. Хяналтын байгууллагын татан авах шаардлага хүргүүлсэн шийдвэр 100 хувь хэрэгжилттэй байна гэсэн мэдээлэл салбарын хяналтын газраас ирүүлсэн. Тухайлбал, 2024 оны хяналт шалгалтын явцад шошгын зөрчилтэй 11 нэр төрлийн 674 ширхэг, 80 кг, 2,296,000 төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгүүлэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна.

Энэ хуулийн 10.1.5.-д “үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэх, урьдчилсан хяналт шалгалтад хамрагдах” гэж заасны дагуу 2018 онд мах, махан бүтээгдэхүүний 16 үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүний 3 үйлдвэрлэл шинээр эрхлэхэд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргасан байсан байна. Мөн онд улсын хэмжээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт 36 хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид шинээр үйл ажиллагаагаа явуулахад хяналт шалгалтад хамрагдаж холбогдох дүгнэлтийг гаргуулж байсан байна. Тухайлбал, ерөнхий боловсролын сургуулийн цайны газрын түрээслэгч солигдох бүрд 2013-2018 онуудад тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хандан ажлын байрны дүгнэлт гаргуулж ажилладаг байсан.

Хүнсний үйлдвэрлэлийн салбар болох тус хуулийн 6.5.1, 6.5.2 дахь заалтын мах, махан, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд урьдчилсан хяналт шалгалтад хамрагдаж үйл ажиллагааны дүгнэлт гаргуулж хэвшсэн байдаг. Харин нялх, балчир, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлд урьдчилсан хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг онцгой анхаарах ёстой байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2022 онд татан буугдаж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орсноос хойш Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын Улсын Ерөнхий байцаагч нарийн хамтран баталсан 2 удирдамжийн дагуу аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын хяналтын нэгж урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хамтран гүйцэтгэж байна.

Аж ахуйн нэгж, иргэнээс өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд дүгнэлт гаргуулах 37 (нийслэлд 8, аймагт 29) хүсэлтийг хүлээн авч, хуульд заасан хугацааны дотор 100 хувь шийдвэрлэн, “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн, 25 үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэнд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор баталсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”, Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR 2:2011-ийн эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа тухай улсын байцаагчийн 25 дүгнэлт үйлдсэн Улсын хэмжээнд цэцэрлэг, сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл шинээр эрхлэх 31 газраас хүсэлт ирүүлсний дагуу хяналт шалгалт хийж, давхардсан тоогоор нийт 116 зөрчил дутагдал илрүүлж, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод албан шаардлага хүргүүлж, 1 объектод гүйцэтгэлийн хяналт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул нийт 30 объектод улсын байцаагчийн дүгнэлт гаргасан байна.

Дээр дурдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд хүнсний хяналтын бодлого алдагдаж, хүсэлт ирүүлснийг хянадаг, хүсэлт ирүүлээгүйг нь хяналтаас хасдаг байдал харагдаж байна. Иймд хуулийн хэрэгжилт нь анх дэвшүүлсэн хуулийн зорилгыг хангах түвшинд байж чадахгүй байна гэж дүгнэлээ.

Хувийн сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох шалгуурт энэ заалтын хангасан нөхцөлд олгох талаар хөшүүрэг байдаггүйгээс энэ заалт хэрэгжихгүй байхад нөлөөлж байна гэж үзэж байна.

Энэ хуулийн 10.1.6.-д заасан “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалах” гэсний хэрэгжилт хувьд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид нь өөрт хамаарах үе шат бүрд тайлан тооцоо, лабораторийн шинжилгээний хариу зэрэг мэдээлэл болон баримт бичгийг хадгалдаг.

Зөвхөн “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2022 оны 06 сарын 17-ний өдрийн А/196 тушаалаар батлагдсан боловч хяналт шалгалтаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тус зүйлд заасан мэдээллийг бүрэн хадгалдаггүй байна. Тухайлбал тухайн бүтээгдэхүүний гарал үүсэл, гэрчилгээ, бүтээгдэхүүний шинжилгээний бичиг зэргийг тухайн импорт болон үйлдвэрлэл тус бүрээр сүлжээний дараагийн үе шатандаа өгдөггүй, эсвэл дараагийн үе шат авч хадгалдаггүй зөрчлүүд байсаар байна.

Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам батлагдсан боловч нэр болон бичвэр хоорондоо уялдаа холбоо муу байгааг анхаарах хэрэгтэй. Тухайн заалт практикт нийцэж байгаа боловч жижиглэн худалдааны үе шатанд бүрэн хэрэгжихгүй байна. Иймд хүнсний үе шат бүрд үйл ажиллагааныхаа чиглэлд тохирсон ул мөрийн мөрдөн тогтоох бүртгэлийн стандарттай болох шаардлагатай.

Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтан халдварт өвчнөөр өвчилсөн, эсхүл ийм өвчтийг асарсан тохиолдол бүрд тухайн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах гэсэн заалтын хэрэгжилт 2013-2018 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээр хоол

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

үйлдвэрлэл эрхлэгчдэд 68 хувь, хүнсний худалдаа эрхлэгчдэд 73,2 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 70,1 хувь, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдэд 38.8 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 62.8 хувийн хэрэгжилттэй байсан байна.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах гэсэн заалтын хэрэгжилт 2013-2018 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээр хоол үйлдвэрлэл эрхлэгчдэд 58.5 хувь, хүнсний худалдаа эрхлэгчдэд 57 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 57 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 79 хувийн хэрэгжилттэй байжээ.

Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлийн 19 хяналтын хуудасны асуумжид тус заалтыг 2019 онд тусгасан.

2020-2021 он, 2023-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 2256 объектын хяналтын хуудасны үнэлгээний нэгтгэлээр “Ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жилд 2 удаа бүрэн хамрагдсан, эрүүл мэндийн дэвтэртэй, бичилт, баталгаажуулалт нь бүрэн” асуумжийн шаардлагын дундаж 74.2 хувь, “Ажилчдыг эрүүл ахуйн, ариун цэврийн сургалтад хамруулсан, цаашид хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө, төсөв, хөтөлбөр, тайлантай” шаардлагын хэрэгжилт 47.7 хувьтай дүгнэгдсэн байна.

Ковидын цар тахлын нөхцөл байдлын улмаас 2021 онд нийслэлд, 2022 онд ЗГ-ын шийдвэрээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй.

Хүнсний хяналтын байгууллагын чадавхыг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг урт хугацаанд төлөвлөх, үүнтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын 2024 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээр хяналт шалгалтад хамрагдсан газруудад ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулдаггүй зөрчил нэлээдгүй байдаг ялангуяа хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчдэд хэрэгжилт хангалтгүй байгаа талаар тус газрын тайланд дурдсан байна.

Мөн хуулийн 10.1.8.-д “энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтан халдварт өвчнөөр өвчилсөн, эсхүл ийм өвчтөнг асарсан тохиолдол бүрд тухайн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах” гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/145 тушаалаар “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ыг баталсан. Тус журамд зааснаар үзлэг шинжилгээнд хамрагдах хүн нь зөвхөн аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд шинжилгээ өгөхөөр тооцсон нь хуурамч шинжилгээ бүрдүүлэх эрсдэлийг бууруулсан гэх боловч томоохон хүнсний үйлдвэрлэлийн хувьд хэрэгжилт хангалттай, харин жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хувьд бүртгэл хөтлөлт хангалтгүй хуулийн заалт хэрэгждэггүй тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан.

Харин ил задгай хүнсний худалдаа, түргэн үйлчилгээний цэг, хуушуурын цэг гэх мэт эрүүл ахуйн наад захын шаардлага хангаагүй нөхцөлд дур зоргоороо худалдаа, үйлчилгээ эрхэлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг алдагдуулж буй үйл

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

ажиллагааг бүрмөсөн зогсоох хууль эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзэж байна.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын 2020-2021 он, 2023-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр хяналтын хуудасны “Ажилтан халдварт өвчнөөр өвчилсөн, эсхүл ийм өвчтийг асарсан тохиолдол бүрд тухайн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг” шаардлагын хэрэгжилт 73,2 хувьтай байна.

Тухайлбал, 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объектод хийсэн хяналт шалгалтаар хяналтын хуудасны “Ажилтан халдварт өвчнөөр өвчилсөн, эсхүл ийм өвчтийг асарсан тохиолдол бүрд тухайн ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг” шаардлагын хэрэгжилт 78.1 хувьтай байна гэж салбарын хяналтын газраас тайлагнасан. Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийт тоотой харьцуулахад хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо хангалтгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.9.-д “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах” гэж заасан бөгөөд **хуулийн хэрэгжилт 66 хувьтай** түргэн гэмтэх тээвэрлэлтийн горим шаарддаг мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ зэрэг бүтээгдэхүүний тээвэрлэлтийн горим нөхцөл шаардлага зөрчдөг гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тайланд дурдсан байна.


Стратегийн хүнсэнд ундны ус ордог. Энэ хүрээнд ундны усыг гэр хорооллын иргэдэд зөөврөөр түгээх үйл ажиллагааг гүйцэтгэдэг усны машины усны сав, ус түгээх байрны ус нөөцлөх савыг тогтмол хугацаанд угааж халдваргүйжүүлэн усны машинаас жилд 1 удаа, зөөврийн ус түгээх байрнаас жилд 2 удаа сорьц авч хими, нян судлалын шинжилгээ хийдэг байна.

Хүн ам, орон сууцны тооллогын 2020 оны дүнгээр Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын 84.0 хувь буюу 2685.5 мянган хүн шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээс ундны усаар хангагдсан гэсэн дүнтэй байна. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнгээр 2023 онд, ундны усны сайжруулсан эх үүсвэр хэрэглэдэг өрхөд амьдардаг хүн амын хувь улсын дүнгээр 93, бүсийн дүнгээр Улаанбаатар хамгийн өндөр 99.3 байна.

Усны эх үүсвэр нь гэдэсний савханцар (Е.коли)-аар бохирдсон өрхөд амьдардаг хүн ам нийт өрхийн 21.5 хувийг эзэлж байгаа бол өрхийн ундны усанд гэдэсний савханцар илэрсэн өрхөд амьдардаг хүн ам нийт хүн амын 37.5 хувийг эзэлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

2 дугаар зураг. Ундны усны эрүүл аюулгүй байдал, хүн амын эзлэх хувь, 2023 он



Эх үүсвэр: НҮТС, ҮСХ

Монгол улсын хэмжээнд газрын доорх усны нөөц тогтоох судалгаанд хамрагдаж, усны нөөц батлагдсан 101 сум, дүүрэг байгаа нь нийт сум, дүүргийн 32.7 хувийг эзэлж байна.

8 дугаар хүснэгт. Газрын доорх усны нөөц батлагдсан сум, дүүргийн тоо, 2023 он

Үзүүлэлт	Тоо	Нийт сум, дүүрэгт эзлэх хувь
Газрын доорх усны нөөц батлагдсан сум, дүүрэг	101	32.7 хувь

Эх үүсвэр: Усны газар

Ковидын цар тахалын нөхцөл байдлын улмаас 2021 онд нийслэлд, 2022 онд ЗГ-ын шийдвэрээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй.

2020-2021 он, 2023-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 2256 объектод хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын хяналтын хуудасны үнэлгээгээр тус заалтын хэрэгжилт 74.1 хувьтай байна.

Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдэд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд зориулалтын тээврийн хэрэгслээр бүтээгдэхүүн нийлүүлж байгаа бол төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулиуд ихэвчлэн зориулалтын бус тээврийн хэрэгслээр өөрсдөө татан авалт хийж байна. Цаашид сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдэд хүнсний бүтээгдэхүүний нэгдсэн хангалт хийх логистикийн систем нэвтрүүлэх шаардлагатай.

Эрүүл мэндийн яамны 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объектод тус заалтын хэрэгжилт хяналтын хуудасны үнэлгээгээр 70.1 хувьтай гэж тайлагнасан боловч дээр дурдсанчлан хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо хангалтгүй буюу хуулийн хэрэгжилтийг 50 хувьтай гэж үнэлж байна.

Энэ хуулийн 10.1.10.-д “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний зураасан кодыг хэрэглэх” гэсэн заалтын хэрэгжилт 60.8 хувьтай байна. Хуулийн хүрээнд 2013-2018 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээр хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 71 хувь, мах махан бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 37.2 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 74.2 хувийн хэрэгжилттэй байсан байна. 2024 оны байдлаар **хуулийн хэрэгжилт хангалттай.**

Энэ хуулийн 10.2.-д “Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/145 дугаар тушаалын хавсралтаар “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ыг баталсан бөгөөд энэ **заалтын хэрэгжилт бүрэн хэрэгжсэн гэж үнэлсэн.**

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.3.-д заасан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно гэсэн заалтын хүрээнд ил задгай хүнсний худалдаа, түргэн үйлчилгээний цэг, хуушуурын цэг гэх мэт газруудад хэрэгжилт хангалтгүй бөгөөд 30 хувьтай байна. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2014-2017 онд хийсэн хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлөөс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй нь 26 хувийг, сав баглаа боодол, хаяг шошгын шаардлага хангахгүй зөрчил 17.9 хувийг эзэлж байсан байна.

Энэ хуулийн 10.3.1.-д “хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх” гэж заасны дагуу хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх гэсэн **заалтын хэрэгжилт 10 хүрэхгүй хувьтай байна** гэж үнэлж байна. Учир нь зах зээл дээр худалдаалагдаж буй хуурамч хүнсийг тогтоох чиглэлээр хяналт шалгалтын ажлыг явуулдаггүй байна.

Энэ хуулийн 10.3.2.-д эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэхийг хориглосон заалтын хэрэгжилтийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018 оны хяналт шалгалтын ажлын тайланд дунджаар 65 хувьтай гэж дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас 2020-2021 он, 2023-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 2256 объектод хийсэн хяналт шалгалтын хяналтын хуудасны үнэлгээгээр ажилтныг шинээр томилж ажлын байранд ажиллуулахаас өмнө хуулийн 10.1.7-д заасны дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан байх шаардлага хангалтгүй, **хэрэгжилтийн дундаж 51 хувьтай гэж үнэлсэн байна.**

2023 оноос эхлэн хуулийн энэ заалтын хэрэгжилтийг хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлийн 19, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны СХГ-тай хамтарсан 2 хяналтын хуудасны “Ажилчдад тавигдах эрүүл ахуйн нөхцөл шаардлага” бүлэг асуумжид тусган хяналт тавин ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.3.3.-д “хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах” гэж заасны дагуу 2014-2017 онд хийсэн хяналт шалгалтаар 336 аж ахуйн нэгж байгууллага, 185 иргэний үйл ажиллагааг түр зогсоосон, зөрчлийг арилгасан 215 аж ахуйн нэгж байгууллага, 95 иргэний үйл ажиллагааг сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу 2017 онд Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд улсын /ахлах/ байцаагчийн акт үйлдэж үйл ажиллагаа түр зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан.

Зөрчлийн тухай хууль мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд хүнсний сүлжээний үе шатанд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг Прокурорын байгууллагад холбогдох эрх зүй баримт бичгийг үйлдэж зөвшөөрөгдсөний үндсэн дээр үйл ажиллагаа хэсэгчлэн болон бүхэлд зогсоох арга хэмжээг хийж хэрэгжүүлдэг болсон.

2020-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар “их эрсдэлтэй” үнэлэгдсэн 38 объектын үйл ажиллагааг улсын байцаагчийн акт, эрх бүхий албан тушаалтны зөрчлийн үр дагаврыг арилгуулах албан даалгавраар зөрчил, дутагдал арилгах хүртэл түр зогсоож, гүйцэтгэлийн хяналтаар 8 газрын үйл ажиллагааг сэргээсэн. Урьдчилан сэргийлэх шалгалтаар 22 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг улсын байцаагчийн 22 актаар түр зогсоож, 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сэргээж, актын биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар “их эрсдэлтэй” үнэлэгдсэн 4 объектын үйл ажиллагааг улсын байцаагчийн 2 акт, эрх бүхий албан тушаалтны зөрчлийн үр дагаврыг арилгуулах албан даалгавраар зөрчил, дутагдал арилгах хүртэл түр зогсоож, гүйцэтгэлийн хяналтаар 2 газрын үйл ажиллагааг сэргээсэн. Урьдчилан сэргийлэх шалгалтаар 22 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг улсын байцаагчийн 22 актаар түр зогсоож, 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сэргээж, актын биелэлтэд хяналт тавин ажилласан байна. Хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд хангалттай тоо хэмжээний хяналт шалгалтад хамрагдсан объект байж чадахгүй байгаа тул хуулийн энэ заалтын хэрэгжилтийг хангалтгүй буюу 30 хувьтай үнэллээ.

2.3. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Үнэлэгдэх Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй хангах тухай хууль	хэсэг байдлыг	11 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн; 12 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго; 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн; 14 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага
--	-------------------------	---

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? Энэхүү хуулиар тогтоосон тусгай шаардлага нь цаг үетэйгээ нийцэж байгаа эсэх буюу практикт нийцэж байна уу?
---------------------------------------	---

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх мөн энэхүү хуулиар тогтоосон тусгай шаардлага нь цаг үетэйгээ нийцэж байгаа эсэхэд заалт тус бүрээр дүн шинжилгээ хийж оролцогчдийн зүгээс үнэлгээ өгсөн.

2.3.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага хэрхэн хангагдаж байгаа асуудлын хүрээнд Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2013-2018 онд хийсэн хяналт шалгалтын дүн, мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын хяналт шалгалтын дүнгээр илэрч буй зөрчилд дүн шинжилгээ хийлээ.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ТХШ, УСХШ, ТБХШ-аар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй эсэхийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр баталгаажуулдаг.

Одоогоор Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүн дэх зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон Эрүүл мэндийн сайдын 2014 оны 11 сарын 7-ны 384 дугаартай Жагсаалт батлах тухай, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2015 оны 06 сарын 26-ны өдрийн А/90 дугаартай Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон гадаад хорио цээртэй болон тус улсад хязгаарлагдмал тархалттай дотоод хорио цээртэй ургамлын өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтдын нэрсийн жагсаалт, Хүнсний нэмэлт MNS CAC 192:2015, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4504:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн дээд хэмжээ” MNS 5868-2008, Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мал, амьтны тэжээлд агуулагдах нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6420:2013, Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6308:2012 гэх мэт стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна. Гэхдээ эдгээр стандартуудад зарим бохирдуулагчийн хэмжээ огт тусгаагүй байдаг байна. Мөн Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори тухайн стандартуудад заасан зарим бохирдуулагчийг тодорхойлох үзүүлэлтүүдийг огт шинжилж чаддаггүй байна.

Хяналт шалгалтын явцад хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр шинжлүүлсэн дээжийн 98.0 шинжилсэн үзүүлэлтийн түвшинд шаардлага хангаж байна. Практикт нийцэж байгаа байдлын хувьд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн шинжлэх үзүүлэлтийн түвшин цөөн байгаагаас тухайн бүтээгдэхүүнийг аюулгүйн шаардлагыг бүрэн хангаж байгааг тогтооход хүндрэлтэй байгаа. Лабораторийн чадамжийн хүрээнд л хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тогтоож байгаа нь хангалтгүй түвшинд байна гэж дүгнэв.

Хуулийн 11.1.1.-д “зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бохирдуулагч агуулсан” хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж

үзэх бөгөөд одоогоор Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүн дэх зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон Эрүүл мэндийн сайдын 2014 оны 11 сарын 7-ны 384 дугаартай Жагсаалт батлах тухай, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2015 оны 06 сарын 26-ны өдрийн А/90 дугаартай Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон гадаад хорио цээртэй болон тус улсад хязгаарлагдмал тархалттай дотоод хорио цээртэй ургамлын өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтдын нэрсийн жагсаалт, Хүнсний нэмэлт MNS CAC 192:2015, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4504:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн дээд хэмжээ” MNS 5868-2008, Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мал, амьтны тэжээлд агуулагдах нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6420:2013, Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6308:2012 гэх мэт стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна. Гэхдээ эдгээр стандартуудад зарим бохирдуулагчийн хэмжээ огт тусгаагүй байдаг бөгөөд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори тухайн стандартуудад заасан зарим бохирдуулагчийг огт шинжилж чаддаггүй гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан.

Харин 2020-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр 3590 түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч, шинжлүүлсний 54 буюу 1.5 хувь, урьдчилан сэргийлэх шалгалтаар авсан 2054 дээжний 45 буюу 2.1 хувь нь эерэг гарсан байна.

Тухайлбал, 2024 оны лабораторийн шинжилгээтэй хяналт шалгалтаар итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 3.1 хувь, боловсруулсан хоолны дээжийн 12.1 хувь нь хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээг заасан MNS 6308:2012 стандартыг хангаагүй дүнтэй шалгагдлаа. Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори болон аймаг, нийслэлийн лабораториуд Стандарт, хэмжил зүйн газрын харьяалалд шилжсэнээс төрийн хяналт шалгалтыг лабораторийн шинжилгээтэй хийхэд хуульд заасан шинжилгээний төлбөрийн асуудал хүндрэлтэй бөгөөд тулгамдсан асуудал болж байгаа талаар салбарын хяналтын газраас дурдсан. Иймд хуулийн энэ заалтын хэрэгжилт хангалтгүй түвшинд буюу 30 хүрэхгүй хувьтай байна гэж үнэллээ.

Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны СХГ-аас Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ТХШ, УСХШ, ТБХШ-аар 2022 онд 671, 2023 онд 570, 2024 онд 560 хүнсний ногоо, жимс жимсгэнэ шинжлүүлж зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байгаа эсэхийг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгээр баталгаажуулахад 98.0 хувь нь шаардлага хангаж байсан байна. Тухайлбал “Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн дээд хэмжээ” MNS 5868-2008 стандартад хүнсний ногоон дах пестицидийн үлдэгдлийг зөвшөөрөгдөх дээд хэмжээг тусгаж оруулах, тухайлбал фенвалерат, лямбда-цигалотрин, пиримифос-метил, имидаклоприд, метсульфурон метил, глифосат, метрибузин, хизалофоп-п-этил, тебуконазол, имазалил, манкоцеб, этефон гэх мэт бусад пестицидийн үлдэгдлийн хэмжээг, “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мал амьтны тэжээлд агуулагдах нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6420-2013” стандартад чинцай, чихэрлэг төмс гэх мэт шинээр тариалагдаж импортлогдож байгаа хүнсний

ногооны нитратын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тусгаагүйгээс аюулгүйн шаардлага хангаж байгаа гэдгийг тогтооход хүндрэлтэй байна.

Сав баглаа боодол, хаяг, шошгын шаардлага хангахгүй зөрчил нийт илэрсэн зөрчлийн 7.1 хувийг эзэлж байсан бол 2017 онд 10.8 хувийг, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл шаардлагыг хангахгүй зөрчил 2014 онд 10.1 хувийг эзэлж байсан бол 2017 онд 12.8 хувийг эзэлж байгаа нь уг зөрчлийн эзлэх хувь буураагүй байсан байна.

Ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн шаардлага хангахгүй зөрчил 2014 онд 15.1 хувийг эзэлж байсан бол 2017 онд 10.3 хувийг эзэлж 4.8 хувиар буурсан дүнтэй гарсан байна. Энэ хуулийн 11.1.2.-д “хүнсний зориулалтын бус сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласан” гэж заасан шаардлагыг хангах хүрээнд хийсэн хяналт шалгалтын дүнгээр нийт зөрчлийн 11.3 хувийг эзэлж байсан байна.

2023-2024 онд хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хүнсний зориулалтын сав баглаа боодол тавих хяналтыг тогтмолжуулж, хяналт шалгалтад ашигладаг хяналтын хуудсанд оруулж өгч холбогдох арга хэмжээг авч зориулалтын бус савны хэрэглээг бууруулах арга хэмжээг авч ажилласан байна. Хүнс импортлогч, үйлдвэрлэгч нарын хувьд зориулалтын тээвэр, логистикийн байдал сайжирсан тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан. Хүнсний сүлжээний үе шат бүрт зориулалтын сав баглаа, боодол, тээврийн хэрэгсэл багаж төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр сургалт, хяналт шалгалтуудыг зохион байгуулсан боловч үр дүнг тайлагнаагүй болно. Хэрэгжилтийг 30 хувьтай гэж үнэлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 11.1.3-д “эрүүл ахуй, ариун цэврийн горим зөрчин хүнсний сүлжээний дараагийн үе шатанд гаргасан” хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж үзэхээр хуульд заасан. Энэ чиглэлээр тухайн үеийн мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнгээр ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангаагүй зөрчил 2014 онд 18.5 хувийг эзэлж байсан бол 2017 онд 19.4 хувийг эзэлсэн нь уг зөрчлийн эзлэх хувь буураагүйг илтгэж байна. 2018 оны байдлаар нийт зөрчлийн 18.9 хувийг эзэлж байсан бол Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас 2020-2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр 3590 түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч, шинжлүүлсний 54 буюу 1.5 хувь, урьдчилан сэргийлэх шалгалтаар авсан 2054 дээжний 45 буюу 2.1 хувь нь эерэг гарсан байна.

Тухайлбал, 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр НЭрүүл мэндийн газраас 12 байгууллагын 22 хоолны дээж авч шинжилгээнд хамруулахад 4 буюу 18.18 хувь нь хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ. MNS 6308:2012 стандартыг хангаагүй дүнтэй шалгагдлаа. Эдгээр үзүүлэлтээс харахад салбарын хяналтын газраас явуулж буй хяналт шалгалтын тоо, хяналт шалгалтад хамрагдаж буй объектын тоо бага байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэхэд хангалттай мэдээлэл болж өгч чадахгүй байна. Иймд энэ заалтын хэрэгжилтийг 30 хувьтайгаар үнэлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 11.1.4.-д “Монгол Улсад болон олон улсад бүртгэгдээгүй, эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй


хувиргасан амьд организмаас гарган авсан” тохиолдолд эрүүл мэндэд сөрөг гэж үзнэ гэж заасны хүрээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хувиргасан амьд организмаас гаралтай эсэхийг улсын бүртгэх үйл ажиллагаа одоог хүртэл эхлээгүй байгаатай холбогдуулан хуулийн энэ заалтын **хэрэгжилтийг “0” гэж үнэлэв.**

Энэ хуулийн 11.1.5.-д “Хүнсний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу бүртгэгдээгүй баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгийг ашиглаж үйлдвэрлэсэн” гэж заасан боловч одоогоор ийм тохиолдол гараагүй буюу **энэ заалт огт хэрэгждэггүй байна.**

Энэ хуулийн 11.1.6.-д “олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аюулгүйн шаардлагад нийцсэн ионжуулагч цацрагийн боловсруулалт хийснээс бусад цацрагаар бохирдсон” тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн гэж үзэх тул олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аюулгүйн шаардлагад нийцсэн ионжуулагч цацрагийн боловсруулалт хийснээс бусад цацрагаар бохирдсон эсэхийг лабораторийн шинжилгээтэй хяналтыг хэрэгжүүлж байна. 2023 оноос эхлэн цөм цацрагийн хяналт нь Эрчим хүчний яамны Цөм цацрагийн хяналтын чиг үүрэгт хамаардаг болсон. **Хэрэгжилт хангалттай** гэхдээ хяналтын үйл ажиллагааг өргөжүүлэх, иргэд олон нийтэд энэ талаарх мэдээ, мэдээллээр хангахад анхаарах хэрэгтэй гэж үзлээ.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн цацрагийн лабораторийн шинжилгээнд хамрагдсан гурван жилийн дүнг харьцуулахад дээж болон шинжилгээний тоо хэлбэлзэлтэй байна (Зураг 17). Цези 137 тодорхойлох үзүүлэлтээр 2021-2023 онд бүх дээжинд, 2022 онд уран 238, ради 226 үзүүлэлтээр тус бүр 2 эмгэгт эдийн дээжинд, 2023 онд кали 40, ради 226, тори 232 үзүүлэлтээр 22 тооны эмгэгт эдийн дээжинд тус тус шинжилгээ хийсэн, эерэг дүн гараагүй байна. Гэвч үр дүнгээс харахад цези 137 нь зөвшөөрөгдөх хэмжээнээс бага илэрсэн боловч эдгээр дүнг харьцуулах стандарт байхгүй байна.

3 дугаар зураг. Цацрагийн лабораторийн шинжилгээний тоо, жилээр



Дотоодын болон импортын бүтээгдэхүүнд яагаад цеци 137 илэрсэн, цаашид шалтгааныг олон талаас нь судлах, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага байгааг тус лабораторийн шинжилгээний үр дүнгээс харж болохоор байна. Олон улсын судлаачдын тэмдэглэснээр цеци 137 нь хүнсний бүтээгдэхүүнд байхгүй ёсгүй, бохирдсон гадаад орчноор дамжин хүнсний бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэл байгааг тогтоосон. Мөн энэ изотоп нь эд, эрхтэн болон эсийн ДНХ бүтцэд өөрчлөлт оруулах, улмаар хавдар үүсгэх аюултай болохыг тэмдэглэсэн байдаг.

Хуулийн 11.1.7.-д “хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн” хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж үзсэний дагуу холбогдох яамдаас улсын бүртгэл хийх журам өнөөг хүртэл гараагүй, бүртгэл хийгдэж эхлээгүй байгаа тул хуулийн тус заалтын хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэв. Цаашид Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас холбогдох журмыг боловсруулж, улсын бүртгэлийг эхлүүлэн, хяналт тавих эрх зүйн орчныг яаралтай горимоор бий болгох шаардлагатай байна.

Шалгалтаар 2023 онд 167 нэр төрлийн 87274 ширхэг 15кг 360800 литр 412.770.400 төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн, 2024 онд 28 нэр төрлийн 5534 ширхэг 7тн 929 кг 137,053,650 (нэг зуун гучин долоон сая тавин гурван мянга зургаан зуун тавин) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг дотоод хяналтаар нь хураан авч тухайн аж ахуйн нэгжүүдээс 11,240,0 (арван нэгэн сая хоёр зуун дөчин долоон мянган) төгрөгийг зардал гарч устгуулсан бөгөөд 143 нэр төрлийн 52554 ширхэг 930,9кг, 37,8 литр 233,052,410 (хоёр зуун гурван сая тавин хоёр мянга дөрвөн зуун арван) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн устгуулсан байна.

Энэ заалт дээр хадгалах хугацаа дууссан гэж нэмж оруулах шаардлагатай байна. Тус хуулийн нэр томьёонд хадгалах болон хэрэглэж дуусах хугацааг томьёолсон боловч хадгалах хугацаа дууссаныг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх гэдэгт огт оруулаагүй байна. Гэтэл хадгалах хугацаа дууссан бүтээгдэхүүний чанарын байдал муудсанаар хэрэглэгч шим тэжээлгүй хүнс хэрэглэж, эрүүл мэнд аажимдаа хохирох магадлал өндөр байна.

2.3.2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг заалт бүрээр авч үзвэл 12.1 дэх “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байна” заалтын хэрэгжилт 2013-2018 онд дунджаар 90.8 хувь, 12.4-12.7 дахь заалтын хэрэгжилт 87.1 хувьтай байсан байна.

Энэ хуулийн 12.1.-д зааснаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байна гэсэн заалтын хэрэгжилтийг товч дурдвал мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнгээр нийт илэрсэн зөрчлийн 2014 онд 7.1

хувийг эзэлж байсан бол 2017 онд 10.8 хувийг эзэлж байгаа нь уг зөрчлийн эзлэх хувь буураагүй байсан байна. Энэ нь нийт зөрчлийн 8.9 хувийг эзэлсэн байна.

Хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хүнсний зориулалтын сав баглаа боодол тавих хяналтыг тогтмолжуулж, хяналт шалгалтад ашигладаг хяналтын хуудсанд оруулж өгч холбогдох арга хэмжээг авч зориулалтын бус савны хэрэглээг бууруулах арга хэмжээг авсан. 2023 онд Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандартад меламина тэмдэглэгээтэй хуванцар аяга, таваг, хэрэгслийг хориглосон заалтыг тусгуулж хэрэгжилтийг хангуулж байна.

Хөдөө орон нутгаас сүү, сүүн төрлийн бүтээгдэхүүний тээвэрлэхдээ зориулалтын бус саванд ачиж тээвэрлэж байгаа зөрчил буураагүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Хүнсний сав баглаа боодолтой холбоотой хуучин стандартууд шинэчлэгддэггүй, лабораторид сав баглаа боодолд агуулагдаж буй зарим үзүүлэлтүүдийг шинжилж чаддаггүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.2-д “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журмыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж, **12.3-д** “Энэ хуулийн 12.2-т зааснаас бусад харагдах байдлаар нь шинж чанарыг тодорхойлох боломжтой хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шаардлагатай мэдээллийг дагалдах хуудсанд тусгана” гэж тус тус заасны дагуу зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журмыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаалаар баталсан. Эрүүл мэндийн яамнаас “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” MNS 6648-2016 стандартыг боловсруулан батлуулсан байна.

“Хүнсний сав боодлын шошгын нүүрэн хэсэгт тэжээлийн бодисын мэдээлэл байршуулах заавар”-ыг боловсруулан, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/221 дүгээр тушаалаар батлуулжээ. Зааврыг мэргэжлийн хяналтын байцаагчид болон хүнсчдийн холбооны салбарын менежерүүдэд танилцуулах уулзалтыг анх 2018 оны 3, 4 дүгээр саруудад Эрүүл мэнд яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран зохион байгуулж байсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн Эрүүл мэндийн хичээлийн “Хооллолт ба хөдөлгөөн” хичээлийн агуулгад хүнсний бүтээгдэхүүний сав баглаа, боодлын тэмдэглэгээний агуулгын талаарх саналыг Эрүүл мэндийн яамнаас боловсруулж Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яаманд тухайн үед хүргүүлсэн боловч сургалтын хөтөлбөрт энэ асуудал тусгагдаагүй болно.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн А/328 дугаар тушаалаар “Нялхсын болон сүүн тэжээл, нэмэгдэл хоол, хооллох хэрэгслийн сав баглаа боодол, шошгын журам” батлагдсан.

Энэ хуулийн 12.4.-12.5.1-д “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошго дараах мэдээллийг агуулсан байна” гэж заасан бөгөөд хэрэгжилт 72.7 хувьтай байсан нь мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнгээр нийт илэрсэн

зөрчлийн сав баглаа боодол, хаяг шошгын зөрчил 2014 онд 7.1 хувийг эзэлж байсан бол 2017 онд 10.8 хувийг эзэлсэн нь уг зөрчлийн эзлэх хувь буураагүйг харуулж байна. 2018 оны дүнгээр нийт зөрчлийн 8.9 хувийг эзэлжээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.4-12.7 дахь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэлтэй холбоотой заалтын хэрэгжилт 2013-2018 онд хоол үйлдвэрлэлийн шатанд 58.8 хувьтай байсан байна. Тус хуулийн 8.1-8.10, 9.1-9.4 дэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн, үзүүлж болзошгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс буцаан авч бүртгэл хөтлөх, 10.1.7 дахь ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах заалтын хэрэгжилт хууль хэрэгжиж эхэлсэн эхний 6 жилийн дунджаар 52.9-65.8 хувьтай байсан байна.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас хийсэн 2023-2024 оны хяналт шалгалтаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгод тавигдах шаардлагын хэрэгжилт дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнд үйлдвэрийн хяналтын хуудасны нэгтгэлээр 72,3 хувьтай, хүнсний үйлдвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдааны сүлжээн дэх импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл хуулийн 12.6-д заасныг хангаагүй (импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна) нийт шошгын зөрчлийн 70 гаруй хувийг эзэлсэн байна.

Дотоодын хүнсний үйлдвэрлэлийн салбарт хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг холбогдох хууль болон стандартад нийцүүлэн шошголох байдал сайжирч, энэ төрлийн зөрчил буурч байна. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод тавих шаардлага буюу **тус хуулийн 12.6 дахь заалтад тавигдах шаардлага БНХАУ, БНСУ-аас орж ирж буй бүтээгдэхүүн дээр бүрэн хангагдахгүй байна. Энэ нь хил, гаалийн хорио цээрийн хяналт хангалтгүй, хууль бусаар оруулж ирж дотоодын зах зээлд нийлүүлдэг байдлаас шалтгаалж зөрчил буурахгүй байхад нөлөөлж байна. Мөн дотоодын хүнсний бүтээгдэхүүний шошгод тавигдах ерөнхий шаардлагууд хангагдаж байгаа боловч шошгод тавигдах /Е тэмдэглэгээ, гаж нөлөө гэх мэт/ мэдээллүүдийг тодорхой тусгахгүй байгаа талаар 2025 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан.**

Цэцэрлэг, сургуульд нийлүүлэгдэж буй гурил, гурилан бүтээгдэхүүний орц найрлага ижилхэн байдаг. Тухайлбал Үдийн хоол хөтөлбөрт нийлүүлэгдэж буй нарийн боовны боодол дээр нэр нь өөр боловч орц нь ижилхэн байдаг. Жимсний чанамалтай боов гэсэн нэртэй боловч орц найрлага дээр жимсний чанамал байхгүй гурил, элсэн чихэр, маргарин, давс, исгэгч гэх мэт түүхий эд, материалыг бичсэн байдаг.

Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна гэж заасан боловч импортлогч аж аж ахуйн нэгжүүд тэр бүр энэ заалтыг хэрэгжүүлэхгүй байна. Энэ нь 2019-2022 оны хооронд хяналт шалгалт хийгдээгүй хяналт суларсантай холбоотой. Сүүлийн 1 жилийн байдлаар 16 нэр төрлийн 91,833,900 (ерэн нэгэн сая найман зуун гучин гурван мянга есөн зуун) төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татан авахуулж хаяг шошгын зөрчлийг арилгуулж болзошгүй эрсдэлээс сэргийлэн ажилласан байна.

Сүүлийн 3 жилд импортын бүтээгдэхүүний шошгын зөрчил буурахгүй байна. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл дутуу, **хуулийн 12.6-д заасан** импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна гэсэн шаардлагыг хангахгүй, хилийн хорио цээрийн хяналт Гаалийн байгууллагад шилжсэнээс хойш зөрчил буурахгүй нэмэгдэж байгаа хандлага ажиглагдлаа. **Хэрэгжилтийг 50 хувьтай гэж үнэллээ.**

Хуулийн 12.5, 12.7 дахь заалтуудыг нэг бүрчлэн задалж хэрэгжилтийг гаргасан мэдээлэл ирүүлээгүй болно. Цаашид хуулийг уг заалтыг хэрэгжилтийг нарийвчилж гаргадаг болох шаардлагатай.

Мөн хуулийн хэрэгжилтийг хангах нөгөө талаас хангуулах хоёр субъектийн үйл ажиллагааг уялдуулах бодлого, харилцан ойлголцох, шошго дээрх мэдээллийн үнэн зөв орчуулсанд хяналт тавих, тухайн бүтээгдэхүүний шошгон дээрх мэдээлэл үнэн зөв байгаа эсэхэд үйлдвэрлэгч, импортлогчдын зүгээс хүлээх хариуцлага зэрэг харилцааг нарийвчлан хуулийн төсөлд тусгах саналтай байна. Эцсийн дүнд хэрэглэгчийг үнэн зөв, бодит мэдээллээр хангахтай холбоотой харилцааг зохицуулах юм.

Үүний дараа хэрэглэгч зах зээлээс ямар хүнсний бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэх эрхтэй холбоотой харилцаа үлдэнэ. Хүнсний баталгаат байдлыг хангахад хүнсний сүлжээнд бүх оролцогч талын оролцоо чухал байдаг. Тэгвэл мөн адил хэрэглэгчийн зүгээс өөрийн эрүүл мэнд, амь насыг хүнсээ зөв сонгох хэрэглэснээр хамгаалах эрх, үүргийн харилцаа үүсэх тул энэ зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах саналтай байна.

Хуулийн 12.7-д тусгагдсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буруу шошголсон гэж үзнэ гэсэн заалт 2013-2018 оны байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байсан байна. Тодруулбал, мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнгээр нийт илэрсэн зөрчлийн сав баглаа боодол, хаяг шошгын зөрчил 2014 онд 7.1 хувийг эзэлж байсан бол 2017 онд 10.8 хувийг эзэлж байгаа нь уг зөрчлийн эзлэх хувь буураагүйг харуулж байна.

2020-2024 оны хяналт шалгалтаар энэ хэсгийн 12.7.1-12.7.7 дахь заалтыг зөрчсөн зөрчил зөрчлийн бүртгэлд бүртгэгдээгүй байна. Энэ хуулийн 12.8. дахь “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгч хариуцна” гэх заалтын хэрэгжилт тухайн онуудад төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан хүнсний худалдааны газруудын 62,3 хувь нь хангаж савласан, багцалсан бүтээгдэхүүн дээр шошгын мэдээллийг хууль, стандартын дагуу тэмдэглэсэн байна.

Хуурамч хүнсний хяналтыг Монгол Улсын хэмжээнд хийхгүй байна. Зах зээл дээр хуурамч хүнс байгаа эсэхэд тавих хяналтыг чангатгах хэрэгтэй байгаа. Учир нь энэ асуудал бол хүний эрүүл мэнд, цаашлаад хүний амь насанд хор хөнөөлтэй үйлдэл юм. Хуурамч хүнсний холбоотой асуудлыг хуулийн төсөлд онцгойлон зааж өгөх хэрэгтэй байна.

Энэ хуулийн 12.8-д заасны дагуу “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлага” стандартыг 2016 онд дахин шинэчлэн тус стандартын

дагуу аж ахуйн нэгжүүдэд тохирлын үнэлгээ гүйцэтгэх явцад хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан байна. Шинэчилсэн стандартад олон улсын нийтлэг шаардлагын дагуу давсны хэмжээ, ханасан тосны агууламж, илчлэгийн хэмжээг заахаар тусгасан байна. Цаашид “Импортын бараа бүтээгдэхүүнд нэмэлт шошгололт хийх” стандартыг батлуулж, түүнийг мөрдлөг болгох хэрэгтэй байна.

2.3.3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн

Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.-д “Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийнэ” гэж заасны дагуу хүнсний бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан бичиг баримтыг үндэслэн, Гаалийн тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл шаардлагыг хангуулсны үндсэн дээр Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн нэр дээр гаалийн бүрдүүлэлт хийн, улсын хилээр нэвтрүүлж байна.

Гаалийн хилээр нэвтрүүлж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэл тооцох аргыг хэрэглэж гаалийн хяналтыг хэрэгжүүлэхээс гадна шаардлагатай тохиолдолд Гаалийн тухай хуулийн 252 дугаар зүйлийн 252.1-д зааснаар гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл болон тэдгээртэй холбоотой бичиг баримтад гаалийн хяналт хийх явцад мэргэжлийн тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах, “гаалийн зорилгоор барааны ангиллыг тодорхойлох тохиолдолд магадлан шинжилгээ хийнэ” хэмээн заасны дагуу тухайн барааг гаалийн болон эрх бүхий байгууллагын лабораторийн магадлан шинжилгээний дүнг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийж байна.

Зөвшөөрлийн тухай хууль болон Хүнсний тухай хуулийн дагуу стратегийн хүнсийг экспортлох, импортлох гаалийн бүрдүүлэлт хийхдээ хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон энгийн зөвшөөрлийг үндэслэж байна.

Хуулийн 13.2.-д “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна” гэж заасан байдаг. Энэ хүрээнд Монгол улсын Засгийн газрын “Шалгуур үзүүлэлт батлах тухай” 2014 оны 233 дугаар тогтоол, Монгол улсын Шадар сайдын “Импортын барааны жагсаалт батлах тухай” 2014 оны 60 дугаар тушаал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/95 тоот тушаалаар Эрсдэлийн ангиллаар импортын бараанд хяналт шалгалт хийх заавар батлагдаж тушаалыг тус тус үндэслэн хяналт шалгалтыг хийж байна.

Зээл тусламжаар авах болон өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журмыг 2013 оны ЗГ-ын 341 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нэмэлт өөрчлөлтөөр оруулж, амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлохын өмнө импортын өмнөх эрсдэлийн үнэлгээ

хийж, импортын мэдэгдэл олгох бүрэн эрх мал, амьтны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус шилжсэн.

Гэсэн хэдий ч энэ чиг үүргийг гаалийн байгууллага хэрэгжүүлэн ажиллаж иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийг гаалийн хорио цээрийн Caps.gaali.mn системээр хүлээн авч шийдвэрлэж байгаад дээрх чиг үүргийг 2025 оны 02-03 дугаар сард холбогдох төрийн байгууллагад бүрэн шилжүүлсэн.

Эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажуулалтын баримт бичгийг үндэслэн хилийн боомт дахь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулан хилээс чөлөөлж байна.

Хил, боомтод лабораторийн итгэмжлэлийн хүрээ, чадамж нь Олон Улсын болон бүс нутгийн хэмжээнд үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх түвшинд хүрэхгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх үндэс болж байна.

2022 онд хилийн мэргэжлийн хяналтын чиг үүргийг гаалийн байгууллагад нэгтгэсэнтэй холбоотойгоор 2023 оны хөрөнгө оруулалтаар хүнсний шинжилгээний тоног төхөөрөмж худалдан авч, 3 хүний нөөцийг сонгон шалгаруулж авсан байна. Хүний нөөцийг сургаж, тоног төхөөрөмжийг хэвийн үйл ажиллагаанд оруулахаар ажиллаж байна. Дутагдалтай байгаа зарим тоног төхөөрөмжийг 2024 онд худалдан авахаар тусган, 2 удаагийн тендер зарласан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй байна. Мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай байна. Тус лабораторид хорио цээрийн хяналтын чиглэлээр иж бүрэн шинжилгээ хийж хараахан чадахгүй байна.

Гаалийн ерөнхий газрын даргын баталсан 2024 оны “Дотооддоо мөрдөх заавар боловсруулах аргачлал, жагсаалт, батлах тухай” 380 дугаар тушаалаар хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх 7 хяналтын чиглэлийн 43 төрлийн цахим зааврыг боловсруулан “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах” цахим системд байршуулан, цахимаар нэвтрүүлэхэд бэлэн болгоод байна. Энэхүү зааврын дагуу албан хаагчид аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу нэгэн жигд шаардлага тавьж буй эсэхэд дотоод хяналт тавихад ач холбогдолтой байна.

Энэ хуулийн 13.3.-д “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шошгон дээр нь заасан нөхцөлийн дагуу хадгална” гэж заасны дагуу хүнсний түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед хуульд заасан заалтыг дагаж мөрдөж ажиллаж байна.

Хүнсний бараа бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх үед тээвэрлэлтийн шаардлага, хангаж байгаа эсэхэд хяналт шалгалтыг хийж байна. Тээвэрлэлтийн үед хадгалалтын горим, зориулалтын тээврийн хэрэгслээр хангагдаж байгаа эсэхэд хяналт тавьж байгаа хэдий ч импортолсны дараа худалдан борлуулах, хадгалах үед бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал алдагдах, хадгалах хугацаа дуусах зэрэг зөрчлүүд илэрч байна.

Хил, гүний хяналт шалгалт хийхдээ хамтарсан хяналт шалгалтыг хийж байсан бол 2014 оны Шадар сайдын 60 дугаар тушаал батлагдсанаас хойш хүнсний бараа бүтээгдэхүүнд тус тусын хариуцсан чиглэл бүрээр нэг улсын байцаагч хяналт

шалгалтыг хийдэг болсон. Чиглэл бүрээр хяналт шалгалт хийхэд хүнсний чанар, аюулгүй байдалтай холбогдолтой зарим хууль, журам, стандартын заалтууд зөрчигдөх хүндрэлүүд гарч байна.

Нэмэлт анхаарах нэг зүйл бол хүнсний нэмэлт импортлогдоход БТКУС код нь химийн бодсын кодтой импортлогдож байгаа нь хүндрэлтэй байгаа тул тусгай зөвшөөрөлтэй бүтээгдэхүүний жагсаалтад оруулсан байна. Хүнсний нэмэлт дээр тавих хяналт шалгалтын үйл ажиллагаа улсын хэмжээнд хангалтгүй байгаа нь лабораторийн чадавх сул байгаатай холбоотой гэж үзэж байна.

Энэ хуулийн 13.4.-д “Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу импортлох болон экспортлох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд холбогдох хяналт шалгалт хийнэ” гэж заасан байдаг.

АУТГТЭБУХНҮХЦХШТ хуульд заасны дагуу Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг импортлохоос өмнө Гаалийн ерөнхий газарт хандаж хүсэлтийг судалж, импортын мэдэгдлийг 2013-2018 онд олгодог байсан байна. Мөн онуудад мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, ургамал, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, Ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчид хяналт шалгалт эрсдэлийн үнэлгээг хийдэг байсан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг нь Гаалийн ерөнхий газарт 2022 оны 01 дүгээр сард бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөд орж шилжсэн. Гаалийн ерөнхий газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/34 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар “Мал, амьтны гаралтай боловсруулсан болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудас”, “Ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудас”, “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлох үеийн хяналтын хуудас”, “Нялх, балчир хүүхдийн хүнс, хооллох хэрэгсэл импортлох үеийн хяналтын хуудас”, “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас”-ыг тус тус батлуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ хуулийн 13.5.-д “Мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлогч эхний удаа импортлох тохиолдолд түүний нэр, төрөл, бүс нутаг, улс, үйлдвэрлэгчийн нэрийг ачилт хийхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэнэ” гэж заасан. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хяналтыг сайжруулж, Хүнсний тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн хилээр нэвтрүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гаалийн байгууллагад мэдүүлэхэд тухайн барааг үйлдвэрлэсэн болон дуусах хугацааг гаалийн мэдүүлэгт бичүүлж, гаалийн цахим системээр мэдүүлэн, холбогдох хуулийн шаардлага хангасан тохиолдолд гаалийн бүрдүүлэлт хийж байх чиглэлийг харьяа гаалийн газар хороодод 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 02-1/4249 дугаартай албан бичгээр хүргүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр бүлгийн **13 дугаар зүйлийн 13.6.-д** “Хяналтын байгууллага энэ хуулийн 13.5-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд импортын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх хяналт шалгалт хийнэ” гэж заасан байдаг. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 4, 5 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжсэн.

Ингээд 2022 оны 01 дүгээр сараас эхлэн Гаалийн тухай хуулийн 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.11 “улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх” чиг үүргийн дагуу улсын хилээр нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслээр дамжин ургамлын гадаад хорио цээртэй өвчин, хортон шавж, хог ургамал, мэрэгч амьтан, мал, амьтны гоц халдварт өвчин хил дамжин тархахаас сэргийлэх, эрүүл ахуй, чанарын тохирол, бүтээгдэхүүний стандарт шаардлагыг хангуулахаар хорио цээрийн хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд гаалийн байгууллагаас 2025, 2026 онд “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтэд тандалт судалгаа хийх” /“Тээвэрлэх ерөнхий шаардлага MNS 5343:2011” стандарт/, “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгололтод тандалт судалгаа хийх” /“Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” MNS 6648:2016 стандарт/- ийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тухайн үеийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бүтцийн нэгжид хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий 4 нэгж хяналтын үйл ажиллагаа явуулдаг байсан. Үүнээс улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад, хүнсний үйлдвэрлэлийн хяналтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтад, хүнсний эрүүл ахуйн хяналтыг Эрүүл мэндийн яамны салбарын хяналтад, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийг Стандартчилал хэмжил зүйн газар-т тус тус шилжүүлсэн явдал бол Монгол Улс хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлаа алдах, хоол, хүнс хяналтгүй зах зээл дээр худалдан борлуулагдах, түгээгдэх, хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл дээрх хяналт суларснаас үүдэн малын гоц халдварт өвчний гаралт, таралтын мэдээ, мэдээлэл сааралтах, улаан буудайн чанар, үрийн нөөцийн бодит мэдээллийн эх сурвалжгүй болох гээд олон сөрөг үр дагаврууд бий болсон. Хүнсний аюулгүй байдлыг хангах засаглалын энэ алдаатай байдлаас үүдэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Эрүүл мэндийн яам тухайн салбарын бодлогыг боловсруулаад, түүнийг хэрэгжүүлээд, өөрийнхөө хэрэгжилтэд хяналт тавьж байгаа үйл ажиллагаа, тогтолцооны гажуудалд орсон байна. Иймд энэ засаглалын алдааг засаж залруулах, салбарын яам нь салбарын бодлогоо боловсруулдаг байх, төрийн захиргааны байгууллага буюу агентлаг нь салбарын бодлогын хэрэгжилтийг хангадаг байх, бодлогын хэрэгжилтэд хяналтыг хөндлөнгийн байр сууринаас тавьдаг байх гэсэн асуудал үүсэх юм.

Ялангуяа хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдалд хяналт шалгалт явуулж байгаа улсын байцаагчид хамтарсан хяналт шалгалтыг хийх нь зүйтэй.

Энэ хуулийн 13.7.-д “Хяналтын байгууллага гадаадын зээл, тусламжаар авах болон энэ хуулийн 6.5-д заасан өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх хяналт шалгалтыг хийж болно” гэж заасан боловч хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нэг ч гадаадын зээл тусламжаар импортлогдсон хүнсний бүтээгдэхүүнийг хяналтад оруулах хүсэлт ирээгүй ба мөн хуульд заасан бүтээгдэхүүнийг гадаадын зээл тусламжаар аваагүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13.8.-д “Энэ хуулийн 13.6, 13.7-д заасан ачилтын өмнөх хяналт шалгалтын журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 341 дугаар тогтоолоор “Зээл тусламжаар авах болон өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан бөгөөд хуулийн энэ заалтыг бүрэн хэрэгжсэн байна. Гэвч хуулийн энэ бүлэгт заасан импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага, хяналт шалгалтын хэрэгжилт 30 хүрэхгүй хувьтай байна гэж үнэлсэн.

2.3.4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 14 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 14.1-д “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална” гэж заасан. Энэ заалтын хүрээнд Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/602/А/393/А/689 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэх журам”-ыг баталсан бөгөөд уг заалт бүрэн хэрэгжсэн.

Энэ хуулийн 14.2.-14.3.-д заасны хүрээнд өнөөдрийн байдлаар импортолсон болон дотооддоо үйлдвэрлэсэн хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийгдээгүй тул энэ чиглэлийн хяналт шалгалтын тоон мэдээ байхгүй байна. Улмаар хуулийн энэ заалтын хэрэгжилтийг одоогоор гаргах боломжгүй буюу огт хэрэгжээгүй гэж дүгнэв.

2.4. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Үнэлэгдэх хэсэг	хэсэг
Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль	15 дугаар зүйл. Үндэсний лавлагаа лаборатори; 16 дугаар зүйл. Эрсдэлийн үнэлгээ хийх; 17 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг; 18 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Лабораторийн чадавх шаардлага хангаж, шинжилгээний дүн нь хүлээн зөвшөөрөгддөг эсэх? Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа явц нь практикт нийцэж буй эсэх? Хуулийн хэрэгжилтэд төр бүрэн хяналт тавьж чадаж буй эсэх?
---------------------------------------	--

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн чадавх өнөөгийн нөхцөл байдлын шаардлага хангаж, шинжилгээний дүн нь хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх мөн тус лабораторид хийгдэж байгаа эрсдэлийн үнэлгээний ажлын ач холбогдол, явц, давтамж нь цаг үетэйгээ нийцэж практикт хэрэгцээ, шаардлагатай байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж оролцогчдын зүгээс үнэлгээ өгсөн. Мөн тус үндэсний лавлагаа лабораторийн зүгээс өөрийн үйл ажиллагаандаа үнэлгээ өгөхөд оролцсон болно.

Эцэст нь энэхүү хуулийн хүрээнд төр хүнсний аюулгүй байдлыг хангахад бүрэн хяналт тавьж чадаж байгаа эсэхийг дүгнэсэн.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавхыг одоо шинжилж байгаа аюулгүйн үзүүлэлт нь нийт баталсан аюулгүйн үзүүлэлтэд эзлэх хувиар тооцсон ба улсын хэмжээнд 2023 онд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавх 70.17 хувь байна.

Пестицидийн үлдэгдлийг хянах үндэсний төлөвлөгөөнд тусгагдсан нийт пестицидийн үлдэгдэлд эзлэх хувиар улсын хэмжээнд хэдэн нэр төрлийн пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй хувийг тооцоход 74.6 хувь байна.

9 дүгээр хүснэгт. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадавх

Үзүүлэлт	2021	2022	2023
Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн хувь ¹	70.17	70.17	70.17
Пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй нэр төрлийн тоо ²	108	129	188
Пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй хувь ²	42.86	51.19	74.6

Эх үүсвэр: ¹Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, ²Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, УХЭШХ, УМЭАЦТЛ, Демо лаборатори

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүнсний үйлдвэрлэлд хэрэглэж буй хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлох лаборатори 35 нэр төрлийн хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлох чадамжтай байгаа бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд транс тосыг шинжлэн тодорхойлох чадамжтай лаборатори бүртгэгдээгүй байна.

2.4.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйл. Үндэсний лавлагаа лаборатори

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр бүлэг **15 дугаар зүйлд** Үндэсний лавлагаа лабораторийн чиг үүргийг тодорхойлсон байдаг. Энэ хуулийн 15.1.-д “Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах,

энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагаа лаборатори ажиллана” гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэд харьяалагдаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ хууль батлагдаж, хэрэгжиж эхэлсний дараа Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолоор хяналтын байгууллагын Нэгдсэн төв лабораторийг Үндэсний лавлагаа лаборатори болгон бүтэц, зохион байгуулалтыг нь өөрчилж байсан. Тухайн үед тус лаборторид нийт 55 гаруй ажилчидтай байсан бол өнөөдрийн Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь 111 алба хаагчтай болж үйл ажиллагаа нь өргөжсөн байна.

Энэ хуулийн 15.2.2.-д “энэ хуулийн 15.4-т заасны дагуу ирүүлсэн шинжилгээний дүнг нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, удирдах” гэж заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг хяналтын чиглэлээр итгэмжлэгдсэн лабораториудын нэгдсэн сүлжээний хэмжээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 10 нэр төрлөөр бүрдүүлж 2019 оны хагас жилээс тус лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцооны (LIMS) програм хангамжтай холбон мэдээллийг цахимаар бүрдүүлж эхэлсэн ажил 50 хувиас хэтрээгүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй, ахиц дэвшилгүйг илтгэж байна.

Төв, нийслэл, орон нутаг, хилийн боомтууд дээрх хяналтын лабораториудыг нэгдсэн сүлжээнд оруулж, хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн нэгдсэн сүлжээ байгуулах, төв лаборатори нь сүлжээ лабораториудаа мэргэжил арга зүйгээр удирдан ажиллах тухай гарсан Засгийн газрын 2012 оны 175 дугаар тушаалын дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь сүлжээ лабораториудын шинжээчдийг мэргэжил арга зүйгээр ханган үйл ажиллагааг уялдуулан зохицуулж байгаа хэдий ч сүлжээ лабораториудын шинжээч мэргэжилтний сургалт, лабораторийн дотоод үйл ажиллагааны аудит, мөн итгэмжлэлд бэлтгэх, лабораторийн шинжилгээний шинэ арга, аргачлал нэвтрүүлэхэд лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодисоор тогтвортой хангахад хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал тус лаборторид тулгамдаж байна. Иймд хуулийн энэ заалтын хэрэгжилтийг 30 хүрэхгүй хувьтай байна гэж үнэллээ.

Мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэхээс өмнө аймаг орон нутаг, хилийн боомт, нийслэлийн лабораториудын шинжилгээний тайланг цаас болон файл хэлбэрээр авч нэгтгэн гаргадаг байсан. Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцооны систем (laboratory information management system-LIMS)-ийг 2019 оны 03 дугаар сараас эхлэн хуучин Мэргэжлийн хяналтын байгууллагын итгэмжлэгдсэн сүлжээ лабораториуд болох 21 аймаг, 2 хилийн боомт, нийслэлийн 3 лаборторид нэвтрүүлэн итгэмжлэгдсэн лабораториудын нэгдсэн сүлжээний мэдээллийн санг бүрдүүлж, жил бүр шинжилгээний тайланг нэгтгэн гаргаж удирдаж эхэлсэн. 2023 оноос хойш Стандартчилал хэмжил зүйн газрын аймаг орон нутгийн CX3X-ийн сорилтын сүлжээ лабораториуд болон үйл ажиллагаа хэвийн явуулж байна. LIMS программ хангамжийг сорилтын лабораториудын шаардлага болох MNS ISO/IEC 17025:2018 стандартаас гадна ур чадварын сорилтын лабораторийн MNS ISO/IEC 17043:2010 стандартын

шаардлагын дагуу хөгжүүлэлтийг хийж, жилдээ 2 удаа хөтөлбөрийг зарладаг бөгөөд 160 гаран төр, хувийн хэвшлийн лабораториудын ур чадварын үнэлгээг гаран ажиллаж байна. Цаашид программ хангамжийг нэг цонхны үйлчилгээ, төр, хувийн хэвшлийн лабораторийн нэгдсэн систем, дундын мэдээллийн сан, хэрэглэгч, үндсэн модуль гэсэн 5 чиглэлээр хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд үүний санхүүжилтэд 480 сая төгрөг орохоор тооцоолол хийгдсэн байна. Энэ асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.

Энэ хуулийн 15.2.3.-д “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах” гэж заасны дагуу Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнд тавих аюулгүйн үзүүлэлтийн жагсаалтыг тус хууль батлагдсанаас хойш Эрүүл мэндийн сайдын 2014 оны 11 сарын 07-ны 384 дугаар “Жагсаалт батлах тухай” болон 2019 оны 04 сарын 22-ны А/200 дугаар “Аюулгүйн үзүүлэлт батлах тухай” 2 удаагийн тушаалаар батлагдсан 5 хавсралт 192 үзүүлэлттэйгээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 2024 онд хүнсний түүхий эд бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалтыг нийт 8 бүлэг 468 үзүүлэлт 276 үзүүлэлтээр нэмэгдүүлэн шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдад танилцуулсан байна. Хэрэгжилтийг 70 хувьтай гэж үнэлсэн.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2.4.-д “эрсдэлийн үнэлгээ хийх удирдамж баталж, эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 16.1-д заасан эрсдэлийн үнэлгээний баг /цаашид “баг” гэх /-аар гүйцэтгүүлэх, багийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, үнэлгээний дүнг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх” гэж, 16.1.2.-д “эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал, амьтанд учирч болзошгүй эрсдэлийн нөлөөллийг тодорхойлж, эрсдэлийн түвшнийг тогтоох” гэж тус тус заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь 2014-2024 онд дараах 19 эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаа хийсэн байна. Үүнд:

1. Төмс, хүнсний ногооны тариалалт, хадгалалтын явцад хэрэглэгдэж байгаа химийн бодисын үлдэгдэлд эрсдэлийн үнэлгээ хийх (I шат-2014; II шат-2015);
2. Шингэн сүүний тандалт судалгаа (2016);
3. Савласан усны эрдэсжилтийн судалгаа, эрсдэлийн үнэлгээ (2016);
4. Хиам, зайдсан бүтээгдэхүүний хими, микробиологийн бохирдлын тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ (2017);
5. Үйлдвэрийн аргаар боловсруулсан ундны сүүний чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа (2017);
6. Хүнсний үйлдвэрүүдэд хэрэглэж буй хүнсний нэмэлтийн чанар, аюулгүй байдал, хэрэглээний тандалт судалгаа (2018);
7. Хувиргасан ген бүхий улаан лоолийн тандалт судалгаа (2018);
8. Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдэл тодорхойлох тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ (2019);
9. Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд нитратийн үлдэгдэл тодорхойлох тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ (2020);
10. “Улаанбаатар хот орчмын гүнийн, төвлөрсөн усан хангамжийн тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ” (2020);

11. “Импортын болон дотоодын сүүн бүтээгдэхүүн /зайрмаг/ дэх химийн болон микробиологийн бохирдлын тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ” (2021);
12. Импортын болон дотоодын жимс, жимсгэнийн тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ (2022);
13. Импортын болон дотоодын үйлдвэрийн иоджуулсан давсны химийн бохирдолд хийсэн тандалт судалгаа (2022);
14. Ариутгалын бодисын химийн найрлага, нянд үйлчлэх идэвхийн тандалт судалгаа (2023);
15. Эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмж-Хүнсний нэмэлт (2023);
16. Эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмж-Хүнсний нэмэлт (2023);
17. Эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмж-Хүнсний нэмэлт (2023);
18. Эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмж-Хүнсний нэмэлт (2024);
19. Эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмж-Хүнсний нэмэлт (2024);

Дээрх тандалт судалгаа хийсэн тоонд дүн шинжилгээ хийхэд энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойших 13 жилийн хугацаанд тус лаборатори нь жилд 1,5 тандалт судалгаа хийсэн байна. Энэ нөхцөл байдал олон хүчин зүйлээс хамаарсан боловч хуулийн хэрэгжилтийг хангалттай түвшинд гүйцэтгэсэн гэж үнэлэх боломжгүй юм. **Иймд хэрэгжилт 15 хувьтай байна.**

Үндэсний лавлагаа лабораторийн “Хүнсний шинжилгээний мэдээллийн санг удирдах” үндсэн чиг үүрэгтэй холбон мэдээллийн сангийн өгөгдөлд тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээ хийх тухай, эрсдэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг нарийвчлан тусгасан журмыг “Багийн ажиллах журам”-ын оронд батлуулах нь хүн амын дундах хүнснээс шалтгаалах өвчлөлийг хүнсний бохирдлын үзүүлэлттэй холбон эрсдэлийг үнэлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Улмаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагуудтай хамтарсан “Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэх нь төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, багаар гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ. Мөн хөтөлбөрт мэргэшсэн эрсдэлийн үнэлгээний мэргэжилтэн багийг удирдах тухай, багийн гишүүдийг мэргэшүүлдэг тогтолцоог бий болгох тухай оруулах нь зүйтэй.

Эрсдэлийн үнэлгээ, тандалт хийхэд дээж авах эрх зүйн орчин байхгүйгээс аль нэг салбарын хяналтын байгууллагаар заавал дээж авхуулах шаардлага үүсдэг. Иймд эрх зүйн орчныг сайжруулж, тандалтын дээжийг хяналтын байгууллагын дэргэдэх эрсдэлийн үнэлгээний хүрээлэн өөрөө авдаг болох нь эрсдэлийн үнэлгээ, тандалтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд чухал ахиц болно.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2.5-д “лабораторийн шинжилгээний шинэ аргачлал боловсруулах, энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын ур чадварын сорилт зохион байгуулах, аргын баталгаажуулалт хийх” гэж заасны дагуу MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” стандартын 7.7.2-р заалтыг үндэслэн сорилтын ур чадварыг үнэлэх хөтөлбөрийг итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лабораториудад хүнсний микробиологи, хими, таримал ургамлын үр, хорио цээрийн чиглэлээр MNS ISO/IEC 17043:2010 “Тохирлын үнэлгээ-Ур

чадварын сорилтод тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу үндэсний хэмжээнд жилд 2 удаа зохион байгуулан ажиллаж байна. 2014 оноос ур чадварын хөтөлбөрийг зохион байгуулж 2016, 2018, 2020, 2024 онуудад тус тус үндэсний итгэмжлэлд хамрагдаж 2024.12.16 өдрөөс 2028.05.26-ны өдрийг хүртэл нийт 73 үзүүлэлтээр итгэмжлэгдсэн. Нийт 188 оролцогч лабораторид нийт 22 ээлжийн ур чадварын хөтөлбөрийг зохион байгуулсан байна. 2014-2024 оны хөтөлбөр зохион байгуулалтын талаарх мэдээллийг хавсралтаар оруулав. Хуулийн энэ заалтын хэрэгжилтийг хангалттай гэж үнэллээ.

Тус хуулийн 15.2.6.-д “энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон стандартын сургалт зохион байгуулах” гэж заасны дагуу 2016-2024 он хүртэлх хугацаанд албан хаагчдад сургалтуудыг амжилттай зохион байгуулсан байна. Олон албан хаагчид магистрантурт суралцаж, шинжээч нар судалгааны ажил хийж, илтгэлүүд хэлэлцүүлж хэвлүүлснээс гадна гадаад сургалт болон олон улсын хөтөлбөрөөр суралцжээ. Иймд хуулийн энэ заалтын хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэж байна.

Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш:

2016 он:

- Лабораторийн дотоод сургалтуудыг төлөвлөгөө, хуваарийн дагуу явуулсан байна. (Эмийн хяналтын лабораторийн хувьд 9 удаа)
- 7 ажилтан магистрантурт суралцаж байна.
- Олон шинжээч нар судалгааны ажил хийж, илтгэлүүд хэлэлцүүлж хэвлүүлсэн байна.
- Шинжээчид дотоод болон гаднын байгууллагуудын сургалтад хамрагдсан (жишээ нь "Хэмжлийн эргэлзээ", ХӨСҮТ-ийн сургалтууд, цацрагийн хамгаалалт Малайз улсад гэх мэт) байна.

2017 он:

- ПГУ ба ХАО-ийн сургалт, микробиологийн стандарт аргын сургалтууд зохион байгуулагджээ.
- Танхимын сургалт зохион байгуулалтын хувьд бэлэн байдлыг хангаж ажилласан байна.

2018 он:

- Лабораторийн дотоод сургалтаар нийт 44 удаа сургалт явуулсан байна.
- 4 ажилтан дотоодын их, дээд сургуульд магистрантур, эрх зүйн чиглэлээр суралцсан байна.
- 44 ажилтан гаднын 20 сургалтад хамрагдсан байна.
- 19 ажилтан гадаадад 13 чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна. (Япон, Хятад, БНСУ, Энэтхэг, Өмнөд Африк, Эквадор, ОХУ гэх мэт олон улс орны сургалтууд)

2019 он:

- Дотоод сургалт 31 удаа
- Гадаад сургалтад 14 ажилтан оролцсон байна.
- 3 ажилтан олон улсын хөтөлбөрөөр суралцсан байна.

2020 он:

- Дотоод сургалт 10 удаа

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

- Цар тахлын улмаас цахим сургалт нэмэгдсэн байна.

2021 он:

- Дотоод сургалтад нийт 83 удаагийн сургалт зохион байгуулж, 262 хүн (давхардсан тоогоор) хамрагдсан байна.
- Гадаад сургалтад БНХАУ-аас зохион байгуулсан онлайн семинар, мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй олон улсын чанартай сургалтад нийт 3 хүн хамрагдсан байна.
- Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн төв лаборатори -165 хүн, орон нутгийн хяналтын итгэмжлэгдсэн сүлжээ лабораториуд- 84 хүн, хувийн хэвшлийн бусад лабораториуд- 16 хүн тус тус хамрагдсан байна.

2022 он:

- Дотоод сургалтад 108 хүн;
- Гаднын сургалтад 24 хүн хамрагдсан ба үүнд хяналтын итгэмжлэгдсэн лабораториудаас 12 шинжээч Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори-д дагалдуулан суралцсан байна.

2023 он:

- Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ажилтан, албан хаагч, шинжээчдийн сургалтад хамрагдсан нийт тоо 145 буюу үүнд орон нутгийн сүлжээ лабораториудаас 45 хүн, хувийн хэвшлийн мэргэжилтнүүдэд тусгайлан 1 өдрийн сургалт зохион байгуулсан байна.

2024 он:

- Хувь хүний хөгжил, ёс зүй, стандартын сургалт, ажилтан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх мэргэжлийн сургалтын чиглэлээр давхардсан тоогоор 434 хүнд зохион байгуулсан байна. Нэгж лабораториуд дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 50 сургалтыг дотооддоо зохион байгуулжээ.

Хяналтын сүлжээ лабораториудынхаа хэмжээнд жилдээ нэг чиглэлээр /хими, микробиологи, хорио цээр/ сургалтыг зохион байгуулж байна. Энэхүү нэгдсэн сургалтад 30-аас доошгүй мэргэжилтнийг онол, дадлагын хосолсон сэдвээр хамруулж, батламж олгож байна. Мөн орон нутгийн хяналтын лабораториудын шинжээч мэргэжилтнийг мэргэшүүлэх ажлын байран дээрх 7-14 хоногийн сургалтад тухайн орон нутгийн албан томилолтоор ирсэн 10-аас доошгүй шинжээчдийг дадлагажуулж байна.

Хуулийн 15.2.6.-д “Энэ хуулийн 15.3-д заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон стандартын сургалт зохион байгуулах” гэсэн заалтын хэрэгжилт 70 хувьтай байна. Хувийн хэвшлийн хүнсний лабораториудын шинжээч мэргэжилтнүүдийг албан хүсэлтийн нь дагуу 7-10 хоногийн сургалтад хамруулж байна. Ур чадварын сорилтын хөтөлбөрийн дараах сургалтыг 3 удаа нийт 40 орчим хүнсний үйлдвэрийн шинжээчдийг сургасан байна. Төсөв, санхүүгийн асуудлаас шалтгаалан Захирлын зөвлөлийг ажиллуулах, орон нутгийн шинжээч мэргэжилтнийг тасралтгүй дадлагажуулах, түүнчлэн хувийн лабораториудын ур чадварын сорилтын дараах сургалт тогтмол явагдах боломжгүй байна. Ялангуяа сургалт зохион байгуулах нэгжтэй байхыг хуульд эсвэл лавлагаа лабораторийн ажиллах журамд тусгагдаагүй тул албан ёсны гэрчилгээтэй сургалтыг хийх эрх авах, мөн төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа.

Хүнсний аюулгүй байдлын талаарх техникийн зохицуулалт, эрүүл ахуйн болон ариун цэврийн арга хэмжээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн төсөлд санал өгөх гэсэн заалтын хэрэгжилтийг Үндэсний лавлагаа лаборатори өөрөө 90 хувьтай байгаа гэж дүгнэсэн байна. Тус лаборатори нь Стандартчилал хэмжил зүйн газраас үндэсний стандартаар батлах хүнсний түүхий эд бүтээгдэхүүний техникийн шаардлагын болон шинжилгээний аргын стандартын төсөлд албан ёсоор санал өгдөг бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаар 12 стандартын төслийг хянаж, шинжилгээг бүрэн хийснээр шинжилгээний аргын сонголт, тухайн бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагад заасан үзүүлэлтийн хэмжээг олон улсын зөвлөмж, шаардлагатай харьцуулан судалж, алдааг залруулах саналыг хүргүүлсэн байна.

Одоогийн байдлаар зөвхөн төрийн байгууллага хоорондын албан хүсэлтээр үйлдвэрлэгчээс боловсруулсан стандартын төслийг хянаж, санал өгч байна. Гэтэл дээрх 12 стандарт нь хүнсний аюулгүйн үзүүлэлтийг шинжлэхэд өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийгээгүй зөвхөн санал өгсөн стандартын тоо тул өндөр оноо өгөх учир дутагдалтай гэж оролцогчдын зүгээс үзсэн. Иймд цаашид үйлдвэрлэгчээс стандарт боловсруулах захиалга авах, хамтран боловсруулж, батлуулах асуудлыг холбогдох төсвийн зардал, орлого, урамшуулалтай нь хуульд эсвэл лавлагаа лабораторийн ажиллах журамд тусгаж өгвөл лабораторийн эрдэм шинжилгээ, судалгаа хөгжихийн зэрэгцээ лабораторийн ажилтнуудад зориулсан стандартын сургалтыг явуулах нөхцөл бүрдэх юм.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2016 оны 167 дугаар тушаалаар батлагдсан аргачлалд хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээс хэрхэн дээж авах тухай, дээжийн тоо хэмжээний талаар санал боловсруулж тусгуулсныг одоогийн байдлаар мөрдөн ажиллаж байна.

Тус хуулийн 15.2.7.-д “хүнсний аюулгүй байдлын талаарх техникийн зохицуулалт, эрүүл ахуйн болон ариун цэврийн арга хэмжээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн төсөлд санал өгөх” гэж заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь жил бүр 10-15 үндэсний стандартын төсөлд хими, микробиологи, цацраг, ургамлын эрүүл ахуй хорио цээрийн чиглэлээр санал өгч ажилласан байна. Хэрэгжилт хангалттай байна.

Шинжилгээтэй холбогдсон маргааныг магадлан шинжлэх асуудлын талаар Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 42 дугаар тушаалаар батлагдсан Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирлын зөвлөлийн ажиллах журмын “3.1.5. Хүнсний лабораториудын шинжилгээний үр дүнгийн зөрүүтэй байдал, түүнтэй холбоотой маргаан, хүсэлтийг эцэслэн шийдвэрлэсэн тухай шинжээчдийн багийн тайланг хэлэлцэж баталгаажуулах”-аар оруулсан. Мөн итгэмжлэгдсэн лаборатори хоорондын шинжилгээний зөрүүгээс гарсан маргааныг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.1.Тохирлын үнэлгээний байгууллагаас итгэмжлэлийн талаар гаргасан маргааныг Маргаан шийдвэрлэх комисс (цаашид “Комисс” гэх) шийдвэрлэнэ.” гэж заасны Итгэмжлэлийн байгууллагаас шийдвэрлэдэг. Энэхүү комиссоос ирүүлсэн 2 дээж буюу цайнд афлатоксин, тарганд сүүн хүчлийн бактери тодорхойлох шинжилгээ хийж, тайланг гаргасан.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2.8.-д “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шинжлэх арга, сорьц, дээж авах аргачлал, шинжлэх асуудлаар зөвлөгөө өгөх, шинжилгээтэй холбогдсон маргааныг магадлан шинжлэх, шаардлагатай бол онцгой байдлын болон гамшгийн үед авсан дээжид шинжилгээ хийх” гэж заасан байдаг. Хуулийн дагуу батлагдсан Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дугаар тушаал “Лабораторид дээж хүлээлгэн өгөх, дээж хүлээн авах, шинжилгээний дүнг олгох, төлбөр барагдуулах үйл ажиллагаанд мөрдөх журам”, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 253 тушаал Хэмжилт, шинжилгээ, халдваргүйжүүлэлтийн үнэ батлах тухай, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны 167-р тушаал “Аргачлал батлах тухай” дээжийн тоо хэмжээ, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 68 дугаар тушаал: “Бүтээгдэхүүнээс дээж авах, түүнийг хадгалах, тээвэрлэх журам”, Монгол Улсын Шадар Сайдын 2024 оны 10 дугаар тушаал “Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” журмын хүрээнд лабораторид дээж хүлээн авдаг байна. 2019 оноос өмнө тоон тайлан цаасан хэлбэрээр гарч байсан бол 2019 оноос ЛИМС систем нэвтэрч тоон тайланг цахимаар гаргаж байна.

2019 онд 25726 дээжид 154187 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 2143 байгаа нь нийт үзүүлэлтийн 1,39 хувийг эзэлсэн байна. Маргаан таслах, баталгаажуулах давтан шинжилгээг 29 дээжид 54 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

2020 онд 26921 дээжид 144387 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 1947 байгаа нь нийт үзүүлэлтийн 1,35 хувийг эзэлжээ. Маргаан таслах, баталгаажуулах давтан шинжилгээг 58 дээжид 100 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

2021 онд 23610 дээжид 129827 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 1596 байгаа нь нийт үзүүлэлтийн 1,23 хувийг эзэлсэн байна. Маргаан таслах, баталгаажуулах давтан шинжилгээг 43 дээжид 76 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

2022 онд 26816 дээжид 143165 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 1880 байгаа нь нийт үзүүлэлтийн 1,31 хувийг эзэлсэн байна. Маргаан таслах, баталгаажуулах давтан шинжилгээг 76 дээжид 99 үзүүлэлтээр шинжилгээ хийжээ.

2023 онд 29660 дээжид 164314 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 1627 байгаа нь нийт үзүүлэлтийн 0,99 хувийг эзэлсэн байна. Маргаан таслах, баталгаажуулах давтан шинжилгээг 56 дээжид 152 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

2024 онд 28119 дээжид 156856 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 1562 байгаа нь нийт үзүүлэлтийн 0,99 хувийг эзэлж байна. Маргаан таслах, баталгаажуулах давтан шинжилгээг 25 дээжид 94 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна. **Хуулийн энэ заалтын хэрэгжилт хангалттай түвшинд хэрэгжсэн байна гэж үнэлсэн.**

Лабораторийн шинжилгээний шинэ аргачлал боловсруулах, энэ хуулийн 15.3-д заасан лабораториудын ур чадварын сорилт зохион байгуулах, аргын

баталгаажуулалт хийх гэсэн заалтын хэрэгжилт 2018 оны байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй байсан байна. Тус лаборатори нь жил бүр хүнсний түүхий эд бүтээгдэхүүний шинжилгээний аргын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах чиглэлээр ажил төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаар 33 үндэсний стандартад засвар өөрчлөлт оруулан батлуулсан байна. Мөн хүнсний шинжилгээний 53 стандарт ажлын зааврыг боловсруулан нэвтрүүлж, итгэмжлэлийн хүрээний тодрхойлолтоо өргөжүүлжээ.

Энэ хуулийн 15.3.-д “Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лаборатори хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, дээжийн шинжилгээ хийхэд оролцоно” гэж заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториос 2020 онд 819 дээжид 2052 үзүүлэлтээр, 2021 онд 240 дээжид 1440 үзүүлэлтээр, 2022 онд 1 дээжид 1 үзүүлэлтээр, 2023 онд 4 дээжид 4 үзүүлэлтээр, 2024 онд 119 дээжид 438 үзүүлэлтээр тус тус тандалт, судалгааны чиглэлээр шинжилгээ хийсэн дүнгээс харахад жил ирэх тусам тандалт судалгааны чиглэлээр хийх шинжилгээний дээж, түүний үзүүлэлтийн тоо буурсаар байгааг харж болно. **Хуулийн энэ заалтын хэрэгжилтийг 30 хувьтай гэж үнэллээ.**

Хувийн хэвшлийн хүнсний шинжилгээний лабораториудын дүнгийн мэдээллийг нэгтгэх боломжгүй байгаа. Учир нь, MNS ISO 17025-2018 олон улсын стандартад сорилтын лаборатори нь хэрэглэгчийн нууцлалыг хангах, шударга байх зарчмыг зөрчиж байна гэж үзэж байгаа тул Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид мэдээллээ өгөхгүй байгаа нь **энэ хуулийн 15.4.-д** “Энэ хуулийн 15.3-д заасан лаборатори шинжилгээний дүнгээ мэдээллийн нэгдсэн санд тухай бүр хүргүүлнэ” гэж заасан заалтын хэрэгжилт огт хэрэгждэггүй байна. Харин Стандартчилал хэмжил зүйн газрын аймаг, орон нутгийн сүлжээ лабораторийн LIMS системийн шинжилгээний мэдээллийг тогтмол төвлрүүлэн ажиллаж байна. Иймд энэ заалтыг хэрэгжүүлэх боломжийг судлах асуудлаар энэ хуулийн 15.3.-д заасан лабораторийн төлөөллүүдтэй хэлэлцүүлэг хийх замаар асуудалд хандах нь зүйтэй байна. Харин хуулийн **хэрэгжилтийг 50 хувьтай гэж үнэллээ.**

Хувийн өмчит итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийг **энэхүү хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтын** хүрээнд батлагдсан Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ажиллах журам”-аар Үндэсний лавлагаа лабораторийн ерөнхий захирлын дэргэд ажиллах Захирлын зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлэх зохицуулалт туссан. Уг зөвлөлийн бүрэлдэхүүн болон түүний ажиллах журмыг хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 2016 онд 42 дугаар тушаалаараа баталж, зөвлөлийг хүнсний лабораториудын төлөөллийн дээд хэлбэр мөн /журмын 1.3 дахь заалт/ бөгөөд холбогдох асуудлыг хэлэлцэж, лабораторийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагааг уялдуулах /журмын 3.1.2 дахь заалт/ чиг үүргийг тодорхойлж өгсөн боловч Захирлын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаагаас лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг хэрэгжих боломжгүй гэж лабораторийн зүгээс үзсэн байна.

Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Эрсдэлийн үнэлгээний багийн ажиллах журам”-ыг мөн баталсан. Энэ журмын хүрээнд

эрсдэлийн үнэлгээний багийн үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон байдаг. Энэ хуулийн 16 дугаар зүйлд эрсдэлийн үнэлгээний багийн үйл ажиллагааны талаар дурдсан болно.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны Жагсаалт батлах тухай 384 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хүнсний бүтээгдэхүүний химийн аюулгүй үзүүлэлт”, 2 дугаар хавсралтаар “Хүнсний бүтээгдэхүүний нян судлалын аюулгүй үзүүлэлт”, 3-р хавсралтаар “Ургамлын эрүүл ахуй хорио цээрийн үзүүлэлт”, 4-р хавсралтаар хүнсний бүтээгдэхүүний хүнд металлын үзүүлэлтийг баталсан бөгөөд хэрэгжилт 2018 оны байдлаар 77.33 хувьтай байсан байна.

Харин Эрүүл мэндийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын А/200 дугаар тушаалаар Ургамлын хорио цээрийн аюулгүйн үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулж, цацрагийн аюулгүй үзүүлэлтийг шинээр боловсруулан баталжээ. Мөн онд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь уг жагсаалтад орсон 92 үзүүлэлтийг цацрагийн бохирдлын 2 үзүүлэлтээр өргөжүүлэхээр химийн, нян судлалын, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн, хүнд металлын болон цацрагийн гэсэн 5 чиглэлээр нийт 94 аюулгүйн үзүүлэлтийг үндэслэн судалгааг гаргахад Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори 57 /62 хувь/, НМХГ-ын Төв лаборатори 42 /46 хувь/, Замын-үүд хилийн боомтын лаборатори 29 /32 хувь/, Увс аймгийн лаборатори 28 /30 хувь/, Сэлэнгэ 27 /29 хувь/, Өмнөговь 26 /28 хувь/, Дорнод 21 /23 хувь/, Ховд 20 /22 хувь/, Архангай 19 /21 хувь/, Дархан-Уул 19 /21 хувь/, Дорноговь 19 /21 хувь/, Орхон 19 /21 хувь/, Булган, Хэнтий, Төв 17 /18 хувь/, Хөвсгөл, Завхан 16 /17 хувь/, Алтанбулаг 15 /16 хувь/, Баян-Өлгий, Говь-Алтай, Сүхбаатар аймгууд 15 /16 хувь/, Дундговь 14 /15 хувь/, Баянхонгор 13 /14 хувь/, Говьсүмбэр, Багануур, Налайх дүүрэг 10 /11 хувь/, Өвөрхангай аймаг 8 /9 хувь/ үзүүлэлтийг тодорхойлдог байсан байна.

2018 онд Хүнсний аюулгүй байдлыг чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нийт 27 итгэмжлэгдсэн лаборатори нь эм болон хүнсний хими, нян судлал, ургамлын эрүүл ахуй, хорио цээр, цацрагийн бохирдлын чанар, аюулгүй байдлын 14593 /давхардсан тоогоор/ үзүүлэлтээр шинжилгээг гүйцэтгэж байгаагаас зөвхөн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 534 аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавхтай байсан байна.

2023 оны “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд” статистикийн мэдээнд Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанарын болон аюулгүйн үзүүлэлтээр Үндэсний MNS/ISO 17025 стандартын дагуу эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн төрийн өмчит 25 лаборатори хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд: 21 аймаг тус бүрд 1, нийслэлд 4 лаборатори үйл ажиллагаа явуулж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх явцад үүссэн давхцал болон хийдэл үүссэн байдлын талаар дурьдвал:

Хуулийн 17 дугаар зүйлд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, биобэлдмэлийн болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн

тогтоох тухай заасан тул Үндэсний лавлагаа лабораторийн аюулгүйн үзүүлэлтүүдийг жагсаалт болгон батлуулах чиг үүрэг давхардаж байсан байна.

Мөн хүнсний бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тусгасан дараах стандартууд мөрдөгдөж байсан байна. Үүнд:

- MNS 6308:2012. Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ;
- MNS 6361:2012. Хүнс, малын тэжээл дэх микотоксины үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 4504:2008. Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын зөвшөөрөгдөх хэмжээ;
- MNS 5867:2008. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах меламины зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 5868:2008. Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 6359:2012. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах бензапирений зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS 6420:2013. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мал амьтны тэжээлд агуулагдах нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS CAC MRL 2:2017. Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
- MNS CAC 193:2007. Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт;
- MNS CAC 192:2015. Хүнсний нэмэлт зэрэг стандартууд болно.

Иймээс хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бохирдлын зөвшөөрөгдөх хэмжээг заасан стандартыг хүнсний хяналт, зохицуулалтын агентлагийн стандартыг хөгжүүлэх нэгжээс боловсруулан, уг стандартын төслийг стандартын байгууллага үндэсний стандартуудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар баталж мөрдүүлдэг болох тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй. Цаашид хуульд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, түүний хэм, хэмжээ, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зохистой дадалд тавигдах шаардлагыг дүрэм, журам, заавар, хялбаршуулсан заавар, аргачлалаар бус зөвхөн үндэсний стандартын түвшинд боловсруулж, батлуулаад, түүнийг мөрдлөг болгох асуудлыг хуулиар зохицуулах хэрэгтэй байна.

Монгол Улсын Шадар сайд, Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 тоот “Журам батлах тухай” тушаал, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны А/192 тоот “Заавар батлах тухай” тушаалын дагуу Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хяналтын лабораториуд бэлэн байдлыг хангаж, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь хяналтын лабораториудын шинжилгээний үр дүнг баталгаажуулан ажиллаж байна.

Хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн нэгдсэн сүлжээнд нийслэл, аймаг, хилийн боомтын 27 лаборатори ажилладаг бөгөөд сүлжээний хэмжээгээр 2016 онд нийт 136573 дээжийн чанар, аюулгүй байдлын шинжилгээ хийсний 74193 /54,32 хувь/ дээж нь хүнсний дээж байсан бөгөөд нийт хүнсний дээжний 3672 /4,94 хувь/ нь шаардлага хангаагүй дүнтэй гарсан бол 2017 оны хувьд 139 181 дээжийн шинжилгээ хийсний 80812 /58,06 хувь/ дээж нь хүнсний дээж байсан бөгөөд нийт хүнсний дээжний 4429 /5,48 хувь/ нь шаардлага хангаагүй дүнтэй гарсан байна. Харин 2018 онд 160431

дээжийн шинжилгээ хийсний 98 828 /31,6 хувь/ дээж нь хүнсний дээж байсан бөгөөд нийт хүнсний дээжний 4547 /4,60 хувь/ нь шаардлага хангаагүй дүнтэй гарсан байна.

Ур чадварын сорилтод оролцогч хувийн хэвшлийн хүнсний лабораториудын мэдээллээс үзэхэд жилдээ дунджаар 85 орчим хүнсний лаборатори өөрийн бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шинжилгээг хийж, ур чадвараа сорьж байна.

Хяналтын лабораториудад хийгдсэн шинжилгээний үр дүнгийн мэдээлэл үнэн бодитой бүртгэгдэх бөгөөд экспорт, импортын хүнсний түүхий эд бүтээгдэхүүний нэр төрлийг бүрэн хамарсан, мөн хүнсээр дамжих өвчлөл болон гамшгийн үед хийгдсэн шинжилгээнүүд, иргэдийн гомдол, бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүндээ хийлгэсэн хөндлөнгийн шинжилгээ гэх мэт цар хүрээ өргөн тул хяналтын сүлжээ лабораториудын мэдээллийн сан манай улсын нийт хүнсний шинжилгээний төлөв байдлыг илэрхийлэх боломжтой тул мэдээллийн санг хяналтын сүлжээ лабораториудын мэдээллээр бүрдүүлж удирдах тухайг хуульд тусгах хэрэгтэй байна. Энэхүү заалтын хэрэгжилт 50 хувьтай байна гэж үнэлсэн.

Хяналтын сүлжээ лабораториуд итгэмжлэгдсэн лабораторийн нэгдсэн сүлжээний хэмжээгээр мэдээллийн санд бүртгэгдсэн зөвхөн аюулгүйн үзүүлэлтүүдээр хийгдсэн шинжилгээний дүнг 2018 оны байдлаар үзүүлбэл, нийт 4061 хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд аюулгүйн үзүүлэлтээр шинжилгээ хийснээс ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хэсэгт 172; хордлого, хордлогот халдварын хэсэгт 32; эрүүл ахуйн шаардлага хангаагүй дээжийн хэсэгт 2974; түүхий сүү, сүүн бүтээгдэхүүний хэсэгт 88; нөөшилсөн бүтээгдэхүүний хэсэгт 12; төмс, хүнсний ногооны хэсэгт дээж алдаа заасан, гурил, гурилан бүтээгдэхүүний хэсэгт 305; ундаа, жүүсний хэсэгт 304; чихэр, чихрэн бүтээгдэхүүний хэсэгт 43; мах, махан бүтээгдэхүүний хэсэгт 78 дээж тус тус бүртгэгдсэн байна. Үүнд дүн шинжилгээ хийхэд лабораториудад хүлээн авсан нийт дээжийн 66.2 хувь буюу 62724 дээжийг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд нян судлалын шинжилгээнд 17280 дээж 46450 үзүүлэлтээр орсноос 985 дээж (5.7 хувь), химийн шинжилгээнд 37324 дээж 122819 үзүүлэлтээр орсноос 1432 дээж (3.8 хувь) стандартын шаардлагад нийцээгүй гарсан байна.

Хувийн хэвшлийн хүнсний шинжилгээний лабораториудын дүнгийн мэдээллийг нэгтгэх боломжгүй. Учир нь, MNS ISO 17025-2018 олон улсын стандартад сорилтын лаборатори нь хэрэглэгчийн нууцлалыг хангах, шударга байх зарчмыг зөрчиж байна. Уг санг хувийн өмчит лабораториуд /АПУ ХК, СББ ХХК, Сүү ХК, Мах импекс ХХК, Витафит ХХК, Жем интернейшнл ХХК, Сtimo ХК, Тесо ХХК, Талх чихэр ХК, Атар-Өргөө ХК, Би-Цэ трейд ХХК зэрэг үйлдвэрийн дотоод хяналтын лабораториуд/-ын шинжилгээний мэдээллээр өргөжүүлэхээр хуулийн 15.4 дэх заалтыг хэрэгжүүлэх тухай албан хүсэлт хүргүүлсэн боловч шинжилгээний дүнгийн талаар ямар нэг мэдээлэл ирээгүй байна.

Төрийн өмчит бусад лабораториуд болон хувийн өмчит хүнсний шинжилгээний итгэмжлэгдсэн лабораториуд нь ISO 17025:2017 олон стандартын хамгийн гол шаардлага болох шударга байдал-бодит үнэнч байх, нууцлалыг хангаж чадахаа баталж итгэмжлэгддэг тул шинжилгээний мэдээллийг өөр газарт хүргүүлэх эсэх нь тэдэнд хандаж үйлчлүүлсэн хэрэглэгчээс хамаарна. Тиймээс энэхүү заалт нь олон улсын стандартын шаардлагатай нийцэхгүй байна.

2.4.2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйл. Эрсдэлийн үнэлгээ хийх

Эрсдэлийн үнэлгээ хийх удирдамж баталж, эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 16.1-д заасан эрсдэлийн үнэлгээний баг /цаашид “баг” гэх /-аар гүйцэтгүүлэх, багийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, үнэлгээний дүнг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх гэсэн заалтын хэрэгжилт 30 хувьтай байна. Хуулийн энэ зүйлийн хэрэгжилтийг хангахад манай улсад мэргэжлийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй гэж дүгнэж байна.

Олон улсын хэмжээнд хүнсний баталгаат байдлыг хангах сайн засаглалын жишээгээр бол Хүнсний хяналт, зохицуулалтын агентлагийн дэргэд Эрсдэлийн үнэлгээний хүрээлэн ажиллах бөгөөд энэ хүрээлэн нь хүнсний баталгаат байдалд шинжлэх ухаанд суурилсан, хараат бус дүгнэлт гаргаж өгдөг мэргэжлийн байгууллага байдаг. Тус хүрээлэн нь лабораторийн өдөр тутмын хяналтын сорилын шинжилгээ хийдэггүй ч шинжилгээний дүнг тайлбарлах чадамжтай, бодлогын түвшин дэх стратегийн зөвлөх байгууллага байхаар зохион байгуулдаг байна. Тухайлбал, АНУ-ын FDA-гийн дэргэдэх Center for Food Safety and Applied Nutrition (CFSAN), Японы Food Safety Commission (FSC), ЕХ-ны EFSA (European Food Safety Authority) нь яг ийм чиг үүрэгтэй байгууллагууд байдаг.

Хуулийн 16.1.1.-д Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим /хуулийн 5 дугаар зүйлийн 5 заалт/ алдагдагдсанаас үүссэн аюулыг үнэлэх болон эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал амьтанд учирч болзошгүй эрсдэлийн нөлөөллийг тодорхойлж, эрсдэлийн түвшинг тогтоох” гэсэн хэт өргөн утгаар орсон нь эрсдэлийн үнэлгээний багийн гишүүдийг салбар бүрээс бүрэн томилох, багийн ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.

Эрсдэлийн үнэлгээ хийх багийн зорилго, бүрэлдэхүүн, чиг үүргийн талаар дэлгэрэнгүй тусгасан журмыг Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлуулсан боловч **хэрэгжилт хангалтгүй түвшинд буюу 30 хувьтай байна.** Уг журамд “Хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” зарчмыг тусгасан байна.

Манай улсын махны экспортод гол нөлөөлөх хүчин зүйл бол малын гоц халдварт өвчний гаралт, тархалтын асуудал байдаг. Жил бүр бруцеллёзын тандалтад зориулж 20 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сумын тасаг, нэгжийн оролцоотой цуглуулсан дээжид илрүүлэх шинжилгээг хийдэг байна. Шинжилгээний дүнд эерэг дээжийн эзлэх хувийг дараах зурагт дүрслэн харуулав.

4 дүгээр зураг. Бруцеллёзын тандалт судалгааны эерэг дээжийн эзлэх хувь



Ялангуяа бохирдлын түвшин өндөр гарсан хүнсний бүтээгдэхүүнд аюулгүйн үзүүлэлтээр эрсдэлийг үнэлэх, хими болон микробиологийн бохирдлын үлдэгдлийг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулах, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, арилгах, хүнснээс шалтгаалах өвчлөлийг бууруулах чиглэлээр зөвлөмж боловсруулдаг байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хэрэгжүүлж буй тандалт судалгааны сэдвийг хүнсний аюулгүй байдлын өнөөгийн байдал, цаашдын төлөвийг хүн амын өсөлт, эрүүл мэндийн үзүүлэлттэй холбоотойгоор сонгон судлах, хүн амын дунд хүнснээс шалтгаалах халдварт бус болон хоол хүнсээр дамжих өвчин, хүнсний бохирдол, нөлөөллийн хүчин зүйлс, эрсдэлийн талаарх судалгааг үр дүнтэй хийж гүйцэтгэх хэрэгтэй байгаа.

Энэ хуулийн 16.2.-д “Үндэсний лавлагаа лаборатори энэ хуулийн 16.1-д заасан багийг ашиг сонирхлын зөрчилгүй, дадлага туршлагатай, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд болон бусад салбарын шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн шинжээч, мэргэжилтнээс тухай бүрд нь бүрдүүлнэ” гэж заасны дагуу Багийг томилсон Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Ерөнхий захирлын удирдамжид заасан багийн бүрэлдэхүүнд тухай бүрд нь холбогдох чиглэлийн хяналтын улсын байцаагч, лабораторийн шинжээч нар оруулсан байхаар баталсан боловч хэрэгжилт хангалттай биш байна.

Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лабораториудын шинжилгээний ур чадварыг сорих, үнэлэх хөтөлбөрийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж эхэлсэн 2014 оноос хойш нийтдээ 8 удаа зохион байгуулж, үндэсний хэмжээнд анх удаа хүнсний ур чадварын сорилтын чиглэлээр 2 удаа итгэмжлэгдээд байна.

Монгол Улсын Шадар сайд, Байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”, 2 дугаар хавсралт “Эрсдэлийн үнэлгээний аргачлал”- уудад дурьдсан байна. Тус лаборатори нь үндэсний хэмжээнд хүнсний шинжилгээний хамгийн өргөн хүрээгээр итгэмжлэгдсэн тул өөрсдийн мөрдөж буй шинжилгээний аргын үндэсний стандарт (MNS)-уудыг засаж сайжруулахаас гадна өөрийн лабораторид тохирсон шинжилгээний арга (in house method)-уудыг боловсруулжээ.

Энэ хуулийн 16.3.1.-д “шинжлэх ухаанаар нотлогдсон мэдээллийг ашиглан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалаар ил тод, бие даасан байдлаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд агуулагдаж болзошгүй бохирдлын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх” гэж заасны дагуу шинжилгээний шинэ арга, аргачлалыг боловсруулах, туршин нэвтрүүлэх эрдэм шинжилгээний ажлын зардал төсвөөс хасагддаг тул олон улсын стандартууд (ISO)-ыг орчуулан, шинжилгээнд нэвтрүүлэх нөхцөл **хангалтгүй түвшинд** байдаг байна.

Энэ заалтын хүрээнд ДЭМБ-аас гаргасан Хүнсэн дэх химийн эрсдэлийн үнэлгээний арга, аргачлал (Principles and methods for the risk assessment of chemicals in food ЕНС 240) болон ОХУ-ын Хүн амын хүнсний бүтээгдэхүүний химийн бохирдуулагчид өртөх эрсдэл ба өртөлтийг тодорхойлох нь (Определение экспозиции и оценка риска воздействия химических контаминантов пищевых продуктов на население, 2009, МУ2.3.7.2519-09) удирдамжуудыг харьцуулан судалж, эрсдэлийн үнэлгээндээ ашигласан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 16.3.2.-д “эрсдэлийн үнэлгээ хийхэд судалгаа, шинжилгээний нотолгоо хангалттай бус, түүнчлэн хүний эрүүл мэндэд аюул учруулахуйц нөхцөл үүссэн тохиолдолд олон улсын байгууллага, бусад улсын боломжит мэдээллийг үндэслэн холбогдох арга хэмжээг авах” гэж заасан байдаг.

Тус лаборатори нь хүнсний бүтээгдэхүүнд тандалт судалгаа, эрсдэлийн үнэлгээний багийг томилон удирдамжийг баталж, үнэлгээний тайланг холбогдох төрийн байгууллагад тайланг хүргүүлнэ гэсэн заалтын хэрэгжилт 30 хувьтай гэж дүгнэсэн боловч үнэлгээний төлөвлөгөөнд хэдэн ажил жилд төлөвлөдөг эсэх, хэдийг нь хийж гүйцэтгэсэн, ойлгомжгүй байсан тул хэрэгжилтийг 15 хувь болгож бууруулж үнэлсэн.

Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний сүлжээнд тавих хяналтыг явуулахын тулд Хүнсний хяналтын байгууллагын дэргэд Эрсдэлийн үнэлгээний хүрээлэн ажиллуулж чадвал энэ хуулийн хэрэгжилтийг хангахад ахиц гарах болно. Энэ Эрсдэлийн үнэлгээний хүрээлэн байгуулах асуудлыг хуулийн төсөлд тусгах саналтай байна.

2.4.3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.-д хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар хэрэгжүүлэх хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байдаг.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай **хуулийн 17.1.1.-д** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь “хүнсний сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар сургалт зохион байгуулах” үүрэгтэй гэж заасан. Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2013-2018 онд хүнсний сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар нийт 10 гаруй удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж, тэдгээрт нийт 30 орчим сая төгрөгийг зарцуулжээ. Төсөв хөрөнгийн дутагдалтай байдлаас шалтгаалан зохистой дадлын сургалтыг тогтмол бус зохион байгуулж ирсэн талаар тайлагнасан байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжилтэй уялдан цаашид зохистой дадлын чиглэлээр зохион байгуулах сургалтын хэрэгцээ, шаардлага нэмэгдэх хандлагатай. Энэ хэрэгцээ, шаардлагыг улсын төсвийн хөрөнгөөр сургалт зохион байгуулах замаар хангах боломжгүй. Иймд хүнсний сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар сургалт зохион байгуулах чиг үүргийг салбарын мэргэжлийн холбоодод шилжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна. Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн 3.5.5-д “... хүнсний сүлжээнд зохистой дадлын сургалт зохион байгуулах зэрэг чиг үүргийг салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, их дээд сургуульд шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх” арга хэмжээг тусгасан.

Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газраас 2018-2024 оныг дуустал 45 удаагийн сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөөнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нийт 3907 төлөөллийг хамруулсан байна.

2017-2018 онд хяналт шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж байгууллагын зохистой дадал нэвтрүүлсэн байх заалтын хэрэгжилт хүнсний худалдаа эрхлэгчдэд 65.7 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 70.4 хувь, мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлд 29.4 хувь -ийн хэрэгжилттэй байна. Эрүүл ахуйн зохистой дадлын хэрэгжилтийн байдлыг тодруулбал: хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд 72.3 хувь, хүнсний худалдаа эрхлэгчдэд 65.7 хувь, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд 67.5 хувийн хэрэгжилттэй байсан байна. **Энэ заалтын хэрэгжилт 30 хүрэхгүй хувьтай гэж үнэллээ.**

Энэ хуулийн 17.1.2.-д “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх мал, амьтны эмийн үлдэц болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох” гэж заасны дагуу Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Зөвшөөрөгдөх дээд хэмжээ тогтоох тухай” А/31 дүгээр тушаалын хавсралтаар “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-г баталсан байна.

Энэ хуулийн 17.1.3.-д “мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээл, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах бордооны аюулгүй байдалд тавих шаардлагыг тогтоох” гэж заасны дагуу бордооны аюулгүй байдалд тавих шаардлагыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А-105 дугаар тушаалаар тогтоосон.

Хууль хэрэгжиж эхлээд 9 жил болсны дараа өмнөх тушаалыг хүчингүй болгоод Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн А-29 дугаар тушаалын хавсралтаар “Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн аюулгүй байдалд тавих шаардлага”-ыг баталсан хэдий ч 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Тушаал хүчингүй болсонд тооцох тухай” А/100 дугаар тушаалаар хүчингүй болгосон байна. **Хуульд заасан эрх зүйн орчин үүсээгүй тул** Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулиар дээрх зохицуулалтыг ханган ажиллаж байна.

Тус хуулийн 17.1.4.-д “ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд пестицид, бордооны үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө батлах” гэж заасан боловч ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд пестицид, бордооны үлдэгдлийн хяналтын төлөвлөгөөний төсөл боловсруулсан гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тайлагнасан. Хуулийн энэ заалт огт хэрэгжээгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай **хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.-д** хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар хэрэгжүүлэх эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байдаг.

Энэ хуулийн 17.2.1.-д “тусгай хоолны дэглэмтэй хүнд зориулсан хүнсний бүтээгдэхүүн, энэ хуулийн 6.5.3-т заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлд тавих шаардлагыг тогтоох” гэж заасан чиг үүргийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Тусгай хоолны дэглэмтэй хүн, нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд тавих шаардлага, түүнийг тогтоох журам” батлагдсан.

Энэ хуулийн 17.2.2.-17.2.3.-д Эрүүл мэндийн яам нь “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох” гэх, “хүнсний нэмэлтийн аюулгүй хэрэглээний түвшинг тогтоож, хэрэглэх нөхцөлийг тодорхойлох” гэх үүргийг тус тус заасан байдаг. Гэвч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн дээд хэмжээг тогтоох, түүнчлэн хүнсний нэмэлтийн аюулгүй хэрэглээний түвшин тогтоож, хэрэглэх нөхцөлийг тодорхойлох асуудал нь улс орнуудын лаборатори, шинжлэх ухааны чадавхаас ихээхэн хамааралтай асуудал юм.

Тиймээс НҮБ-ын ХХААБ, ДЭМБ-ын хамтарсан хамтарсан Хүнсний Эрх Зүйн Комисс нь Франц, Герман, Австрали, Англи, Канад, АНУ, Голланд, Япон, БНХАУ гэх мэт улс орнуудын олон улсын томоохон лавлагаа лабораториудын дата, дэлхийн нэртэй эрдэмтдээс бүрдсэн шинжээчдийн багийн олон жилийн судалгааны дараах үр дүнг үндэслэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн дээд хэмжээ, мөн хүнсний нэмэлтийн аюулгүй хэрэглээний түвшинг тогтоодог.

Тухайлбал хүнсний хэрэглээ (өртөмтгий бүлэг); хорт бодисын кинетик, хөдлөл зүй; хүн ба амьтны бие махбодын бодисын солилцоо; цочмог болон архаг хордлого болон өөр бусад холбогдох хордлогын талаарх мэдээлэл; сувиллын зориулалттай

хүнсэнд бохирдуулагчийн илрэх байдал; өргөн хэрэглээний хүнсэнд бохирдуулагчийн илрэх байдал; малын тэжээл болон тэжээлийн бүрэлдэхүүнд илрэх байдал; тухайн хорт бодист онцгой эмзэг хүн амын тодорхой бүлгийн талаарх мэдээллийг багтаасан тухайн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшин; хэрэглээ болон аюулгүй байдалтай холбоотой хор судлалын мэргэжилтнүүдийн хамтарсан зөвлөгөө, мэдээлэл зэрэг олон улсын хэмжээний статистикийн мэдээ, судалгааны үр дүнд үндэслэн хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлдог байна.

Улмаар шинжлэх ухааны нотолгооны дээр үндэслэн тооцсон хүнд металл, пестицид, цацраг идэвхт бодис, афлатоксин, микотоксин, малын эм бэлдмэл (мөн хүнсний нэмэлт)-ын бохирдуулагч бодис хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд байх зөвшөөрөгдөх дээд хэмжээг НҮБ-ын ХХААБ, ДЭМБ-ын хамтарсан Хүнсний Эрх Зүйн Комиссын хурлаар 5-8 жил хэлэлцэж, гишүүн орнууд хүлээн зөвшөөрсөн (80 хувь-ээш хувь) үед баталдаг бөгөөд цаашид гишүүн орнуудад зөвлөмж болгох зарчмаар хэрэгжүүлдэг.

Өнөөдөр, Монгол Улсын хүнсний лабораторийн чадавх, шинжлэх ухааны нотолгоо нь дээр дурдсан түвшинд хараахан хүрээгүй байна. Тиймээс “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 17.2.2 болон 17.2.3 заалтыг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна. Гэвч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтэд агуулагдах бохирдуулагчийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтооно гэсэн хуулийн энэхүү заалтын хэрэгжилт 30 хувьтай байна гэж үнэлсэн.

Энэ хуулийн 17.2.4.-д “хоол хүнснээс шалтгаалсан байнгын болон өвчлөлийн үеийн тандалт судалгаа хийж, яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг олон улсын мэдээллийн сүлжээнд болон нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журмыг хамтрагч талуудаар хэлэлцүүлэн зөвшилцөж, Эрүүл мэндийн сайдын А/328 дугаар тушаалаар баталсан байна. Журмыг тархвар судлаач, халдвар судлаач нар болон хамтрагч талуудад танилцуулах уулзалтыг 2 удаа зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Монгол Улсын Шадар Сайдын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаалаар батлагдсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-аар Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед Халдварт өвчин судлалын үндэсний төв тэргүүлэх байгууллагаар ажиллан, салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулан, эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг болсон байна.

Нийт халдварт өвчний 39.1 хувь амьсгалын замын халдварт өвчин, 25.0 хувь бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 18.8 хувь гэдэсний халдварт өвчин, 0.8 хувь зоонозын халдварт өвчин, 16.3 хувь бусад халдварт өвчин тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 10 000 хүн ам тутамд гэдэсний халдварт өвчин 11-ээр буюу 48.8 хувиар өссөн байна. 10 000 хүн ам тутамд сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулж үзэхэд гэдэсний халдварт өвчин 1.4-оор өссөн үзүүлэлттэй байна (Эрүүл мэндийн үзүүлэлт-2023, Эрүүл мэндийн хөгжлийн төв).

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан


Улсын хэмжээнд 2023 онд гэдэсний халдварын 6 төрлийн (цусан суулга, хүнсний гаралтай бактерийн хордлого, сальмонеллэзын халдвар, суулгалт халдвар, гар, хөл, амны өвчин, цочмог гепатит А) халдварт өвчин бүртгэгдэж, 10 000 хүн ам тутамд 22.9 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.0-оор өссөн үзүүлэлттэй байна. Гэдэсний халдварт өвчин нийт халдварт өвчний 18.8 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэдэсний халдварын 54.5 хувь нь гар, хөл, амны өвчин, 31.2 хувь нь цусан суулга, 6.3 суулгалт халдвар, 4.5 хувь нь сальмонеллэз, 3.4 хувь нь бактерийн гаралтай хоолны хордлого, 0.03 вируст гепатит А тус тус эзэлж байна.

5 дугаар зураг. Гэдэсний халдварт өвчний тохиолдол, 10 000 хүн амд, төрлөөр, 2014-2023 он



Улсын хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварын 8 дэгдэлт бүртгэгдэж, өнгөрсөн оноос 4 (33.3 хувь)-өөр буурсан байна. Дэгдэлтээр нийт 683 хүн өвдөж, 105 хүн эмнэлэгт хэвтэн, 578 хүн гэрээр өрхийн эмчийн хяналтад эмчлэгдсэн байна.

6 дугаар зураг. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоо



Тайлбар: Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтэд ижил төрлийн хоол хүнс хэрэглэснээс үүдэн нэг өвчний гурав ба түүнээс олон тохиолдол илрэхийг авч үзсэн. Нийт хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, өвчилсөн хүний тоонд химийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогын дүн ороогүй болно.

Эх үүсвэр: ЭМЯ

Улсын хэмжээнд 2023 онд хоол хүнсээр дамжих өвчнөөр өвчилсөн 683 хүнээс нян судлалын шинжилгээгээр 644 хүнд гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илэрсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

10 дугаар хүснэгт. Нянгийн гаралтай хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдварт өвчлөл

зүүлэлт	2020	2021	2022	2023	Өөрчлөлт, хувиар
Өвчилсөн хүний тоо	205	264	515	644	25.0
Хот	125	10	450	256	-43.1
Хөдөө	80	254	65	388	6 ¹

¹дахин их, Эх үүсвэр: ЭМЯ

Аюултай бактери, вирус, паразит болон химийн бодис агуулсан хүнс нь гэдэсний халдварт өвчин, хавдар гэх мэтчилэн 200 гаруй өвчнийг үүсгэж байна. Манай оронд хавдрын тохиолдол жил тутам өндөр байна, иймээс эрсдэлт хүчин зүйлийг олон талаас нь шинжлэх, судлах, нэгтгэсэн дүн шинжилгээ хийх, мэдээллээ хуваалцах, хүнсний аюулгүй байдлын баталгааг хангах, хүнсний хяналтын бодлого, түүний шийдвэр, хэрэгжилт нь мөн шинжлэх ухаанч байснаар иргэдийнхээ эрүүл аж төрөх үндсэн эрхийг хангах чухал үүрэгтэй юм.

“Нэг эрүүл мэнд” хэмээх үзэл баримтлал нь байгаль орчин, хүн ам, ургамал, мал амьтны харилцан шүтэлцээ, эрүүл аж төрөхөөс эхлэх бөгөөд хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэж вирус, нянгууд ч хувьсаж, урьд хожид байгаагүй шинэ халдварт өвчин үүсэж байгаа төдийгүй ББТ үүсэх эрсдэл нүүрлээд байна. 2019 оны байдлаар дэлхий дахинаа 5 сая гаруй хүн тэсвэржсэн нянгийн халдварын шалтгаантай холбоотойгоор амь насаа алдсан бөгөөд үүнээс 1,3 сая нь шууд тэсвэржсэн нянгийн халдвараас шалтгаалан нас барсан.⁵ Энэ тоо 2050 он гэхэд 10 сая хүн эмчилгээнд хэрэглэх антибиотикийн сонголтгүй болж нас барна гэж ДЭМБ тооцоолсон байна.⁶

“Дэлхий дээр халдварт өвчний дотор зоонозын халдвар 75-80 хувийг, түүний дотор вируст халдвар 75 хувийг эзэлдэг. Монгол орон 70 сая гаруй мал, ан, араатан, жигүүртэн, хачиг, шумуул, эгэл биетэн, халдварын агуулагчтай байгаа нь зоонозын 30 гаруй өвчин гарах боломж нөхцөл бүрдсэнийг илтгэж байна.

Нэг улс орон, нэг салбар дангаараа шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнүүдтэй /Зика вирус, Эбола г.м/ тэмцэж чадахгүй учраас дэлхийн улс орнууд, нийгмийн бүх салбарууд “Нэг эрүүл мэнд” үзэл санаан дор нэгдэж байна. Нутагшмал, шинэ болон сэргэж буй халдварт өвчнүүд болон Нийгмийн эрүүл мэндийн аюул, ноцтой байдлын эрсдэл нэмэгдэж буй үед үр дүнтэй хариу арга хэмжээ авах түүнчлэн хүн, малын Эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаа төдийгүй, орчны ЭМ, мал амьтан, ургамал, ус, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай болж ирсээр байна.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх явцад Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, манай улсын материаллаг болон хүний нөөцийн боломж, тэдгээрийн чадавх, оролцогч талуудын оролцооны идэвх зэрэг олон хүчин зүйлээс хамааран “Хүнсний тухай”, “Хүнсний

⁵ Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах дэлхийн 7 хоног

⁶ Эрүүл мэнд 2050 он гэхэд “супер бактери”-ийн улмаас жилд 10 сая хүн нас барах төлөвтэй

бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн зарим заалтыг эргэн харж өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний хяналтын бодлогыг боловсруулахад тандалт судалгааны дүнг ашиглах, улмаар хүнсний хяналтын бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, түүнд үндэслэн төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, хяналтын үр дүнгээр хүнсний хяналтын бодлогыг засаж залруулах эрх зүйн орчныг бий болгосноор төрийн бодлогын эргэх холбоог хангагдана.

2.4.4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих төрийн хяналт

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай **хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.-д** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд хэрхэн хяналт тавих талаар заасан байдаг.

Энэ хуулийн 18.1.1.-д “хүнсний сүлжээний үе шат болон үйл ажиллагааны явцад эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн шалтгааныг тогтоох, таслан зогсоох, нийтэд шуурхай мэдээлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөгөө өгөх, хяналт шалгалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх” гэж заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд төрийн зүгээс тавьж байгаа хяналт, шалгалт нь зөвхөн эрсдэлд суурилсан хяналт, шалгалт явуулж байгаа нь учир дутагдалтай байна. Учир нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэг улсын байцаагчийн дүгнэлтээр төлөвлөн зөвхөн дунд болон их эрсдэлтэй аж ахуй нэгж байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж байна.

2022 оны 12 дугаар сарыг дуустал Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2023 оны 01 дүгээр сараас эхлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газар төрийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2013-2018 онд нийт 29722 объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулан, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг даалгавар, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Гэвч эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөлт нь эрсдэлтэй газруудыг бүрэн хамарч чаддаггүй, урьдчилж мэдэгдэж байж хийсэн хяналт шалгалтын үр нөлөө бага, хяналт шалгалтад хамрагдаагүй газруудад эрсдэл, зөрчил, хордлого халдвар гарсан тохиолдол байсан. Гүйцэтгэлийн хяналтыг 41 объектод хийснээс 26 нь эрсдэлийн түвшин буурсан, 15 объектын эрсдэл үүсэх магадлал 4 хувиар буурсан дүнтэй байна.

Улсын хэмжээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн удирдамжийн дагуу мах, махан /хиам, бууз, банш, хагас боловсруулсан, нөөшилсөн/ бүтээгдэхүүний 161 үйлдвэр, цехийг 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулахаар зарласнаас нийслэл, орон нутаг дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй хиамны 36, нөөшилсөн 1, бууз банш, хагас боловсруулсан бүтээгдэхүүний 49, бусад 10, нийт 80 аж ахуйн нэгж, 20 иргэний нийт 100 объект (62.1 хувь)-од хяналт шалгалт хийлээ. Шалгалтад хамрагдсан объектуудаас их эрсдэлтэй 5,

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

дунд эрсдэлтэй 49, бага эрсдэлтэй 49 үнэлэгдсэн ба нийт 680 зөрчил, дутагдал илэрснээс 401 буюу 58.9 хувийг арилгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 45 иргэн, аж ахуйн нэгжид улсын байцаагчийн 607 заалт бүхий хугацаатай албан шаардлага, 7 эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлж, зөрчил гаргасан 15 аж ахуйн нэгж, 2 иргэнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээж нийт 36 сая 100 мянган төгрөгийн шийтгэл оногдуулж, зөрчлийн үр дагаврыг арилгуулсан байна.

Энэ хуулийн 18.1.2.-д “хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс, барилга байгууламж, ажлын байр нь эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг шалгалт хийх” гэж заасан.

Хүнсний тухай хуулийн 10.1.2 дахь стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, 10.1.3 дахь хүнсний үйлдвэрийн барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгэх, 10.1.6 дахь үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө хуульд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байх заалтуудын хэрэгжилт 2013-2018 онд 43.0-56.5 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлттэй байжээ.

2019-2024 онд үйлдвэрийн гадна орчин, барилга байгууламжид тавигдах шаардлага 65.4 хувь, Ажиллагсдын ариун цэвэр, эрүүл ахуй нөхцөлд тавигдах шаардлага 49.7 хувь, Үйлдвэрийн ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлд тавигдах шаардлага 56.4 хувь, Ахуйн шавж, мэрэгчтэй тэмцэх үйл ажиллагаанд тавих шаардлага 71 хувь, Түүхий эд, материалд тавих эрүүл ахуйн шаардлага 54.1 хувь, Эрүүл ахуйн дотоод хяналтын тогтолцоонд тавигдах шаардлага 44.9 хувийн хэрэгжилттэй байсан байна.

Улсын хэмжээнд 281 цэцэрлэг, 224 ерөнхий боловсролын сургууль, 48 дотуур байр, 37 бусад (худалдааны төв, бэлтгэн нийлүүлэгч), нийт 590 объектыг хамруулан хяналт шалгалт хийсэн байна. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдамжид заагдсан асуумжийг чиглэл болгон шалгаж, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдал, дотоод хяналтын үйл ажиллагаа, хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналт шалгалт хийжээ. Шалгалтад хамрагдсан газруудын 336 (60,7 хувь) нь барилга байгууламж стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн, эрх бүхий байгууллагын баталсан зураг төслийн дагуу баригдсан, 280 (47,4 хувь) хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай, хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахтай байхаар зохион байгуулсан, 392 (70.8 хувь) нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй, 250 (45.2 хувь) нь аяга таваг угаах төхөөрөмжтэй, 436 (78.8 хувь) нь аяга таваг ариутгах төхөөрөмжтэй, 95 буюу 71.4 хувь нь түүхий эд хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын гэрчилгээ, баталгаажилттай, 476 (86.7 хувь) нь хүүхдэд зориулсан иж бүрдэл бүхий хоолны цэстэй, 380 (68.7 хувь) нь хоол тус бүрд боловсруулах технологи ажиллагааг бүрэн тусгаж эрх бүхий албан тушаалтнаар батлуулсан, мөрдөж ажилладаг, 312 (56,4 хувь) нь хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалт, хадгалалтын горимд

температурын хяналт хийж, бүртгэл хөтөлж хэвшсэн, цэцэрлэг, сургуулиудын 111 (20 хувь) нь хоол зүйчээр хангагдсан, 364 (65.8 хувь) нь дотоод хяналт шалгалтын журмыг боловсруулан, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгах арга хэмжээ авч, хэрэгжүүлж хэвшсэн байна.

Хяналт шалгалтаар нийт 1398 зөрчил илрүүлсэн бөгөөд 937 зөрчил буюу 67 хувийг арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 864 заалт бүхий улсын байцаагчийн 108 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, зөрчил гаргасан 7 аж ахуйн нэгжид 2750.0 мян/төгрөгийн шийтгэл ногдуулсан байна.

Улсын хэмжээнд 281 цэцэрлэг, 224 ерөнхий боловсролын сургууль, 48 дотуур байр, 37 бусад (худалдааны төв, бэлтгэн нийлүүлэгч), нийт 590 объектыг хамруулан хяналт шалгалт хийсэн байна. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдамжид заагдсан асуумжийг чиглэл болгон шалгаж, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдал, дотоод хяналтын үйл ажиллагаа, хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналт шалгалт хийсэн байна.

Шалгалтад хамрагдсан газруудын 336 (60,7 хувь) нь барилга байгууламж стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн, эрх бүхий байгууллагын баталсан зураг төслийн дагуу баригдсан, 280 (47,4 хувь) хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай, хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахтай байхаар зохион байгуулсан, 392 (70.8 хувь) нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй, 250 (45.2 хувь) нь аяга таваг угаах төхөөрөмжтэй, 436 (78.8 хувь) нь аяга таваг ариутгах төхөөрөмжтэй, 95 буюу 71.4 хувь нь түүхий эд хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын гэрчилгээ, баталгаажилттай, 476 (86.7 хувь) нь хүүхдэд зориулсан иж бүрдэл бүхий хоолны цэстэй, 380 (68.7 хувь) нь хоол тус бүрд боловсруулах технологи ажиллагааг бүрэн тусгаж эрх бүхий албан тушаалтнаар батлуулсан, мөрдөж ажилладаг, 312 (56,4 хувь) нь хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалт, хадгалалтын горимд температурын хяналт хийж, бүртгэл хөтөлж хэвшсэн, цэцэрлэг, сургуулиудын 111 (20 хувь) нь хоол зүйчээр хангагдсан, 364 (65.8 хувь) нь дотоод хяналт шалгалтын журмыг боловсруулан, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгах арга хэмжээ авч, хэрэгжүүлж хэвшсэн байна.

Хяналт шалгалтаар нийт 1398 зөрчил илрүүлсэн бөгөөд 937 зөрчил буюу 67 хувийг арилгуулсан бөгөөд илэрсэн зөрчлийг арилгуулахаар 864 заалт бүхий улсын байцаагчийн 108 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, зөрчил гаргасан 7 аж ахуйн нэгжид 2750.0 мян/төгрөгийн шийтгэл ногдуулсан байна

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5^{3.1} дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 5.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний 62 дугаар асуудал Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 08-00-02/025 дугаартай удирдамжийн дагуу зах зээлд худалдаалагдаж буй дотоодын үйлдвэрийн нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний худалдаалдаг худалдаа, үйлчилгээ эрхлэгч 214 иргэн, 127 аж ахуй нэгжийг хамруулсан ба хяналтын явцад

давхардсан тоогоор 236 зөрчил илрүүлэн, 124 буюу 52.5 хувийг арилгуулсан байна. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/221 дүгээр тушаалын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх зорилгоор 9 аймаг, нийслэлд худалдаалагдаж байгаа 187 нэр төрлийн бүтээгдэхүүнээс дээж авч лабораторийн шинжилгээнд чанар аюулгүй байдлын 2, тэжээллэг чанарын 3 үзүүлэлтээр хамруулахад нийт дээжийн 66 буюу 35.2 хувь нь норматив үзүүлэлтийг хангахгүй байна. Иймд шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 30 заалт бүхий 4 албан шаардлага, 38 заалт бүхий 7 зөвлөмж хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт хийхэд 82 хувиар хангагдсан дүнтэй гарсан байна.

Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ нь хүний эрүүл мэнд, амь настай шууд холбоотой тул хамгийн багадаа хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүдийг жилд 1 удаа хяналт, шалгалтад хамруулах шаардлагатай.

Хяналтын байгууллага үзлэг шалгалтыг шинээр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан бүх газруудад хийж хэвших, эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангаагүй газруудын үйл ажиллагааг зогсоож, мэдээллийн сангаас хасах, олон нийтэд мэдээлж сэрэмжлүүлдэг болох, улмаар хэрэглэгчийг хамгаалах хэрэгцээ шаардлага байгааг анхааран хуулийн нэмэлт өөрчлөлтөд энэ зохицуулалтыг тусгах саналтай байна.

Энэ хуулийн 18.1.3.-д “импортын болон дотоодод үйлдвэрлэсэн хүнс холбогдох техникийн нөхцөл, эрүүл ахуй, ариун цэврийн бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох, эрсдэлд суурилсан тандалтыг зохион байгуулах” гэж заасан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 8 тортны үйлдвэрийг сонгон ашиглаж буй хүнсний нэмэлтийн талаар судлахад 21 төрлийн нэмэлтийг нийтлэг ашигласан байна. Эдгээр нэмэлтүүдийг БНХАУ болон ОХУ-аас импортолдог. Үүнд: Будагч бодис Е120-кармин, 122-азорубин, 132-индигокармин, 150с-аммиак карамель, 170, нөөшлөгч 202-сорбат кали, 263-кальцийн ацетат, 282 кальцийн пропионат, 330-нимбэгийн хүчил, 331(iii)-нимбэгийн хүчлийн 3 халагдсан натрийн давс, 340ii, 341(iii)-фосфат, 450 пиррофосфорхүчлийн натрийн давс, 471-тосны хүчлийн моно ба диглицерид, 472е-эмульгатор, 481-лактилат натри, 491-сорбитан моностеарат, хүчиллэг тохируулагч 500-натрийн карбонат, 516-кальцийн сульфат, 522-хөнгөн цагаан-калийн сульфат, амт сайжруулагч 637-этилмальтол зэрэг багтжээ. Эдгээр хүнсний нэмэлт бодисуудаас Е 170, 450, 481, 500, 522 код бүхий нэмэлтүүд нь НҮБ-ын ХХААБ, ДЭМБ-ын Хүнсний хууль эрх зүйн хорооноос батлан гаргадаг “*Codex general standard for food additives*” САС 192 стандартад тусгагдаагүй байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 08-00-02/07 дугаар удирдамжийн хүрээнд бялуу, бялууны бүтээгдэхүүний 146 үйлдвэрт төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэхээс 111 (76 хувь) үйлдвэр хамрагдсан байна.

Хяналт шалгалтыг удирдамжид тусгагдсан хяналтын хуудасны асуумжийн хүрээнд үнэлэхэд хуулийн хэрэгжилт улсын хэмжээнд дунджаар 69 хувьтай байна. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг

хангуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 858 заалт бүхий 71 албан шаардлагыг хүргүүлж, 57(51.4 хувь) үйлдвэрт гүйцэтгэлийн хяналт хийж, биелэлтийг хангуулан ажилласан байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр 28 заалт бүхий 3 зөвлөмж боловсруулан 10 үйлдвэрт хүргүүлсэн байна. Шалгалтад хамрагдсан 61(55 хувь) үйлдвэрийн 83 нэрийн бүтээгдэхүүнээс 63 актаар 109 дээж авч Стандарт хэмжил зүйн газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хими, хор судлалын лабораторид суурийн болон чимэглэлийн кремийн чихэрлэгийн агууламжийг тодорхойлуулсан. Мөн байгууллагын сургалтыг 41 иргэн, аж ахуйн нэгжийн 350 албан хаагчдын дунд зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтаар 12 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 1 зөрчилд зөрчлийн хэрэг нээж, 8 хуулийн этгээд, 5 иргэнд нийт 17.4 сая/төгрөгийн шийтгэл оногдуулан бүрэн барагдуулан ажиллажээ.

Гүйцэтгэлийн шалгалтыг 57(51.4 хувь) үйлдвэрт хийж, биелэлтийг хангуулсны дүнд эрсдэлийн түвшнийг 6.8 хувиар бууруулан ажилласан. Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд мөрдөгдөж буй хуулийн хэрэгжилт улсын хэмжээнд дунджаар 69 хувьтай байна.

Энэ хуулийн 18.1.4.-д тусгагдсан зохистой дадлыг нэвтрүүлэх болон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлд хяналт тавих гэсэн заалтын хэрэгжилт 2013-2018 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн хяналт шалгалтын дүнгээр хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн түвшинд 51 хувь, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд 52 хувь, хүнсний үйлдвэр эрхлэгчдэд 61.4 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд 68.9 хувийн хэрэгжилттэй байсан байна.

БНХАУ-д экспортолсон мах, махан бүтээгдэхүүнээс эмгэг төрүүлэгч илэрч, нянгийн ерөнхий тоо стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсантай холбогдуулан мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй үйлдвэрүүдэд БНХАУ-ын Гаалийн ерөнхий газраас 2023 оны 2 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 07-нд цахим хяналт шалгалт хийж, мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын талаар 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/1016 дугаартай албан бичгээр 5 аж ахуйн нэгжид 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв. ХХААХҮС-ын 2023 оны 05 сарын 23-ны өдрийн А/253 дугаар тушаалаар улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд хяналт шалгалт зохион байгуулах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсгийн хүрээнд улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулахаар удирдамж боловсруулж, “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ын хэрэгжилтийг хангуулахаар ОУСК-ийн Монгол мах төслийн баг, Монголын махны холбооны удирдах зөвлөлийн гишүүд болон холбогдох байгууллага, газрын албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулжээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан "Улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 08-00-02/29 тоот удирдамжийн хүрээнд Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, МЭГ, Эрүүл мэндийн газар, БОГ-ын хамтарсан ажлын хэсгүүд хяналтын хуудасны дагуу Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ын хэрэгжилтэд хяналт тавьж, эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.

Нийслэлийн хэмжээнд 110 аж ахуйн нэгж буюу 87.3 хувь, орон нутагт 26 аж ахуйн нэгж хамрагдсан. Хяналт шалгалтын явцад үйл ажиллагаа явуулаагүй зогссон 31 үйлдвэр байна. Үүнд: Мал төхөөрөх үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудсаар нийт 73 үйлдвэрийн 21.9 хувь буюу 16 үйлдвэр бага эрсдэлтэй, 19 үйлдвэр буюу 26 хувь дунд, 37 үйлдвэр 50.7 хувь их эрсдэлтэй үнэлэгдээд байгаа болно. Мах боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар нийт 42 үйлдвэрийн 23 үйлдвэр 54.8 хувь буюу бага, 28.6 хувь буюу 12 дунд, 16.6 хувь буюу 7 их эрсдэлтэй байсан байна.

Шалгалтын явцад 10 аж ахуйн нэгж байгууллага, иргэний мал төхөөрөх, боловсруулах үйлдвэрээс 13 нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтээс 21 дээж авч Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид шинжилгээнд хамруулахад стандартын шаардлага хангасан дүнтэй байна. 3 аж ахуйн нэгжид нийт 7.2 сая төгрөгийн торгууль ноогдуулж хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 5 аж ахуйн нэгж, 1 иргэнд 221 заалт бүхий 6 албан шаардлага хүргүүлсэн байна. Хэрэглэж дуусах хугацаа нь дууссан 61 сая төгрөгийн үнэ бүхий 4,6 тонн шувууны махыг битүүмжилж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан. Шалгалтын явцад Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Байгаль орчны тухай хуулийг зөрчсөн 5 аж ахуйн нэгж, 1 иргэний үйл ажиллагаанд илэрсэн зөрчилд зөрчлийн хэрэг нээж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/27 тоот удирдамжаар нөөшилсөн мах, махан бүтээгдэхүүн, хиам, бууз баншны үйлдвэр эрхлэгч 19 аж ахуйн нэгж, 15 иргэний нийт 34 үйлдвэр, цехийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар нийт 139 зөрчил, дутагдал илрүүлж 90 буюу 63 хувийг арилгуулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 9 аж ахуйн нэгж, иргэнд 61 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж, 13 нэр төрлийн 26 дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулжээ.

Урьдчилан сэргийлэх шалгалтаар хүнсний үйлдвэрт хугацаа дууссан уураг, хүнсний будаг, бэлэн жор, перец, хиамны бүрхэвч хадгалсан, үйлдвэрлэлд хэрэглэсэн, хугацаа дууссан хадгалсан, хугацаа дууссан хадгалсан, агуулахад чийг, температурыг хянаж бүртгэдэггүй, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр бэлэн бүтээгдэхүүн дэх давсны агууламж стандартад заагдсан хэмжээнээс их гарсан зэрэг зөрчил гаргасан

4 аж ахуйн нэгж, 1 иргэнд нийт 26800000 (хорин зургаан сая найман зуун мянган) төгрөгийн шийтгэл ногдуулсан байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар 10 заалттай 4 албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, 3 аж ахуйн нэгж, 1 иргэнд 21 396 458 төгрөгийн хууль бус орлого тооцож, хүнсэнд хэрэглэх хугацаа дууссан 2 аж ахуйн нэгжийн 8 нэр төрлийн 1300 кг 56 047 151 (тавин зургаан сая дөчин долоон мянга нэг зуун тавин нэгэн) төгрөгийн үнэ бүхий бэлэн жор, хиамны бүрхэвчийг устгуулжээ.

Хугацаа дууссан 2 нэр төрлийн 26.3 кг (уураг, хүнсний будаг) 414 064 төгрөгийн түүхий эдийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх устгалын зөвлөлд шилжүүлж ажилласан байна.

Энэ хуулийн 18.1.5.-д заасан хүнсний аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахдаа багийн гаргасан эрсдэлийн үнэлгээ, техникийн зөвлөмжид тулгуурлах гэсэн заалтын хүрээнд 2013-2018 онуудад Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулахдаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тандалт судалгаа, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрсдэлийн үнэлгээ зэргийг харгалзан үздэг байсан байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18.1.6.-д “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, зохих өөрчлөлт, хөдөлгөөн хийх, төрийн, төрийн бус байгууллага болон хэрэглэгчид шаардлагатай мэдээ, мэдээлэл өгөх” гэж заасан нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэсэн заалттай шууд хамааралтай тул хэрэгжилтийг 6 дугаар зүйлээс харж болно.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах ажлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2013 оны “Заавар батлах тухай” 37, 2014 оны “Заавар батлах тухай” 129 тушаалаар тус тус батлуулан мөрдөж эхэлсэн байна. Тус тушаалаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн маягт”-ын загвар, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр”, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн маягтыг нөхөн бичих заавар”, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч мэдээллээ цахимаар бүртгүүлэх аргачлал, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах заавар”, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэлийг ашиглах аргачлал”-ыг тус тус батлаад 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүртгэсэн байна.

2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн бүртгэлийн санд нийт 147150 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 396387 төрөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн байжээ. Тухайн жилд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх зааврын хэрэгжилт хуулт хэрэгжиж эхэлсэн эхний 6 жилийн дунджаар 81.5 хувьтай байна гэж үнэлэгдэж байсан байна.

Одоогоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн зохих өөрчлөлт, хөдөлгөөн хийх, төрийн, төрийн бус байгууллага болон хэрэглэгчид шаардлагатай мэдээ, мэдээлэл өгөх үйл ажиллагаа хийгдээгүй байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, ХӨСҮТ, БСШУСЯ, НХХЯ, УБЕГ, ҮСГ, Стандартчилал хэмжил зүйн газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар бусад төрийн байгууллага хооронд бүртгэлийн нэгдсэн сан, мэдээлэл солилцох урсгал тодорхойгүй байдалд байна.

Нөгөө талаас харахад “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэж заасны дагуу одоо ашиглаж буй www.fsi.gov.mn сайтыг буцаан болон татан авсан бүтээгдэхүүний мэдээлэл эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудсаар хийсэн хяналт, шалгалтын мэдээлэл, хууль тогтоомжийн сан, шилэн хяналтын цахим мэдээллийн сантай яаралтай уялдуулан программчлах шаардлагатай байна.

Нэгдсэн сан, мэдээлэл солилцох боломж нөхцөл бүрдээгүй байна. Тухайлбал нэг сургуулийн цайны газрыг түрээслэн үйл ажиллагаа явуулж байх хугацаанд хоолны хордлого гарсан бол тоног төхөөрөмжөө ачаад өөр сургуулийн цайны газрыг түрээслээд явж байдаг. Үүнийг хянах, бүртгэх тогтолцоо огт байхгүй байна.

Энэ хуулийн 18.2-д “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 55.3-т заасан эрсдэлд суурилсан хяналт шалгалтын давтамж тухайн үйлдвэрлэлийн онцлог, үйл ажиллагааны чиглэл, эрсдэлийн ангилалтай уялдсан байна” гэсэн өөрчлөлтийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар оруулсан байдаг.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2013 оноос хойш эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа ба хяналт шалгалтын давтамжийг тухайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэл, эрсдэлийн ангилалтай уялдуулан төлөвлөн хэрэгжүүлж байсан. Энэ хүрээнд 2013-2018 онд нийт 29722 их, дунд эрсдэлтэй объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн 2013-2018 онд хяналт шалгалтын дүнгээс авч үзвэл 15.4 хувь нь их эрсдэлтэй, 78.8 хувь нь дунд эрсдэлтэй, 5.8 хувь нь бага эрсдэлтэй ангилалд хамрагдсан 94 аж ахуйн нэгжийн 104 нэр, төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хяналт шалгалтад хамруулсан байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториос 2013-2018 онд нийт 3 удаагийн эрсдэлийн үнэлгээ, 4 удаагийн тандалт судалгааг хийж, дүгнэлт гарган, 21 чиглэлийн зөвлөмж боловсруулж холбогдох төрийн байгууллагуудад тайланг хүргүүлж байсан байна.

Хяналт шалгалтын давтамж, нэг байцаагчийн жилд хяналт шалгалт хийх объектийн тоог эргэж харж хүнсний хяналтын бодлого, мэргэжлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хүнсний талаарх зар сурталчилгаа нь хяналтаас гадуур явагдаж байна гэж харж байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд хоол, хүнсний талаарх зар сурталчилгаанд тавигдах ерөнхий шаардлага болон хориглосон хэм хэмжээ тогтоогоогүй мөн хоол хүнсний талаар буруу мэдээ мэдээлэл өгсөн,

сурталчилсан тохиолдолд авах хариуцлагыг зааж өгөөгүй байна. Тухайлбал: хүүхдэд ээлгүй, чихэр, давс, тосны агууламж өндөртэй хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа хүүхдэд зориулсан зар сурталчилгааны дийлэнх хувийг эзэлж байна. Улмаар эрүүл бус хүнсийг хэрэглэх дадал, зуршлыг бий болгож байна. Иймд хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаанд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох, зар сурталчилгааны сөрөг хамаарлаас хүүхдийг хамгаалах зайлшгүй шаардлагатай баяа. Иймээс хуулийн төслийн шинэчилсэн найруулгад хүнсний талаарх зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээх, хяналт тавих гэсэн үндсэн гол харилцаанд тулгуурлан, хориглолт, хязгаарлалтыг тогтоохдоо хэт туйлширч зах зээлийн өрсөлдөөний хязгаарлахгүйгээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг зэрэгцүүлэн холбогдох хэм хэмжээг тогтоох нь зүйтэй байна.

Гарч буй хоол, хүнсээр дамжих хордлого халдварын дийлэнх хувийг хяналт шалгалтад хамрагдаагүй хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч буюу хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болох сургууль, цэцэрлэгийн гал тогоо, уул уурхайн газруудын гал тогоо, нийтээр үйлчилдэг хоолны газар эзэлж байгаа. Өнөөдрийн байдлаар манай улсад хүнсний хяналтын бодлого, мэргэжлийн удирдлага алдагдсан. Үүнээс үүдэн хүнсний хяналтын үйл ажиллагаа суларч хяналтгүй хоол, хүнсний асуудал үүсэж эхэлсэн. Тогтолцооны хувьд салангид бүтэцтэй олон хяналтын байгууллагууд өөр хоорондоо мэдээлэл солилцох, хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах гээд олон асуудал үүсэж энэ нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дарамт учруулаад эхэлсэн. Хүнсний сүлжээний бүх үе шатыг хамруулан хяналт шалгалт хийх асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай.

Энэ хуулийн 18.3.-д “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналтын байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын нэгжтэй байна” гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүнсний хяналтын газартай болсон.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих **төрийн хяналтын хэрэгжилтийг 30 хүрэхгүй хувьтай** байна гэж үнэллээ.

Энэ хуулийн 5 дугаар бүлэг 19 дүгээр зүйлд “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага”-ыг заасан бөгөөд хуулийн 19.1.-д “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасны дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүнс хангамж, хоол үйлдвэрлэл, хүнсний сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, хууль зөрчсөн албан тушаалтанд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Зөрчил гаргасан ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлагуудад Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулах талаарх албан бичгийг дээд шатны байгууллагад хүргүүлдэг.

Тус хуулийн 19.2.-д “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасны дагуу 2019-2024 онд СХГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас тус хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн холбогдох заалтуудыг үндэслэн 164 аж ахуйн нэгж, иргэнд нийт 267,351,600(хоёр зуун сая найман зуун далан

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

мянган) төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, зөрчлийн үр дагаврыг арилгуулах албан даалгавар хүргүүлж, 38 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоож, 3 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг холбогдох эрх бүхий байгууллагын албан тушаалтанд хүргүүлэн ажилласан байна.

Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчил Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөрчилд тохирсон хариуцлага тооцох арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд сүүлийн 2023, 2024 онуудад 242 аж ахуйн нэгж, байгууллага, 165 иргэнд 592.860.000 төгрөгийн шийтгэл ногдуулж, 359 албан даалгавраар зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулсан байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар 10 хуулийн 19 заалтаар хариуцлага тооцсныг дараах хүснэгтээр харуулав.

11 дүгээр хүснэгт. Хариуцлага тооцсон байдал

Хууль тогтоомж	Зөрчлийн тоо	Торгуулийн дүн /сая.төг/
Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль зөрчих	259	195.6
Тамхины хяналтын тухай хууль зөрчих	14	4.2
Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих	38	100.2
Хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах	1	5
Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих	51	131.4
Хүнсний тухай хууль зөрчих	35	159
Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих	146	37.25
Эрүүл ахуйн тухай хууль зөрчих	4	4.4
Эрүүл мэндийн тухай хууль зөрчих	2	8
Хог хаягдлын тухай хууль зөрчих	1	
НИЙТ	551	645.05

Дээрх үзүүлэлтээс харвал “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль” зөрчсөн 259 үйлдэл байгаа нь нийт зөрчлийн 47 хувийг, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” зөрчсөн үйлдэл 26.5 хувийг, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”, “Хүнсний тухай хууль” зөрчсөн үйлдэл 15.6 хувийг тус тус эзэлсэн байна.

Хүнсний тухай хууль зөрчсөн 35 зөрчил нь нийт зөрчлийн 6.3 хувийг эзэлж байна. Иргэн, хувь хүн хууль бусаар хүнсний зүйлс нэвтрүүлэх, хүнсний хадгалах хугацаа хуульд заасан шаардлага хангаагүй, холбогдох гэрээ, бусад бичиг баримтгүй хүнсний зүйлс импортолсон зөрчил бүртгэгдсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчсөн 51 зөрчил бүртгэгдсэн нь нийт зөрчлийн 9.2 хувийг эзэлж байгаа бөгөөд хаяг, шошго шаардлага хангаагүй, буруу шошголсон, шаардлагатай мэдээлэл шошго дээр бичигдээгүй, хаяг шошгогүй хүнсний бүтээгдэхүүн импортолсон зөрчил гарсан байна.

Хүнсний аюулгүй байдалд төрийн хяналт тавих гол асуудлуудын нэг объектын суурь судалгаа, дата мэдээлэл хангалттай байж, хяналт шалгалтыг зөв, оновчтой төлөвлөх ач холбогдолтой юм. Зөрчлийн тухай хууль 2017 оноос мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор хяналт шалгалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан буюу улсын байцаагч нь хяналт шалгалт хийх явцдаа өндөр болон бага эрсдэл дагуулах олон төрлийн зөрчлүүдийг илрүүлдэг. Энэ нь Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заагдсанаар зөрчил гаргасан этгээдэд заавал хариуцлага тооцох нөхцөлтэй байдаг. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хийж буй улсын байцаагч нар тухайн шалгуулагчийн илэрсэн зөрчлийг үр дагавраас хамаарч албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч арилгуулах гэтэл зөрчилдөөд байдаг. Энэ 2 хуулийн зөрчилтэй байдлаас шалтгаалж, шалгуулагч этгээдийн ач холбогдлын хувьд ноцтой бус зөрчилд торгох шийтгэл ногдуулж буй нь бодит амьдралд нийцэхгүй, шалгуулагч этгээд, улсын байцаагч нарын хооронд үйл ойлголцлыг бий болгож байна. Зөрчлийн тухай хуульд Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг ноцтой зөрчөөгүй бол сануулах, албан даалгавар, шаардлага хүргүүлж шийдвэрлэх боломжийг нээж өгөх талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хуулийн хэрэгжилтийг хангах хяналтын бодлого алдагдаж, хуулийн хэрэгжилтийг хангах мэргэжлийн удирдлага, тогтолцооны гажуудалд орсон, хүнсний сүлжээний зарим үе шат, үйл ажиллагаанд тавих стандартын шаардлагыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт дутагдалтай, улсын хэмжээнд хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо, засаглалын оновчгүй байдлаас үүдэн нэгдсэн үнэлгээ 50 хүрэхгүй хувьтай буюу Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар хийсэн үнэлгээний нэгдсэн дүн 44.6 хувьтай гэж дүгнэгдсэн.

4.1. Дүгнэлт

Монгол Улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхэд дүн шинжилгээг хийхдээ үүсэж байгаа болон үүсэж болзошгүй эрсдэлт хүчин зүйлсийг тооцон хүнсний сүлжээгээр нь авч үзье:

➤ Хүнсний анхан шатны үйлдвэрлэлд хамааралтай малын эрүүл мэнд, удмын сан, мал бэлтгэлийн тогтолцоо, бүртгэл, мал төхөөрөх үйлдвэрийн сул зогсолт, газар тариалангийн үйлдвэрлэлийн механикжуулалт, технологийн шийдэл, импортын болон дотоодын хүнсний түүхий эд, туслах материал, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын тогтолцоо бүрдээгүй, аюулгүй байдал хангагдаагүй байгаа нь хүнсний сүлжээний анхан шатанд үүсэж байгаа эрсдэлт хүчин зүйлс юм. Хүнсний сүлжээний анхан шатны үйлдвэрлэл нь ийнхүү баталгаагүй байдалтай байгаа нь хэрэглэгчийн гар дээр баталгаатай, эрүүл хүнс очиж байгаа гэдэгт итгэхэд хэцүү нөхцөл байдал үүсээд байгаа юм.

➤ Улмаар гарал үүсэл нь баталгаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэж, зориулалтын бус агуулах, зооринд хадгалж байгаа нь мөн л хүнсний сүлжээний гол үе шат болох логистикийн тогтолцооны эмх замбараагүй хөгжилтэй⁷ холбоотой. Ингээд хүнсний сүлжээний 2 дахь гол үе шат нь мөн л баталгаагүй байна.

➤ Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, тусгай зөвшөөрөл, экспорт, импортын гэрчилгээ болон бусад тусгай гэрчилгээг олгосон бүртгэл, мэдээллийн сантай холбох нь нь хүнсний хяналт тавих үйл ажиллагааг хялбаршуулах юм.

➤ Хүнсний сүлжээний анхан шат болох хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хамаарагдах бүх хүчин зүйлсийг тооцон үйл ажиллагааг жигдрүүлэх, сайжруулах арга хэмжээ авснаар дараагийн хүнсний сүлжээний баталгаа хангагдах учиртай.

➤ Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь харьцангуйгаар хүнсний сүлжээн дотроо жигдэрсэн, сүүлийн үеийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, олон улсын хөгжилтэй эн зэрэгцэх хэмжээнд хөгжиж байгаа боловч тухайн хүнсний боловсруулах үйлдвэрт хэрэглэгддэг хүнсний түүхий эд, туслах болон нэмэлт бүтээгдэхүүний гарал үүсэл тодорхойгүй, стандартын дагуу анхан шатны үйлдвэрлэлээ явуулдаггүй газраас мах, сүү нийлүүлж авч байгаа нь тус боловсруулах үйлдвэрээс гарч байгаа эцсийн бүтээгдэхүүн баталгаатай гэж хэлэхэд хэцүү юм.

⁷ “Мах, хүнсний ногооны хангамжийн баталгаат байдал” хэлэлцүүлгийн эмхэтгэл, 2019-5-6

➤ Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдааны эрх зүйн зохицуулалт байхгүйгээс зах зээл дээр худалдан борлуулагдаж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний, туслах болон нэмэлт хүнсний бүтээгдэхүүн нь төрийн хяналт, шалгалтад бараг хамрагдахгүй зарагдаж байна. Хувь хүн хүнс импортлохыг хуулиар хориглосон⁸ боловч хяналтгүй орж ирдэг, хулгайн хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа учир тусгай ажиллагаа явуулж хилээр бүртгэлгүй, хяналтад хамрагддаггүй орж ирдэг хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрөл, тоо хэмжээгээр нь тогтоох нэн шаардлагатай. Учир нь энэхүү албан ёсны судалгааны дүнг Үндэсний статистикийн хороонд тооцон гаргадаг Хүнсний баланс бодоход ашигласнаар Монгол Улсын хэмжээнд хүнсний хангамж, хүртэмжийн баланс үнэн бодитоор гарах болно.

➤ Хуулийн хэрэгжилт хүнсний сүлжээний үе шатанд үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл мал төхөөрөх үйл ажиллагаанд 44.3 хувь, өрхийн шувууны аж ахуйд 58.8 хувь байгаа нь хамгийн бага, мал, амьтны шилжилт хөдөлгөөн, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн шатанд 80.6 хувь, гурилын үйлдвэрлэлд 76.1 хувийн хэрэгжилттэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Ургамлын гаралтай жижиглэн савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 61.3 хувь, нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 61.7 буюу хамгийн бага хувьтай байна.

➤ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг дагаж гарах нийт 12 эрх зүйн баримт бичиг байхаас 9 журам, нэг загвар, нэг заавар, нэг аргачлал байхаар хуульчилсан боловч 2025 оны байдлаар 7 журам, нэг заавар батлагдсан байна. Батлагдсан журмаас 3 журмыг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойших 6-12 жилийн дараа баталсан, огт батлагдаагүй 2 журам, нэг загвар, нэг аргачлал байгаа нь энэ хуулийн хэрэгжилтэд нөлөөлсөн гэж үзэж байна.

➤ Зарим нэг эрх зүйн баримт бичгүүд хоорондоо уялдаа холбоогүй, шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй байна. Тухайлбал нийтийн хоол, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын үед хүнсний баталгаат байдлыг хангах, хуурамч хүнсний бүтээгдэхүүн, транс тосны хэрэглээ, стратегийн хүнсний хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тусгай, нэмэлт зохицуулалт байхгүйгээс хүнсний хяналтын тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.

➤ 2014 оноос эхлэн Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт гаргадаг болсон нь хүнсний аюулгүй байдалтай холбоотой албан ёсны мэдээллийг нэгдсэн нэг ойлголтод хүргэн, холбогдох байгууллагууд нэг тоогоор мэдээлдэг, харилцдаг болсон. Энэхүү аргачлалыг 2023 оны 12 дугаар сард шинэчлэн баталж хүнсний баталгаат байдлыг илэрхийлэх зарим үзүүлэлтийг нэмж оруулсан болно.

➤ Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд туссан “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны нэршил нь хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж байгаа төдийгүй эрдэмтэн судлаачдын дунд маргаан үүсгэсэн. Иймд хуулийн нэр томъёог ойлгомжтой болгох, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн хэлэлцэн баталсан “Хүнсний нэр томъёоны толь”⁹-ийг баримтлан

⁸ Хүнсний тухай хууль-2012

⁹ Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны ... тоот тогтоолоор баталсан.

“хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоноос ялгаж, нэршлийг нь “хүнсний баталгаат байдал” гэж өөрчилж, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулсан. Үүнтэй холбоотойгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж, холбогдох зүйл, заалтад байгаа “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг өөрчилж “Хүнсний баталгаат байдал” гэж өөрчлөх шаардлага гарсан.

➤ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын зарим нэг статистикийн үзүүлэлтийг тооцоход салбар дундын нэр томъёоллын зөрүүтэй ойлголтоос үүдэн саад учирч байсныг хүнсний болон эрүүл мэндийн салбарын судлаачид харилцан зөвшилцсөний дүнд нэр томъёог жигдэлсэн байна. Тухайлбал архины хордлогын тоог нийт хоол, хүнсээр дамжих хоолны хордлогот халдварт өвчлөлд хамруулдаггүй байсан харин одоо архины хордлогын статистикийн тоог улсын хэмжээнд тооцдог болсон.

➤ Сүүлийн үед хоолны хордлого ихээр гарах үед улсын хэмжээнд лабораторийн түвшинд хоолны хордлогыг үүсгэж байгаа эх сурвалжийг үнэн бодитоор тогтооход лабораторийн хүчин чадал, мэргэжлийн хүний нөөцийн чадавх хангалттай биш, хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох лабораторийн бэлэн байдал хангагдаагүй байна.

➤ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид хийгдсэн эрсдэлийн үнэлгээний тайлан, дүнгээс харахад 2012 оноос хойш нийт 19 эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал үнэхээр хангалтгүй гэж дүгнэж байна. Хуулиар тогтоосон эрх зүйн эрх хэмжээ, чадамжийнхаа хүрээнд уг лаборатори нь 13 жилийн хугацаанд жилд 1.5 эрсдэлийн үнэлгээ явуулж байсан нь хуулийн хэрэгжилтийг маш хангалтгүй биелүүлсэн байна.

➤ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтийг шинжлэн тогтоох лабораторийн болон хүний нөөцийн чадавх хангалтгүй, лабораторийн түвшинд тогтсон хэдхэн үзүүлэлтийг шинжилдгээс шинжилгээний дүнг баталгаажуулах, нотлох, хяналт шалгалтыг үнэн бодитоор явуулах, хүнсний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, бодит үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна. Ялангуяа лабораторид нарийн мэргэжлийн шинжээчид ажиллах ёстой байтал улс төрийн томилгоогоор мэргэжлийн бус хүнийг ажиллуулах явдал гарсаар байна.

➤ Хүнсний сүлжээний бүх үе шатанд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид хүнсний технологич, мал зүйч, агрономич зэрэг мэргэжлийн боловсон хүчний дутагдал, гачигдалд орсон тул хөдөө аж ахуй болон хүнсний үйлдвэрлэл технологийн дагуу тэр бүр ном ёсоор явагдахгүй байна. Энэ нь нэгж талбайгаас авах ургацын хэмжээ, нэг малаас авах ашиг шимийн хэмжээ норм хэмжээнээс бага, үйл ажиллагаа нь зардал өндөртэй, тухайн бүтээгдэхүүний өөрийн өртөг өндөр гарч үр ашиггүй, алдагдалтай ажилладаг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Улмаар арьс шир, ноос ноолуурын чанар зах зээлийн шаардлагыг хангахгүй, үнэгүйдэх байдал гарсаар байна.

➤ Хүнсний талаарх зар сурталчилгаанд оролцогчдын эрх, үүргийг оновчтой тодорхойлох, хүнсний талаарх мэдээ, мэдээлэл өгөх, хүнсний чиглэлийн зар сурталчилгаанд тавигдах ерөнхий шаардлага болон тусгай шаардлагыг хэрэгжих боломжтой байдлаар тогтоох, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа түгээх хэлбэрт тавигдах шаардлагыг тусгай шаардлагаас ялгах, шинэ төрлийн зар сурталчилгаа түгээх хэлбэрт буюу цахим орчин дахь хоол, хүнсний талаарх зар сурталчилгаанд тавигдах шаардлагыг томъёолж хуульчлах нь зүйтэй байна.

➤ Салбарын хэмжээнд хүний нөөцийн бодлого 1990 оноос хойш алдагдсан, хүнсний салбарт эрдэм шинжилгээний хүрээлэн байхгүй байгаа нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжилд сөрөг үр дагаврыг бий болгосон.

➤ Эцэст нь дүгнэхэд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль нь эрх зүйн зохицуулалтынхаа хувьд сайн хууль болсон боловч хэрэгжилтийн үе шатанд хангалтгүй байна гэж дүгнэж байна. Хүнсний сүлжээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад зарим нэг зохицуулалт дутуу байна. Үүнийг хуульд нэмэлтээр өөрчлөлт оруулах замаар шийдэх нь зүйтэй гэж үзлээ.

➤ Хүнсний баталгаат байдал алдагдаж хүн амын дунд хоол, хүнсээр дамжсан хордлого гарсан үед одоогийн манай тогтолцоогоор Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймаг, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Гаалийн ерөнхий газар, Стандартчилал хэмжил зүйн газар, тэдгээрийн салбарын хяналтын газар, Боловсролын яам, Үндэсний итгэмжлэлийн газар, Халдварт өвчин судлалын төв, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Нийслэлийн нэгдсэн төв лаборатори зэрэг төрийн олон байгууллага хамтран ажилладаг бөгөөд харин хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байна. Энэ нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын асуудлыг бие даан хариуцах, шинжлэх ухаанд суурилсан төрийн бодлого, стратеги боловсруулах, батлуулах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэл харилцааны ил тод байдлыг хангах, хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн, бие даасан Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг манай улсын хэмжээнд байхгүйтэй холбоотой юм.

➤ Хүнсний баталгаат байдалд шинжлэх ухаанд суурилсан, хараат бус дүгнэлт гаргаж өгдөг мэргэжлийн байгууллага болох Эрсдэлийн үнэлгээний хүрээлэн нь Хүнсний хяналт, зохицуулалтын агентлагийн дэргэд байгуулж, ажиллуулбал Монгол улсын хэмжээнд хүнсний баталгаат байдлыг хангах засаглалын хувьд хамгийн оновчтой гэж дүгнэж байна.

4.2. Санал, зөвлөмж

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

➤ Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх, хууль хэрэглээнд гарч байгаа хүндрэлийг арилгах зорилгоор энэ хуулийн нэр болох “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний баталгаат байдал” болгон өөрчлөх саналтай байна.

➤ Хүнсний салбарын төрийн бодлого, стратеги, хууль тогтоомжийг гаргахад шинжлэх ухааны үндэслэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад чухал үүрэг гүйцэтгэх улсын хэмжээнд Хүнсний эрдэм шинжилгээ, судалгаа, эрсдлийн үнэлгээний хүрээлэнгийн үйл ажиллагааг тэлж, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт явуулах санхүүжилтийг бүрэн, тасралтгүй шийдвэрлэх, үр дүнг бүх шатанд хүртэх боломжийг бий болгох зорилгоор Хүнсний хяналтын бодлого, түүнийг чиглэлийг тодорхойлох.

➤ Ингэхдээ эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналтыг явуулах, хүнсний сүлжээний бүх шатанд хяналт тавих, шинжлэх ухаанд суурилсан, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, шинэ дэвшилтэт технологи ашиглах, ил тод, олон нийтэд нээлттэй хяналт явуулах, оролцогч талуудын хамтын хариуцлагыг тодорхой болгох, хууль эрх зүйн суурь, тогтолцооны уялдааг хангах гэсэн хүнсний хяналтын бодлогын чиг үүрэгтэй байхаар хуулийн төсөлд тусгах;

➤ Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийн санг төвлөрүүлэх, байнга шинэчилж байх, бизнес эрхлэгчид үйл ажиллагаандаа тусгай зөвшөөрөл авах, лиценз гэрчилгээ олгох, түүнийг бүртгэлийг нэгтгэх, холбогдох бусад байгууллагад мэдээлэх, хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд гэнэтийн болон эрсдэлт суурилсан хяналт, шалгалтыг явуулах, зөрчилтэй хүнсний талаарх үнэн зөв мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх, хэрэглэгчдийн хоол хүнсний талаарх мэдлэг, боловсрол, хандлагыг өөрчлөх чиг үүрэг бүхий Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн, бие даасан, хариуцлагын тогтолцоотой Хүнсний хяналт, зохицуулалтын агентлагтай болох;

➤ Ингэхдээ **Хүнсний хяналт, зохицуулалтын агенлагыг** бүтэц зохион байгуулалтаар шинээр байгуулах, ингэхдээ тус агентлагын чиг үүрэгт хүнсний сүлжээний бүх шатны хяналт зохицуулалтыг удирдах, эрсдэлийн үнэлгээ ба шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргалт, хүнсний бүтээгдэхүүний хяналт шалгалт, импортын хүнс, хил дээрх хяналт, шошгололт, мөшгөлт, мэдээллийн нэгдсэн систем, хүнсний хяналтын үндэсний лавлагаа лабораторийн бодлого гаргах, түүнийг удирдах, шуурхай сэрэмжлүүлэх, эргүүлэн татах тогтолцоо ажиллуулах, хүнсний хуулийн хэрэгжилтийг зохицуулах, дэмжих, гадаад хамтын ажиллагаа, олон улсын стандартын нийцлийг хангахаар тодорхойлох;

➤ Хүнсний хяналт, зохицуулалтын агентлагын дэргэд хүнсний баталгаат байдалд шинжлэх ухаанд суурилсан, хараат бус дүгнэлт гаргаж өгдөг мэргэжлийн байгууллага буюу **Эрсдэлийн үнэлгээний хүрээлэнг** эсвэл төвийг байгуулж, ажиллуулах, тус хүрээлэнгийн чиг үүрэгт хүнсний аюулын эрсдэлийн үнэлгээ хийх, судалгаа, тандалт, мэдээлэл цуглуулах, шинжлэх ухаанд суурилсан зөвлөмж гаргах, эрсдэлийн үнэлгээний аргачлал, гарын авлага боловсруулах, сургалт, чадавхжуулалт зохион байгуулах, олон улсын мэдээллийн сүлжээтэй холбогдох, олон улсын харилцаа ба шинжлэх ухааны тайлбар, орчуулгын албатай байх, бие даасан зөвлөмж гаргах үүрэгтэй байхаар тодорхойлох;

➤ Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг нь дэргэдээ Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийн сорил, шинжилгээ хийх, стандартын дагуу баталгаажуулах, хяналт шалгалтыг нотлох үндсэн үүрэгтэй байгууллага болох **Хүнсний үндэсний лавлагаа лабораторитой** байх бөгөөд тус лабораторийн чиг үүргийг шинэчлэн тогтоох саналтай байна. Тус саналд хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, ISO 17025 болон бусад итгэмжлэлийн шаардлагыг хангах, гадаад харилцаа, судалгааны төсөл, хамтын ажиллагаа хариуцах, микробиологи болон химийн шинжилгээний, физик шинж чанарын лаборатори, хүнсний шошгололт, найрлага баталгаажуулах, сорьц хүлээн авах, бэлтгэх ба хадгалах, мэдээлэл боловсруулах ба дүн гаргах зэрэг чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг явуулах, харин

аймаг бүрд салбар бүхий төвлөрсөн системтэй байгаа тул үндсэн лаборатори нь “лавлагаа төв” хэлбэрээр ажиллана. Ийм учир лабораторийн нэрийг өөрчлөхгүй;

➤ Хүн амыг эрүүл, чанартай, баталгаатай хоол, хүнсээр хангахын тулд захиргааны шинжтэй журам, заавраар шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулагддаг стандартын шаардлагыг бууруулах, түүнийг хэрэгжүүлэх аргачлал зөвлөмж баталж байгааг өөрчилж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрт хамаарах үе шатанд тохирох **зохистой дадлын стандартыг мөрдүүлэхээр тусгах**;

➤ **Худалдааны тухай хуулийг** батлан гаргаж хүнсний импорт, хүнсний дотоодын бөөний болон жижиглэн худалдаанд баримтлах зарчмыг тодорхой болгох, бөөний худалдааны төвийг хөгжүүлснээр зах зээл дээр худалдан борлуулах, түгээх хүнсийг хянах боломжтой болох;

➤ Хөдөө аж ахуй, эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хүрээг өргөжүүлж, тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний гэх мэтчилэн хүнсний сүлжээний үе шатуудад холбогдох зохистой дадлыг нэвтрүүлэхийг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд үүрэг болгох, зохистой дадлуудыг Монгол Улсын стандартаар баталж, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага батлахаар тусгах, уг **баталгаажуулалтын байгууллагыг бойжуулж, баталгаажуулалтын тогтолцоог бий болгох**;

➤ Хүнсний аюулгүй байдлыг хангахад хамгийн их үүрэг гүйцэтгэдэг хүчин зүйл бол **үнэн, зөв, бодит мэдээллийн урсгал** юм. Үүнтэй холбоотойгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл, үйл ажиллагааны талаарх мэдээллийн нэгдсэн санг “Block chain” технологийг ашиглан бий болгож улмаар төрийн байгууллага хоорондоо үнэн бодит, зөв мэдээлэл солилцох нэг сувагтай болох,

➤ Дээрх мэдээллийн сувгийг мөн адил импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хувьд бий болгох хэрэгтэй байна. Иймд импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэл, баталгаажуулалтын нэгдсэн мэдээллийн сан, мэдээлэл солилцох тогтолцоотой болох талаар импортлогч орны ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах ;

➤ Хувь хүн бэлэн хоол гэртээ бэлдэж худалдан борлуулж байгаа байдлыг яаралтай хяналтанд авах, энэ асуудлыг “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуульд эрх зүйн зохицуулалтыг нэмэлтээр оруулж өөрчлөх;

➤ Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд импортын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн заалтыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг тодорхой болгож бусад хуулиудтай уялдуулах, Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хувийн хэрэглээний хүнсний хэмжээ, хязгаарыг тогтоосон эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх асуудлыг судлах, шийдвэрлэх;

➤ Хоол хүнсээ зөв сонгож зөв хэрэглэдэг болохын тулд хэрэглэгчийн боловсролыг нэмэгдүүлэх улмаар сургуулийн насны хүүхдэд хоол, хүнсний талаар хичээлийн тусгай хөтөлбөр бий болгох, холбогдох яам, агентлагаас нөлөөллийн үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд хяналт тавих;

➤ Хүнсний баталгаат байдлыг хангахтай холбоотойгоор шинэ болон шинэчлэн стандартын шаардлага, түүний хэм хэмжээг мэргэжлийн хяналтын

байгууллагын хяналт шалгалт хийхэд ашигладаг хяналтын хуудсанд нэмж тусгах, сайжруулах;

➤ Хүнсний баталгаат байдлыг хангахад чухал дэд бүтцийн нэг бол бүртгэл мэдээллийн дэд систем юм. Энэ дэд системийг бүрэн ажиллуулахын тулд “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэж заасны дагуу одоо ашиглаж буй www.fsi.gov.mnсайтыг буцаан болон татан авсан бүтээгдэхүүний мэдээлэл эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудсаар хийсэн хяналт, шалгалтын мэдээлэл, хууль тогтоомжийн сан, шилэн хяналтын цахим мэдээллийн сантай уялдуулан программчлах;

➤ “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 15.4 дэх заалтын дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, удирдахад төрийн болон хувийн хэвшлийн итгэмжлэгдсэн хүнсний лабораториуд мэдээллээ ирүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж, хувийн лабораториудын мэдээллийг бүртгэж мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, санг идэвхжүүлэх, тус лабораторийн нэрийг Хүнсний хяналтын үндэсний лавлагаа лаборатори гэж өөрчлөх;

➤ Улсын хэмжээнд ажиллаж буй хүнсний аюулгүй байдлын лабораториудын зарим нэг лабораторийн итгэмжлэлийг олон улсын түвшинд хүргэх, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний бүтэц, найрлагыг нарийвчлан шинжлэн тогтоох, зарим эрсдэл ихтэй хүнсийг иж бүрэн шинжлэх лабораториудын чадамжийг (хүнсэнд вирус, хувиргасан амьд организм, транс тосны агууламж тодорхойлох) дээшлүүлэх, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, судалгаа шинжилгээ хийх, судлаач, шинжээчийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр чадавхжуулах;

➤ Хуульд заасан хүнсний чиглэлийн хувийн лаборатори нь тухайн үзүүлэлтээр итгэмжлэгдсэн, лабораторийн чадамж, хүний нөөцийн ур чадвар өндөртэй бол Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторитой урт хугацааны гэрээ байгуулж, хүнсний хяналт шалгалтын явцад шинжилгээнд хамрагдах дээжийг хуваарилан, шинжилгээний ажлын ачааллыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн замаар бууруулж хамтран ажиллах;

➤ Хоол, хүнсний талаарх мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаанд тавигдах шаардлага, эрх, үүрэг, хариуцлагын хэм хэмжээг тогтоож, хуульчилж өгөх;

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1.Монгол Улсын хууль тогтоомж

- 2010-07-15 УАБ-ын Үзэл баримтлал
- 2012-12-20 Хүнсний тухай хууль
- 2012-12-20 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- 2016-04-07 Органик хүнсний тухай хууль
- 2017-05-12 Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль
- 2017-05-11 Зөрчлийн тухай хууль
- 2017-12-08 Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- 2017-12-14 Малын генетик нөөцийн тухай хууль
- 2018-05-03 Баяжуулсан хүнсний тухай хууль
- 2019-05-30 Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль
- 2017-05-18 Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай
- 2015-10-26 Гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөө
- 2015-11-13 Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратеги 2016-2021,
- 2015-11-16 “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр
- 2015-11-26 Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
- 2023-12-25 Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

2.Төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны тайлан, танилцуулга мэдээ, тоон мэдээлэл

- Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд 2015-2023
- Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний тавдугаар судалгааны дүн 2017
- Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний зургаадугаар судалгааны дүн 2024
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал үндэсний статистикийн мэдээ 2019, 2023
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн тайлан мэдээ 2018, 2019, 2023
- Эрүүл мэндийн яамны статистикийн мэдээ-2018, 2019, 2023
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны тайлан мэдээ -2018, 2019, 2023
- Ядуурлын дүр төрх, Үндэсний статистикийн хороо, 2018-2024
- Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, Дэлхийн банкны ядуурал ба тэгт байдлын дэлхийн туршлага 2018-2024
- Ажиллагчдын сарын дундаж цалин, 2018, 2019, 2023
- Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо 2019, 2023
- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Үндэсний статистикийн хороо 2019, 2023
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт шалгалтын үр дүнгээс 2019-2022
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрын хяналт шалгалтын дүн, бусад мэдээлэл 2023, 2024

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт
хийсэн үнэлгээний тайлан

- Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын хяналт шалгалтын дүн, бусад мэдээлэл 2023, 2024
- ХНХЯ-ны хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний талаар 2019, 2023
- Гаалийн ерөнхий газрын хил хорио цээрийн хяналтын талаарх мэдээ 2019, 2023
- Боловсролын яамны албаны мэдээлэл 2023, 2024

3.Олон улсын тайлан мэдээ

- Global Report on Food Crises 2019, 2023
- Food security and Nutrition around the World in 2019, 2023
- The State of Food and Agriculture 2019, 2023
- Asia and the Pacific regional overview of Food security and Nutrition 2018, 2023

4.Веб хуудас

- www.legalinfo.mn
- www.parliament.mn
- www.fao.org
- www.ifpri.org
- www.unicef.org
- www.who.int

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ	3
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	5
ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	12
ТАВ. ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ.....	41

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Хүнсний баталгаат байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-т заасан “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;” хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар бэлтгэсэн болно.

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалтууд нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зорилгод нийцсэн, түүнд хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно. Мөн хуулийн төслийн зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдөх боломжтой, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд нийцсэн эсэх, хэм хэмжээнүүд ойлгомжтой байдлаар тусгагдсан эсэх талаар хуулийн төслийн зохицуулалтууд нь ойлгомжтой, харилцан уялдаатай байгаа эсэхийг дээр дурдсан аргачлалын дагуу шалган тогтоож дүгнэсэн ба гарсан үр дүнд үндэслэн анхаарах асуудлын талаар хууль санаачлагчид зөвлөмж өгсөн. Энэхүү үнэлгээг хийснээр Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хүний эрүүл мэндийг дэмжихүйц ямар нэг сөрөг нөлөөгүй хүнс үйлдвэрлэхийн тулд хүнсний сүлжээний үе шат бүрт эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, түүнд тавих хүнсний хяналт, зохицуулалтад оролцогч талуудын чиг үүргийг тодорхой болгох, хяналт, тандалт, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулсан эсэх, давхардал, зөрчилгүй байдлаар боловсруулагдсан эсэхэд хариулт өгсөн болно.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал

¹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал (2016)

4. Хүлээн зөвшөөрөх байдал

5. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь уг хуулийн төслөөр шинээр, шинэчлэн найруулж, өөрчилж байгаа зохицуулах харилцааны онцлогтой холбоотой. 2012 онд Монгол Улсын Их Хурлаас Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль²-ийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажилласан 13 жилийн хугацаанд тус хуульд нийт 9 удаа өөрчлөлт оржээ. Эдгээр өөрчлөлтүүд нь цаг үеийн шинжтэй бусад хуульд өөрчлөлт орсонтой холбоотой үүссэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийгдсэн. Харин одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэсэн зорилтын хэрэгжилт хангалтгүй байгааг хууль хэрэгжиж эхэлснээс хойшх 13 жилийн хугацаанд хүн амын дундах хоол, хүнсний гаралтай халдварт болон халдварт бус өвчлөл буурахгүй, зарим хорт хавдрын өвчлөл нэмэгдсэнг Хүн амын дундах хоол, тэжээлийн 5 болон 6 дугаар судалгааны дүнгээс харж болно. Өөрөөр хэлбэл, хүнсний баталгаат байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчин цогц байдлаар хараахан бүрдээгүй байгаагаас гадна хуулийн хэрэгжүүлэх механизм дутуу байгаатай холбоотой байгааг боловсронгуй болгоход хуулийн төслийн зорилго чиглэжээ. Иймд, хууль хэрэгжих явцад илэрсэн зөрчил, дутагдал, хийдлийг арилах, хуулийн нэр томъёог нэр мөр ойлгомжтой байдлаар олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх томъёолох, хүнсний чанар, эрүүл ахуйд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, хүнсний сүлжээний үе шат бүрт тохирох зохистой дадлыг нэвтрүүлэх, хүнсний сүлжээнд мөрдөж байгаа стандарт, техникийн зохицуулалтыг тодорхой заах, хүнсний бүтээгдэхүүний шошгоны болон хоолны цэсний мэдээллийг хэрэглэгчдэд ээлтэй байдлаар сайжруулах, хүнсний аюулгүй үзүүлэлтийг олон улсад хэрэглэж байгаа тоо хэмжээ, жишигт нийцүүлэн тогтоох, хүнсний шинжилгээ, тандан судалгаа хийх чадавхийг нэмэгдүүлэх, хүний биед сөрөг нөлөөтэй болон баталгаат байдлыг хангаагүй хүнсний хэрэглээг бууруулах, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагыг тодорхой болгохтой холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэсэн үндэслэлээр эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

“Зорилгод хүрэх байдал” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл (Цаашид “Хуулийн төсөл” гэх)-ийн холбогдох зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд туссан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхэд үнэлгээ хийхийг зорьсон.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“Практикт хэрэгжих боломж” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгах аргаар сонгож авна.

“Ойлгомжтой байдал” бүхий шалгуур үзүүлэлтийг дараах шалтгаанаар сонгов. Тус хуулийн төсөл нь одоо байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулагдсан тул хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектэд ойлгомжтой, салаа утгагүй байх, хуулийн төсөлд тусгасан зүйл, заалтууд нь найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хууль

²Монгол Улсын Их Хурал 2002 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2002 оны №23 дугаарт нийтлэгдсэн.

тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах байдлаар хуулийн төслийг бүхэлд үнэлнэ.

“Хүлээн зөвшөөрөх байдал” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүний оролцогч талууд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгасан. Энэ хүрээнд тус хуулийн төсөл нь бүхэлдээ Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн зохицуулалтад нийцэж байгаа эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийнэ.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын гуравдугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг нь үнэлнэ. Тухайн зохицуулалтыг сонгохдоо мөн зүйлийн 3.2-т заасны дагуу “гол ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоох нь зүйтэй бөгөөд тухайн зохицуулалт бодитой судалгаа хийж болохуйц байх шаардлагатай” гэснийг урьдчилсан нөхцөл болголоо.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зохицуулалт нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан³, хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж үнэлгээ хийв.

“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”-гийн үр дүнгээр дараахь дүгнэлтийг гаргажээ. Үүнд:

➤ Хүнсний сүлжээнд хамгийн их асуудал үүсгэж байгаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй байдал маш хангалтгүй түвшинд байна. 2019 оны хагас жилийн байдлаар нийт 23 удаагийн хоол, хүнснээс шалтгаалсан хоолны хордлогот өвчин гарсан. Хордлого гарсан эх сурвалжийг дурьдвал боловсролын байгууллага -1 /107-сургууль үдийн цай /, Аж ахуйн нэгж- 18 /худалдааны-3, хоол ресторан-15, иргэн -4/, Худалдааны -3, Хоол ресторан -1 тус тус гарсан байна⁴.

➤ Хуулийн хэрэгжилт хүнсний сүлжээний үе шатанд үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл мал төхөөрөх үйл ажиллагаанд 44.3 хувь, өрхийн шувууны аж ахуйд 58.8 хувь байгаа нь хамгийн бага, мал, амьтны шилжилт хөдөлгөөн, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн шатанд 80.6 хувь, гурилын үйлдвэрлэлд 76.1 хувийн хэрэгжилттэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Ургамлын гаралтай жижиглэн савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 61.3 хувь, нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 61.7 буюу хамгийн бага хувьтай байна.

³ Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 2025 он

⁴ НМХГ-ын Төв лабораторийн мэдээ-2019-06 сарын байдлаар

➤ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг дагаж гарах нийт 12 эрх зүйн баримт бичиг байхаас 9 журам, нэг загвар, нэг заавар, нэг аргачлал байхаар хуульчилсан боловч 2025 оны байдлаар 7 журам, нэг заавар батлагдсан байна. Батлагдсан журмаас 3 журмыг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойших 6-12 жилийн дараа баталсан, огт батлагдаагүй 2 журам, нэг загвар, нэг аргачлал байгаа нь энэ хуулийн хэрэгжилтэд нөлөөлсөн гэж үзэж байна.

➤ Нийтийн хоол, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын үед хүнсний баталгаат байдлыг хангах, хуурамч хүнсний бүтээгдэхүүн, хүнсний шошгонд байх зарим мэдээллийг зохицуулаагүй, хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг хязгаарлагдмал байдлаар тусгасан зэргээс улбаалан хүнсний сүлжээнд тавих хяналт бүрэн хэрэгжих нөхцөл бүрдээгүйд нөлөөлж байна.

➤ Сүүлийн үед хоолны хордлого ихээр гарах үед улсын хэмжээнд лабораторийн түвшинд хоолны хордлогыг үүсгэж байгаа эх сурвалжийг үнэн бодитоор тогтооход лабораторийн хүчин чадал, мэргэжлийн хүний нөөцийн чадавхи хангалттай биш, хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох лабораторийн бэлэн байдал хангагдаагүй байна.

➤ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид хийгдсэн эрсдэлийн үнэлгээний тайлан, дүнгээс харахад 2012 оноос хойш нийт 19 эрсдлийн үнэлгээ хийсэн байдал үнэхээр хангалтгүй гэж дүгнэж байна. Хуулиар тогтоосон эрх зүйн эрх хэмжээ, чадамжийнхаа хүрээнд уг лаборатори нь 13 жилийн хугацаанд жилд 1.5 эрсдлийн үнэлгээ явуулж байсан нь хуулийн хэрэгжилтийг маш хангалтгүй биелүүлсэн байна. Хүнсний сүлжээний бүх үе шатанд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид хүнсний технологич, мал зүйч, агрономич зэрэг мэргэжлийн боловсон хүчний дутагдал, гачигдалд орсон тул хөдөө аж ахуй болон хүнсний үйлдвэрлэл технологийн дагуу тэр бүр ном ёсоор явагдахгүй байна.

➤ Хүнсний талаарх зар сурталчилгаанд оролцогчдын эрх, үүргийг оновчтой тодорхойлох, хүнсний талаарх мэдээ, мэдээлэл өгөх, хүнсний чиглэлийн зар сурталчилгаанд тавигдах ерөнхий шаардлага болон тусгай шаардлагыг хэрэгжих боломжтой байдлаар тогтоох, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа түгээх хэлбэрт тавигдах шаардлагыг тусгай шаардлагаас ялгах, шинэ төрлийн зар сурталчилгаа түгээх хэлбэрт буюу цахим орчин дахь хоол, хүнсний талаарх зар сурталчилгаанд тавигдах шаардлагыг томъёолж хуульчилах нь зүйтэй байна.

➤ Хүнсний баталгаат байдал алдагдаж хүн амын дунд хоол, хүнсээс шалгаалсан хордлого гарсан үед одоогийн манай тогтолцоогоор Эрүүл мэндийн яам, ХХААХҮЯ, аймаг, НХХААГ, ГЕГ, СХЗГ, тэдгээрийн салбарын хяналтын газар, Боловсролын яам, Үндэсний итгэмжлэлийн газар, Халдварт өвчин судлалын төв, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Нийслэлийн нэгдсэн төв лаборатори зэрэг төрийн олон байгууллага хамтран ажилладаг бөгөөд харин хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байна. Энэ нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын асуудлыг бие даан хариуцах, шинжлэх ухаанд суурилсан төрийн бодлого, стратеги боловсруулах, батлуулах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэл харилцааны ил тод байдлыг хангах, хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн, бие даасан Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг манай улсын хэмжээнд байхгүйтэй холбоотой юм.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд туссан дээрх дүгнэлтийн хүрээнд боловсруулсан Хүнсний баталгаат байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн дор дурдсан агуулга бүхий зохицуулалтыг тус тус сонгон авч үнэлнэ. Үүнд:

Хүснэгт 1. Хуулийн төслөөс түүний үр нөлөөг үнэлэхээр сонгон авсан зохицуулалт тусгагдсан байдал

№	Зүйлийн дугаар, нэр	Зохицуулалт
1	1 дүгээр зүйлийн 1; 2; 3 ба 4 дэх заалтуудыг хамтад нь; 5, 8 ба 9 дэх заалтуудыг хамтад нь; 11 дахь заалт,	1/ 7 дугаар зүйлийн 7.1.4-7.1.8 дахь заалт, 7.2 дахь хэсэг: “7.1.4. хүнсний сүлжээний нэг үе шатаас нөгөө үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэх, түгээх, хүргэхэд тээвэрлэлтийн зохистой дадал; 7.1.5. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтын шатанд худалдааны зохистой дадал; 7.1.6.хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалтын зохистой дадал; 7.1.7.нийтийн хоол үйлдвэрлэл, түүгээр үйлчлэх шатанд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой дадал; 7.1.8. нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүд холбогдох зохистой дадал; 7.2.Хүнсний сүлжээний бүх шатанд зохистой дадлын стандарт, техникийн зохицуулалтыг зөрчсөн нь тогтоогдвол тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцлага хүлээлнэ”. 2/10¹ дүгээр зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллгаанд хориглох зүйл 10¹.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно: 10¹.1.1.хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх; 10¹.1.2.энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.2-т заасан эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэх; 10¹.1.3.хүнс үйлдвэрлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хүнсний нэмэлтийг хэмжээнээс нь хэтрүүлэн хэрэглэх, зориулалтыг өөрчилж хэрэглэх; 10¹.1.4. түүсэн ойн дагалдах баялгийн өнгө, зүс, амт чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт дур мэдэн хольж хэрэглэх, зах зээлд нийлүүлэх; 10¹.1.5.ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидын үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотекийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх;

		10¹.1.6.газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх; 10¹.1.7.Хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах. 10¹.2.Энэ хуулийн 10¹.1-д заасныг зөрчсөн дараах этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ: 10¹.2.1.Энэ хуулийн 10¹.1.1-10¹.1.2-т заасныг зөрчсөн буруутай этгээд; 10¹.2.2.Энэ хуулийн 10¹.1.3-10¹.1.6-д заасныг зөрчсөн нь лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдвол тариаланч, малчин, малын эмч, үйлдвэрлэгч, ойн дагалдах баялаг түүсэн, худалдаалсан этгээд.
		3/11¹ дүгээр зүйл.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага 11¹.1.Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах шаардлага тавигдана: 11¹.1.1. хоолны цэсний агууламжийн бодлогыг нэвтрүүлэх; 11¹.1.2.эрүүл хоолыг санал болгох цэсэнд илчлэг, нийт сахар, уураг, ханасан өөх тос, натрийн агууламж, хоолны хэмжээг ил тод байрлуулах. 11¹.2. Энэ хуулийн 11.1-д зааснаас бусад нийтийн бусад орчинд үйлчилдэг хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэг зэрэг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдөнө.
		4/12 дугаар зүйлийн 12.6-12.9 дэх хэсэг 12.10.Энэ хуулийн 12.4, 12.5-д заасан шаардлага импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод нэгэн адил хамаарна. 12.11.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах гадаад хэл дээрх мэдээлэл, монгол хэл дээрх орчуулга агуулгын хувьд нийцсэн байна. 12.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүн брайль болон программ хангамж ашиглан мэдээлэл авах боломжтойгоор хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгыг хийж болно. 12.13.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошго нь цаасан, эсхүл цахим, хэлбэртэй байна.
		5/15¹ дугаар зүйл.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо 15¹.1.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо нь улсын хэмжээнд хүнсний, асуудал эрхэлсэн төрийн захиргааны

	төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага/цаашид “хяналт, зохицуулалтын байгууллага” гэх/, Үндэсний лавлагаа лаборатори, эрсдэлийн үнэлгээний төв, аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ. 15¹.2.Хүнсний баталгаат байдлыг хангахад доор дурдсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд оролцоно: 15¹.2.1. эрүүл мэндийн, боловсролын, гадаад харилцааны болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; 15¹.2.2.стандартчилал, хэмжил зүй, гааль, мал эмнэлэг, ургамал хамгаалал, үндэсний итгэмжлэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага. 15¹.3.Хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “хяналт зохицуулалтын байгууллага” гэх/ нь салбарын хүнсний хяналтын бодлогыг тодорхойлон энэ хуулийн 15¹.2.-т заасан байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангана. 15¹.4.Аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага энэ хуулийн 15¹.3-т заасны дагуу тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнана. 15¹.5.Энэ хуулийн 15¹.1-д заасан хүнсний хяналт зохицуулалтын байгууллагын дарга буюу хүнсний хяналтын ерөнхий байцаагч нь хүнсний чиглэлээр магистр, ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан хүнсний технологич байна.” 6/15 дугаар зүйлийн 15.2.9 дэх заалт: “15.2.9.хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх харшил үүсгэгч, бичил биетний тэсвэржилтийн тандалт шинжилгээг хийж, эрсдэлийн үнэлгээний төвд хүргүүлэх.” 7/15 дугаар зүйлийн 15.7-15.9 дэх хэсэг: 15.7.Тухайн шинжилгээний нэг, эсхүл хэд хэдэн үзүүлэлтээр олон улсын стандартын хүрээнд итгэмжлэгдсэн тохиолдолд төрийн, орон нутгийн болон хувийн хэвшлийн хүнсний сорилын лабораторитой урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллуулж болно. 15.8.Хүнсний хяналт зохицуулалтын байгууллага энэ хуулийн 15.7-д заасан гэрээ байгуулах, чиг үүрэг гүйцэтгүүлэх шийдвэрийг гаргана.
--	--

		15.9.Лабораторийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах эрсдэлийн тандалтын шинжилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, дээж авах, урвалж бодис зэрэг зардлыг төрийн болон орон нутгийн лаборатори жил бүр төсөвтөө тусгана.
		8/16 дугаар зүйлийн 16.3.4, 16.3.5 дахь заалт: 16.3.4.эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, өөрчлөлт оруулах, эрсдэл бүхий хүнсний бүтээгдэхүүний жагсаалт гаргах, шинэчлэх, эрсдэлийн зураглал хийх, шошгон дээрх орчуулгыг хянах, залруулах; 16.3.5.Эрсдэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэж, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан бэлтгэх, хяналтын арга зүйг боловсруулах.
		9/18 дугаар зүйлийн 18.1.7-18.1.9 дэх заалт: “18.1.7.хүнсний сүлжээнд мөрдөх стандартын шүүлт хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтэд үндэслэн стандартыг хүчингүй болгох санал, стандартын төсөл боловсруулах, батлуулах, мөрдүүлэх, хэрэгжилтийн үнэлгээ хийх; 18.1.8.шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний хяналтын бодлогыг боловсруулахад эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгааны үр дүнг ашиглах, бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, түүнд үндэслэн төсөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, хяналтын үр дүнгээр хяналтын бодлогод өөрчлөлт оруулах.
		10/18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг: 18.2.Энэ хуулийн 6.1, 8.11, 16.5 дэх хэсэгт заасан мэдээллийн санг уялдуулан зохицуулах, шинэчлэх, баяжуулах, хасалт хийж байгаа эсэхэд хяналт тавина.
		11/19^{1.1} дүгээр зүйл.Эрүүл зөв хүнс сонгон хэрэглэхийг дэмжих 19^{1.1}.Хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжинэ. 19^{1.2}.Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлана. 19^{1.3}.Хэвлэл мэдээллийн байгууллага хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүнсний бүтээгдэхүүнийг дэмжин сурталчлахгүй байх, энэ талаар сэрэмжлүүлэг, анхааруулга өгч байх үүрэг хүлээнэ.
		3/7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг: 7.4.Хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7.1, 7.3-т заасан зохистой дадлын стандарт, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын
2	3 дугаар зүйлийн 1, 7 дахь заалтууд	

		тогтолцоог нэвтрүүлэх талаар нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, стандартыг хэрэгжилтийг хангуулна. 6/12 дугаар зүйлийн 12.6, 12.7 дахь хэсэг: “12.6.Энэ хуулийн 12.4, 12.5-д заасан шаардлага импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод нэгэн адил хамаарна. 12.7.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах гадаад хэл дээрх мэдээллийг монгол хэл дээр үнэн зөв орчуулж, шошгод байршуулна.
3	4 дугаар зүйлийн аюулгүй байдлын гэснийг баталгаат байдлын гэж өөрчилсөн хэсгүүд	4 дүгээр зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийн “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 2 зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 3.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “аюулгүй байдал” гэснийг “баталгаат байдал” гэж, 4.1.13 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 4.1.19, 4.1.20, 4.1.21 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 5 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1, 5.1.2, 5.1.3 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 5.1.4 дэх заалтын “байх” гэснийг “шинжлэх ухааны үндэслэлтэй байх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “хүнсний хяналт, зохицуулалтын байгууллага” гэж, 7.1 дэх хэсгийн “зохистой дадлыг нэвтрүүлнэ” гэснийг “зохистой дадлын стандартыг мөрдөнө” гэж 7 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 7.3 дахь хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 8 дугаар зүйлийн 8.6, 8.7 дахь хэсгийн “журмын” гэснийг “стандартын” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “журмын дагуу” гэснийг “стандартын дагуу” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “хууль, холбогдох дүрэм, журмыг” гэснийг “хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтыг” гэж, 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “зохицуулж болно” гэснийг “зохицуулна” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 13.7 дахь хэсгийн “хийж болно” гэснийг “хийнэ” гэж, дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсгийн “Стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэснийг “хүнсний хяналт, зохицуулалтын байгууллага” гэж, 15.2.1 дэх заалтын “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 15.2.4 дэх заалтын “баг” гэснийг “төв” гэж, 15.2.7 дахь заалтын “аюулгүй байдлын талаарх техникийн зохицуулалт” гэснийг “баталгаат байдлын талаарх стандарт, техникийн зохицуулалт” гэж, 15.3 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат

		байдлын” гэж, 15.5 дахь хэсгийн “багийн” гэснийг “төвийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “баг” гэснийг “төв” гэж, 16.1.1 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 16.3.4 дэх заалтын дугаарыг “16.3.6” гэж, 16.2 дэх хэсгийн “багийг” гэснийг “төвийг” гэж, 16.3 дахь хэсгийн “баг” гэснийг “төв” гэж, өөрчлөх, 17 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 17.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 17.1.1 дэх заалтын “зохистой дадлыг нэвтрүүлэх” гэснийг “хүнсний баталгаат байдлыг хангах” гэж, 17.1.3 дахь заалтын “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 17.2 дахь хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 18 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 18.1 дэх хэсгийн “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналтын байгууллага” гэснийг “хяналт, зохицуулалтын байгууллага, аймаг, нийслэлийн хяналтын байгууллага” гэж, “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 18.1.3 дахь заалтын “техникийн нөхцөл, эрүүл ахуй, ариун цэврийн бусад шаардлагыг” гэснийг “эрүүл ахуй, ариун цэврийн стандартын шаардлагыг” гэж, 18.1.5 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж, “багийн” гэснийг “төвийн” гэж, “техникийн” гэснийг “дүгнэлт” гэж тус тус өөрчилсүгэй.
--	--	--

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Хүснэгт 2. Тохирох шалгах хэрэгслийг сонгосон байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1; 2; 3 ба 4 дэх заалтуудыг хамтад нь; 5, 8 ба 9 дэх заалтуудыг хамтад нь; 11 дахь заалт, 3 дугаар зүйлийн 2, 4 дахь заалтууд, 4 дүгээр зүйлийн аюулгүй байдлын гэснийг баталгаат байдлын гэж өөрчилсөн хэсгүүд	Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын судалгаанд дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэж чадах эсэхэд дүн шинжилгээ хийх, сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт	Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа

			эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцох.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь сонгож үнэлсэн.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт	Тус хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор эрх ашиг, сонирхол нь хөндөгдөх этгээдүүдийн байр суурийг тодорхойлох.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Тус хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай, Хүнсний тухай, Усны тухай, Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Тариалангийн тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй эсэхийг үнэлэх.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1.“ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ:

Энэ хэсэгт дээрх сонгож авсан зохицуулалтууд нь хуулийн төслийн боловсруулагдах үндэслэл, хэрэгцээ шаардлагад тусгагдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг үнэлэх байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Нэг.Хүнсний сүлжээний үе шат бүрт тохирох зохистой дадлыг нэвтрүүлэхийг үүрэг болгох талаар:

Хэрэгцээ, шаардлага , зорилго	Нийцэж байгаа эсэх
“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” ⁵ -ын 3.4.2.1.-д “Хүнсний	1/ 7 дугаар зүйлийн 7.1.4-7.1.8 дахь заалт:

⁵ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

хангамжийн баталгаат байдлыг хангаж, ..." гэж, 3.4.2.4.-д "Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна" гэж, 3.4.2.5.-д "Хүнсний түүхий эд үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно" гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-д "... баталгаат хүнсээр хангана" гэж заасан ба 2021-2030 онд хүрэх үр дүнг "4.хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ" гэж, 2031-2040 онд хүрэх үр дүнг "3.баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон ... эрүүл хүнсний хэрэглээтэй болно." гэж тус тус тодорхойлжээ. Хүнсний сүлжээний үе шатны зохицуулагд харилцааг нарийвчлан тусгах, хүнсний чиглэлий ажиллагаа эрхлэгч бүр өөрт хамаарах ажиллагааны үе шат бүрд зохистой дадлыг мөрд үүрэг болгоно. Хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаандаа хөдөө аж ахуйн, үйлдвэрлэлийн, эрүүл ахуйн, тээвэрлэлтийн, хүнсний худалдааны, хадгалалтын, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүд зохистой дадлын стандартыг хэрэгжүүлэх	"7.1.4. хүнсний сүлжээний нэг үе шатаас нөгөө үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэх, түгээх, хүргэхэд тээвэрлэлтийн зохистой дадал; 7.1.5. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтын шатанд худалдааны зохистой дадал; 7.1.6.хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалтын зохистой дадал; 7.1.7.нийтийн хоол үйлдвэрлэл, түүгээр үйлчлэх шатанд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой дадал; 7.1.8. нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүд холбогдох зохистой дадал; 7.2.Хүнсний сүлжээний бүх шатанд зохистой дадлын стандарт, техникийн зохицуулалтыг зөрчсөн нь тогтоогдвол тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцлага хүлээлнэ".
---	---

ХБАБХТ хуулийн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.1.1.-7.1.3.-д "хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал (GAP)", "хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал (GHP)" "хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)"-ыг тус тус нэвтрүүлэх үүргийг хүлээлгэсэн. Энэ заалтын хэрэгжилт маш хангалтгүй түвшинд байна гэж хуулийн үр дагаврын үнэлгээгээр дүгнэсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 156 дугаар тушаалаар зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийг баталсан. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 6 жилийн дараа 2018 оны 06 дугаар сарын 31-ний өдрийн Стандартчилалын үндэсний зөвлөлийн 20 дугаар

тогтоолоор Хөдөө аж ахуйн зохистой дадал /ХААБЗД/ хэрэгжүүлэх удирдамж MNS6737:2018 стандартыг баталсан. Мөн ХБАБХТ хуулийн 7.2-т “Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална” гэж хуульчилсныг дагуу 2018 онд⁶ “Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ыг ХХААХҮ-ийн болон ЭМ-ийн сайд хамтарч баталсан. Үүний үр дүнд тариалангийн үйлдвэрлэлд ХААЗД нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд ШХА-ийн санхүүжилттэй НҮБ-ын ХХААБ болон МХШФХ-ноос хэрэгжүүлж байсан “Монгол ногоо” төслийн үйл ажиллагааны хүрээнд ХААЗД-ыг нэвтрүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг эхлүүлсэн. 2023 оны байдлаар манай улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар баталгаажуулах эрх авсан байгууллага 1, ХААЗД-ын гэрчилгээ авсан аж ахуй нэгж, иргэдийн тоо 40 гаруй болсон⁷ боловч төслүүдийн үйл ажиллагаа дуусгавар болсноор энэ ажил зогсонги байдалтай байна. Мөн хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд тавих тэмдгийн загварыг баталсан. Харин хоол үйлдвэрлэлийн салбарт Эрүүл ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулсан боловч батлагдаагүй байна. Үйлдвэрлэлийн зохистой дадлын талаар ямар нэг эрхзүйн баримт бичиг гараагүй өдий хүрчээ. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нийтлэг зөвлөмжийн дагуу МХЕГ-аас болон олон улсын төслүүдийн хүрээнд 2013-2018 онд хүнсний үйлдвэр эрхлэгчдэд тогтмол сургалт зохион байгуулдаг байсан. Гэхдээ дээрх нөхцөл байдлаас харахад энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойших нийт 13 жилийн хугацаанд зохистой дадлыг нэвтрүүлэх үүргээ хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид бараг хэрэгжүүлээгүй байна.

Зохистой дадлыг нэвтрүүлж түүнийгээ баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулалт, магадлан баталгаажуулалт хийлгээд явбал зохистой дадлын бүрэлдэхүүн хэсгүүд болох дотоод хяналт, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөлт, бүтээгдэхүүний шошгололт стандартын хэрэгжилт сайжрах учиртай. Үүний үр дүнд ХБАБХТ хуулийн 12.1-т заасан “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна” гэсэн үүрэг мөн биелэгдэх юм.

Хүнсний сүлжээнд зохистой дадал нэвтрүүлэхэд үйлдвэрлэгчдийг сургах, баталгаажуулалтын байгууллагын бойжуулах ажлууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэтэл үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлэх талаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд сургалт явуулах, мөн олон нийтэд таниулах, сурталчлах ажил хангалттай сайн хийгдээгүй байгааг мөн илтгэж байна. Хэдийгээр Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих: 5 дахь заалтад “Хуульд заасныг зөрчиж:

5.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхдээ үйлдвэрлэлийн холбогдох дүрэм, журам стандарт мөрдөөгүй;

5.2.үйл ажиллагаандаа хуульд заасан зохистой дадлыг нэвтрүүлээгүй;

5.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн бүрд ул мөр мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж хариуцлага тооцохоор хуульчилсан ч энэ заалт мөн хэрэгжээгүй. Энэ заалт нь зохистой дадлыг нэвтрүүлээгүйгээс болж ямар нэг хохирол учирсан бол хариуцлага хүлээлгэхээр байгаа, хэрэглэгч мөн зохистой дадал нэвтрүүлэх нь ямар сайн талтай, түүнийг нэвтрүүлснийг шошгоноос харж ялгах талаар сайн ойлголтгүй нөхцөлд ямар ч гомдол, хүсэлт гаргадаггүй нь тодорхой. Тиймээс нөлөөллийн ажлыг аль аль талд нь сайн зохион байгуулах хэрэгтэй байгаа. 2012 онд баталсан

⁶ 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдөр, Дугаар А/166, А/251, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14483>

⁷ ХХААХҮЯ-ны вебсайт, https://mofa.gov.mn/branch/qazar_tarialan/616fa59e73bc4a5fc70f2224

ХБАБХ тухай хуулийн 7 дугаар зүйлээр хүнсний сүлжээнд зөвхөн 3 зохистой дадал нэвтрүүлэхээр хуульчилсан байдаг. Гэтэл хадгалалтын, тээвэрлэлтийн, хүнсний худалдааны, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүд зэрэг сүлжээний бусад үе шатуудад мөн зохистой дадлуудыг нэвтрүүлж байж хүнсний баталгаат байдал хангагдах юм. 2023 онд⁸ нийт халдварт өвчний 18.8 хувь гэдэсний халдварт өвчин эзэлсэн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэдэсний халдварын 54.5 хувь нь гар, хөл, амны өвчин, 31.2 хувь нь цусан суулга, 6.3 суулгалт халдвар, 4.5 хувь нь сальмонеллөз, 3.4 хувь нь бактерийн гаралтай хоолны хордлого, 0.03 вируст гепатит А тус тус эзэлж байна. Улсын хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн хоолны хордлогот халдварын 8 дэгдэлт бүртгэгдсэн ба дэгдэлтээр нийт 683 хүн өвдөж, 105 хүн эмнэлэгт хэвтэн хоёр тэрбум гаруй төгрөгийг эмчилгээний зардалд зарцуулсан байна. Харин 578 хүн гэрээр өрхийн эмчийн хяналтад эмчлэгджээ. Эдгээр статистикийн үзүүлэлтээс харахад хоол, хүнснээс шалтгаалсан, түүгээр дамжсан халдварт болон халдварт бус өвчлөлийн гаралт, давтамж нэмэгдэж байгааг илэрхийлж байна. Тиймээс хуулийн төслөөр зохистой дадлуудын төрлийг нэмэхээр байгаа нь хуулийн төслийн зорилго, хэрэгцээ, шаардлагатай уялдаж байна. Мөн, зохистой дадлыг нэвтрүүлэх, баталгаажуулах талаарх чадавхижуулах ажил, сургалт, сурталчилгаа хийх, хэрэглэгчдийн дунд нөлөөллийн ажил явуулах, нэвтрүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох зэрэг зохицуулалтууд нь зохистой дадлыг нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах үүрэг болгосон заалтын хэрэгжилтийг дэмжсэн зохицуулалтууд болжээ. Түүнчлэн, цаашид энэ хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг үйл ажиллагаанд тохирох зохистой дадал нэвтрүүлэх чиг үүргийг мэргэжлийн холбоод болон Засгийн газрын бус байгууллагад өгч, төрийн үйл хэргийг төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилж явуулахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг тусгасан нь хууль хэрэгжих механизм оновчтой болжээ гэж дүгнэв. Мөн “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”⁹-ын 3.4.2.5-д “Хүнсний түүхий эд үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-д “..., баталгаат хүнсээр хангана” гэж заасан ба 2021-2030 онд хүрэх үр дүнг “4.хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ” гэж, 2031-2040 онд хүрэх үр дүнг “3.баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон ... эрүүл хүнсний хэрэглээтэй болно.” гэж тус тус тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх зохицуулалт болжээ.

Мөн одоогийн хүчин төгөлдөр хуулийн 7.2-т заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлахаар байсныг хуулийн төслөөр стандарт байхаар зохицуулжээ. Зохистой дадлууд нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд сонгон хэрэглэх боломжтой хяналт, удирдлагын тогтолцоо буюу ISO стандартуудын урьтал нөхцөл тул стандартаар батлах нь илүү тохиромжтой бөгөөд энэ хуулийн 12.2-т “Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандарт нь тухайн баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна” гэж заасны дагуу зохистой дадлуудын стандартууд нь ХББХТХ-ийн нэг адил хүчинтэй үйлчлэх буюу заавал дагаж мөрдөхөөр журамлагдаж байна. Нөгөө талаас Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн 4.1.10-т “тохирлын баталгаа” гэж бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгааг тодорхойлсон баримт бичгийг тухайн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаандаа зохистой дадлуудад заасан шаардлагыг тодорхойлж олгох үүрэг нь Үндэсний итгэмжлэлийн байгууллагаас итгэмлэгдсэн баталгаажуулалтын байгууллагууд хэрэгжүүлэхтэй нийцсэн байна.

Хоёр. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаар

⁸ <https://www.1212.mn/mn>

⁹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан.

Хэрэгцээ, шаардлага, зорилт	Нийцэж буй эсэх
Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг өндөржүүлэх, хүнсний сүлжээний бүх үе шатны үйл ажиллагаа бүрэн зохицуулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүр өөрт хамаарах үйл ажиллагааны үе шат бүрд зохистой дадлыг мөрдөхөөр тусгана. Үйлдвэрлэл эрхлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориулалтын бусаар хэрэглэх, ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэхийг хориглож, зөрчсөн нь лабораторийн шинжилгээгээр тогтоогдвол холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх нь чухал. Эрүүл хооллолтыг дэмжих, эрүүл бус хооллолтыг хязгаарлах хориглох замаар хэрэглэгчийн хоол, хүнсээ зөв сонгох хэрэглэх, эрүүл мэндээ хамгаалах соёлыг төлөвшүүлэх зорилгоор нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хоолны цэсний шошго, зар сурталчилгаа, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, тухайлбал, нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэгт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдүүлэх хэрэгцээ шаардлагатай байна. Олон улсад хүнсний үйлдвэрлэлд 2000 гаруй хүнсний нэмэлт¹⁰-ийг хэрэглэдэг боловч хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэсэн, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэсэн, зориудын бусаар хэрэглэсэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө /харшил үүсгэх, хавдарыг өдөөх/ үзүүлэх төдийгүй хүний хүний амь насанд ч аюул учруулж болзошгүй юм. Мөн иргэд ойн дагалт баялаг буюу байгалийн жимс, самар,	“10¹ дүгээр зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хориглох зүйл 10^{1.1}. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно: 10^{1.1.1}.хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх; 10^{1.1.2}.энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.2-т заасан эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэх; 10^{1.1.3}.хүнс үйлдвэрлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хүнсний нэмэлтийг хэмжээнээс нь хэтрүүлэн хэрэглэх, зориулалтыг өөрчилж хэрэглэх; 10^{1.1.4}. түүсэн ойн дагалдах баялгийн өнгө, зүс, амт чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт дур мэдэн хольж хэрэглэх, зах зээлд нийлүүлэх; 10^{1.1.5}.ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидын үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотекийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх; 10^{1.1.6}.газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх; 10^{1.1.7}.Хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах. 10^{1.2}.Энэ хуулийн 10^{1.1}-д заасныг зөрчсөн дараах этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ: 10^{1.2.1}.Энэ хуулийн 10^{1.1.1}-10^{1.1.2}-т заасныг зөрчсөн буруутай этгээд; 10^{1.2.2}.Энэ хуулийн 10^{1.1.3}-10^{1.1.6}-д заасныг зөрчсөн нь лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдвол тариаланч, малчин, малын эмч,

¹⁰ өнгө оруулах буюу өнгийг сэргээж тодотгох, байгалийн өнгийг нь далдлах, бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, төрөл бүрийн нян, бактери мөөгөнцрөөс хамгаалах, бүтээгдэхүүнийг исэлдэх, гашлахаас хамгаалах, бүтээгдэхүүний хэлбэрийг хадгалах, хөөс буулгах, бүтээгдэхүүний амт, үнэрийг сайжруулах зорилгоор хэрэглэдэг.

мөөг түүж, түүнийг зах зээлд худалдан борлуулахдаа дур мэдэн хүнсний нэмэлт хольж хэрэглэж байна. Иймд хуульд заасны дагуу бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэн хүнс үйлдвэрлэх, эсхүл хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориулалтын бусаар хэрэглэхийг хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заана.	үйлдвэрлэгч, ойн дагалдах баялаг түүсэн, худалдаалсан этгээд.
--	---

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.3.-д Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно:

10.3.1.хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;

10.3.2.энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.2-т заасан эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэх;

10.3.3.хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах.

Эдгээр хориглосон заалтын хүрээнд ил задгай хүнсний худалдаа, түргэн үйлчилгээний цэг, хуушуурын цэг гэх мэт газруудад хэрэгжилт хангалтгүй. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2014-2017 онд хийсэн хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлөөс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй нь 26 хувийг, сав баглаа боодол, хаяг шошгын шаардлага хангахгүй зөрчил 17.9 хувийг эзэлж байсан байна. **Энэ хуулийн 10.3.2.-д** эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэхийг хориглосон заалтын хэрэгжилтийг МХЕГ-ын 2018 оны хяналт шалгалтын ажлын тайланд дундажаар 65 хувьтай гэж дүгнэсэн байна.

Эдгээрээс гадна дараахь хориглосон заалтуудыг нэмж тусгасан:

10¹.1.3.хүнс үйлдвэрлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хүнсний нэмэлтийг хэмжээнээс нь хэтрүүлэн хэрэглэх, зориулалтыг өөрчилж хэрэглэх;

10¹.1.4. түүсэн ойн дагалдах баялгийн өнгө, зүс, амт чанарыг алдагдуулахгүйгээр урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт дур мэдэн хольж хэрэглэх, зах зээлд нийлүүлэх

10¹.1.5. 10.1.8.ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидын үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотекийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх,

10¹.1.6.газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх.

Энэ зохицуулалт нь хүнсний нэмэлтийг хэтрүүлэн хэрэглэх, зориулалтыг өөрчлөх, пестицид, бордоо, малын эмийн зохисгүй хэрэглээ зэргээс үүдэн хүнсний сүлжээний үе шат бүрт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц бохирдол бий болохоос сэргийлэхэд

чиглэгдсэн байна. Олон улсад хүнсний үйлдвэрлэлд 2000 гаруй хүнсний нэмэлт¹¹-ийг хэрэглэдэг боловч хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэсэн, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэсэн, зориудын бусаар хэрэглэсэн тохиолдолд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө /харшил үүсгэх, хавдарыг өдөөх/ үзүүлэх төдийгүй хүний хүний амь насанд ч аюул учруулж болзошгүй юм. Мөн иргэд ойн дагалт баялаг буюу байгалийн жимс, самар, мөөг түүж, түүнийг зах зээлд худалдан борлуулахдаа дур мэдэн хүнсний нэмэлт хольж хэрэглэж байна. Тухайлбал, байгалийн жимс, самар, мөөг түүж, түүнийг зах зээлд худалдан борлуулдаг иргэн, хуулийн этгээд тухайн жимс, мөөг, самарны өнгө зүс, амт чанарыг алдагдуулахгүйгээр урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт болох тогтворжуулагч, будагч, амт оруулагч бодисыг ямар ч мэргэжлийн хүний зөвлөгөө, тусламжгүйгээр хольж хэрэглэж байгааг таслан зогсоож, хяналт тавих, тэдгээрт ургамал хамгааллын бодис, хүнсний нэмэлт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн нь лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдсон бол түүсэн, худалдаалсан иргэн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмнө нь байсан хориглосон заалтын хамрах хүрээ, төрлийг нэмж, нэгтгэсэн зохицуулалт хийсэнээр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хориглосон заалтууд тодорхой болж, хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэхэд дөхөмтэй байх нөхцлийг бүрдүүлсэн байгаа ба хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцсэн.

Гурав. Хүнсний шошго, хоолны цэсний шаардлагын талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилго	Нийцсэн эсэх
УИХ-аас 2012 онд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг батлан хэрэгжүүлж байгаа ч хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт үр дүнтэй хэрэгжээгүй байна. Энэ нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй, бүтэц, зохион байгууллалтын оновчгүй тогтолцоо, хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний лабораторийн чадавх сул, зах зээл дэх дотоодын болон импортын хүнсэнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тандалт хийх зэрэг хяналтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлага алдагдсан, зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулах харилцааг захиргааны хэм хэмжээгээр зохицуулах гэж оролдсон, нөгөө талаас хэрэглэгчийн шошготой танилцаж, эрүүл хүнсээ сонгон авах чадвар сул, хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрт хамаарах үйл ажиллагаанд тохирох	4/12 дугаар зүйлийн 12.10-12.13 дэх хэсэг: “12.10.Энэ хуулийн 12.4, 12.5-д заасан шаардлага импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод нэгэн адил хамаарна. 12.11.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах гадаад хэл дээрх мэдээлэл, монгол хэл дээрх орчуулга агуулгын хувьд нийцсэн байна. 12.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүн брайль болон программ хангамж ашиглан мэдээлэл авах боломжтойгоор хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгыг хийж болно. 12.13.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошго нь цаасан, эсхүл цахим, хэлбэртэй байна.”

¹¹ өнгө оруулах буюу өнгийг сэргээж тодотгох, байгалийн өнгийг нь далдлах, бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг уртасгах, төрөл бүрийн нян, бактери мөөгөнцрөөс хамгаалах, бүтээгдэхүүнийг исэлдэх, гашлахаас хамгаалах, бүтээгдэхүүний хэлбэрийг хадгалах, хөөс буулгах, бүтээгдэхүүний амт, үнэрийг сайжруулах зорилгоор хэрэглэдэг.

зохистой дадал болон хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлээгүйтэй холбоотой байна¹².	
-нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хоолны цэсний шошго, хоолны илчлэгийн хэмжээг хянах, зар сурталчилгаатай холбоотой зохицуулалтыг төсөлд тусгана. Тухайлбал, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд ¹³ -ын хоолны цэсний агууламжийн бодлогыг нэвтрүүлж, эрүүл хоолыг санал болгох цэсэнд илчлэг, нийт сахар, уураг, ханасан өөх тос, натрийн агууламж, хоолны хэмжээг ил тод байрлуулж байх, нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэгүүдийн зардаг цэгүүдэд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдүүлэхээр заана. -хүнсний бүтээгдэхүүний шошгонд “анхааруулах байршуулах”-ыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчидэд үүрэг болгох, түүнчлэн давс ихтэй хүнсний бүтээгдэхүүн, чипс, шар буурцаг, чихэрлэг, хийжүүлсэн болон согтууруулах ундаа зэрэг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлах, харин жимс, хүнсний ногоо зэрэг хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүний үйлдвэрлэх асуудлыг зээлийн бодлогоор дэмжихээр тусгана. -хүнсний хууль тогтоомж, стандартаар хүнсний шошготой холбоотой харилцааг зохицуулсан боловч “анхааруулах мэдээлэл”-ны асуудлыг орхигдуулжээ. Энэ нь нэг талаас хэрэглэгч эрүүл мэндэдээ сөрөг нөлөө үзүүлэх орц, найрлагын агууламжтай бүтээгдэхүүнийг танин боломжгүй, нөгөө талаас хүнсний үйлдвэрлэгч хүнс үйлдвэрлэхдээ транс тос, харшил үүсгэгч найрлага, хүнсний	3/11¹ дүгээр зүйл: “11¹ дүгээр зүйл.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага 11¹.1.Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах шаардлага тавигдана: 11¹.1.1. хоолны цэсний агууламжийн бодлогыг нэвтрүүлэх; 11¹.1.2.эрүүл хоолыг санал болгох цэсэнд илчлэг, нийт сахар, уураг, ханасан өөх тос, натрийн агууламж, хоолны хэмжээг ил тод байрлуулах. 11¹.2. Энэ хуулийн 11.1-д зааснаас бусад нийтийн бусад орчинд үйлчилдэг хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэг зэрэг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдөнө.”

¹² Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ.2025 он

¹³ Нийтийн хоолоор үйлчилдэг газарт ресторан сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээний газар, асрамжийн газар, эмнэлэг, хүмүүжүүлэх газар, төрийн захиргааны байгууллагууд хамаарна.

нэмэлтийг зориудын бусаар хяналтгүй хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд хүнсний шошгонд “анхааруулах мэдээлэл” байршуулахаар заана.

-хэвлэл мэдээлэл байгууллагуудад сахар, ханасан өөх тос, натрийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн, эсвэл нэмэлт транс тос агууламжтай, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүнсний бүтээгдэхүүнийг дэмжин сурталчлахгүй байх, мөн энэ талаар сэрэмжлүүлэг, анхааруулга өгч байхыг үүрэг болгоно.

УИХ-аас 2012 онд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг батлан хэрэгжүүлж байгаа ч хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт үр дүнтэй хэрэгжээгүй байна. Энэ нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй, бүтэц, зохион байгууллалтын оновчгүй тогтолцоо, хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний лабораторийн чадавх сул, зах зээл дэх дотоодын болон импортын хүнсэнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тандалт хийх зэрэг хяналтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлага алдагдсан, зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулах харилцааг захиргааны хэм хэмжээгээр зохицуулах гэж оролдсон, нөгөө талаас хэрэглэгчийн шошготой танилцаж, эрүүл хүнсээ сонгон авах чадвар сул, хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрт хамаарах үйл ажиллагаанд тохирох зохистой дадал болон хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлээгүйтэй холбоотой байна¹⁴. 2.Хүнсний бүтээгдэхүүн боловсруулах: Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах нийтлэг шаардлага тавина:”, 10.1.5 дахь заалтад “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд мэргэжлийн, эсхүл мэргэшсэн хүний нөөцтэй байх;”, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.5-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт, түүнийг боловсруулах, үйлдвэрлэх нөхцөл, шаардлагыг техникийн зохицуулалтад тусгана.”, мөн зүйлийн 6.8 дахь хэсэгт “Уламжлалт аргаар сүү, цагаан идээ боловсруулах үйл ажиллагаанд энэ хуулийн 6.5 дахь хэсэг хамаарахгүй.”, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошго, дагалдах хуудсанд энэ хуулийн 12.3, 12.4-т зааснаас гадна дараах мэдээллийг тусгана:”, мөн зүйлийн 12.5.2 дахь заалтад “хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг гүйцэд боловсруулах аргачлал;” гэсэн заалтуудаар зохицуулсан байна. 6.Савлах: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байна.”, мөн зүйлийн 12.2 дахь хэсэгт “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журмыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”, мөн зүйлийн 12.8 дахь хэсэгт “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгч хариуцна.” гэж тус тус заасан. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг

¹⁴ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ.2025 он

хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасныг үндэслэсэн Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2013 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/46/115 дугаар 23 тушаалын нэгдүгээр хавсралтаар "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам", хоёрдугаар хавсралтаар "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтын маягт"-ыг баталсан захиргааны хэм хэмжээний акт мөрдөгдөж байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.2.-д "Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрсдэлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, шошголохтой холбогдсон журмыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж, **12.3.-д** "Энэ хуулийн 12.2-т зааснаас бусад харагдах байдлаар нь шинж чанарыг тодорхойлох боломжтой хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шаардлагатай мэдээллийг дагалдах хуудсанд тусгана" гэж тус тус заасны дагуу зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журмыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаалаар баталсан. Эрүүл мэндийн яамнаас "Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага" MNS 6648-2016 стандартыг боловсруулан батлуулсан байна. Иймд хуульд заасны дагуу бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгөөр хүнс үйлдвэрлэх, хүнсний үйлдвэрлэлд нэмэлтийг хэтрүүлэн хэрэглэх, зориулалтын бусаар хэрэглэхийг хориглох, хүнсний шошгонд анхааруулах мэдээлэл байршуулахаар тусгахаар хуулийн төсөлд үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгод нийцсэн байна.

"Хүнсний сав боодлын шошгын нүүрэн хэсэгт тэжээлийн бодисын мэдээлэл байршуулах заавар"-ыг боловсруулан, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/221 дүгээр тушаалаар батлуулжээ. Зааврыг мэргэжлийн хяналтын байцаагчид болон хүнсчдийн холбооны салбарын менежерүүдэд танилцуулах уулзалтыг анх 2018 оны 3, 4 дүгээр саруудад Эрүүл мэнд яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран зохион байгуулж байсан байна Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас хийсэн 2023-2024 оны хяналт шалгалтаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгод тавигдах шаардлагын хэрэгжилт дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнд үйлдвэрийн хяналтын хуудасны нэгтгэлээр 72,3 хувьтай, хүнсний үйлдвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдааны сүлжээн дэх импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл хуулийн 12.6-д заасанг хангаагүй (импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна) нийт шошгын зөрчлийн 70 гаруй хувийг эзэлсэн байна.

Дотоодын хүнсний үйлдвэрлэлийн салбарт хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг холбогдох хууль болон стандартад нийцүүлэн шошголох байдал сайжирч, энэ төрлийн зөрчил буурч байна. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод тавих шаардлага буюу тус хуулийн 12.6 дахь заалтад тавигдах шаардлага БНХАУ, БНСУ-аас орж ирж буй бүтээгдэхүүн дээр бүрэн хангагдахгүй байна. Энэ нь хил, гаалийн хорио цээрийн хяналт хангалтгүй, хууль бусаар оруулж ирж дотоодын зах зээлд нийлүүлдэг байдлаас шалтгаалж зөрчил буурахгүй байхад нөлөөлж байна. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний шошгод тавигдах ерөнхий шаардлагууд хангагдаж байгаа боловч шошгод тавигдах /Е тэмдэглэгээ, гаж нөлөө гэх мэт/ мэдээллүүдийг тодорхой тусгахгүй байна.

Сүүлийн 3 жилд импортын бүтээгдэхүүний шошгын зөрчил буурахгүй байна. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгын мэдээлэл дутуу, хуулийн 12.6-д заасан импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна гэсэн шаардлагыг хангахгүй, хилийн хорио

цээрийн хяналт Гаалийн байгууллагад шилжсэнээс хойш зөрчил буурахгүй нэмэгдэж байгаа хандлага ажиглагдлаа. Хуулийн 12.7-д тусгагдсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буруу шошголсон гэж үзнэ гэсэн заалт 2013-2018 оны байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байсан байна. Тодруулбал, мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнгээр нийт илэрсэн зөрчлийн сав баглаа боодол, хаяг шошгын зөрчил 2014 онд 7.1 хувийг эзэлж байсан бол 2017 онд 10.8 хувийг эзэлж байгаа нь уг зөрчлийн эзлэх хувь буураагүйг харуулж байна.

Энэ хуулийн 12.8-д заасны дагуу “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлага” стандартыг 2016 онд дахин шинэчлэн тус стандартын дагуу аж ахуйн нэгжүүдэд тохирлын үнэлгээ гүйцэтгэх явцад хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан байна. Шинэчилсэн стандартад олон улсын нийтлэг шаардлагын дагуу давсны хэмжээ, ханасан тосны агууламж, илчлэгийн хэмжээг заахаар тусгасан байна. Цаашид “Импортын бараа бүтээгдэхүүнд нэмэлт шошгололт хийх” стандартыг батлуулж, түүнийг мөрдлөг болгох хэрэгтэй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчсөн 51 зөрчил бүртгэгдсэн нь нийт зөрчлийн 9.2 хувийг эзэлж байгаа бөгөөд хаяг, шошго шаардлага хангаагүй, буруу шошголсон, шаардлагатай мэдээлэл шошго дээр бичигдээгүй, хаяг шошгогүй хүнсний бүтээгдэхүүн импортолсон зөрчил гарсан байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/12 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хүнсний аюулгүй байдлын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрэн бий болгож, хүнсний аюулгүй байдлын түвшинг тодорхойлон, нийгмийн эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын чиглэлийг боловсруулж, цаашид авч хэрэгжүүлэхэд шаардлагатай статистикийн тоо баримтыг бүрдүүлэн ажиллаж байгаа. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг хүнсний хангамж; хүнсний хүртээмж; хүнсний илчлэг, шим тэжээл; хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн дөрвөн хэсэгт хуваан 2014 оноос эхлэн статистикийн үзүүлэлт гаргадаг болсон.

Энэ хуулийн 12.8-д заасны дагуу “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлага” стандартыг 2016 онд дахин шинэчлэн тус стандартын дагуу аж ахуйн нэгжүүдэд тохирлын үнэлгээ гүйцэтгэх явцад хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан байна. Шинэчилсэн стандартад олон улсын нийтлэг шаардлагын дагуу давсны хэмжээ, ханасан тосны агууламж, илчлэгийн хэмжээг заахаар тусгасан байна. Цаашид “Импортын бараа бүтээгдэхүүнд нэмэлт шошгололт хийх” стандартыг батлуулж, түүнийг мөрдлөг болгох хэрэгтэй байна.

Дөрөв. Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилго	Нийцсэн эсэх
“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” ¹⁵ -ын 3.4.2.7.-д “Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн	5/15¹ дугаар зүйл: “15¹ дугаар зүйл.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо 15¹.1.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо нь улсын хэмжээнд хүнсний, асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны

¹⁵ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, ..." гэж, стратегийг тодорхойлсон байдаг. "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хэсэгт "... хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах ... хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх" арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгажээ. Төслийн үзэл баримтлалд "... хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй, бүтэц, зохион байгууллалтын оновчгүй тогтолцоо, хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний лабораторийн чадавх сул, зах зээл дэх дотоодын болон импортын хүнсэнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тандалт хийх зэрэг хяналтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлага алдагдсан,	байгууллага/цаашид "хяналт, зохицуулалтын байгууллага" гэх/, Үндэсний лавлагаа лаборатори, эрсдэлийн үнэлгээний төв, аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ. 15¹.2.Хүнсний баталгаат байдлыг хангахад доор дурдсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд оролцоно: 15¹.2.1. эрүүл мэндийн, боловсролын, гадаад харилцааны болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; 15¹.2.2.стандартчилал, хэмжил зүй, гааль, мал эмнэлэг, ургамал хамгаалал, үндэсний итгэмжлэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага. 15¹.3.Хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "хяналт зохицуулалтын байгууллага" гэх/ нь салбарын хүнсний хяналтын бодлогыг тодорхойлон энэ хуулийн 15¹.2.-т заасан байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангана. 15¹.4.Аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага энэ хуулийн 15¹.3-т заасны дагуу тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнана. 15¹.5.Энэ хуулийн 15¹.1-д заасан хүнсний хяналт зохицуулалтын байгууллагын дарга буюу хүнсний хяналтын ерөнхий байцаагч нь хүнсний чиглэлээр магистр, ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан хүнсний технологич байна." 8/16 дугаар зүйлийн 16.3.4, 16.3.5 дахь заалт: "16.3.4.эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, өөрчлөлт оруулах, эрсдэл бүхий хүнсний бүтээгдэхүүний жагсаалт гаргах, шинэчлэх, эрсдэлийн зураглал хийх, шошгон дээрх орчуулгыг хянах, залруулах; 16.3.5.Эрсдэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэж, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан бэлтгэх, хяналтын арга зүйг боловсруулах." 9/18 дугаар зүйлийн 18.1.7, 18.1.8 дэх хэсэг: "18.1.7.хүнсний сүлжээнд мөрдөх стандартын шүүлт хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтэд үндэслэн стандартыг хүчингүй болгох санал, стандартын төсөл
---	--

	боловсруулах, батлуулах, мөрдүүлэх, хэрэгжилтийн үнэлгээ хийх; 18.1.8. шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний хяналтын бодлогыг боловсруулахад эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгааны үр дүнг ашиглах, бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, түүнд үндэслэн төсөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, хяналтын үр дүнгээр хяналтын бодлогод өөрчлөлт оруулах.
--	---

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа ХБАБХТ хуулийн Дөрөвдүгээр бүлгээр “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналт”-ын зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, хамгийн эхний зохицуулалт нь Үндэсний лавлагаа лаборатори (15 дугаар зүйл) байх ба энэ лабораторийг 2022 онд МХЕГ татан буугдсантай холбоотойгоор 15.1 дэх заалтад өөрчлөлт оруулж, “Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагаа лаборатори ажиллана” гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. Мөн энэ зүйлд Үндэсний лавлагаа лабораторийн чиг үүргийг тодорхойлсон байдаг. Энэ бүлгийн 16 дугаар зүйлээр Үндэсний лавлагаа лаборатори нь ашиг сонирхлын зөрчилгүй, дадлага туршлагатай, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд болон бусад салбарын шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн багийг тухай бүрд нь бүрдүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан эрсдэлийн үнэлгээг хийлгэж байхаар хуульчилж, багийн чиг үүргийг тодорхойлсон. Түүнчлэн хуулийн 18.1-т 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулан, хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналтын байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт тавина, хуулийн 18.3-т Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналтын байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын нэгжтэй байна гэж заасан нь хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар хоёрдмол утгатай байна. Нэг талаас яам, нөгөө талаас хяналтын байгууллага хүнсний хяналтыг хэрэгжүүлэхээр байна. Гэсэн хэдий ч яг аль байгууллага нь хяналтыг яаж хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт уг хуульд тусгагдаагүй байгаа нь хяналт шалгалтын давхардал үүсгэж хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хүндрэл учруулахаар зохицуулалт болжээ. 2022 онд МХЕГ татан буугдснаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яаманд шилжиж, салбарын хяналтын газар гэсэн нэгж яамны бүтцэд бий болсон.¹⁶ Хуулийн төслөөр “15¹ дугаар зүйл. Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо гэсэн шинэ зүйл нэмж, 15¹ 1-т “Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо нь улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Үндэсний лавлагаа лаборатори, эрсдэлийн үнэлгээний төв, эрдэм шинжилгээний байгууллага, аймаг, нийслэлд хүнсний хяналтын байгууллага, байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ” гэж хүнсний сүлжээнд хүнсний баталгаат байдлыг хангуулах төрийн мэргэжлийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэх байгууллагуудыг тодорхой зааж өгснөөрөө шинэлэг зохицуулалт болсон. Мөн эдгээр нэр дурдагдсан байгууллагуудын хүнсний баталгаат байдлыг хангахад оролцох чиг үүргийг байгууллага тус бүрээр тодорхойлон заасан нь чиг үүргийн давхардлыг арилгах, байгууллага хоорондын ажлын уялдааг хангахад

¹⁶ мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, Дугаар 469

чухал ач холбогдолтой болжээ. Ялангуяа, төрийн мэргэжлийн хяналтыг бодлого, мэргэжлийн удирдлагаар хангах хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг Засгийн газрын тохируулагч агентлагийн статустай байхыг тодорхойлсноор хүнсний сүлжээнд баталгаат байдлыг хангахад оролцогч төрийн, орон нутгийн, хувийн хэвшлийн байгууллага, лабораторийн үйл ажиллагааг нэгдмэл бодлого, зохицуулалт, мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт, шалгалт, судалгаа, шинжилгээний үр өгөөжийг нэмэгдүүлэх чухал зохицуулалт болжээ. Мөн энэ агентлаг нь хүнсний салбарт мөрдөж байгаа стандарт, техникийн зохицуулалтад шүүлт хийж, дүгнэлт гарган, тэдгээрийг шинэчлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, эрсдлийн үнэлгээг хийх зэрэг асуудлыг хариуцахаар хуулийн төсөлд туссан байна. Энэ зохицуулалт нь “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹⁷-ын 3.4.2.7.-д “Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, ...” гэж, стратегийг тодорхойлсон, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хэсэгт “... хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах ... хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх” гэсэн зорилтуудад нийцсэн байна. Хуулийн төслийн үзэл баримтлалд “... хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй, бүтэц, зохион байгууллалтын оновчгүй тогтолцоо, хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний лабораторийн чадавх сул, зах зээл дэх дотоодын болон импортын хүнсэнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тандалт хийх зэрэг хяналтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлага алдагдсаныг засаж сайжруулах практик шаардлагын хүрээнд боловсруулсан байна гэж дүгнэв. Хэдийгээр өмнө нь байсан Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд МХЕГ нь тохируулагч агентлаг¹⁸ байхаар байгуулагдсан байсан. Гэсэн хэдий ч тохируулагч агентлаг байх чиг үүргийг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд оновчтой тодорхойлоогүй тул тус хуульд “Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн гэж заасан хүрээнд хяналт шалгалтын үйл ажиллагааг голлон хэрэгжүүлж ирсэн. Тохируулагч агентлаг нь төрийн нэрийн өмнөөс зах зээлийн болон нийгмийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг хянах, зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд олон улсын эрх зүйн онолд эдгээрийг “бие даасан зохицуулах байгууллага” (*independent authority*) гэж нэрлэдэг. Ийм байгууллагуудын нийтлэг онцлог нь бие даасан шийдвэр гаргах чадвартай, тухайн салбартаа мэргэжлийн чиг үүрэгтэй, Засгийн газраас хэт хараат бус, зах зээлийн шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлтэй ажилладаг.¹⁹ Хуулийн төсөлд нэмж томъёолсон хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний хяналтын бодлогыг боловсруулахад тандалт судалгааны дүнг ашиглах, хүнсний хяналтын бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, түүнд үндэслэн төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, хяналтын үр дүнгээр хүнсний хяналтын бодлогыг засаж залруулах, эргэх холбоог хангах практик шаардлагад нийцсэн зохицуулалт болжээ гэж дүгнэлээ. Мөн энэ агентлаг нь дэргэдээ хүнсний баталгаат байдлын эрсдлийг төлөвлөх, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий эрсдэлийн үнэлгээний хүрээлэн, хяналтын лаборатори ажиллуулахаар зааж байгаа нь хүнсний хяналт, зохицуулалтын асуудлын хариуцсан байгууллагуудын бүтэц, тогтолцоог олон улсын жишигт хүргэхэд чиглэсэн оновчтой зохицуулалт болсон ба энэ нь

¹⁷ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

¹⁸ Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

¹⁹ Монгол Улсын Засгийн газрын тохируулагч ба хэрэгжүүлэгч агентлаг Чиг үүрэг, эрх зүйн суурь, бүтэц, шинэчлэлийн практик судалгаа, Ж.Танан

хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцсэн гэж дүгнэв. Түүнчлэн 15¹.6.Хүнсний хяналт зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд хүнсний хяналтын ерөнхий байцаагч нь хүнсний технологийн чиглэлээр магистр, ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан хүнсний технологич байх шаардлагыг тогтоосон нь салбарын байгууллагыг мэргэжлийн түвшинд удирдах, улмаар хүнсний баталгаат байдлын хяналт, зохицуулалтыг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсийг худалдан авч хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх, хүнснээс шалтгаалсан өвчлөл буурах зэрэг нөхцөлийг бүрдүүлэхэд түлхэц болох боломжтой юм.

Тав. Хүнсний хяналт, зохицуулалтын бүртгэл, мэдээллийн талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилт	Нийцэж буй эсэх
“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”²⁰-ын 3.4.2.1.-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, ...” гэж, 3.4.2.4.-д “Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна” гэж, 3.4.2.5.-д “Хүнсний түүхий эд үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно” гэж, 3.4.2.6.-д “...малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг дээшлүүлж, халдвар хамгаалал биоаюулгүй байдлыг хангах..., байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ” гэж заасан	10/18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг: “18.2.Энэ хуулийн 6.1, 8.11, 16.5 дэх хэсэгт заасан мэдээллийн санг уялдуулан зохицуулах, шинэчлэх, баяжуулах, хасалт хийж байгаа эсэхэд хяналт тавина.”

Одоогоос 10 гаруй жилийн өмнө мал эмнэлгийн лабораторийн мэдээллийн тогтолцооны дэд бүтэц сул, мэдээллийн урсгал нэгдсэн санд хуримтлагдаагүйгээс мэдээлэх, дүгнэх үйл ажиллагаа дутагдалтай байсан. Цахимд суурилсан системийг 2016 оноос лабораторийн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн нь мал эмнэлгийн лабораторид ирсэн дээж бүртгэл, шинжилгээний мэдээлэл, үр дүнг багтаасан удирдлагын нэгдсэн систем (vetlab.shinjlgee.mn) болж хөгжиж байна. Бүх үйл ажиллагааны дүн мэдээллийн санд хуримтлагдаж эхэлж байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахим бүртгэл захиргааны шинжтэй, админ суурьтай, бүртгэсэн мэдээллийг ашиглах харилцааг дутуу төлөвлөсөн, мэдээллийг захиргаа болон олон нийтэд хандсан байдлаар төрөлжүүлээгүй байна. Тодруулж хэлбэл, цахим санг бүрдүүлэх, ашиглах, хэрэглэх, удирдах үйл ажиллагаа

²⁰ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

цогц биш байна. Иймд тус мэдээллийн санг шинэчлэснээр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хооронд хийгдэх түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох үйл ажиллагааг тус санд түшиглэн зохион байгуулах, зардал, цаг хугацаа хэмнэх боломжтой.

Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хяналт тавих журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран баталж бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцдог тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ шаардлага гарч ирсэн. Улмаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэж заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах ажлыг МХЕГ-ын даргын 2013 оны “Заавар батлах тухай” 37, 2014 оны “Заавар батлах тухай” 129 тушаалаар тус тус батлуулан мөрдөж байсан. Тус тушаалаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн маягт”-ын загвар, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр”, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн маягтыг нөхөн бичих заавар”, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч мэдээллээ цахимаар бүртгүүлэх аргачлал, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах заавар”, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэлийг ашиглах аргачлал”-ыг тус тус батлаад 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн гүйцэтгэсэн байна. Энэ хүрээнд 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийн бүртгэлийн санд нийт 147150 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 396387 төрөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх зааврын хэрэгжилт хууль хэрэгжиж эхэлснээс хойших эхний 6 жилийн дунджаар 81.5 хувьтай гэж тухайн үеийн МХЕГ-ын тайланд дурдагдсан байна. 2022 оны 12 дугаар сард Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан боловч мэргэжлийн хяналтын байгууллагын хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим бүртгэл одоог хүртэл өөрчлөгдөөгүй тус цахим бүртгэлд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэл хийгдэж байгаа гэж Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас тайлагнасан боловч бодит байдал дээр МХЕГ байх үед бүртгэгдсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээлэл нь 2025 оны байдлаар ХХААХҮЯ-ны салбарын хяналтын газрын мэдээлэлтэй зөрүүтэй байсан бөгөөд энэ нь бүртгэлийн системд харилцан өөр мэдээлэл байх магадлал өндөр байна. Тухайлбал, 2019-2024 онд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон тохиолдолд энэ бүртгэлийн системээс хасалт хийхгүй байгаа нь бүртгэлийн мэдээлэл үнэн зөв, бодит байж чадахгүй байна юм гэж ХБАБХТ хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний тайланд дурджээ. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” А/76 дугаар тушаалын хавсралтаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг бүртгэх, сан бүрдүүлэх, ашиглах журам”-ыг баталсан байна.

Энэ хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (хуучнаар)-ын цахим бүртгэлийн <https://igov.mn/certificates> цахим системээр дамжуулан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн хүсэлтийг хүлээн авч бүртгэж байгаа гэж ХХААХҮЯ-наас тайлагнах боловч хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нарыг бүртгэдэг цахим бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан байна. Тодруулбал, Мэргэжлийн хяналтын

байгууллагын нэр дээр бүртгэдэг, хяналтын улсын байцаагч нарт тус системд нэвтрэх эрх байхгүй, цахим системд бүртгэгдсэн үйл ажиллагаа эрхлэгч нар мэдээлэл давхардуулан оруулсан, үйл ажиллагааг зогсоосон, мэдээлэл буруу оруулсан байдлыг шалгах, бүртгэх боломжгүй, тус хуулийн 6.5 дахь заалтад заагдсан улсын байцаагчийн ажлын байранд гаргасан дүгнэлт ордоггүй зэрэг хэвийн үйл ажиллагаа алдагдсан.

Хүнсний аюулгүй байдлыг хангахад хяналтын, бүртгэл, мэдээллийн, баталгаажуулалтын, эрсдлийн удирдлагын, харилцан хамтын ажиллагааны мөн хүний нөөц, сургалт мэдээллийн дэд системүүд ажиллах учиртай гэтэл эдгээр дэд системүүдийн үйл ажиллагаа доголдсон, зарим дэд системийг бий болгоогүй буюу огт байхгүй байгаа тул хүнсний салбарт оролцогчдын эрх ашиг хөндөгдөж, үүрэг хариуцлагаа ухамсарлах асуудал алдагджээ гэж дүгнэхээр байна. Импортын болон дотоодын хүнсний түүхий эд, туслах материал, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын тогтолцоо бүрдээгүй, аюулгүй байдал хангагдаагүй байгаа нь хүнсний сүлжээний анхан шатанд үүсч байгаа эрсдэлт хүчин зүйлс юм. Хүнсний сүлжээний анхан шатны үйлдвэрлэл нь ийнхүү баталгаагүй байдалтай байгаа нь хэрэглэгчийн гар дээр аюулгүй, эрүүл хүнс очиж байгаа гэдэгт итгэхэд хэцүү нөхцөл байдал үүсээд байгаа юм. Улмаар гарал үүсэл нь баталгаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэж, зориулалтын бус агуулах, зооринд хадгалж байгаа нь мөн л хүнсний сүлжээний гол үе шат болох ложистикийн тогтолцооны эмх замбараагүй хөгжилтэй ²¹ холбоотой. Хүнсний сүлжээний үе шатанд бүртгэл, мэдээллийн тогтолцоо бүрдээгүй байгаа нь хэрэглэгчийн гар дээр аюулгүй, эрүүл хүнс очиж байгаа гэдэгт итгэхэд хэцүү нөхцөл байдал үүсээд байгаа юм. Хүнсний хяналт, зохицуулалттай холбоотой бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгох, түүнийг хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцах, хүнсний шинжилгээний болон эрсдлийн хяналтын бүртгэл, мэдээллийн сангуудыг мөн хөгжүүлж, хоорондын уялдааг хангах зэрэг агуулга бүхий хуулийн төслийн зохицуулалтууд нь өнөөдрийн тулгамдаад байгаа хэрэглэгчийн ширээн дээр эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаатай хүнс хүргэхэд чухал ач холбогдолтой юм. Эдгээр зохицуулалтууд нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.2 дахь /Энэ хуулийн 6.1-д заасан маягтын загварыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална/ заалт Мэргэжлийн хяналтын байгууллага тарсанаас хойш шинэчлэгдээгүй зэргээс дүгнэхэд хуулийн хэрэгжилт маш хангалтгүй түвшинд байна. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”²²-ын 3.4.2.1.-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, ...” гэж, 3.4.2.4.-д “Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна” гэж, 3.4.2.5.-д “Хүнсний түүхий эд үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно” гэж, 3.4.2.6.-д “...малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг дээшлүүлж, халдвар хамгаалал биоаюулгүй байдлыг хангах..., байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх, хяналт, шалгалтын бодлого, үйл ажиллагаанд нэгдмэл байдлаар дүн шинжилгээ хийх, дүгнэх, цаашдын зорилтыг тодорхойлоход мэдээллийн санг тогтмол хэвийн ажиллуулах, тухай бүр хяналт шалгалтын болон бусад дүн мэдээг оруулах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүртгүүлэх, үйл ажиллагаагаа зогсоосон бол хасалт хийж байх бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, шинэчлэлт, сайжруулалт хийгдэх хэрэгцээ, шаардлагад нийцсэн зохицуулалт болжээ.

²¹ “Мах, хүнсний ногооны хангамжийн баталгаат байдал” хэлэлцүүлгийн эмхэтгэл, 2019-5-6

²² Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан

Зургаа. Хуулийн нэр болон холбогдох зүйл, заалтын нэршлийг өөрчилж томъёолох талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилт	Нийцэж буй эсэх
1/Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний судалгаанд²³ “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний баталгаат байдал” болгон өөрчлөх нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх, хууль хэрэглээнд гарч байгаа хүндрэлийг арилгахад эерэг нөлөө үзүүлнэ гэж тусгажээ. Тус хуулийн үзэл баримтлалд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчилж, хуулийн холбогдох зүйл, үг хэллэгийг жигдлэх замаар хууль хоорондын уялдаа холбоог хангахыг тэмдэглэсэн.	4 дүгээр зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийн “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 2 зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 3.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “аюулгүй байдал” гэснийг “баталгаат байдал” гэж, 4.1.13 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 4.1.19, 4.1.20, 4.1.21 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 5 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1, 5.1.2, 5.1.3 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 5.1.4 дэх заалтын “байх” гэснийг “шинжлэх ухааны үндэслэлтэй байх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “хүнсний хяналт, зохицуулалтын байгууллага” гэж, 7.1 дэх хэсгийн “зохистой дадлыг нэвтрүүлнэ” гэснийг “зохистой дадлын стандартыг мөрдөнө.” гэж 7 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 7.3 дахь хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 8 дугаар зүйлийн 8.6, 8.7 дахь хэсгийн “журмын” гэснийг “стандартын” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “журмын дагуу” гэснийг “стандартын дагуу” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “хууль, холбогдох дүрэм, журмыг” гэснийг “хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтыг” гэж, 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “зохицуулж болно” гэснийг “зохицуулна” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 13.7 дахь хэсгийн “хийж болно” гэснийг “хийнэ” гэж, дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дахь хэсгийн “Стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэснийг “хүнсний хяналт, зохицуулалтын байгууллага” гэж, 15.2.1 дэх заалтын “аюулгүй байдалд” гэснийг

²³ Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний судалгаа, 2025

	“баталгаат байдалд” гэж, 15.2.4 дэх заалтын “баг” гэснийг “төв” гэж, 15.2.7 дахь заалтын “аюулгүй байдлын талаарх техникийн зохицуулалт” гэснийг “баталгаат байдлын талаарх стандарт, техникийн зохицуулалт” гэж, 15.3 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж, 15.5 дахь хэсгийн “багийн” гэснийг “төвийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “баг” гэснийг “төв” гэж, 16.1.1 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 16.3.4 дэх заалтын дугаарыг “16.3.6” гэж, 16.2 дэх хэсгийн “багийн” гэснийг “төвийг” гэж, 16.3 дахь хэсгийн “баг” гэснийг “төв” гэж, өөрчлөх, 17 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 17.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 17.1.1 дэх заалтын “зохистой дадлыг нэвтрүүлэх” гэснийг “хүнсний баталгаат байдлыг хангах” гэж, 17.1.3 дахь заалтын “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 17.2 дахь хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 18 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 18.1 дэх хэсгийн “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналтын байгууллага” гэснийг “хяналт, зохицуулалтын байгууллага, аймаг, нийслэлийн хяналтын байгууллага” гэж, “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 18.1.3 дахь заалтын “техникийн нөхцөл, эрүүл ахуй, ариун цэврийн бусад шаардлагыг” гэснийг “эрүүл ахуй, ариун цэврийн стандартын шаардлагыг” гэж, 18.1.5 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж, “багийн” гэснийг “төвийн” гэж, “техникийн” гэснийг “дүгнэлт” гэж тус тус өөрчилсүгэй.
--	---

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих шаардлага, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаарх төрийн чиг үүрэг, хяналттай холбогдсон харилцааг зохицуулсан 5 бүлэг 20 зүйлтэй батлагдсан.

Хуулийн хэрэгжилтийг 4 бүлэг 14 зүйл, 116 заалтын хүрээнд гаргаж, нэгтгэн дүгнэхэд өнөөгийн хүнсний хяналтын бодлого алдагдаж, хүнсний сүлжээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах мэргэжлийн удирдлагын тогтолцооны гажуудлаас үүдэн энэ хуулийн хэрэгжилт, хуулийн үзэл баримтлалд анх дэвшүүлсэн зорилгодоо хүрч чадахгүй байна гэж дүгнэж байна. Иймд хуулийн хэрэгжилтийн хувь доогуур байна. Үүнд нөлөөлсөн нэг хүчин зүйл бол хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд чухал үүрэгтэй гол нэр томъёо болох “хүнсийг хүн идэж уухад хүний биед ямар нэг сөрөг нөлөөгүй байдлыг баталгаажуулахтай холбогдсон нэр томъёоны нэршлийн асуудал байсныг хуулийн хэрэгжих явцад оролцогч талууд удаа дараа гаргаж тавьж ирсэн. Тийм учраас Хүнсний тухай хуулийн үзэл баримтлалд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын

хангах тухай хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчилж, хуулийн холбогдох зүйл, үг хэллэгийг жигдлэх замаар хууль хоорондын уялдаа холбоог хангахыг тэмдэглэсэн байна. Олон улсын хүнсний хууль, эрх зүйн хороо (CAC), Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) болон НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO) нь олон улсын хүнсний баталгаат байдлын стандартыг тогтоож, шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмжөөр хангах, улс орнуудад баталгаатай, шударга хүнсний системийг тогтооход дэмжлэг үзүүлдэг. Хүнсний чиглэлийн олон улсын байгууллагаас “хүнсний баталгаат байдал”-ыг хэрхэн томъёолсныг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Олон улсын байгууллагууд хүнсний баталгаат байдлыг тодорхойлсон байдал

FAO defines Food safety is a science-based discipline, process or action that prevents food from containing substances that could harm a person's health. Food safety aims to have food that is safe to eat. Safe food is vital to achieve food security and healthy diets	НҮБ-ын ХХААБ-ын тодорхойлолт: Хүнсний баталгаат байдал гэж хүний эрүүл мэндэд гэмтээх бодис хүнсэнд агуулагдахаас сэргийлэх шинжлэх ухаанд суурилсан дэг журам, арга хэмжээ, үйл явц юм. Хүнсний баталгаат байдлын зорилго нь хүнсийг хүн идэхэд баталгаатай байхад чиглэгдэнэ. Баталгаатай хүнс бол хүнсний аюулгүй байдал болон эрүүл хооллолтыг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй.
WHO defines Food safety as the conditions and practices necessary to ensure that food is safe, sound, and wholesome, and fit for human consumption throughout its journey from production to consumption. This means preventing contamination and ensuring food remains safe and nutritious throughout the food chain.	ДЭМБ-ын тодорхойлолт: Хүнсний баталгаат байдал гэж Үйлдвэрлэлээс хэрэглэгчид хүрэх бүх үйл явцад хүнсийг баталгаатай, чанартай, шим тэжээлтэй байлгахад шаардлагатай нөхцөл, дадлуудыг хэлнэ. Энэ нь хүнс бохирдохоос сэргийлэх, хүнсний гинжин хэлхээний туршид хүнсийг баталгаатай, шим тэжээлтэй байлгах зорилготой.
The Codex Alimentarius Commission (CAC) defines food safety as ensuring that foods are safe for human consumption and free from hazards that could cause illness or injury. This includes protecting consumers' health and facilitating fair practices in food trade. The CAC achieves this through developing and adopting international food standards, guidelines, and codes of practice	Хүнсний хууль, эрх зүйн хорооны тодорхойлолт: Хүнсний баталгаат байдал гэж хүнс нь хүн хэрэглэхэд баталгаатай, өвчин үүсгэх эсвэл гэмтэл учруулж болзошгүй эрсдэлүүдээс ангид байхыг хангах явдал. Үүнд хэрэглэгчийн эрүүл мэндийг хамгаалах болон хүнсний худалдаанд шударга байдлыг дэмжих зорилго мөн багтдаг. ХХЭЗХ энэ зорилгод хүрэхийн тулд олон улсын хүнсний стандарт, удирдамж, үйл ажиллагааны дүрэм журмыг боловсруулж, баталдаг.

Эдгээр олон улсын байгууллагуудын тодорхойлолтоос харахад хүнсний баталгаат байдал нь хүнсийг хүн идэж, уухад хүний эрүүл мэндэд ямар нэг өвчин эмгэг үүсгэхгүй байхад чиглэгддэг хүнсний сүлжээний явцад ийм байдлыг хангахад чиглэгддэг гэсэн агуулгатай байна. Өөрөөр хэлбэл хүнс нь баталгаатай байна гэсэн санаа бүгд тодорхойлолтод байна. Тиймээс Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хүнсний баталгаат байдал” гэсэн нэр томъёог нэмж тусгасантай холбоотой Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өөрчилж, хуулийн холбогдох зүйл, заалтад байгаа “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг “хүнсний баталгаат байдал” гэж өөрчилсөн хуулийг нэг мөр ойлгох, хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилго, хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

2. “ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ:

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгах аар хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу хүнсний сүлжээний бүх үе шатанд тохирох зохистой дадлын төрлүүдийг өргөжүүлсэн дараахь зохицуулалтыг сонгож авч үнэлэв. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцож гаргана. Аргачлалын Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх хэсэгт зааснаар тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ гэж заасан ба шалгах хэрэгсэл нь шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байна гэжээ. Тэгвэл, практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэл нь “турших” гэж заажээ.

Дэлхийн хүн ам өсөн нэмэгдэж байгаа өнөө үед тэдгээрийн хоол хүнсний хангамж, хэрэгцээг шийдвэрлэх хамгийн чухал салбар бол хөдөө аж ахуйн салбар болоод байгаа бөгөөд дэлхийн ихэнхи орон газар тариалангийн үйлдвэрлэлээр энэхүү асуудлыг шийдэж байна. Харин газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн буюу ургацын чанар тоо хэмжээг нэмэгдүүлэхэд Хөдөө аж ахуйн зохистой дадал (ХААЗД) чухал үүрэг гүйцэтгэж байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас эрүүл, аюулгүй, шим тэжээлтэй хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн зэрэгцээ тариаланчид болон үйлдвэрлэл эрхлэгчдийн эрүүл мэндийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах зорилгоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмж заавруудыг гарган гишүүн орнуудад хүргүүлж байна. Тиймээс ХБАБХТ хуулиар хөдөө аж ахуйн, эрүүл ахуйн эсхүл үйлдвэрлэлийн зохистой дадлыг хүнсний сүлжээний холбогдох үе шатанд заавал хэрэгжүүлэх үүргийн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ХБАБХТ хуулийн 7 дугаар зүйлээр тусгайлан хүлээлгэсэн байдаг. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран 3 зохистой дадлыг нэвтрүүлэх үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа. Хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи 7 дахь жилд ХХААХҮ, ЭМ сайд нарын 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хамтарсан А/166, А/251 дугаартай тушаалаар “Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ыг баталсан байна. Мөн, хүрээнд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд тавих тэмдгийг ХХААХҮ-ийн сайдаар батлуулсан. Харин, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн

7 дугаар зүйлийн 7.2.-д заасан зохистой дадлыг үйлдвэрлэлд хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш 12 жилийн дараа ХХААХҮС, ЭМС-ын 2024.02.16-ны өдрийн А/100, А/68 дугаар тушаалаар батлуулсан байна. Тушаалын нэгдүгээр хавсралтаар “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”, хоёрдугаар хавсралтаар “Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар” тус тус батлагдаад нэг жил болж байна. Эрүүл ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар одоог хүртэл батлагдаагүй. Тариалангийн үйлдвэрлэлд ХААЗД нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтаар 2016-2023 онуудад НҮБ-ын ХХААБ болон Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбооноос 2 үе шаттай хэрэгжүүлсэн “Монгол ногоо” төслийн бүрэлдэхүүн хэсгүүдээс ХААЗД-ыг нэвтрүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд манай улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар баталгаажуулах эрх авсан байгууллага 2, ХААЗД-ыг нэвтрүүлснээ баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулан, гэрчилгээ авсан аж ахуй нэгж, иргэдийн тоо 80 гаруй байна.²⁴. Гэхдээ энэ тоо буурч байгаа ба давтан аудитад хамрагдахаа больсон байгаа дүр зураг ажиглагдаж байгаа хэдий ч хуулийн төслийн энэхүү заалтыг практикт туршиж хэрэгжих бүрэн боломжтойг ХААЗД-ын жишээгээр харуулж байгаа. Тиймээс хуулийн төсөлд хүнсний сүлжээний үе шатуудад заавал хэрэгжүүлэх зохистой дадлуудын төрлийг ХБАБХТ хуульд байснаас нэмэгдүүлэн тээвэрлэлтийн, худалдааны, хадгалалтын, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний, нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүд истой дадлуудыг хэрэгжүүлэхээр тусгасан нь практикт хэрэгжих боломжтой байна гэж дүгнэв. Түүнчлэн хуулийн төсөлд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, худалдааны явцад стандарт, техникийн зохицуулалт зөрчсөн, технологийн горим алдагдсан тогтоогдвол тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг нэмсэн нь зохистой дадлуудыг хэрэгжүүлэхэд түлхэц болно. Зохистой дадал гэдэг бол хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавигдах эрүүл ахуй, ариун цэврийн хамгийн доод түвшиний шаардлага буюу үйл ажиллагаа эрхлэхийн өмнөх урьтал нөхцөл юм. Үүнээс доош эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага буюу хялбаршуулах заавар гэж байх ёсгүй. Тиймээс хуулийн төслөөр эдгээр зохистой дадлуудыг хялбаршуулан нэвтрүүлэх заавраар бус стандарт байхаар хуульчлах гэж байгаа нь зарчмын хувьд маш зөв шийдэл болжээ гэж үзэж байна. Хүн амыг эрүүл, чанартай, баталгаатай хоол, хүнсээр хангах энэ хуулийн зорилгын биелүүлэхийн тулд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг үйл ажиллагааных нь цар хүрээнээс нь үл хамааран үйл ажиллагаандаа тохирох зохистой дадлын хялбаршуулсан зааврыг биш зөвхөн стандартыг заавал мөрдүүлэхээр тусгаж байгаа нь стандартыг хэрэгжүүлж байгаад баталгаажуулалт хийх практик боломжийг нэмэгдүүлж байна гэж үзэв.

3. “ОЙЛГОМЖТОЙ БАЙДЛЫГ СУДЛАХ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ:

Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана.

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд

²⁴ <https://mofa.gov.mn/files/pdf-files/cx8b8v9r6pm/652fa11ad945cd6f70cf5fed.pdf>

заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хүснэгт 4.Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үнэлгээ хийсэн байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын	Шаардлага хангасан..

төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгаж, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлага хангасан гэж дүгнэв.

4."ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ БАЙДАЛ" ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг сонгон авч үнэлэв. Энэ заалтын хүрээнд хүнсний баталгаат байдлыг хангахад чухал үүрэгтэй лабораторийн шинжилгээг хийхэд хувийн хэвшлийн лабораторийг татан оруулах зорилгоор хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага урт хугацааны гэрээ байгуулж ажиллахаар тусгасан. Ингэхдээ тухайн шинжилгээний нэг, эсхүл хэд хэдэн үзүүлэлэлтээр олон улсын стандартын дагуу итгэмжлэгдсэн байх шалгуурыг заажээ.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавхыг одоо шинжилж байгаа аюулгүйн үзүүлэлт нь нийт баталсан аюулгүйн үзүүлэлтэд эзлэх хувиар тооцсон ба улсын хэмжээнд 2023 онд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавх 70.17 хувь байна. Тухайлбал, пестицидийн үлдэгдлийг хянах үндэсний төлөвлөгөөнд тусгагдсан нийт пестицидийн үлдэгдэлд эзлэх хувиар улсын хэмжээнд хэдэн нэр төрлийн пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй хувийг тооцоход 0.81 хувь байна.

Хүснэгт 5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадавх

Үзүүлэлт	2021	2022	2023
Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн хувь ¹	70.17	70.17	70.17
Пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй нэр төрлийн тоо ²	108	129	188
Пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй хувь ²	42.86	51.19	74.6

Эх үүсвэр: ¹ХАБҮЛЛ, ²ХАБҮЛЛ, УХЭШХ, УМЭАЦТЛ, Демо лаборатори

Түүнчлэн, улсын хэмжээнд 2023 оны байдлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүнсний үйлдвэрлэлд хэрэглэж буй хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлох лаборатори 35 нэр төрлийн хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлох чадамжтай байгаа бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд транс тосыг шинжлэн тодорхойлох чадамжтай лаборатори бүртгэгдээгүй байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлд Үндэсний лавлагаа лабораторийн чиг үүргийг тодорхойлсон байдаг. 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсны дагуу "... хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, төр, хувийн хэвшлийн лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагаа лаборатори нь Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэд харьяалагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. ХБАБХТ хууль 2012 онд хууль батлагдаж, хэрэгжиж эхэлсний дараа Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 330 дугаар тогтоолоор хяналтын байгууллагын Нэгдсэн төв лабораторийг Үндэсний лавлагаа лаборатори болгон бүтэц, зохион байгуулалтыг нь өөрчилж байсан. Төв, нийслэл, орон нутаг, хилийн боомтууд дээрх хяналтын лабораториудыг нэгдсэн сүлжээнд оруулж, хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн нэгдсэн сүлжээ байгуулах, төв лаборатори нь сүлжээ лабораториудаа мэргэжил арга зүйгээр удирдан ажиллах тухай гарсан Засгийн газрын 2012 оны 175 дугаар тушаалын дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь сүлжээ лабораториудын шинжээчдийг мэргэжил арга зүйгээр ханган үйл ажиллагааг уялдуулан зохицуулж байгаа. Гэсэн хэдий ч сүлжээ лабораториудын шинжээч мэргэжилтний сургалт, лабораторийн дотоод үйл ажиллагааны аудит, мөн итгэмжлэлд бэлтгэх, лабораторийн шинжилгээний шинэ арга, аргачлал нэвтрүүлэхэд лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодисоор тогтвортой хангахад хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал тус лабораторид тулгамдаж байна. Иймд, лабораторийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаа, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, дээж авах, урвалж бодис зэрэг зардлыг хүнсний хяналт зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон тухайн лаборатори жил бүр төсөвтөө тусгаж байхаар дараагийн заалтыг боловсруулсан нь лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах, улмаар хүнсний баталгаат байдлыг хангахад чухал ач холбогдолтой болжээ. Мөн, тус хуулийн 18.3-т итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн

болон хувийн өмчит лаборатори хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, дээжийн шинжилгээ хийхэд оролцоно гэж заасныг хуулийн төслөөр улам баталгаажуулан хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага урт хугацааны гэрээ байгуулахаар тусгасан байгаа нь хуулийн хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлжээ гэж үзэв. Тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгах тухай Аргачлалын шаардлагын дагуу үнэлж үзэхэд хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, худалдаалж, үйлчилж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний биед сөрөг нөлөөгүй байгааг шинжилгээ хийх, тандалт хийх зэрэг үйл ажиллагаанд чадавхи бүхий мэргэшсэн, итгэмжлэгдсэн хувийн лабораториудыг татан оруулах нь төрийн лабораторийн ачааллыг бууруулахаас гадна хувийн лабораториуд хөгжих, хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжийг нээж байна. Хэдийгээр лабораторийн асуудал одоогийн хуульд байгаа ч түүнийг улам баяжуулсан дэвшилтэт агуулгатай байна гэсэн үнэлгээ хийв.

5. “ХАРИЛЦАН УЯЛДАА” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд дурдсан асуултуудад хариулт өгөх зорилгоор хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар зохицуулалт хоорондын уялдаа холбооны үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Асуулт	Хариулт
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилготой нийцэж буй эсэх	Тийм.
Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг ХБАБХТ хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан байгаа ба эдгээр нь хүнсний баталгаат байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр зохицуулах харилцаанд хамаарч байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм. Хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолтууд нь төсөл болон төсөлд тусгасан бүлэг, зүйл, заалтын нэр томьёотой нийцсэн байна.
Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм. Хуулийн төслийн зохицуулалт хоорондоо агуулгын хувьд зөрчилгүй байна.

Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай давхардсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтын агуулгыг давхардаагүй байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм. Хуулийн төслийн 5/15¹ дугаар зүйл: “15¹ дугаар зүйл.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо 15¹.1.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо нь улсын хэмжээнд хүнсний, асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага/цаашид “хяналт, зохицуулалтын байгууллага” гэх/, Үндэсний лавлагаа лаборатори, эрсдэлийн үнэлгээний төв, аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ гэж иж бүрнээр нь тусгасан.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зорилгод хүрэх хэмжээний зохицуулалт тусгагдсан гэж үзэж байна. Иймд төсөлд орхигдуулсан шаардлагатай зохицуулалт байхгүй.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй. Хуулийн төслөөр төрийн захиргааны болон бусад холбогдох байгууллагын чиг үүргийн давхцал үүсгээгүй байна.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломж байгаа эсэх	Үгүй.
Татварынхаас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тийм. Тус хуулиар “19¹.1 дүгээр зүйл.Эрүүл зөв хүнс сонгон хэрэглэхийг дэмжих 19¹.1.Хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжинэ.

	19 ¹ .2.Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлана.” гэсэн зохицуулалт туссан.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Үгүй. Тус хуулийн төслөөр тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулаагүй тул Зөвшөөрлийн тухай хууль тусгах шаардлагагүй байна.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төсөлд хүний эрхийг аливаа хэлбэрээр хязгаарласан, хориглосон зохицуулалт тусгагдаагүй байна.
Хуулийн төслийг зохицуулалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм. Хуулийн төсөл бүхэлдээ жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн байна.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зохицуулах харилцаанд шударга бус өрсөлдөөнтэй холбоотой харилцаа хамаарахгүй.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн зорилго болон зарчмыг хангахад чиглэсэн байх бөгөөд зохицуулалтууд нь аливаа хэлбэрээр авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдээгүй байна.
Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан эсэх	Тийм. Тус хуулийн төслийн хамт Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлж байх бөгөөд дээрх хуулийн төсөлд хариуцлагын талаар зохицуулсан байна.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт хоорондоо болон бусад хуулиудтай зөрчилдөж буй эсэх, агуулгын хувьд давхцал үүссэн эсэхэд дүн шинжилгээ хийж үзэхэд, эрх зүйн зохицуулалтын давхардал, зөрчилгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д үндэслэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайланг хийж гүйцэтгэлээ. Тус хуулийн төслөөс түүний үр нөлөөг үнэлэхэд ач холбогдол бүхий зохицуулалтыг сонгон авч зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан уялдаа гэсэн шалгуураар үнэллээ.

Аргачлалын 4.1-д “энэ үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ.” гэж, мөн аргачлалын 4.4-д “Шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн үр нөлөөг яаж үнэлэхийг тогтооно” гэж тус тус заасныг хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээнд мөрдөж ажиллав.

ДҮГНЭЛТ:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д хуульчилсан “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинээр нэмэх, шинэчлэн найруулах, өөрчлөх, хасах, хүчингүй болгох замаар хуулийн төслийг боловсруулсан байна, ингэхдээ одоогийн хүчин төгөлдөр хуулийн зорилго, зарчимд нийцүүлэн, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага, зорилгын хүрээнд боловсруулагдсан байна гэсэн нэгдсэн дүгнэлт хийв.

Хуулийн төслийг хүний биед сөрөг нөлөөгүй баталгаатай хүнсээр хангах тогтолцоог хөгжүүлэх, дэмжих чиглэлээр хангалттай түвшинд хүргэх зорилготойгоор боловсруулсан байна.

Хуулийн төсөлд туссан зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловруулах хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг бүрэн илэрхийлэх түвшинд томъёологдсон байна.

Хуулийн төслийн зохицуулалт нь одоогийн хүчин төгөлдөр хуулиар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлжээ гэж үзэв.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр хуулийн хоёрдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн бүлэг, зүйл, заалт, дэд заалт хооронд зөрчилгүй, Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байна.

ЗӨВЛӨМЖ

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй дагалдаж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хуулийн төслийг боловсруулж, хамтад нь өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

ГАРЧИГ

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ**

ТАЙЛАН.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
1. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО.....	6
2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО.....	7
ДҮГНЭЛТ	14
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	15

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

Зардлын тооцоо хийсэн аргачлал:

Сонгон авсан хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр бичигдсэн байх ба тус хуулийн төсөлд хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад хэрэгжүүлэх нэмэлт чиг үүрэг бий болгож байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.

Хуулийн төслийн үзэл баримтлалд “хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй, бүтэц, зохион байгууллалтын оновчгүй тогтолцоо, хүнсний хяналтын чиглэлийн сорилт, шинжилгээний лабораторийн чадавх сул, зах зээл дэх дотоодын болон импортын хүнсэнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт, тандалт хийх зэрэг хяналтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлага алдагдсан, зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулах харилцааг захиргааны хэм хэмжээгээр зохицуулах гэж оролдсон, нөгөө талаас хэрэглэгчийн шошготой танилцаж, эрүүл хүнсээ сонгон авах чадвар сул, хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрт хамаарах үйл ажиллагаанд тохирох зохистой дадал болон хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлээгүйтэй холбоотой байна.

Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд дараах зарчмын шинжтэй өөрчлөлт хийхээр хуулийн төсөлд тусгасан болно.” гэж заасны дагуу уг зорилтыг хангахад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад ямар төрлийн шинэ чиг үүрэг бий болж, үүнтэй холбоотой гарч болох зардлын тооцоог хийхийг зорилгоо.

Хуулийн төсөлд шинээр бий болсон бүтэц, төрийн байгууллагын нэмэлт чиг үүргийн бүтэц гэсэн агуулгаар зардлын ерөнхий тооцоог гаргана. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр нэмж буй 15¹ дугаар зүйл нь хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоог тодорхойлсон байх ба энэ хүрээнд бий болгох улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Үндэсний лавлагаа лаборатори, эрсдэлийн үнэлгээний төв, аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ гэж заажээ. Үүнээс хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “агентлаг” гэх), эрсдэлийн үнэлгээний төвийн чиг үүргийг нэмэлтээр хөндсөн байна.

Хуулийн төслийн зардлын тооцоог гаргах зорилгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаж, судалгааг боловсруулсан, хуулийн төслийг боловсруулсан мэргэжилтэнгүүдтэй уулзалт, ярилцлага хийлээ.

Хуулийн төсөлд заасан шинэ бүтэц болох агентлаг, Эрсдэлийн үнэлгээний төвийн чиг үүргийг тодорхойлж, холбогдон гарах зардал, тоон үзүүлэлтийг тооцож, нийт зардлыг гаргалаа.

Агентлаг нь хуулийн төсөлд заасны дагуу салбарын хүнсний хяналтын бодлогыг тодорхойлон мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна. Энэхүү агентлагийн чиг үүргийг одоо хүчин төгөлдөр хуулийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (цаашид “ХХААХҮЯ”)–ны салбарын хяналт хариуцсан газар, нэгж хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү бүтцийг шинээр байгуулах агентлагт шилжүүлнэ. Мөн агентлагийн доор одоо үйл ажиллагаа явуулж байгаа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (цаашид “ХАБҮЛЛ” гэх) болон энэ хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа Эрсдэлийн үнэлгээний төвийг мөн ажиллуулна.

Агентлагийг байгуулж байгаатай холбоотойгоор нэмэлт шинэ орон тоог үүсгэхгүй бөгөөд агентлагийн албан хаагчдыг ХХААХҮЯ болон ХАБҮЛЛ-аас шилжүүлэн авах замаар бүрдүүлнэ. Дээрх агуулгаар агентлаг нь нийтдээ 319 хүний бүрэлдэхүүнтэй байх ба үүнд агентлагийн үндсэн орон тооноос гадна, ХАБҮЛЛ, Эрсдэлийн үнэлгээний төвийн орон тоог хамруулна.

Хуулийн төслөөр шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдох боломжтой тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Зардлын тооцоонд ашигласан үзүүлэлт, тоо баримтыг хуулийн төсөл боловсруулагчтай зөвлөсний дагуу доор дурдсан асуулт, хариултын хүрээнд хийлээ. Үүнд:

№	Асуулт	Хариулт
1	Төслийн 1 дүгээр зүйл. “15.10. Лабораторийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах эрсдэлийн тандалтын шинжилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, дээж авах, урвалж бодис зэрэг зардлыг төрийн болон орон нутгийн лаборатори жил бүр төсөвтөө тусгана.” гэж заасны дагуу нэмэлт төсөв шаардагдах эсэх?	Уг зардлууд нь одоо ч төсвөөс гардаг бөгөөд үүнийг шинэчилдэг байх асуудлыг төсөлд тусгасан. Хуулийн төсөлтэй холбоотой шууд зардал гарахгүй.
2	Төслийн 1 дүгээр зүйл “16.3.4.эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, шинэчлэх, эрсдэлийн зураглал хийх, эрсдэл бүхий хүнсний бүтээгдэхүүний жагсаалт гаргах, шинэчлэх; 16.3.5.Эрсдэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэж, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан бэлтгэх, шинэ стандарт, хяналтын арга зүй боловсруулах.” зэрэг чиг үүргийг шинээр бий болгосон байна. Энэ чиг	Одоо энэ чиг үүрэг нь ХАБҮЛЛ дээр хэрэгждэг. Тусдаа шинэ бүтэц гаргахгүй, одоогийн хуулиар ХАБҮЛЛ-ийн Эрсдэлийн үнэлгээний баг хэрэгжүүлдэг чиг үүрэг болно.

	үүргийг хэрэгжүүлэх шинэ бүтэц бий болох уу?	
3	Төслийн 1 дүгээр зүйл 12.6-д заасан шошгожуулалттай холбоотой зардал гарах уу?	Энэ хүрээнд бол зардал одоо ч гардаг. Шошгонд тавих шаардлагыг илүү тодруулж өгсөн.
4	Төслийн 1 дүгээр зүйл 15 ¹ -т заасан байгууллагад ажиллах нийт ажилтны тоо, албан тушаалын ангилал тус бүрээр, бүтцийн задаргаатай өгнө үү.	Задаргааны мэдээллийг өгсөн. Одоо байгаа ХАБҮЛЛ-ыг агентлагийн дор ажиллуулна. ХАБҮЛЛ-ээс эрсдэлийн үнэлгээний багийн үйл ажиллагааг тусгаарлаж, тусдаа бие даасан бүтэц буюу эрсдэлийн үнэлгээний төв болгон зохион байгуулж байна. Агентлаг нь ХХААХҮЯ-нд шилжсэн салбарын хяналт буюу мэргэжлийн хяналтын чиг үүргийг буцаан төвлөрүүлнэ. Иймээс агентлагийн хувьд шинэ орон тоо бий болохгүй ба одоо байгаа бүтцийн хүрээнд чиг үүргийн хуваарилалт хийж, үйл ажиллагааг тусгаална. Нийтдээ 319 хүнтэй байна.
5	Төслийн 1 дүгээр зүйл 15 ¹ -т заасан байгууллагад ямар ямар байгууллагаас ямар албан тушаалын ангилал бүхий хэдий тооны ажилтан шилжүүлэн ажиллуулах талаарх мэдээлэл. Тухайлбал, ХХААХҮЯ-ны бүтцийн бүдүүвчид энэ чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ямар газар, хэлтэс, алба, мэргэжилтэн шилжих талаарх мэдээлэл	Яамны салбарын хяналтын газрын чиг үүргийг шилжүүлнэ. Анх салбарын хяналтаар шилжүүлсэн 16 ажилтныг буцаан татна. Эдгээр албан хаагчид нь албан тушаалын ангиллын хувьд буурахаар байна. Мөн ХАБҮЛЛ үйл ажиллагааг шилжүүлэхтэй холбоотой зарим нэг албан хаагчийг ХАБҮЛЛ-аас шилжүүлнэ. Түүнчлэн Эрсдэлийн үнэлгээний төвийн хувьд одоо ажиллаж буй багаас гадна, ХАБҮЛЛ-ын одоогийн бүтцээс 10 хүнийг нэмж шилжүүлнэ.
6	Төслийн 1 дүгээр зүйл 15 ¹ -т заасан байгууллагын үйл ажиллагаа явуулах байр сав, техник хэрэгслийг одоо байгаа нөөцөөр хангах боломжтой эсэх?	Энэ талаар тодорхой мэдээлэлгүй байна. Агентлагийн байрны хувьд 28 албан тушаалтантай оффис, тавилга, компьютер шаардлагатай. Харин Эрсдэлийн үнэлгээний төвийн хувьд 15 ажилтны оффис, тавилга, компьютер шаардлагатай бол, бусад ажилтан буюу ХАБҮЛЛ ажилчдын хувьд одоо байгаа байр, ажлын байр дээр үйл ажиллагаа хэвийн явагдана.
7	Төслийн 1 дүгээр зүйл 15 ¹ дугаар зүйл.Эрдэм шинжилгээний байгууллага нь одоо байгаа байгууллага уу? чиг үүрэг нэмэгдэж байна уу? нэмэгдэх бол ямар чиг үүрэг, үүнийг хэрэгжүүлэх ажилтны тоо нэмэгдэх эсэх нэмэгдэх бол ямар албан тушаалаар ажиллах ажилтан, хэдэн хүн нэмэгдэх вэ?	Эрдэм шинжилгээний байгууллагад одоо байгаа хүрээлэн, сургууль гэх мэт орно. Зардал гарахгүй, шинээр бий болгоогүй чиг үүрэгт багтана.
8	Төсийн 1 дүгээр зүйл 7.1 дэх хэсэгт нэмсэн заалтуудын хувьд шинээр нэвтрүүлэх дадалтай холбоотой зардал иргэн хуулийн этгээдэд нэмэлтээр бий болох уу?	Одоо ч энэ дадлыг бий болгох асуудал журмын хүрээнд зохицуулагддаг, үүнийг албан ёсоор хуульчилж байгаа.

9	Төслийн 2 дугаар зүйл “9.5.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөхтэй холбогдсон зохицуулалтыг энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадалд тусгана”. Энэ хүрээнд шинэ чиг үүрэг бий болж байна уу? хэрхэн хийгдэх вэ? Зардал гарах уу?	Одоо энэ чиг үүрэг байдаг. Иймд нэмэлт төсөв шаардахгүй.
10	Татвартай холбоотой дэмжлэг байгаа юу?	Байхгүй, харин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлана.

1. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдийн хэрэгжүүлэх нэмэлт чиг үүргийг бий болгоогүй. Иргэн, хуулийн этгээдээс хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдож болох хуулийн төслийн зохицуулалт нь:

7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ: “7.1.4. хүнсний сүлжээний нэг үе шатаас нөгөө үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэх, түгээх, хүргэхэд тээвэрлэлтийн зохистой дадал; 7.1.5. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтын шатанд худалдааны зохистой дадал; 7.1.6.хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалтын зохистой дадал; 7.1.7.нийтийн хоол үйлдвэрлэл, түүгээр үйлчлэх шатанд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой дадал; 7.1.8. нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүд холбогдох зохистой дадал; 10¹.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно: 10¹.1.1.хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх; 10¹.1.2.энэ хуулийн 10.1.7, 10.1.8, 10.2-т заасан эрүүл мэндийн шаардлага хангаагүй ажилтныг ажлын байранд нэвтрүүлэх; 10¹.1.3.хүнс үйлдвэрлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хүнсний нэмэлтийг хэмжээнээс нь хэтрүүлэн хэрэглэх, зориулалтыг өөрчилж хэрэглэх; 10¹.1.4. түүсэн ойн дагалдах баялгийн өнгө, зүс, амт чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт дур мэдэн хольж хэрэглэх, зах зээлд нийлүүлэх; 10¹.1.5.ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидын үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотекийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх;
--

10¹.1.6.газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх;

10¹.1.7.Хяналтын байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах.

10¹.2.Энэ хуулийн 10¹.1-д заасныг зөрчсөн дараах этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ:

10¹.2.1.Энэ хуулийн 10¹.1.1-10¹.1.2-т заасныг зөрчсөн буруутай этгээд;

10¹.2.2.Энэ хуулийн 10¹.1.3-10¹.1.6-д заасныг зөрчсөн нь лабораторийн шинжилгээний дүнгээр тогтоогдвол тариаланч, малчин, малын эмч, үйлдвэрлэгч, ойн дагалдах баялаг түүсэн, худалдаалсан этгээд.

11¹ дүгээр зүйл.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах шаардлага

11¹.1.Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах шаардлага тавигдана:

11¹.1.1. хоолны цэсний агууламжийн бодлогыг нэвтрүүлэх;

11¹.1.2.эрүүл хоолыг санал болгох цэсэнд илчлэг, нийт сахар, уураг, ханасан өөх тос, натрийн агууламж, хоолны хэмжээг ил тод байрлуулах.

11¹.2. Энэ хуулийн 11.1-д зааснаас бусад нийтийн бусад орчинд үйлчилдэг хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэг зэрэг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний холбогдох стандартыг мөрдөнө.”

Дээр дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээдийн хувьд нэмэлт ажлын байр бий болгох шаардлага байхгүй. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд заасан чиг үүрэгтэй ижил чиг үүрэгтэй байна.

Энэхүү хуулийн зорилт нь “хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан. Энэ агуулгаар үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг хуульчилж байгаа ба үүнтэй холбоотойгоор үйлдвэрлэл эрхлэгч нь нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах зарчмыг энэ хуулиар бий болгож байгаа. Энэ хуулийн төсөлтэй холбоотойгоор ямар нэг нэмэлт зардлыг төрд төлөхгүй.

2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн дараах нэмэлт чиг үүргийг төр өөртөө хүлээсэн байна. Үүнд:

1. Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг байгуулах;
2. Агентлагийн дэргэд хяналтын лаборатори болон эрсдэлийн үнэлгээний төв ажиллуулах;

Эдгээрийг хуулийн төсөлд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

ХҮНСНИЙ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АГЕНТЛАГ, ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИ БОЛОН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ:

15¹ дугаар зүйл.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо

15¹.1.Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо нь улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Үндэсний лавлагаа лаборатори, эрсдэлийн үнэлгээний төв, эрдэм шинжилгээний байгууллага, аймаг, нийслэлд хүнсний хяналтын байгууллага, байгууллага, төрийн, орон нутгийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ.

15¹.2.Хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “хяналт зохицуулалтын байгууллага” гэх/ нь салбарын хүнсний хяналтын бодлогыг тодорхойлон мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавина.

“15.2.9.хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх харшил үүсгэгч, бичил биетний тэсвэржилтийн тандалт шинжилгээг хийж, эрсдэлийн үнэлгээний төвд хүргүүлэх.”

“7.4.Хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7.1, 7.3-т заасан зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх талаар нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, стандартыг хэрэгжилтийг хангуулна.”

Хуулийн дээрх зохицуулалтаас харахад доор дурдсан чиглэлээр төрөөс нэмэлт зардал гарахаар байна. Үүнд:

1. Агентлагийн чиг үүргийн хүрээнд нийт 319 албан хаагчийн зардал;

Дээрх чиг үүрэг, зардлыг тодорхойлж үзвэл:


2.1. Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг:

Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг нь нийт 319 ажилтнаас бүрдэх ба үүнээс улсын байцаагч 20, захиргааны 8, ХАБҮЛЛ 96+180, Эрсдэлийн үнэлгээний төв нь 15 албан хаагчтай байна.

Үүнээс агентлагийн хувьд 2022 оны 12 сард МХЕГ-аас ХХААХҮЯ-руу шилжсэн 16 улсын байцаагчийг ХХААХҮЯ-наас, захиргааны 8, байцаагч 4 албан хаагчийг ХАБҮЛЛ-оос шилжүүлэн ажиллуулахаар байна. Харин Эрсдэлийн үнэлгээний төвийн хувьд ХАБҮЛЛ-аас эрдэслийн үнэлгээний багийн үндсэн 5 орон тооноос гадна, нэмж 10 орон тоог тус тус шилжүүлнэ.

Иймд агентлаг, Эрсдэлийн үнэлгээний төвтэй холбоотой шинэ орон тоо бий болгоогүй болно. Үүнээс ХАБҮЛЛ-ын хувьд харьяалах газар өөрчлөгдөж байгаагаас бусдаар ажилтны цалингийн ангилалд өөрчлөлт оруулахгүйгээр тооцно.

Дээрх бүтцийн дагуу гарах хүний нөөц буюу зардлын тооцооллыг хийхдээ ажиллах хүний тоо, үндсэн цалин нэмэгдэл зэргийг тооцож үзвэл:



Үндсэн цалингийн хувьд: Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийг хэмжээг авч үзнэ. Үүнд:

**Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн
захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын
цалингийн ХЭМЖЭЭ**

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ /сард, төгрөгөөр/
T3-1	2,586,000
T3-2	2,301,000
T3-3	2,171,000
T3-4	2,049,000
T3-5	1,862,000
T3-6	1,693,000
T3-7	1,539,000
T3-8	1,399,000
T3-9	1,283,000
T3-10	1,166,000

Нэмэгдэл: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол (цаашид “Тогтоол” гэх)-оор төрийн үйлчилгээний албан тушаалтны нэмэгдлийг тогтооно:

Албан тушаалд тавигдах шаардлага: Төрийн албанд 10-аас дээш жил ажилласан байх шаардлага тавих тохиолдолд Тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл: **10 хувь байна.**

Ур чадварын нэмэгдэл: Үйлчилгээний албан хаагчийн хувьд олгогдоно. Тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-т зааснаар ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно. гэж заасан. Үүнээс хамгийн дээд хэмжээгээр тооцож үзвэл **25 хувиар** ур чадварын нэмэгдэл тооцно.

Мэргэшлийн зэргийн нэмэгдэл: Тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан журмын 2. Эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны хувьд: Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:

- Тэргүүлэх 20 хувь
- Ахлах 15 хувь
- Дэд 10 хувь

Докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл: Тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан журмын дагуу олгоно. Үүнд:

- Шинжлэх ухааны доктор зэрэг 20 хувь
- Профессор цол 10 хувь
- Боловсролын доктор зэрэг 15 хувь
- Дэд профессор цол 5 хувь

Дээрх тоон мэдээллээр дундчилан тооцвол, нэмэгдлийг дунджаар 60 хувиар тооцлоо.

**АГЕНТЛАГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРДАЛ
(ХАБУЛЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ ОРОЛЦУУЛААД)**

							Сая төгрөг
Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын ангилал зэрэглэл	Орон тоо	Үндсэн цалин	Сарын үндсэн цалин	Нэмэгдэл (дундажаар 60 хувь)	Унаа хоолны хөнгөлөлт (10000 төг)	Нийт цалингийн дүн
Хүнсний хяналтын Ерөнхий байцаагч	ТЗ-1	1	2,586	2,586	1,552	220	4,358
Газрын дарга	ТЗ-2	5	2,301	11,505	6,903	1,100	19,508
Хэлтсийн дарга	ТЗ-3	18	2,171	39,078	23,447	3,960	66,485
Албан хаагч	ТЗ-(4-10)	295	1,767,000	521,265,000	312,759,000	64,900	834,088,900
Албан хаагч		-					
Албан хаагч				-	-	-	-
Албан хаагч				-	-	-	-
Албан хаагч				-	-	-	-
Албан хаагч				-	-	-	-
Сарын дүн		319	443,515	521,318,169	312,790,901	70,180	834,179,250
Дүн (2026.01.01-12.31)			5,322,174	6,255,818,028	3,753,490,817	842,160	10,010,151,005
Нийт дүн				6,255,818,028	3,753,490,817	842,160	10,010,151,005

Агентлаг нь байнгын үйл ажиллагаатай бүтэц болохын хувьд үйл ажиллагааны төсвийг дараах байдлаар тооцлоо:

ХҮНСНИЙ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АГЕНТЛАГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

		/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	2026 оны төсвийн санал	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,211,204.6	
УРСГАЛ ЗАРДАЛ	13,211,204.6	
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,211,204.6	
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	10,756,293.9	
Үндсэн цалин	6,196,333.7	
Нэмэгдэл	3,717,800.2	
Унаа хоолны хөнгөлөлт	842,160.0	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,355,293.0	
Тэтгэврийн даатгал	925,041.3	
Тэтгэмжийн даатгал	107,562.9	
ҮОМШ-ний даатгал	53,781.5	
Ажилгүйдлийн даатгал	53,781.5	

Эрүүл мэндийн даатгал	215,125.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,000.0
Байрны түрээс	228,000.0
Хангамж, бараа материалын зардал	92,280.0
Бичиг хэрэг	38,280.0
Тээвэр, шатахуун	48,000.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000.0
Эд хогшил, урсгал засварын зардал	408,500.0
Багаж, техник, хэрэгсэл	344,000.0
Тавилга	64,500.0
Томилолт, зочны зардал	277,945.0
Гадаад албан томилолт	62,475.0
Дотоод албан томилолт	215,470.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,740.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,740.0
Мэдээлэл технологийн үйлчилгээ	60,000.0
Бараа үйлчилгээний бусад зардал	25,152.6
Бараа үйлчилгээний бусад зардал	20,723.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,429.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,211,204.6
Улсын төсвөөс санхүүжих	13,211,204.6
Улсын төсвөөс санхүүжих	13,211,204.6
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	319
Удирдах албан тушаалтан	24
Гүйцэтгэх албан тушаалтан	295
Үйлчилгээний албан тушаалтан	-

Дээрх зардлын хүрээнд зардлыг нарийвчлан харуулбал:

Хүснэгт 4

ХАНГАМЖ, БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мөрийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	2
1. БИЧИГ ХЭРГИЙН ЗАРДАЛ /2*3/	1	төгрөг	38,280,000
1.1 Бичгийн ажилтны тоо	2	тоо	319
1.2 Бичгийн нэг ажилтанд жилд ногдох зардал	3	төг	120,000
2.ТЭЭВЭР, ШАТАХУУНЫ ЗАРДАЛ /5*6*7/	4	төгрөг	48,000,000
2.1.5 Дуудлагын автомашины тоо (орон нутагт томилолтоор ажиллах)	5	ширхэг	3
2.1.6 Жилийн гүйлт норм	6	км	10,000
2.1.7 ЗГАБ-ын тариф	7	төг	1,600
3. БАГА ҮНЭТЭЙ, ТҮРГЭН ЭЛЭГДЭХ ЗҮЙЛС ХУДАЛДАН АВАХ ЗАРДАЛ /9*10/	8	төгрөг	6,000,000
3.1 Бараа бүтээгдэхүүний тоо	9	тоо	300
3.2 Бараа бүтээгдэхүүний нэгжийн үнэ	10	төгрөг	20,000

ШИНЭ БҮТЭЦ БОЛОХ АГЕНТЛАГ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЭД ХОГШИЛ, УРСГАЛ ЗАСВАРЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мөрийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	2
1. Багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардал	1	төгрөг	344,000,000
Бараа материалын тоо	2	төгрөг	43
Бараа материалын нэгжийн үнэ (Компьютер, принтер)	3	төгрөг	8,000,000
2. ТАВИЛГА	4	төгрөг	64,500,000
Тавилгын тоо	5	төгрөг	43
Тавилгын нэгж үнэ (Ширээ, сандал)	6	төгрөг	1,500,000
НИЙТ			408,500,000

ТОМИЛОЛТ, ЗОЧНЫ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мөрийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	2
1. ДОТООД АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ /6+8+9/	1	төгрөг	215,470,000.0
1.1 Албан томилолтоор ажиллагчдын тоо	2	тоо	177
1.2 Нэг ажилтны томилолтын дундаж хугацаа*давтамж	3	хоног	10
1.3 Албан томилолтын нийт хvн хоног (2*3)	4	хvн/хоног	1,765
1.4 Нэг ажилтны хоногт ногдох томилолтын зардал	5	төг	28,000
1.5 Томилолтын зам хоногийн бүх зардал (4*5)	6	төгрөг	49,420,000
1.6 Нэг ажилтны хоногт ногдох байрны зардал	7	төг	90,000
1.7 Томилолтын байрны бүх зардал (6*7)	8	төгрөг	158,850,000
1.8 Томилолтын унааны бүх зардал	9	төгрөг	7,200,000
2. ГАДААД АЛБАН ТОМИЛОЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ /16+18+19/	10	төгрөг	62,475,000
2.1 Гадаадад албан томилолтоор ажиллагчдын тоо	11	тоо	7
2.2 Нэг ажилтны томилолтын дундаж хугацаа*давтамж	12	хоног	5
2.3 Гадаад албан томилолтын нийт хvн хоног (12*13)	13	хvн/хоног	35
2.4 Нэг ажилтны хоногт ногдох томилолтын зардал	14	төг	175,000
2.5 Томилолтын зам хоногийн бүх зардал (14*15)	15	төгрөг	6,125,000
2.6 Нэг ажилтны хоногт ногдох байр, зочид буудлын зардал	16	төг	560,000
2.7 Томилолтын байрны бүх зардал (16*17)	17	төгрөг	19,600,000
2.8 Томилолтын унааны бүх зардал	18	төгрөг	36,750,000

БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мөрийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	4
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1	төгрөг	67,740,000
1.1. Бусдаар гүйцэтгүүлэх ажлын төлбөр	2	төгрөг	7,740,000
1.1.1 Үйлчилгээний тоо	3	тоо	3
1.1.2 Үйлчилгээний нэгжийн үнэ	4	төгрөг	2,580,000
2. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР	5	төгрөг	60,000,000
2.1 Програм хангамж, лицензийн тоо	6	тоо	3
2.2 Бүтээгдэхүүний нэгжийн үнэ	7	төгрөг	20,000,000

БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, үйлчилгээний бусад зардлын төрөл	Мөрийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	4
1. Бараа үйлчилгээний бусад зардал	1	төгрөг	20,723,000

Хэлэлцүүлэг зохион байгуулах тоо	2		2
Нэг удаагийн хэлэлцүүлгийн зардал	3		10,361,500

Бараа, үйлчилгээний бусад зардлын төрөл	Мерийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	4
2. ХИЧЭЭЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ ЗАРДАЛ	1	төгрөг	4,429,600
Сургалт зохион байгуулах тоо	2		2
Ажлын албаны чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах	3		2,214,800

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, агентлагийн нийт бүтцийн хүрээнд жилийн төсөв нь 13.2 тэрбум төгрөгийн зардал гарахаар байна. Үүнээс 10.7 тэрбум төгрөгийн зардал нь нийт ажилтны цалингийн зардалд хамаарах хэдий ч энэ зардал нь хуулийн төсөлтэй хамааралгүйгээр гарах бодит зардал болно. Өөрөөр хэлбэл, дээрх цалингийн сан нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжих юм.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор гарах нэмэлт зардал нь:

- Агентлагийн ажлын байрны түрээсийн зардал;
- Эрсдэлийн үнэлгээний төвийн ажлын байрны түрээсийн зардал;
- Агентлагийн 28 ажилтны тавилга, техник хэрэгслийн зардал;
- Эрсдэлийн үнэлгээний төвийн 15 ажилтны тавилга, техник хэрэгслийн зардлыг тооцно.

ХАБҮЛЛ-ын хувьд одоо байгаа байр, тавилга, техник хэрэгслийг ашиглах тул хуулийн төсөлтэй холбоотой нэмэлт зардал гарахгүй.

Түүнчлэн, агентлагт хамаарах ажилтнууд нь бүгд төрийн бусад байгууллагаас шилжүүлэн томилогдох тул шинээр цалингийн зардал үүсгэхгүй, төсөв дотроо зохицуулалт хийх замаар зохион байгуулагдаж, одоо байгаа төсвийн хүрээнд шийдвэрлэгдэхээр байна. Үүнээс бодитоор тооцож үзвэл, хуулийн төсөлтэй холбоотой нэмэлт зардал нь байр түрээс болон шинээр бий болох байгууллагын эд хогшлын зардалд 636.5 сая төгрөгийн зардал гарахаар байна. Үүнээс байр түрээслэхгүй төрөөс гаргах боломжтой гэж үзвэл 228 сая төгрөгийг хэмнэх, улмаар уг шилжин ирж буй ажилтнууд нь өөрсдийн өмнөх ажлын байранд ашиглаж байсан техник хэрэгсэлтэй хамт шилжих бол төсвөөс зардал гаргахгүйгээр хэмнэх боломжтой байна.

ДҮГНЭЛТ

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэд, хуулийн этгээдээс зардал гарахгүй гэж тооцсон. Харин төрийн байгууллагаас жилд гарах зардлын тооцоог хийлээ.

Төсвийн тухай хуулийн 6.2.5.төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх. гэж заасан тул уг тооцооллыг 2026 оноос хэрэгжихээр хийлээ. Төсөвт тодотгол хийхээс бусад тохиолдолд 2025 оны дундуур энэ агентлагийг шинээр зохион байгуулах замаар шинэ зардал үүсгэх боломжгүй байна.

Төрөөс гарах зардал, агентлагийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой гарах зардлын тооцоог хийсэн. Агентлагийн чиг үүрэгт одоо ажиллаж байгаа ХХАХҮЯ-ны салбарын хяналтын газрыг чиг үүргийг шилжүүлнэ. Мөн ХАБҮЛЛ болон шинээр байгуулах Эрсдэлийн үнэлгээний төвийг уг агентлагийн доор ажиллуулахаар байна. Агентлаг нь бүтцийн хувьд ХАБҮЛЛ, Эрсдэлийн үнэлгээний төвтэй нийлээд 319 ажилтантай ба үүнээс шинэ ажилтан нэмж авахгүй, чиг үүргийн дагуу ХХАХҮЯ дээр ажиллаж буй салбарын хяналтын орон тоог агентлагт шилжүүлнэ. Эдгээр бүтцийн хувьд цалингийн нэмэлт зардал үүсэхгүй ба төсвийн ерөнхийлөн захирагч хооронд цалингийн санг шилжүүлнэ. Иймээс төсөвт үзүүлэх зардлын тооцооллыг хийхдээ цалингийн зардлыг шинээр нэмэгдэхгүй байхаар тооцлоо.

Харин шинээр агентлаг байгуулахтай холбоотойгоор үйл ажиллагаа явуулах ажлын байр, тавилга хэрэгсэл, компьютер техник хэрэгслийг лаборатороос тусад нь үйл ажиллагаа явуулах 28 хүний орон тоо, мөн Эрсдэлийн үнэлгээний төвийн 15 хүний орон тоо буюу нийт 43 хүнийг тусад нь ажлын байр гаргаж, ажиллуулах шаардлагатай байна.

Зардлыг нэгтгэн авч үзвэл, нийтдээ агентлагийн 2026 оны үйл ажиллагааны урьдчилсан төсөв нь 13.2 тэрбум төгрөгийн зардал ба үүнээс хамгийн өндөр зардал болох 10.7 тэрбум төгрөгийн зардал нь цалингийн зардал эзэлж байна. Гэвч, агентлагт хамаарах 319 ажилтан нь одоо ажиллаж байгаа ажилчид тул шинээр орон тоо бий болгохгүй болно. Иймд хуулийн төслийн хүрээнд цалингийн зардал, бичиг хэргийн зардал болон томилолтын зардал нэмэлтээр бий болохгүй.

Харин, шинэ байгуулагдах агентлагийн 28 ажилтан, Эрсдэлийн үнэлгээний төвд хамаарах 15 ажилтны ажлын байрны түрээс, тавилга, компьютер хэрэгслийн зардал нь нийтдээ 636.5 сая төгрөгийн зардал гарахаар байна. Үүнээс ажлын байрыг түрээслэхгүй төрийн өмчийн бусад байрыг ашиглах тохиолдолд 228 сая төгрөг хэмнэх боломжтой ба улмаар тавилга, компьютер хэрэгслийг төрийн өмчийн хөрөнгөөс ашиглах бол төрөөс ямар ч зардал гаргахгүйгээр агентлагийн үйл ажиллагааг шийдвэрлэх бүрэн боломжтой байна.

Өөрөөр хэлбэл, энэхүү хуулийн төсөлтэй холбоотойгоор одоо байгаа чиг үүргийн дагуу ажилтнуудыг шилжүүлэн ажиллуулахдаа техник хэрэгслийн хамт шилжүүлэх, улмаар төрийн өмчийн байранд уг агентлаг болон Эрсдэлийн үнэлгээний төвийг байрлуулах тохиолдолд төсөвт нэмэлтээр зардал тооцох шаардлагагүй. Харин төсвийн ерөнхийлөн захирагч хооронд буюу Шадар сайдын төсвийн багцаас ХАБҮЛЛ-ыг ХХАХҮС-ын багцад шилжүүлэх шаардлага бий болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль;
3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан;
4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал;
5. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
6. Төрийн албаны тухай хууль;
7. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”;
8. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол;
9. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол;
10. Төсвийн тухай хууль.

6 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

төслийн файлууд

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ -ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ -ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

(ХБАБХТХуулийн төсөл.docx)

ХОЛБОО БАРИХ

+976-51-267016 (Утас)
+976-11-327016 (Факс)

d@parliament.mn

Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улс 14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон.

НЭР

УТАС

ИМЭЙЛ

САНАЛ ХҮСЭЛТ





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүрэнжавын ЛҮНДЭГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-03-85, Факс: 32-70-16
E-mail: lundeg@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.05.16 № ЧИХ-03/0294
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн миний бие Хүнсний Бүтээгдэхүүний Аюулгүй Байдлыг Хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу Хүнсний Бүтээгдэхүүний Аюулгүй Байдлыг Хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлт авахаар Танд хүргүүлж байна. Хуулийн төслийн талаарх санал, дүгнэлтийг зохих журмын дагуу ирүүлнэ үү.

Хавсралт ²⁴⁵ хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЛҮНДЭГ

00000102

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
ТУСГАСАН БОЛОН ТУСГААГҮЙ САНАЛЫН ТОВЬЁГ

2025.06.16.

УБ хот

№	Санал ирүүлсэн байгууллага	Саналын агуулга	Төсөлд тусгасан үндэслэл	Төсөлд тусгаагүй үндэслэл
1	УИХГишүүн М.Нарантуяа-Нара 2024.06.04 хэлэлцүүлэг	Энэ хууль хэрэгжихэд Мэргэжлийн хяналтын байгууллага дахин сэргээгдэх үү? Яаж хянах вэ?	"Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" төсөлд "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын тохируулагч агентлаг" гэсэн хэсэгт "Хүнсний хяналт, зохицуулалтын газар" гэж нэмсүгэй." гэж тусгасан. Хуулийн төслийн "141 дүгээр зүйлд Хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо, холбогдох төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлж тусгасан.	
2	Боловсролын яам Түмэнжаргал 2024.06.04 хэлэлцүүлэг	1. Мэдээллийн санд ямар ямар мэдээлэл байх вэ? 2. Хангамжийн тогтолцоонд захиалагч болох сургууль тендерийн үйл ажиллагааг явуулдаг ханган нийлүүлэлтийн төв байгуулмаар байна. Магадгүй ложистикийн төвийг олон улсын туршлагаар байгуулахад ямар зохицуулалтыг хуульд тусгах вэ? 3. Хууль болгон дээр татварын хөнгөлөлт хуульд ороод явах уу?	1. Хүнсний тухай хуулийн "171 дүгээр зүйлд "Мэдээллийн нэгдсэн сан"-д нийт 14 мэдээллийг төвлөрүүлэхээр заасан. Үүнд: 17 ¹ .1.1.салбарын хүний нөөцийн бүртгэл; 17 ¹ .1.2.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн; 17 ¹ .1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл; 17 ¹ .1.4.газар тариалан, малын бэлчээр, оторлох газрын бүртгэл;	

	Малгай хууль болох Хүнсний тухай хуульд тусгагдаад явах уу?	17¹.1.5.хүн амын болон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах ус хангамжийн бүртгэл; 17¹.1.6.хүнсний техник, тоног төхөөрөмж, технологийн бүртгэл; 17¹.1.7.хүнсний нөөцийн бүртгэл; 17¹.1.8.хүнсний эрэлт, нийлүүлэлтийн статистик; 17¹.1.9.хяналт шалгалтын үйл ажиллагааны тайлан; 17¹.1.10.ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн; 17¹.1.11.импорт, экспортын зөвшөөрлийн; 17¹.1.12.итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын; 17¹.1.13.хүнсний сорилын лабораторийн шинжилгээний дүн 17¹.1.14.хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан. 2. Хүнсний тухай хуулийн 5.5-5.8 дахь заалтад сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой 3 зохицуулалтыг тусгасан. Үүнд: “5.5.Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, худалдаа, ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хүнсний хангамж бүрдүүлнэ.
--	--	--

			5.7.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан хүнсний хангамжийг тодорхойлохдоо нэн тэргүүнд нялх балчир хүүхдийн хоол тэжээл болон цэцэрлэг, сургуулийн хүнсний хүртээмжийн асуудлыг тусгана. 5.8.Энэ хуулийн 5.5-т заасан цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.”	
УИХГишүүн П.Батчимэг 2024.06.12 хэлэлцүүлэг		Энэ хуулийн төслийг боловсруулах явцад монголын, үндэсний гэхээсээ илүүтэй гадаад орны, хөгжингүй орны туршлагаас судалж, газар дээр нь очиж үзсэн туршлага байна уу ? Засгийн Газраас өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн төсөлтэй танилцмаар байна. Тэнд бүр яг стандартын тухай яриад байна шүү. Дүрэм журмаасаа илүү давсан стандарт гэж шаардлага тавиад байгаа бол С.Амарсайхан сайдаас өргөн мэдүүлж байгаа тэр хуулийн заавал үзнэ үү.	Хуулийн төслийг боловсруулж байгаа баг гадаад улсад хүнсний чиглэлээр сурч, эрдмийн зэрэг хамгаалсан туршлагатай эрдэмтэн докторууд ажилласан. Стандартчилал, техникийн зохицуулалт, Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөлтэй танилцсан. Хуулиас давсан стандартыг батлуулахгүйн тулд хуульд тухайлбал, хүнсний үйлдвэрлэлд ямар зохистой дадлын стандартыг нэвтрүүлэхийг тодорхойлж заасан. Хүнсний тухай хууль болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хүнсний сүлжээнд зохицуулагдаагүй үлдсэн тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой харилцааг нэмж тусгасан. Тухайлбал, хүнсний анхан шатны болон боловсруулах үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, худалдаанд холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг, хүнсний сав баглаа, боодол, туслах	

			материалд хамаарах стандартыг мөрдөхөөр заасан. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг дээшлүүлж, хүнсний баталгаат байдлыг хангах зорилгоор зөвхөн стандартын урьтал нөхцөл болсон зохистой дадлыг нэвтрүүлж, баталгаажуулахыг үүрэг болгосон. Тус хуулийн 18.1.7-18.1.8 дахь хэсэгт хүнсний баталгаат байдлыг хангахтай холбоотой үндэсний стандартыг боловсруулах үйл ажиллагааг тусгасан. Тухайлбал, “18.1.7.хүнсний сүлжээнд мөрдөх стандартын шүүлт хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтэд үндэслэн стандартыг хүчингүй болгох санал, стандартын төсөл боловсруулах, батлуулах, мөрдүүлэх, хэрэгжилтийн үнэлгээ хийх; 18.1.8.шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хүнсний хяналтын бодлогыг боловсруулахад эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгааны үр дүнг ашиглах, бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, түүнд үндэслэн төсөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, хяналтын үр дүнгээр хяналтын бодлогод өөрчлөлт оруулах.”
		Хүнсний баталгаат байдал гэдэг бол тухайн бус нутагтаа иддэггүй, хамгийн болдоггүй хүнсний бүтээгдэхүүнийг л импортоор оруулж ирэхгүй байх тухай хууль л гэж би ойлгоод байгаа. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх хяналт хангалтгүй урт удаан хугацаанд явснаас үүдэн манай улсын хүн ам дэлхийд хорт хавдраараа нэг номерт, хорт хавдрын	Тус хуулиар хүнсний баталгаат байдалд тавих хяналтын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон. Жишээлбэл, “18.4. Хүнсний баталгаат байдалд тавих хяналт дараах чиглэлтэй байна:
	УИХГишүүн Р.Сэддорж 2024.06.12 хэлэлцүүлэг		4

	үхлээрээ нэг номерт орчихсон явж байгаа. Тэгэхээр энэ хуульд хяналтыг явуулах зохицуулалт хэр орсон бэ? Дорнын ангаах ухаан, дорнын хүнсийг хэрэглэх тал дээрээ анхаарна уу. Энэ хуультайгаа малын эм тариа вакцины хяналтыг холбож өгөх арга байна уу? Нарантуул зах дээр малын эм тариа зарж байгаа нийгэмд амьдарч байгаа шүү. Малчдад мал эмнэлгийн боловсрол байхгүй, зүгээр л сургаар явж байгаа. Тэгээд яг ийм мах, хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэж байна. Энэ нь дээр наад хуулийн өөрчлөлт дээр чинь оруулах юм байхгүй уу? Одоо Европ, Америк даандаа л том E үсэгтэй импортын бүтээгдэхүүний хэрэглэж болохгүй, органик гэсэн бичигтэй юм хэрэглэнэ. Тэгэхээр одоо манайх хүнсний нэмэлтийг хэрэглэх бодлогоо бариад энэ хууль нь ийм өөрчлөлтүүдийг оруулж болохгүй юу. Хамгийн болохгүй юмнуудыг л хэрэглээд байх шиг байгаа нь. Хамгийн гол нь үр дүн нь хорт хавдраараа нэг номерт байгаа байхгүй юу. Энэ газар зүйн байршлаасаа болоод байгаа юмуу, эсвэл хүнсний бүтээгдэхүүнээсээ болоод байгаа юм уу ? Улам бэлэн бүтээгдэхүүн хэрэглээд явна. Гэхдээ одоо бид нар хөгжихсөн орны араас явах шаардлага байдаг юм уу ? Соён гэгээрүүлэх талын асуудлыг тусгасан уу?	стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилт; 18.4.1.хууль тогтоомж, зохицуулалтын 18.4.2.энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан зохистой дадлыг нэвтрүүлж, баталгаажуулсан эсэх; 18.4.3..дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгололт, шошго дох тэмдэг, тэмдэглэгээ; 18.4.4.Хүнсний тухай хуулийн 5¹ зүйлд заасан стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрөл олголт; 8.4.5.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авалт; 18.4.6. Энэ хуулийн 9.5.1, 9.5.2.- д заасан ул мөрийг мөрдөж тогтоох бүртгэл; 18.4.7. Хуульд заасан бусад. Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.4-7.1.8 дахь заалтад дараах зохистой дадлыг тодорхойлсон. Үүнд: “7.1.4.хоол үйлдвэрлэл, үйлчилгээний; 7.1.5.хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалтын зохистой дадал; 7.1.6. хүнсний сүлжээний нэг үе шатаас нөгөө үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээх, хүргэх шатанд тээвэрлэлтийн зохистой дадал; 7.1.7. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтын шатанд худалдаа үйлчилгээний зохистой дадал; 7.1.8.мал эмнэлгийн үйлчилгээний зохистой дадал;
--	---	--

7.1.9.мал, амьтныг эрүүл өсгөх, тэжээх үе шатанд холбогдох зохистой дадал.

Тус хуулийн 10 дугаар зүйлд Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд **хориглох зүйлийг тодорхойлж тусгасан**. Үүнд:

10¹.1.3.хүнс үйлдвэрлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хүнсний нэмэлтийг хэмжээнээс нь хэтрүүлэн хэрэглэх, зориулалтыг өөрчилж хэрэглэх;

10¹.1.4. түүсэн ойн дагалдах баялгийн өнгө, зүс, амт чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт дур мэдэн хольж хэрэглэх, зах зээлд нийлүүлэх;

10¹.1.5.ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэх;

10¹.1.6.газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэх;

18.5.Энэ хуулийн 13¹.1-д заасан байгууллага, нэгж, улсын байцаагч нь хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран үйл ажиллагааных нь чиглэлээр мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилыг сайжруулахад чиглэсэн **сургалт, сурталчилгаа зохион байгуулах,**

			зөвлөгөө, мэдээллээр хангах, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.”	
		Улсын Их Хурлын Гишүүн Г.Хосбаяр 2024.06.04 хэлэлцүүлэг	Олон стандарт байдаг, тухайлбал барилга, эмнэлэг, хүнсний стандарт гэх мэт, Сая Мэргэжлийн Хяналтын байгууллагын тухай ярьж байна. Салбарынхан хяналт тавиад хуулийн дагуу хуулиа хянаад явж байгаа. Хяналтыг хэрхэн тусгасан бэ? Харин стандартыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Стандарт нутагшуулах боловсруулах техникийн ажил байдаг. Хувийн компаниуд стандартыг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг болох асуудал байна. Хүнсний тээвэр ложистик дээр анхаарах. Хадгалалтад дээр Засгийн газарт чиглэл өгөх том бодлого оруулах нь шаардлагатай гэж бодож байна. Улаанбаатар тойрсон агуулах дээр бүрэлдэхүүнд орж ажилласан. Бүх зүйлийг хувийн хэвшилд оруулах нь зүйтэй байна.	Хуулийн төсөлд хүнсний сүлжээнд үйл ажиллагаа эрхлэгч өөрт хамаарах үе шатанд зохистой дадлыг нэвтрүүлэхээр заасан. Зохистой дадлын тодорхойлолтыг тусгасан болно. Үүнд: “7.5.Энэ хуулийн 7.1.4-д заасан зохистой дадалд хоол үйлдвэрлэл, нийтийн орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зуушаар үйлчилдэг цэгүүдэд зориулсан стандарт, хоолны орц, давтан хэрэглээ, кросс бохирдлоос сэргийлэх, үйлчлүүлэгчид хүрэх хүртэлх баталгаат байдлыг хангах үйл ажиллагаа хамаарна. 7.6.Энэ хуулийн 7.1.5-д заасан зохистой дадалд хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнс хадгалах, агуулах, зоорь, хөргүүрийн зохистой ашиглалт, температур, чийгшил, хугацаа, ялгах хураах, QR код, хөлдөөлт, гэсгээх үйл ажиллагаа хамаарна. 7.7.Энэ хуулийн 7.1.6-д заасан зохистой дадалд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээх үеийн хяналт, хөргүүртэй машин, тээврийн бичиг баримт, хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь тусгаарлах, температур, чийг, бохирдолд тогтмол хяналт хийх, тээврийн эрсдлийг бүртгэх үйл ажиллагаа хамаарна. 7.8.Энэ хуулийн 7.1.7-д заасан зохистой дадалд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, түүгээр үйлчлэх, малын болон ургамлын гаралтай хүнсний түүхий

		эд, бүтээгдэхүүнийг худалдан авах, борлуулах үйл ажиллагаа хамаарна. 7.9.Энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д заасан зохистой дадалд мал эмнэлгийн үйлчилгээ, түүний хяналт, мал үржлийн үйлчилгээг хамруулна. 7.7.Хүнсний сүлжээний бүх шатанд зохистой дадал, техникийн зохицуулалтыг зөрчсөн нь тогтоогдвол тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцлага хүлээнэ.	
--	--	--	--